

# ӨӨРТӨӨ ТУСЛАХ УХААН

Япон хэлнээс  
Очирхүүгийн Жаргалсайхан орчуулж,  
монгол найруулгыг  
Бүдрагчаагийн Даш-Ёндон хянав.

## ХҮНИЙ САЙН ҮЙЛС

Миний бие Самуэл Смайлын "Өөртөө туслах ухаан" хэмээхбүтээлийн бүлгүүдийг "Манай Монгол" сэтгүүлээс уншсан юм. Тэгээд энэ номыг бие даалган хэвлүүлэхийг нөхөддөө зөвлөсөн. Гэтэл бас тэр номыг хэвлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлбэ гэж дотоод, гадаадын зарим хүмүүс сэтгэл, гар хоёроо дэлгэжээ. Тэдгээр сайн санаатнууддаа талархал илэрхийлбэ.

Эрдэнэт хүний биеийг олсон хэнд ч гэсэн энэ ном ихээхэн тус болно гэж би бодож байна. Хүн яаж хичээх, яаж ажиллавал өөрийгөө эзэмдэж, хүссэн үр дүндээ хүрдэг талаар энэ номд гайхамшигтай бодомжууд хэлж эерэг жишээ баримтуудаар нотолжээ. Хүн өөрийгөө төгөлдөржүүлэх гэдэг гойд онцгой үзэгдэл юм.

Энэ номд дурдсан жишээ баримтуудыг он цагийн хувьд эртнийх тул одоогийн бидэнд нөлөөлөхгүй хуучирсан зүйл гэж бодох хэрэггүй. Аль ч цаг үе хүнээс хичээл зүтгэл шаарддаг. Хүн өөрийгөө төгөлдөржүүлэх хэрэгцээ аль ч цаг үед байдаг. Эхээс заяасан хэн ч гэсэн зүгээр суугаад байхад л бүх амьдралдаа хүрэлцэх, нэр алдраа дуурсгах тийм үнэмлэхүй авьяас чадвартай төрдөггүй юм. Эхээс заяасан хэн ч гэсэн оролдоод, зүтгээд, хичээгээд байвал бүүр өөрийнхөө санаагүй тийм томоохон үр дүнд хүрч чадна.

Хорвоод амьдралын төлөө ажиллаж тэмцэх хичээл зүтгэл, идэвх зориг аль ч цаг үед хуучирна гэж байхгүй. Иймд эл ном үнэ цэнээ алдахгүйгээр их удаан хугацаанд хүн төрөлхтөнд тус дэм болж, оюуны тэнхээ өгнө буйзаа гэж бодож байна.

Энэ номыг манай залуучууд сайтар уншиж санаа аваарай. Эцэг эхчүүд маань ч түүнийг нарийвчлан судалж үр хүүхдээ сурган хүмүүжүүлэхдээ ашиглах нь чухал юм.

Манай иргэд өөрөө өөрийгөө ямагт төгөлдөржүүлэн үнэнхүү хичээн зүтгэвээс улс орноо аянд нь өөд татах болно, өөрсдөө ч сайхан амьдрана.

Номын цагаан буян дэлгэрч, энэ зохиол Таны өврийн ном, байнгын зөвлөгч болог.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ

НАЦАГИЙН  
БАГАБАНДИ

## 1866 ОНД ДАХИН ХЭВЛЭСЭН ХЭВЛЭЛИЙН ОРШИЛ

Дотоод, гадаадад олон түмнээс ихээхэн үнэлэлт авсаар байгаа энэхүү номныхоо анхны эхээ засан сайжруулаад хэвлэж байна. Анхны эх маань Америкийн Нэгдсэн Улсад хэдэнтээ хэвлэгдэж, Голланд, Францад орчуулагдан, Герман, Дани улсад орчуулагдахаар бэлтгэгдэж байна. Ийнхүү олон орны хүн зо нд уншигдаж байгаа нь түрүүчийн хэвлэл маань хүмүүсийн зан төрх, ахуй амьдралын талаар хүмүүст тэр бүр танил биш янз бүрийн жишээг гаргаж тавьснаас тэр юм. Үүнд емнөх үеийн хүмүүсийн хичээл зүтгэл, туршил сорил, тэмцэл, амжилт бичигдсэн буй. ...

Зохиогч би вээр анхны хэвлэлд эрээвэр хураавар жишээ олон хэмээх шүүмжлэлийг бүрнээ ойлгож буй билээ. Миний бие дан гагц хэвлэх тухай үл бодон, залуу хүмүүст уншуулахсан хэмээн он удаан жилийн турш юухныг ч тэмдэглэн авч хадгалж ирсэн билээ. Түүнийгээ эмхтгэн хэвлүүлсэн нь тэр бөгөөд, олон жишээтэйн дутагдал байх нь үгүй гэхийн газаргүй бөлгөө. Энэхүү засан сайжруулсан номондоо анхны эхийнхээ нэгэн хэсгийг хассаны хамт, бас уншигчдын сонирхолыг татахаар олон шинэ жишээг нэмж хийсэн болно.

Энэ номын гарчиг төдийлөн сайн оноогүй байж магадгүй юм. Эл гарчигнаас хараад уг номыг аминч үзлийг магтан дуулж байна хэмээж магадгүй Гэвч энэхүү номын үзэл санаа тэс өөр билээ. Уг номын гол зорилго нь залуу хун бусдын ивээл хишгийг горьдох бус, бат чанга өөрийн бодолтой байж, зөв зорилгын араас хөөцөлдөхийн тулд ажил хөдөлмөр, зовлон бэрхшээл, өөрийгөө золиослоход шантралгүй хичээл чармайлт гаргахыг уриалж байгаад оршино. Гэхдээ хамгийн дээд утгаараа өөртөө туслана гэдэг бол өөрийнхөө хавь орчны хүмүүст туслана гэдгийг ч мөн багтааж буй. Энэ ном чухамхүү үүнийг зохиолч, эрдэмтэн судлаач, урлагийн авьяастан, зохион бүтээгч, сурган хүмүүжүүлэгч, буяны үйлтэн, санваартан нарын жишээгээр илэрхийлж байгаа юм.

Энэхүү номын талаар, өөрөө өөртөө тусласны хүчинд амжилт олсон хүний жишээ хангалттай байвч, аддаж будилсан хүний жишээ байхгүй гэсэн шүүмжлэл дуулддаг. Ийм шүүмжлэлд ч үнэний хувь бий. Гэхдээ алдааны цуглуулгыг уншивч урам л дундрахын нэмэр, хүний амьдралын сургамж болно гэхэд бэрх юм. Зөвхөн алдахын аюул буй учир, түүнээс зайлсхийхийн тулд өөрийгөө батжуулж, зан араншингаа цэвэршүүлж, сахилгажуулж, мэдлэг ухааныг хуримтлуульа хэмээн бүхий л чадлаараа хичээн зүтгэх ёстой юм. Үүнийг л энэ номондоо бүрэн дүүрэн бичихийг хичээсэн билээ. Товчоор хэлэхэд, алдаа ч тэсвэр тэвчээрээр таягдан хаягдвал сургамжинд бялхсан сонирхлыг дуудан босгодог зүйл, энэ тухай ч тус номонд хангалттай бичихийг хичээсэн болно.

Эцэст нь хэлэхэд уг номын зорилго нь хуучны, түүгээр зогсохгүй эрүүл саруул сургаалийг залуу хүмүүст давтан сургахад оршино. Хичээл зүтгэл, шаргуу оролдлогогүйгээр үнэ цэнэтэй ямар ч хэргийг бүтээж үл чадмой. Зовлон бэрхшээлд сөгдөлгүй, түүнийг арилгахын тулд тэвчээртэйгээр сөрж, тэгээд бас юунаас ч илүүтэйгээр зан араншингаа төлөвшүүлэхэд шамдах хэрэгтэй, үүнгүйгээр авьяас чадвар ч үнэ цэнэ үгүй, хорвоод олсон амжилт ч үгүй хоосонтой адил болно, эдгээр зүйл бол хичнээн онцловч онцолж илүүдэхийн аргагүй бөлгөө. Хэрвээ зохиогч миний бие эдгээр сургаалийг тодорхой жишээгээр тайлбарлахад амжилт олоогүй байх ахул, харин энэхүү номыг аддаа болжээ гэхэд болох буй за.

САМУЭЛ СМАЙЛС

## Уншигч танаа

Самуэл Смайлс бол хүнд хайртай, хүнд сайхан ханддаг, хүний үнэ цэнийг мэддэг нэгэн байжээ гэдгийг энэ номыг уншигчид та мэдэрэх болно, түүнд баярлан талархах сэтгэлээр ухаан бодол чинь дүүрэх болно.

Эрхэм хүн Самуэл Смайлсын энэхүү сайхан номыг Монгол Улсын Ерөнхийлөгч **Нацагийн Багабандийн даалгавар, ивээлээр** япон хэлнээс орчуулан хэвлэлээ.

Зуун зууныг дахин дахин эзэгнэсэн ийм номыг бүтээхэд амаргүй. Энд үнэхээрийн сайхан сэтгэл, асар их хүч чармайлт хэрэгтэй. Энэтхэгийн суут хүн Рабиндранат Тагор: "Миний сүмийг энэрэл шүтлэгийн эд эсээр барих байх гэж бурхан бодож байдаг, гэтэл хүмүүс түүн рүү чулуу тэвэрч очдог" гэж уран гайхалтай хэлжээ. Тэгвэл Смайлс хүн төрөлхтний сүмийг энэ номонд шингээсэн үзэл санаагаараа бүтээчихжээ гэж хэлмээр байна.

Тэхдээ энэ ном бол үзэл суртал биш, гүн ухааны юм уу хүн судлалын шинжилгээ ч биш, шашны номлол ч биш, энэ ном бол хүмүүн Та бидний нэгэн төрөлтөн бусдыгаа, амьдралыг ажиглан байж орчин цагийнхандаа болон хойч үеийнхэндээ чин сэтгэлээсээ үлдээсэн сайн санааны гэрээс, захиас юм. Надад ингэж л бодогдсон.

Хүн, түүний оюун ухаан, цаг үеийн, нийтийн бүтээгдэхүүн гэдэг нь үнэн боловч бас хүн эцсийн эцэст өөрөөрөө эхэлж, өөрөөрөө дуусдаг нь жам бөлгөө. Иймээс ч Бурхан Будда "өөрөө өөртөө зул бол!" гэж сургасан нь гүн нарийн учиртай ажгуу. Үнэхээр, хүн өөрөө хичээхгүй, өөрөө чармайхгүй, өөрөө зүтгэхгүй бол хэн ч хэнийг ч сайн сайхан амьдруулж чадахгүй. Эцэг эхийн халамжийн хойно хэн ч өөрөө л амьдрах нь хорвоогийн ёс билээ. "Эзэн хичээвэл заяа хичээнэ" гэж аав нь хүүхдүүддээ сургажээ. Манай Монгол ийм л ухаантай.

Энэ бүх санаа амьдралд яаж хэрэгжих вэ, хэрэгжүүлэхийн оньсон түлхүүр нь юу вэ, "хүн хичээнэ" гэж юуг, яахыг хэлж байгаа вэ гэсэн асуултуудад Смайлс энэ номондоо гайхалтай сайхан хариу өгчээ.

Хүн өөрөөрөө байна гэдэг бас бусдын дэмжлэг огт хэрэггүй гэсэн үг биш билээ. Бусдаас гадна хэнбугай ч байж чадахгүй. Иймд бусдын дэм, халамж, үүргийг ойлгодог хүн л "хол явна", өөрөөр хэлбэл, "жинхэнэ хүн" мөн. Яаж тийм болох вэ гэдэгт Нагаржунай хариу өгсөн нь: "Өгөөмөр бөгөөд ёс суртахуунтай байвал бусдад тус болно, хэвчээртэй хийгээд шийдэмгий байвал өөрт хэрэг болно" гэжээ.

Хүн өөрөө хичээвэл тэр өөрт нь тус болоод зогсохгүй, улс орон, элэг нэгт үндэстэнд ч хэрэг болдог. Улс орны хөгжил хэмээх хийсвэр уйлдлийн буюу зүгээр л нэг "бодлогын" дүн болж бүтдэггүй, харин хүн бүрийн бодит хүчин чармайлтын үр дүн болж биеждэг юм.

Смайлсын эл номыг уншсан хүн өөрийгөө эзэмдэж заавал өөдлөх болно.

Тэгвээс улс орон аяндаа өөдөө явмой.

Бид энэ номын "сүмийг барихдаа" хад чулуу, элс шороо, барьж очих хэрэггүй, харин сэтгэлээ, өөрөө өөрийгөө тэвэрч очвол л болох нь тэр. Тэгвээс өөрийгөө дайчлан эзэмдэх бүхий л чадварыг Та эзэмшиж, "амьд арзайгаад, мэнд мэлтийгээд" байх нь гол бус гэдгийг ухаарч санаагаа тэлж, ухаанаа нэмэх болно. "Тэнгэрт дүүлбэ гэж оролдохгүй оюун санаа удалгүй газарт унамой". С.Смайлс

БҮДРАГЧААГИЙН ДАШ-ЁНДОН

## **Гарчиг**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

Өөртөө туслах ухаан

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**

Тэвчээр

**ГУРАВДУГААР БҮЛЭГ**

Нэг тохиосон хувь дахиж ирдэггүй

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

Ажил хөдөлмөр

**ТАВДУГААР БҮЛЭГ**

Зориг хийгээд амьдрах хүч

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ**

Цаг хугацааны ухаан

**ДОЛДУГААР БҮЛЭГ**

Мөнгөний ухаан

**НАЙМДУГААР БҮЛЭГ**

Өөрийгөө боловсруулахуй

**ЕСДҮГЭЭР БҮЛЭГ**

Гайхамшигтай учрал

**АРАВДУГААР БҮЛЭГ**

Хүмүүний чансаа

Уялга үг

## Өөртөө туслах ухаан

*Амьдрал гэдгийг чи өөрийн гараар л нээнэ..*

### 1. Өсч хөгжихийн хүслэн, өөртөө туслах ухаан

"Бурхан гагцхүү өөрөө өөртөө тусладаг хүнд л тусладаг..." (Heaven helps those who help themselves) хэмээх энэхүү зүйр үг асар их зам туулж үе үеийг дамжиж өнөөд ирсэн билээ. Энэхүү богинохон хэллэг хүмүүсийн тоолж баршгүй туршлагаас улбаалагдан гарсан нэгэн үнэнийг илэрхийлж буй юм. Өөртөө туслах оюун ухаан бол хүмүүс өсөлт хөгжилтөө шулуутгахын тулгын чулуу мөн. Өөрөө өөртөө туслах ухаан олон хүний амьдралын хөрс суурь болж, тэгснээрээ амьдралын эрчим буцалсан хүчтэй төр улсыг байгуулахад цаад хөдөлгөх хүч нь болж өгдөг бизээ.

Гадаад талын тусламж хүнийг үлбэгэр сул болгодог. Өөрөө өөртөө тусалж, өөрийгөө аварья хэмээх оюун санаа л хүмүүсийг хэзээд зоригжуулж өөдрөг болгож байдаг. Хүнд сайн тус хүргээ гээд гараа сунгаад байвал нөгөө тал өөрөө хөл дээрээ босох сэтгэлээ алдаж, өөртөө туслахын чухалыг мартдаг. Халамж бөөцийлөл хийгээд хатуурхаж барих аль аль нь хэрээсээ хэтрэхээр тус биш ус болж хүч чадалгүй хүмүүнийг бий болгодог нь үнэн юм.

Яаж ийгээд гайхалтай систем тохинууллаа ч түүгээр хүмүүсийг аврах учир үгүй. Хамгийн сайн нь юу ч хийлгүй зөнгөөр нь орхих явдал ч байж магадгүй. Тэгвэл хүн өөрийнхөө чадлаар өөрийгөө хөгжүүлж, өөртөө байгаа нөхцөл байдлыг засан сайжруулж явах бизээ.

Тэхдээ аль ч үед хүмүүс аз жаргал, мандал бадралд хүрэх нь өөрийн үйлдлээр бус системийн хүчээр болох зүйл хэмээн итгэсээр ирэв. Тиймээс ч "хууль цаазыг бий болговол хүмүүс дэвжиж хөгжинө" гэх мэт асар том дүгнэлт мэдээжийн зүйл шиг байх болов.

Мэдээж хэрэг, хууль цааз сайтар хэрэгжвэл хүн хувьдаа золиос бололгүй, өөр өөрсдийнхөө хөдөлмөрийн /оюун санаа болон биеийн хүчний хөдөлмөр/ үр шимээ хүртэж чадах юм. Гэвч ямар ч хүчирхэг хууль тогтоолоо гэсэн залхуу этгээд ажилсаг болон хувирч, үрэлгэн хүн тооцоотой болж эхлэх, архичин архиа болихын учир үгүй билээ. Өөрийнхөө гэмийг ухаарч, хэмнэхийн утга учрыг мэдэж, архинд живсэн амьдралаа буруушааж эхлэсэн хүн л өөрчлөгддөг. Хүн бүр Ллүү шилмэл амьдралын үзэл санааг өөртөө шингээгээгүй цагт ямар ч зөв хууль тогтоолоо гэсэн хүн хувьсаж өөрчлөгдөж чадахгүй бус уу. *Гадна талаас нь биш дотор талаас нь эзэмд* Улс төр гэдэг нь ард түмний үзэл бодол хийгээд үйл хөдөлгөөний тусгалаас өөр юм биш. Ямар ч агуу үзэл санааг гаргаж тавьлаа ч ард түмэн түүнийг нь дагахгүй бол улс төр нь энгийн олон түмний төвшинд хүртэл доош ордог. Нөгөө талаас ард түмэн тэргүүний байвал ямар ч балмад мунхаг улс төрийг өөрийн хэмжээнд хүртэл дээш татаж нийцүүлдэг. Өөрөөр хэлбэл ард түмний бүхий л чанар тэр орны улс төрийн чанарыг тодорхойлдог юм. Энэ нь ус нам дор газар л урсдагтай адилхан мэдээжийн үнэн мөн.

Ард түмэн чадалтай байвал улс төр ч чадалтай болдог, ард түмэн үл мэдэх хийгээд ялзрал доройтлоос сугарч гарч чадахгүй бол авилгач улс төр хүрээгээ тэлдэг. Төр улсын үнэ цэнэ агаад хүчин чадал нь улс орны систем бус ард түмний чанараар хэмжигддэг ажгуу.

Хүн бүр хичээнгүйлэн хөдөлмөрлөж, амьдрах чадавхи, үнэнч шударга сэтгэлийг алдахгүй байхын хэрээр нийгэм урагш хөгжинө.

Харин залхуурах хийгээд амиа бодох муу муухай явдал ард түмний дунд газар авбал нийгэм хагдран унах болно."Иийгмийн муу муухай явдал" хэмээн бидний нэрлээд байгаа тэр зүйлийн томоохон хувь нь угтаа бол бидний доошилж унасан амьдралаас үүсч бий болдог. Тиймээс хуулийн хүчинд дулдуйдаж энэхүү нийгмийн муу муухайг таслан зогсооё хэмээн хичнээн хүчин чармайлт гаргалаа ч уг муу муухай бас дахин зүсээ хувилгаж өөр хэлбэрээр үзэгдэж, газар аван дэлгэрэх нь дамжиггүй юм. Ард түмний, хүн бүрийн аж амьдралын байр байдал хийгээд чанар үндсээрээ өөрчлөгдөж эхэлвэл иймэрхүү нийгмийн муу муухай байдал арилах жамтай.

Нөгөө талаар хуулиа өөрчилж, системээ засан сайжруулснаар агуу их эх оронч сэтгэл, хүнч тусч үзэл санааг тэтгэчихнэ гэж байхгүй. Харин ард түмэн өөрийгөө өөд нь татаж явъя хэмээхийг дэмжиж туслан зоригжуулах нь хавьгүй илүү үр дүнтэй болох юм.

Энэ хүртэл хүн бүр өөрөө өөрийгөө яаж захирах тухайд хөндөж ярилаа. Үүнтэй харьцуулахад уг хүн гадаад талаас яаж эзэмдүүлэх вэ? гэдэг нь тийм их чухал асуудал бус. Жишээлбэл дарангуйлагч этгээдэд захируулсан ард түмэн мэдээж хэрэг хувь тавилангүй. Гэвч өөрийгөө үл мэддэгбөгөөд аминч муухай суртахуунд идэгдсэн хүн л боолд ойрхон. Боолын сэтгэлгээтэй ард түмэн гагц төр улсын удирдагчийг юмуу системийг өөрчилсөн төдийд уг сэтгэлгээнээсээ ангижрахгүй. Улс төрийн хүч төдий зүйлээр ард түмнийг аварна гэдэг угтаа аюултай гэнэн сэтгэлгээ бөгөөд иймэрхүү үзэл аль ч үед газар авахдаа тун амархан байдаг. Асар их төлөөс төлж улс орноо өөрчилье гэж зүтгэвч ард түмний сэтгэл өөрчлөгдөж хувирахгүй л бол хувьсал өөрчлөлт барагтай бол үр дүнгээ өгөхгүй бизээ.

Бүдүүлэг харанхуй, аминч, болхи мууд адал ёсны хүлээснээс хүн тайлагдах эсэх нь гагцхүү уг хүний шинж төрхөөс хамаарна. Тиймээс ард түмний доторхи хүн бүрийн шинжтөрхийн дэвшил л нийгмийн дархлал, улс орны хөгжлийн баталгаа болж байдаг.

Жон Стювард Милл энэ тухай чухалчлан дурьдсан нь бий. Тэрээр бичихдээ "Хүн дарангуйллын дор байлаа ч бодгаль шинжээ хадгалж чадаж байвал асар муу нөхцөл байдалд унахгүй. Харин бодгаль шинжийг нь алдуулах улс төр бол ямар ч нэрээр нэрлэлээ гэсэн угтаа дарангуйллаас өөр юу ч биш" гэжээ.

## **2."Хичээл зүтгэл тасралтгүй үргэлжлэн дамжигддаг"**

Ямар ч улс орон олон үеийн хүмүүсийн сэтгэлгээ, үйл ажиллагааны хуримтлалыг дамжиж байж өнөөгийн дүр төрхөнд хүртэл хөгжиж ирсэн. Нийгмийн давхраа болон амьдралын нөхцөл байдлаасаа үл хамаарч лазагналгүй, олон таван үггүй ажилладаг хүн олон бий. Тариаланч, хайгуулчин, зохион бүтээгч, шинжлэн судлаач, ажилчин, худалдаачин, яруу найрагч, бас улс төрч...

Тэдний хичээл зүтгэлээр агуу их үр дүн бий болж, түүний дээр тэрхүү үр дүн үе дамжигдсанаас хөгжил улам бүр шуудардаг.

Ийнхүү"иргэншлийг бүтээж бий болгодог дархан" гэж нэрлэвэл зохих хүмүүсийн хүчин чармайлт тасралтгүй дамжигдаж байдаг.

Эх захгүй байдалд автсан дэлхий ертөнцөд үүний ачаар дэвшингүй аж үйлдвэр, шинжлэх ухаан болон технологи төрж гарсан юм.

Тэгэхлээр, хүмүүс өвөг дээдсийнхээ технологи, чармайлтаар бий болсон баялаг өв хөрөнгийн залгамжлагч юм. Бид энэхүү өвийг хохироолгүйгээр өөрсдийн хариуцлагаар хамгаалан өсгөж, хойч үеийн хүмүүст гардуулж явах ёстой.

Өөртөө туслахын ухаан нь эрчимтэй ажилладаг хүмүүст үзэгддэг онцлог шинж агаад, тэр шинж бидний англичуудын дэвшилтэт иргэнлэг шинж байсан. Өөртөө туслахын ухаан нь тэр улсын бүх ард нийтийн онцгой шинж болж чадаж байна уу, үгүй юу гэдэг нь нэгэн улсын хүчийг харах хамгийн зөв хэмжүүр болдог.

Мэдээж хэрэг, ямар ч тохиолдолд, бусдаасаа илүү гарсан хүч огшоож, хүмүүсийн өмнө зогсож, бусдын хүндлэлийг нэгэн биедээ хуримтлуулдаг хүн байдаг. Бас түүнчлэн хүчгүй, нэр нь ч

дуурсагдаагүй олон хүн, нийгмийн дэвшилд нэн чухал үүрэг гүйцэтгэж байдаг. Тухайлбал, түүхэнд томоохон дайнд нэрээ үлдээсэн нь зөвхөн жанжид билээ. Гэтэл угтаа бол хязгааргүй олон эгэл цэргийн зоригтой баатарлаг үйлдэлгүйгээр ялан дийлэх учиргүй юм. Хүний амьдрал ч бас тулаанаас өөрцгүй. Тэнд ч нэргүй баатрууд чухамдаа асар их хөдөлмөрлөж ирсэн. Түүхээс мартагдаж одсон олон хүн судар номонд нэрээ үлдээсэн хувь тавилантай агуу хүмүүстэй адилханаар иргэншил хийгээд нийгмийн дэвшилд тун их нөлөөлж байдаг.

Хамгийн чухал нь хичээнгүйлэн хөдөлмөрлөж, шургуу чармайж, амьдралынхаа зорилгыг идэвхтэй мөрдөн хөөцөлдөхөд оршино. Түүнийг хавь орчиндоо өөрийн биеэр илэрхийлж яваа хүн олон. Тэдгээр хүмүүс байр суурь, эрх хүчийг яагаад ч авч чадахгүйгээ мэддэг ч гэсэн орчин үе, цаашлаад ирээдүйн нийгмийн мандал бадралд ихээхэн нэмэр хандив оруулж байдаг. Тэдний амьдрал хийгээд амьдралыг үзэх үзэл ухаамсарлагддаггүй нь хамаагүй, хавь орчныхоо хүмүүсийн амьдралд нэвтэрч, хойч үеийн сонгомол хүний дүр төрх болж тэлж байдаг л гол нь оршдог тул ийн өгүүлж байна.

*Хамгийн дээд "боловсрол" өдөр тутмын амьдрал хийгээд ажил хөдөлмөрийн дотор л байдаг.*

Эрчимтэй үйл ажиллагаа явуулдаг хүн бусдын амьдрал, үйлдэлд хүчтэй нөлөөлж байдаг. Тэнд л хамгийн практикч боловсрол оршдог. Сургууль зэргийг түүнтэй харьцуулахад боловсролын өчүүхэн бага анхны алхмыг зааж өгдгөөс хэтэрдэггүй. Амьдралд түшсэн боловсрол үр өгөөжөөр хавьгүй их байдаг. Айл гэрт, зам дээр, дэлгүүр, үйлдвэр, тариалангийн талбай гээд л хүмүүс цуглардаг л газар бол хаана ч гэсэн өдөр тутмын амьдралын боловсрол туршигдаж байдаг.

Тэр боловсрол нь нийгмийн нэг гишүүн болохын төлөөх сургалт юм. Түүнийг германы жүжгийн зохиолч Шиллер "хүн төрөлхтний боловсрол" гэж нэрлэсэн байдаг.

Бодит ажилд суралцангаа хүмүүнлиг чанараа зүлгэж, өөрийгөө эзэмдэх сэтгэлийг тэтгэж чадвал хүн зөв хэв ёсыг биедээ авч, өөрийн үүрэг хийгээд ажлаа сайн гуйцэлдүүлэх чадвартай болдог. Ийм боловсролыг номын сурах бичгээс сурдаггүй, сургуулийн хялбархан хичээлээс олдоггүй юм.

Бэкон: "Ямар ч шинжлэх ухааны судалгаа нь түүнийг өөрийг нь яаж хэрэглэвэл дээр вэ? гэдэг тухай зааж өгдөггүй. Харин түүний нөгөө тал, бодит амьдралыг сайн шинжвэл шинжлэх ухаан дөхөж очоогүй, шинжлэх ухаанаас хавьгүй илүү мэдлэг ухааныг хүн өөртөө олж авч чаддаг".

Бэконы энэхүү үгэнд бодит амьдралын утга учир зөв илэрхийлэгдсэн байна. Түүгээр ч үл барам оюун ухааныг гэгээрүүлэхэд юу чухал вэ? гэдгийг тодорхой гаргаж иржээ.

Хүн бичиг номоор бус ажил хөдөлмөрөөр өөрийгөө төгсжүүлдэг. Өөрөөр хэлбэл, хүнийг өөд нь татах зүйл бол уран зохиол бус амьдрал, шинжлэх ухаан бус үйлдэл, намтар цадиг бус тэр хүний угийн хүмүүнлиг чанар мөн болой.

Гэхдээ гайхамшигтай хүмүүсийн намтар цадигаас мэдээж суралцах их юм бий, амьдралын гарын авлага болгож, бас сэтгэлээ өөд нь татахын тэжээл болгож ашиглах зүйл ч бий. Гайхамшигтай хүн чанартай хүн бол өөртөө туслахын ухаан хийгээд зорилгодоо хүрэх тэвчээр, зорьсон ажлаа хийж дуусгах зориг хүч, бас амьдралаа дуустал үл хувирах шургуу хичээнгүй чанар сэлтийг тааруулж тохируулж эзэмшсэн байдаг.

Намтар цадиг ховор чухаг хүний нэг насны амьдралыг ойлгомжтой үгээр дамжуулж, бид зорилгоо хэрэгжүүлэхэд юу чухал болохыг тодорхой өгүүлж байдаг. Бас гол баатар таатай бус орчин ахуйгаас биеэ өндийлгөж алдар хүнд, нэр төрийг хэрхэн ялж олсон алхмыг өөдрөг зураглаж, өөрийгөө хүндэтгэх сэтгэл, өөртөө итгэх итгэл чухал болохыг уншиж буй хүнд ухааруулдаг.

Шинжлэх ухааны ч бай, утга зохиол урлагийн ч бай салбарт агуу их хэмээн алдаршсан хүн хаа нэгтээ тогтсон дэй зиндаа хийгээд анги давхаргад харьяалагддаггүй. Их сургууль төгссөн нь ч бий, бага балчраасаа ажил хөдөлмөр хийсэн нь ч бий. Ядуухан бор гэрт өссөн нь байхад баячуудын тансаг өргөөнд төрсөн нь ч буй.

Туйлын ядуу тавилангаас үл шалтгаалж, хамгийн дээд өндөрлөгт гарч чадсан хүний жишээг үзвэл, ямар ч хатуу хэцүү бэрхшээл хүн амжилтанд хүрэхэд гайтай саад болдоггүй гэдгийг харуулдаг. Олонхи тохиолдолд иймэрхүү бэрхшээл цаад талаасаа эргэж хүнийг өөд нь татдаг. Өөрөөр хэлбэл гачигдлыг тэсвэрлэж хөдөлмөрлөө гэх хүслэн бий болгодог бөгөөд бэрхшээлтэй тулгарахгүй бол унтсан чигээрээ хоцрох бололцоотойг ухааруулж өгдөг.

Ийнхүү саад тотгорыг даван туулж ялалтанд хүрсэн хүмүүсийн жишээ олон бий. Түүнийг "зориг байвал мянган хэргийг бүтээнэ" / With will one can do anything/ хэмээсэн зүйр үг энэ замыг гайхалтай илэрхийлсэн байна.

**"Хэрвээ би баян чинээлэг байсан бол өнөөгийн би байхгүй байсан "**

Хэд хэдэн жишээ авч үзье.

Жереми Тэйлор яруу найргийн авъяастай санваартан юм. Ричард Аркрайт утас ээрэгч машин бүтээгч, хөвөнгийн үйлдвэрлэлийн хөгжлийн үндсийг тавьсан хүн юм. Бас Дендатен английн хуулийн хүрээлэнгийн тэргүүн шүүгчийнхээ хувьд алдартай, Жозеф Гарнер байгалийн зургийн мастер юм. Тэд цөм борчуудын гэрээс гарч ийм нэр алдарт хүрсэн билээ.

Шекспер жүжгийн зохиолч болж нэрд гарахаасаа өмнө ямар ажил эрхэлж байсан тухайд тодорхойгүй. Гэвч харц гаралтай нь маргаангүй юм. Эцэг нь мал маллаж, мал нядлагч байсан тул Шекспир ч залуудаа хонины арьс элдэх ажил эрхэлдэг байсан гэлцдэг. Мөн сургуулийн жижүүрээр ажиллаж байсны дараа нэгэн нотариатын нарийн бичгийн дарга хийж байсан гэсэн мэдээ ч бий.

Угтаа бол Шекспир хувь хүний шинж төрх төдий бус улмаар янз бүрийн хүний бичил загварыг өөрийн хүн чанарын дотроо аваачиж тааруулсан мэт санагдана. Зохиол бүтээлд нь гарч буй далайчны, хэллэг маш зөв оновчтой тул усан онгоцны талаар их мэддэг зохиолч, Шекспир далайн аянд дуртай байснаас зайлахгүй хэмээн гэгцгээдэг Үнэн алдартны шашны нэгэн лам Шекспирийн бүтээлийг уншаад тэрээр санваартан байсан хэмээн батлахыг оролдож байлаа. Нөгөө талаар түүнийг морь адгуулж, наймаа хийдэг байсан гэж нотлохыг оролдсон хүн ч бий.

Энэ бүхнээс харахад Шекспер лавтайяа агуу их од бөгөөд түүний амьдрал хүмүүст ихээхэн үүрэг гүйцэтгэсэн гэж хэлж болох юм. Түүний дээр тэрээр өргөн салбараар туршлага хийж ажиглалт хуримтлуулж, түүнээсээ гайхалтай өргөн мэдлэгийг эрж олсон байна. Тэрээр ямар ч ажлыг гүнзгий анхааран судалж, хичээнгүйлж, ажилдаа улайрч байсан нь гарцаагүй. Гиймээс өнөөг хүртэл түүний бүтээл бидний араншин бүрдэж төлөвшихөд гүн гүнзгий нөлөө үзүүлсээр ирсэн билээ.

Одон орны шинжлэх ухаанд ихээхэн зүтгэл гаргасан хүмүүсийн дотор ч үгээгүй ядуучуудаас төрж гарагсад олон бий.

Коперник Польшийн малчны хүү байв. Кепел Германы архины мухлагийн эзний хүү бөгөөд өөрөө архины газрын үйлчлэгч байлаа. Бас Даламбер өвлийн шөнө Парисын сүмийн чулуун шатан дээр орхигдож хаягдсан хүүхэд агаад түүнийг шилчний гэргий хүн болгож өсгөжээ. Ньютон английн Линколн мужийн Грандсама хавийн багахан тариачны хүү юм. Лаплас Сейн мөрний амны нэгэн хотын ойролцоо ядуу тариачны гэрт төржээ.

Тэд цөм бага балчир үеэсээ хар бор орчны дарамтанд уналгүй, төрөлхийн авъяасаа хөгжүүлж бат нот, өнө мөнхийн нэр алдрыг олж авсан. Тэдний нэр алдар дэлхийн баялгийг бүгдийг цуглуулавч үл дарагдах цуутай юм. Эд баялаг бол ядуу буурай байхаас илүүгээр хүний өсөлт хөгжилтөд садаа тотгор болох нь олонтаа.

Лагранжийн эцэг Италийн Торинод түшмэл байв, тэр буруу замаар будаа тээснээс эрх мэдлээ алдаж, гэр орныхон нь ядуу амьдралд унажээ. Хожим өвгөн болсон хойноо Лагранж би алдар нэр олж, аз жаргалд хүрсэн нь энэхүү бэрх хүнд орчин нөхцлийн маань ач тус байсан гэж дурссан байдаг. "Хэрвээ би баян чинээлэг байсансан бол математикч болохгүй нь лавтай билээ" гэжээ.

**3. Хүмүүний мандах буурахыг чадлаа шавхсан хичээл зүтгэл л шийддэг**

Дээр өгүүлсэнчлэн, хүний мандах, буурах нь тэр хүний аль хэр хичээж зүтгэж байгаагаар шийдвэрлэгддэг. Залхуу хүн ямар ч салбарт гайхалтай амжилт бүтээл гаргаж яавч чадахгүй. Чөмгөө дундартал суужсурч хөдөлмөрлөхгүйгээр өөрийгөө цэвэршүүлж, оюун ухаанаа дээшлүүлж, бизнест амжилт олох зам үгүй юм.

Бас хүн эхээс төрөхдөө ямар ч их эд баялаг, өндөр байр суурин дээр уналаа ч алдар нэр олох нь уг хүний залхуугүй хичээл зүтгэлээс л хамаарна. Эд агуурс, газар сэлтийг эх эцгээс өвлөн залгамжилж хүртэж болох боловч мэдлэг хийгээд оюунлиг санааг бусдаас авч чадахгүй. Баян хүн бусдад мөнгө төлөөд өөрийнхөө төлөө ажилуулж чадах боловч, тэднээс хэрсүүжилт хийгээд оюунжилтыг худалдан авах аргагүй юм.

Ямар ч салбарт зорьсондоо хүрэхээр чин сэтгэлээсээ хичээл зүтгэл гаргахгүй бол гайхалтай бүтээмж бий болохгүй. Үүнийг бид ой ухаандаа хатуу тогтоож, зүрх сэтгэлдээ тод сийлж үлдээх ёстой юм.

### ***Зовлон бэрхшээл хүнийг хөл дээр нь босгодог***

Аль ч цаг үед хүний нийгэм ядуу буурай амьдрал дундаас хөл дээрээ боссон хүмүүсээс ихээхэн ач тус хүртэж ирэв. Энэ талаар бодож үзвэл, хүмүүс хамгийн дээд боловсрол олж эзэмшихэд эд баялаг, амар тайван байдал л зайлшгүй хэрэгтэй гэх мэтээр үзэж сэтгэх нь алдаатай болох нь тодорхой. Бие амар, тансаг амьдрал зовлон бэрхшээлийг даван туулах хүчийг өгдөггүй юм.

Хэрвээ, иймэрхүү гөлгөр аж байдалд автвал хүч нь бялхсан, өгөөжтэй, үр жимстэй амьдралыг туулах хүсэлгүй болж зэвэрнэ.

Иймээс ядуу зүдүү байдал бол золгүй байдал, зовлон гуниг гэсэн үг хараахан биш юм. Өөртөө туслах ухаан сайтай байж чадвал ядуу гуцуу байдал хүнд хишиг буян болж хувирна. Зовлон бэрхшээл хүнийг өөд нь босгож, нийгэмтэй тулалдах зориг хүчийг өгдөг. Нийгэмд амарлил олгох гэсний учир өөрийгөө эрхшээлд нь унагах хүн ч байдаг. Гэхдээ тэр хүн хичээнгүй чармайх сэтгэлээ алдалгүй зоригжиж, өөртөө итгэх итгэлээ олбол их ялалтад хүрэх нь дамжиггүй.

Бэкон: "Хүн өөрийнхөө эд баялгийг ч, чадал авъяасыг ч зөв ухаардаггүй. Эд баялгийн тухайд бол юмс хэрэгцээнээс илүү л байж байвал гайхалтай сайхан хэрэг хэмээн итгэдэг атлаа хүний авъяас чадал түүнээс илүү агуу их зүйл юм гэдгийг анзаардаггүй. Өөрийн эд баялгаа үгүйсгэж, гагцхүү хүч чадалдаа итгэж чадах хүн л өөрийнхөө аяганаас ус уух, талхаа идэх аргад сурдаг. Өөрөөр хэлбэл, амьдралынхаа чигийг тогтоох замд суралцаж, хүн өөрөө өөрийгөө сайн сайхан гэж бодохыг бусдад ч ойлгуулахаар болдог" гэжээ.

Эд баялаг хүнийг зугаа цэнгэл, дур зоргоор аашлах амьдрал руу хүчтэй хөтөлдөг. Уг нь хүмүүн бид эхийн хэвлийгээс төрөхдөө төрөлхийн иймэрхүү татаасанд чангаагдаагүй байдаг. Ийм учраас эд баялганд умбасан гэр бүлд хүмүүжсэн атлаа тэр цаг үедээ чухал үүрэг гүйцэтгэж чадсан хүн, өөрөөр хэлбэл чинээлэг хангалуун амьдралаа дор үзэж, өдөр бүр хичээнгүй амьдарч өндөр хүндлэлд хүрсэн хүн цөөнгүй. Хойгийндайн (1808-1813 онд болсон Наполеоны дайралтыг эсэргүүцсэн Испаничуудын тулалдаан. (Энэ дайнд англичууд испанид туслаж байв)-д чамгуй их орлоготой англи бага дарга салаатайгаа хамт бүслэлтийг сэтлэн давшиж байсан хэмээх яриа өнөөг хүртэл сэтгэл татам яригсдаар байдаг билээ. Ийнхүү өндөр язгуур, өв хөрөнгөтэй хүмүүс ч гэсэн төр улсынхаа тусын тулд янз бүрийн салбарт ихэнх нь өөрсдийн амь насаар дэнчин тавьж баатарлагаар тулалдан, үүргээ гайхамшигтай биелүүлж ирсэн байдаг. Гүн ухаан, шинжлэх ухааны тухайд ч дээрх Бэконтой нэгэн адил язгууртны хүрээлэлд төрсөн авч өндөр дээд алдар нэр олсон хүмүүс олон бий.

#### **4. Хүний амьдралд завтай цаг гэж байдаггүй**

Хүмүүний амжилт бүтээл хийгээд алдар нэр тэр хүний өөрийнх нь ажиллах хүч чадал, идэвх чармайлтаас шалтгаалах нь их юм. Гэхдээ түүний сацуу амьдрах хэмээх аяны зам зуурт бусдын үзүүлсэн тусламж дэмжлэг хэмжээлшгүй их утга чанартай байдаг.

Английн нэгэн найрагч энэ тухайд гайхалтай онож хэлжээ.

Тэрээр "Хүнээр мэдүүлэх сэтгэл хийгээд биеэ мэдэх сэтгэл, өөрөөр хэлбэл бусдад шүтэж амьдрах болон өөртөө найдах явдал, энэ хоёр өнгөц харвал зөрчилдсөн зүйл мэт бодогдоно. Гэвч энэ хоёр хоёулаа гар гараасаа барилцан урагшлахаас өөр аргагүй юм" гэжээ.

Бид цөм бага балчир үеэсээ өтөлж хөгширтлөө ямар нэгэн хэлбэрээр бусдаар өсгүүлж, үг сургаалыг нь хүлээж байдаг. Тиймээс арван хуруу тэгш болон чадалтай хүн л өөрөө бусдын дэм авснаа хүлээн зөвшөөрөхөөсөө ичдэггүй юм.

Нэгэн жишээ авч үзье.

Францын улс төрч Алекс де Токвилли баян чинээлэг айлын гэр төрсөн юм. Эцэг нь үе дамжсан язгууртан, эх нь нэртэй улс төрчийн ач охин байлаа. Иймэрхүү гэрийнхнийхээ нөлөөгөөр дөнгөж 21 -хэн настайдаа тэрээр Версалийн дээд зиндааны шуугч болов.

Гэвч тэрээр энэхүү албан тушаал нь өөрийн амжилт чадлаар үнэн зөвөөр олгогдсон зүйл биш хэмээн бодсон болов уу, удалгүй хэргэм зэргээ орхиж, өөрийнхөө хүчээр өөрийн ирээдүйн замаа нээхээр шийдсэн билээ. "Балай тэнэг амьтан" гэж шүүмжлэх хүн ч байв. Тэрээр бууж өгсөнгүй.

Ажил албаа орхисныхоо дараа тэрээр Францыг орхиж АНУ-д хэдэнтээ жуулчилсан юм. Тэр үедээ үзсэн, дуулснаа шинжилж "Америкийн ардчилал" хэмээх ном бичсэн нь түүнийг алдаршуулсан билээ.

Түүний анд нөхөр агаад Америкт хамт аялж байсан Гюстав Де Бормон найз нөхөр нь аялалд явж байх үедээ аяншиж ядрахаа үл мэдэн суралцаж байсан тухайд өгүүлсэн нь:

"Тэрээр бараг л залхуурч назгайрах гэдгийн эсрэг чанарыг эзэмшигч байв. Аялаж явах замдаа ч, түр амсхийх үедээ ч сэтгэл зүрх нь ямагт судалгааны ажилдаа чиглэгдэж байлаа...

Түүний хувьд хамгийн хөгжилтэй яриа гэдэг нь хамгийн тустай яриаг хэлдэг байв.

Дэмий өнгөрөөсөн нэг өдөр хамгийн муу өдөр байх бөгөөд цөөхөн цагийг дэмий сул өнгөрүүлэх явдал түүнийг бүр багтрааж орхидог байсан" гэжээ.

Токвилли ч найздаа бичсэн захиандаа:

"Хүний амьдралд борив бохисхийн амарч суух цаг зав байдаггүй юм. Бусдын тусламж, өөрийн бүхий л чадлаар сэтгэл шуудрах хоёрын аль алийг нь дутааж болохгүй. Тэр нь залхуу байхад ч, хэмжээлшгүй өсч хөгжсөн үед ч нэгэн адил хамаатай. Хүн гэдэг хойт туйлын хүйтэн газрыг чиглээд амралтгүй алхах аянчинтай адилхан юм. Зорьсон газартаа ойртохын хэрээр аянчин хүн алхаагаа хурдасгахгүй бол болдоггүй. Тэнд тахир хүйтэн гэгч аянчин хүний санаа сэтгэлийн хувьд аймшигтай дайснаас биеэ хамгаалахад оюун санаагаа шавхуурдаж хөдөлгөхийн хамт, ямагт анд нөхөртэйгээ харьцаа холбоогоо хадгалах явдал хамгийн чухал байдаг" гэжээ.

### ***Өөрөө өөртөө "хамгийн сайн туслагч" болох нь чухал***

Токвилли "өөрийн хүч чадалдаа итгэж, эрчимтэй хөдөлмөрлөх нь хүний хувьд маш чухал" гэдэг ойлголтыг хатуу баримталдаг байв. Бас нөгөө талаар бусдын тусламж дэмжлэг ямар их чухал болохыг ч хэнээс ч илүү гүнзгий ухамсарласан байлаа. Хүмүүс олон ч бай, цөөн ч бай бусдын тус дэмгүйгээр амьдарч чадахгүй юм.

Тиймээс тэрээр анд найз Григорий болон Стофьер нарынхаа тусад гүн талархаж байдгаа илэрхийлсэн байдаг. Григорий нь түүнд мэдлэгийн тал дээр тус дэм өгч, Стофьер санаа сэтгэлийн дэм хийгээд андын сэтгэлээ өргөсөн юм. Тэрээр Григорийд бичсэн захидалдаа:

"Миний итгэдэг хүн чамаас өөр байхгүй. Чи миний сэтгэл санаанд үнэхээр нөлөөлж байдаг.

Мэдээж хэрэг өдөр тутмын аар саархан асуудалд олон хүнээс тус дэм авч байгаа ч миний бодол санааны уг үндэс хийгээд үйлдэл бүрийн маань чиг шугамын тухайд чам шиг их нөлөөлж байдаг нь үгүй билээ" гэжээ.

Бас тэрээр эхнэр Марийдаа ч талархсан сэтгэлээ илэрхийлэхээ мартаагүй юм. Тэр бүсгүйн тэсвэр тэвчээр хийгээд халамж анхаарал байснаас л тэрээр өөрийн судалгаагаа эцэст нь хүртэл үргэлжлүүлсэн. Өндөр дээд, хиргүй цэвэр зан араншинтай эхнэр хүн үл анзаарахын хооронд эр

нөхрийнхөө хүн чанарыг өөд нь татсан байдаг бол охор сэтгэлт эхнэр хүн эр нөхрөө заавал уруудуулж унагаадаг гэж тэр итгэдэг байв.

Дүгнэж хэлэхэд, хүний мөс чанар нүдэнд үл харагдах тоо томшгүй зүйлсийн хэлхээсээс хэлбэршиж бүтдэг. Ухаант мэргэд хийгээд эрт эдүгээгийн цэцэн үгс, амьдралд тулгарах туршилт, судар ном, найз нөхөд, хөрш, орчин цагийн нийгэм, эцэг өвгөдийн сургааль энэ бүхнийг бид өвлөн үргэлжлүүлж, ухамсартай, ухамсаргүйгээр тэдгээрийн их нөлөөлөлд орж байдаг билээ.

Харин мэдээжийн зүйл нэг байна. Юу гэвэл хүн өөрийнхөө аз жаргал, амжилт бүтээлийн тухайд хэзээ ямагт өөрөө хариуцлага хүлээх ёстой бөлгөө.

Ямар ч гайхамшигтай, ухаантай хүн бусад хүмүүсээс том хишиг тус хүртэж байдаг нь мэдээж. Гэхдээ эртнээс наашхийг эргэцүүлж хэлбэл, бид өөрсдөө: өөртөө хандсан хамгийн сайн туслан дэмжигч байхгүй бол болохгүй билээ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Тэвчээр

*Бороо хяруунд цохиулах тусам нялх ногооны ургац сөөм сөөмөөр ахидаг*

1.Зөв ухаанд өөдрөг, хатуу чанга тэвчээртэй байх.

Аз жаргалын охин тэнгэрт хүнийг ялгаварлах чадал байдаггүй гэсэн эсэргүүцлийн маягийн үг чих дэлсдэг. Уг нь бол аз жаргалын охин тэнгэр бид мэтийн хүмүүс шиг харалган биш юм. Өнөө цагийн хүмүүсийг харвал ойлгох бизээ. Хашир далайчинд цаг ямагт салхи, давалгаа хоёр талтай байдаг шиг, аз жаргал ч ажилсаг хичээнгүй хүнийг л дагалдаж байдаг.

Ямар ч хүнд хэцүү салбарт эрдмийн ажлаар хөөцөлдөхөд зөв сэтгэлгээ, төвлөрүүлж харах чадвар, идэвх чармайлт, тэсвэр тэвчээр зэрэг чанар хамгийн их үүрэг гүйцэтгэдэг.

Энд төрөлхийн авьяас зэрэг нь хэрэгцээтэй биш ч байж магадгүй юм. Тухайлбал, гоц авьяастай гээд иймэрхүү мэдээж чанарыг хөнгөнцөр үзвэл үр дүн бага гарах билээ.

Дэлхийд цуутай хүмүүс төрөлхийн авьяас сэлтэд тэр бүр үнэмшдэггүй. Харин тэд авьяас чадвараасаа хамааралгүй амжилт олсон эгэл жирийн хүмүүстэй адилхан л ертөнцийн зөв ухаанд өөдрөг байхыг хатуу чанга тэвчээртэй эвцэлдүүлж иржээ.

Нэгэн судлаач "гоц авьяас гэдэг зөв ухааны хувилгаан дүр" гэж тодорхойлсон байна. Бас нэгэн цуутай профессор сэтгэл зүрхнээсээ хичээж чармайхын чин хүслэнг гоц авьяас гэж нэрлэж байна. Нийтлэлч Жон Фостер "гоц авьяас гэдэг хүний дотоодод буй онгодын галыг асааж дүрэлзүүлэх хүчийг хэлнэ" гэжээ. Францын нэгэн байгалийн шинжээч: "гоц авьяас нь тэсвэр тэвчээрээс өөр юу ч биш" гэсэн байна.

Ньютон эргэлзэх юмгүй өндөр дээд оюун ухаан цогцлоосон хүн байв. Тэрээр олон гялалзсан нээлт хийж ирсэн агаад түүний нууцыг асуухад "... дандаа л тэр асуудлаа тунгаан бодсоор ирсэн учраас л ..." гэж түгдрэлгүй хариулсан гэдэг. Ньютон нэгэн удаа өөрийнхөө судалгааны аргын тухайд ярихдаа: "Би судлаж байгаа сэдвээ ямагт Урдаа дэлгээд удаан гэгч ажиглаж суудаг. Ингэхэд балар харанхуйд гэгээ түгэж, үүр цайхын адилаар асуудлын мөн чанар аяндаа тодроод ирдэг юм даа" гэжээ.

Ийнхүү судалгааны ажилдаа өөрөө шингэж, бас гүн тэвчээрийнхээ ачаар И.Ньютон их эрдэмтний алдрыг хүртсэн билээ. Тэрээр Английн эрдэмтэн судлаач Ричард Вентлей-д ийн ярьсан байна: "Би энэ нийгмийнхээ төлөө ямар нэгэн тахил өргөж чадсан гэвэл, тэр нь бүхий л судалгаандаа чармайж тэсвэр тэвчээртэйгээр бодож сэтгэсээр ирсний л ач гавьяа гэж бодож байна" гэжээ.

Ньютонтой эн зэрэгцэх астрономич Кепул ч судалгааны ажлынхаа амжилтын тухайд Ньютонтой адил өгүүлсэн байдаг. "Ямар нэг ганц зүйлийг ч ухаан санаагаа төвлөрүүлээд бодож үзвэл тэр нь шалтгаан болон дэлгэрч цаашаа улам гүнзгийрээд бодол болон хөвөрдөг. Эцэст нь зангилагдаагүй асуудалд бүхий л оюун санаагаа чиглүүлээд гартаа оруулж авдаг" гэжээ.

*"Миний оюун ухаан зөгийн үүртэй адилхан"*

Гуйвалтгүй сэтгэлээр эрдэм судлалд хандаж, шавхагдашгүй зүтгэлтэй байвал гайхалтай үр дүнг бий болгож чадна. Энэ ертөнцөд цуутай хүмүүсийн олонхи нь төрөлхийн авъяасыг нийтийн бодож буй шигээр тусгай шинж чанар гэж үзэж байгаагүй учраас тэр ажээ. Жишээ нь Францын сэтгэгч Вольтер "Гоц авъяастан хийгээд жирийн хүмүүний ялгаа нь ширхэг цаасны жин лугаа адил" гэжээ. Италийн нэгэн хуульч "хэн ч гэсэн шүлэг бичиж, уран илтгэхийн авъяасыг агуулж байдаг" гэсэн байдаг. Зураач Леонард "ямар ч хүн зураач, сийлбэрчин болж чадах ёстой" гэж бичсэн нь үүнтэй адил бөлгөө.

Үүнээс гадна нэр алдартай гүн ухаантнууддухайлбал Локк, Дидро нарын тайлбарласнаас үзвэл "бүх хүмүүс авъяасын тухайд эрх тэгш юм. Тиймээс аль нэг хүний хийж чадах зүйлийг адилхан орчинд байж, адилхан зорилго мөрдлөө гэж үзвэл бусад хүн ч хийж чадна" гэнэ.

Мэдээж, төрөлхийн түгээмэл бус авъяас чадвар байхгүй бол хэчнээн хичээж чармайлаа ч хоёрдугаар Шекспир, Ньютон, Бетховен, Микеланжело төрж гарахгүй нь ойлгомжтой. Гэлээ гэхдээ хичээнгүй хүч чармайлт гайхалтай үр дүнд хүргэдэгт эргэлзээ байхгүй. Түүгээр үл барам гоц ухаантан хэмээн цууд гарсан бүх хүмүүс бараг заавал гайхалтай чармайлт гаргагчид байдаг.

Биологич Жон Далток хүмүүс өөрийг нь гоц авъяастан хэмээн нэрлэхийг үл зөвшөөрөн өөрийн бүтээлээ бүхэлдээ идэвх чармайлтыг хураан цуглаасны үр дүн гэж үзэж байжээ.

Анатомич Жон Хейнд өөрийнхөө тухай өгүүлэхдээ:

"Миний оюун ухаан зөгийний үүртэй адилхан. Үймээн шуугиан, эмх замбараагүй мэт харагдавч, угтаа бол ёс жаяг, дэг журмаар нэгд нэгэнгүй хүлэгдсэн байдаг. Тэгээд тасралтгүй хүчин чармайлт гаргасны дүнд байгалийн эрдэнэсийн агуулахаас мэдлэг хэмээх хүнс цуглуулагдан ирдэг билээ" гэжээ.

Ийнхүү агуу хүмүүсийн намтар цадигаас өчүүхэн төдий нээхэд л бид гэм алдасаа хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

Зохион бүтээгч, технологич, сэтгэгч болон бусад олон салбарт нэрээ дуурсгасан хүн залхахыг мэдэхгүй идэвх чармайлт гаргасны үр дүнд амжилт олжээ. Тэгээд тэд ертөнцийн байдал хийгээд бүхий л зүйл, тухайлбал цаг хугацааг хүртэл шижир алт болгон хувиргаж чаддаг юм.

Дейзлер "амжилтын нууц нь өөртөө тулгарсан асуудалд эзэн болоход оршдог. Үүний тулд эрдэм судлалд бүхнээ зориулах учиртай" гэж бичжээ.

Үнэн хэрэг дээрээ, ертөнцөд агуу их нөлөөлсөн хүмүүсийг судлаад үзэхэд тээднний дотор нэн тодорхой утгаар, гоц авъяас, өөрөөр хэлбэл төрөлхийн гойд гоц ухаан, гялалзсан зан төрх цогцолсон хүмүүс нь цөөхөн, харин авъяас чадвараас үл хамаарч, байнгын их идэвх чармайлт гарган эрдэм, судалгаа хуримтлуулж байж алдар хүндэд хүрсэн нь олон байдаг.

Хичнээн авъяаслаг хүн байлаа ч тогтворгүй, тэвчих хүч дутагдах аваас, авъяас чадваргүй ч байнга чармайдаг хичээнгүй хүнд ялагддаг. "Аажуу удаан алхдаг нь алс хол газар хүртэл очиж чаддаг" гэсэн Италийн цэцэн үг бий (Who goes slowly goes long and goes far).

## **2. Амьдралын мөн чанарын аравны есөн хувь нь өөдрөг сэтгэл болон идэвх чармайлтад байдаг.**

Хязгааргүй хүчин чармайлт гаргалаа ч хичээл оролдлогын зуршлыг биедээ наахгүй бол амжилт гаргахгүй. Тэгэж чадвал ямар ч зүйлд ахиц хөгжил нүдэнд дөхөөд ирэх буюу. Бас "сурахаасаа хэвших нь чухал" гэдэг үг байдагчлан ижил зүйлийг хэдэн удаа ч давтан хийх хэрэгцээ байдаг. Түүнгүйгээр, тухайлбал, хичнээн хялбар технологи байлаа ч эд зүйл болж чадахгүй. Хэдэнтээ дасгал сургууль хийвэл ямар ч хүнд бэрх зорилт байсан заавал биелэх болно.

Нэртэй улс төрч Роберт Пеел гоц содон авъяастай байгаагүй ч бага насныхаа хэвшил болон дасгал сургуулийн хүчинд өндөр нэр алдарт хүрчээ.

Бага байхад нь эцэг нь түүнийг дандаа ширээний өмнө зогсоож цээжээр яриулдаг байжээ. Пеел ч өөрөө "шашны номлол"-ыг дахин давтан уншиж цээжлэхийг зорилго болгож байв. Эхлээд тийм ч ахицтай байгаагүй ч, бага багаар дасгал сургуулиа үргэлжлүүлж байх хооронд анхаарал төвлөрүүлэх чадвар нь нэмэгдсээр нэг мэдэхэд номлолыг үг үсэг гээхгүй уншиж чаддаг болтлоо сайжирчээ. Дараа нь тэрээр зүйрлэшгүй илтгэх чадвараараа улс төрийн өрсөлдөгчдөө унагааж

ирсэн бөгөөд бусдаас гоц зөв цээжлэх чадвар нь багадаа эцгээсээ сурсан дасгал сургуулийн үр дүн байсантай маргах аргагүй билээ.

### **"Хичээл зүтгэлээр баавгай ч бүжиглэж сурна "**

Урлагийн салбарт ч адилхан гэлцдэг. Жишээлбэл, хийл хөгжмөөр тоглож сурахад урт удаан хугацааны хөлс дуслуулсан дасгал сургууль хэрэгтэй. Нэрт хийлч Жордан гайхалтай энэ зэмсгийг эзэмшлээ хорин жил өдөрт арван хоёр цагийн дасгал сургууль хийж байсан гэдэг.

"Хичээл зүтгэлээр баавгай ч бүжиглэж чадна" гэдэг зүйр үгийг францууд ярьдаг ба үүнтэй адил, туслах дүрийн балетчин биеийн хөдөлгөөний тансаг эвсэлтэй байж хөлөө олтлоо бараг хүлцэнгүйгээр хатуу бэрх тэвчээртэйгээр хэдэн жил хичээллэх ёстой ажээ.

Нэгэн нэрт балетчин тайзанд гарах өдрөө хүртэл эцэгтэйгээ хатуу чанд хичээллэсээр байжээ. Ядаргаа болж ухаан алдан унаж, түргэн тусламж дуудаж байсан удаа цөөнгүй байв. Үзэгчдийг өөртөө татах тэр бүсгүйн тансаг бүжиг ийнхүү их хөдөлмөр дээр цэцэглэсэн байна.

Хүний хөгжил дэвшлийн хурд угтаа бол аажуусаж байна. Агуу их бүтээл ганц хормын хооронд ирдэггүй. Тиймээс алхам алхмаар ч болов итгэлтэйгээр биеэ дайчилж чадвал түүнийг зорьсондоо хүрлээ л гэж бодох хэрэгтэй. "Зорьсноо яаж ийгээд гартаа оруулахаа мэдэх хэрэгтэй. Тэр л амжилтын хамгийн том цөм хэсэг юм" гэж Францын гүн ухаантан Местолл хэлжээ.

Бүтээлийн ургац хураахад эхлээд үрээ тарих хэрэгтэй. Түүний дараа ургац авах цагаа тэвчээртэйгээр хүлээж суух хэрэгтэй болно. Тэгээд ихэнх тохиолдолд хамгийн их хүсч хүлээдэг тэрхүү үр жимс боловсрох нь удаан байдаг. Тиймээс юу юугүй үр дүнгээ хурдан үзэхээр яарах нь дэмий хэрэг. Дорно дахины зүйр үгэнд "цаг хугацаа, тэвчээр хоёр ялам модны навчийг сатин болгож хувиргадаг" гэдэг дээ. (Time and patience change the mulberry leaf to satin)

Тэвчээртэй хүлээх хооронд санаагаар унаж болохгүй. Өөдрөг сэтгэл бол гайхалтай чанар бөгөөд, ямар ч зовлон, горьдлого тасрахад бөхийхгүй хүчийг хүнд өгч байдаг. Нэгэн санваартан "христосын шашны дотоод үнэний аравны есөн хувь нь төвийг сахихад байдаг" гэж өгүүлсэн байдаг, энэхүү үгнээс "хүний амьдралын мөн чанарын аравны есөн хувь нь өөдрөг сэтгэл, хичээл зүтгэлд байдаг" гэж хэлж болох бизээ. Өөдрөг сэтгэлээ алдалгүй хичээж чармайж явах нь амжилт, аз жаргалд хүрэхийн гишгүүр болж өгнө. Өөдрөг цайлган сэтгэлээр үнэнч шударга ажиллах нь хүний амьдралын хамгийн гол баяр баясгалан мөн. Өөртөө итгэх итгэл, эрчим чадал эндээс л төрж гардаг. Христосын санваартан Смитт Английн хөдөө тосгоны сүм рүү илгээгджээ. Тэрээр ийнхүү тушаал буурч нутаг заагдахдаа ч санаагаар уналгүй, харин бүр урагшилж тэндээ бүхий л хүчээ гаргахаар шийдсэн гэдэг. Тэрээр "Ямар ч ажил байсан, түүндээ дур сэтгэлээ өгч улмаар өөрөө өөрийгөө дасгах хэрэгтэй юм. Тэр нь одоогийн орчин нөхцөлдөө сэтгэл дундуур байгаадаа автагддаг, надад бүр өөр ч чадал хүч байна гэх мэтээр омгойтон шазруун юм бодсоноос хавьгүй илүү хүн ёсных биз дээ?" гэж өгүүлсэн байдаг.

### **3. Тааламж муутай орчинд ч өвс ногоо сөөм сөөмөөр ургадаг**

Нийгэмд агуу их бүтээл туурвин үлдээсэн хүний урт удаан хугацааны хүнд бэрх хөдөлмөрийг нь барагтай бол нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөхгүй байх тохиолдол олонтоо байдаг. Тэдний тарьсан ур заримдаа өвлийн хөр цасан дор булагдан орхигддог, бас хаврын сайхан цаг ирэхийг үзэж чадалгүй амь тавьдаг ч удаатай.

Эдийн засагч Адам Смитт ядуухан байж, Глазго-ийн их сургуульд судалгааны ажилдаа шимтэж байх зууртаа "Улс орон баяжихын онол"-оо бичиж нийгэм өөрчлөгдөхийн үрийг тарьсан билээ. Гэвч түүний судалгаа өнөөгийн нийгэмд биеллээ олтол түүнээс хойш 70 жил өнгөрсөн билээ. Тэгээд өнөө хүртэл түүний эрдмийн үр өгөөжийг бүгдийг хурааж авсан гэж хэлэхгүй бизээ. Харин ямарч тааламжгүй нөхцөлд хүсэл мөрөөдлөө гэж болохгүй. Гээж л орхивол түүнийгээ өөрт байгаа ямар ч зүйлээр сольж авч чадахгүй. Түүгээр зогсохгүй хүсэл мөрөөдлөө орхисон хүний хүн чанар нь хүртэл доошилж орхидог. Хүсэл мөрөөдлөө аддалгүй байж, ямар ч доор уналаа гэсэн

тэндээсээ хөл дээрээ босч, алдаагаа залруулан гайхамшигтай бүтээл үлдээсэн хүмүүсийн жишээг одоо өгүүлье.

### *Ажилдаа татагдахын хүч*

Америкийн шувуу судлаач Аудебен нэгэн туршилт хийхийн тулд судалгааны ажилдаа цөхөртлөө чармайж байжээ. Тэрээр ийн өгүүлсэн байдаг: "Тэр үед зүрх сэтгэл маань бэрх хэцүүтэй навсайтлаа тулалдаж байсан ба түүнийг давж чадсан нь би өөрийнхөө судалгааны ажилд "бурхны авралаар онгод"-той байснаас тэр гэж боддог. Тэр цагийн миний тэвчээртэй байсныг "бурхны аврал" гэдэг үгнээс өөрөөр илэрхийлэх аргагүй.

Гай түйтгэр гэж ийм л юм байдаг, юу гэвэл тэр үед би Гентакки мужийн Хендерсон гэдэг тосгонд амьдарч байсан бөгөөд өөр газар ажил гараад хэсэг хугацаанд гэрээ эзгүй орхих болсон юм. Тэгэхэд би янз бүрийн шувууны дүрсийн эскиз хийж байсан бөгөөд тэр зураг оараг 1100-д дөхөж очсон байв. Ингээд явахынхаа өмнөхөн тэр зургуудаа бүгдийг нь нямбай гэгч нь хайрцганд савлаж, хамаатны <sup>х</sup>Үндээ хадгалуулав. Мэдээж хэрэг, ховорхон судалгааны материал учраас өчүүхэн ч сэв суулгалгүй хадгалж өгөхийг хүсээд орхисон юм.

Миний ажил хэдэн сарын дараа бүтэж би удалгүй тосгондоо буцаж ирээд хоёр гурав хоног амарсны дараа нөгөөх хайрцгаа авахаар очлоо. Үнэт эрдэнэс шиг нандигнадаг өөрийн зургуудынхаа барааг дахин харна гэдэг надад үнэхээрийн жаргалтай байв. Хайрцгаа гаргаж ирээд, тагийг нь нээтэл... юу болсон гэж санана! Хайрцаг дотор хоёр хулгана жинхэнэ эзэн этгээд шиг царайтай орогнон сууж, бүр байтлаа гөлчгий хүртэл төрүүлчихээд байж байдаг байгаа. Миний зурагнууд бүгд хигдэс болон идэгдээд гөлчгийн ор болсон байлаа. Яг энэ агшинд толгойд цус харваж, учир начраа мэдэхгүй болов. Хүнд цочролд орлоо. Тэр газраа ухаан алдаад хоёр гурван өдөр би орон дээрээ тэр чигээрээ хэвтсэн юм. Тэр хооронд үнэхээр юугаа ч мэдэхгүй байсан бололтой.

Гэлээ ч тэгсгээд би өөрийнхөө бие болоод сэтгэлээ амьтны зөн билэг гэж хэлж болохоор хүчээр дүүрэхийг мэдэрсэн юм. Тэр хүч намайг ажилд дахин оруулж, босгосон билээ. Удалгүй буу, эскизийн ном, бийрээ бариад ой руу гарсан юм. Нөгөөх гай түйтгэр огт болоогүй юм шиг чөлөөтэй, урамтай байв.

Ингээд би дахин гайхалтай эрч хүчээр эскизээ хийж эхлэв. Зураг маань өмнөхөөс улам илүү чадварлаг болж байна гэж бодогдож байлаа. 3 жил ч хүрэхгүй хугацаанд алдсан зургуудаа нөхөөд зогсоогүй илүү гарахаар олон эскиз бүтээж чадсан билээ" гэжээ.

### *Унах бүрдээ улам чадалтай босож ирдэг*

И.Ньютоны тэжээсэн нохой Даймонд нь ширээн дээрх лааг яагаад ч юм унагааж, чухал материалыг нь нэг агшинд үнс болгож орхижээ гэдэг яриа байдаг. Урт удаан жилийн судалгааныхаа үр дүнг үнс болгож алдсандаа цохилт авч, Ньютон түүний дараа багагүй хугацаанд эрүүл мэндээр хохирч сэтгэн бодох хүч нь нэлээд буурсан гэдэг.

Түүхч Томос Карлил -д ч бас адилхан явдал тохиолдсон байна.

Тэрээр өөрийн бичсэн "Францын хувьсгал" номынхоо I ботийн гар эхийг нэгэн найддаа өгчээ. Гэтэл тэрхүү найз нь уул гар эхийг коридорынхоо довжоон дээр тавиад мартжээ. Хэдэн долоо хоног өнгөрсөн хойно хэвлэлээс гар эхийг нэхсэн тул Карлил авчруулахаар зарцаа явуулав. Харин нөгөө найзынх нь зарц бүсгүй уг гар эхийг хуучин бичиг цаас гэж бодоод шатаачихсан байжээ.

Энэ явдлыг сонссон Карлилын сэтгэлийг төсөөлөхөд бэрх юм.

Түүнд дахин ширээндээ сууж үзгээ барихаас өөр зам байгаагүй бололтой. Ой тойныхоо утсыг хөөж, аль эрт мартагнасан агуулга хийгээд хэллэгээ сэргээж бодонгоо, тэрээр бүр эхнээс нь дахин бичиж эхэлжээ. Хамгийн анх бичиж байсан үе бийр янтайнх нь баяр баясгалан байсан бол адилхан зүйлийг дахин эхнээс нь хийж дуусгана гэдэг шаналгаан болоод бухимдлаас өөр юу ч биш байсан. Гэвч Карлил тэр бэрхийг тэвчиж, эцсийг нь хүртэл хийж давсан билээ. Түүний энэхүү туршлага хатуу шийдвэр л байвал ихэнхдээ зорилтоо гүйцэлдүүлж болохыг бидэнд сургаж байна.

#### **4. Ялах ялагдахын түлхүүр болох "тогтвортой үргэлжлүүлэх хүч"**

Аливаа юмны эцэст нь хүртэл бат зүтгэх ухаан бол юугаар ч содыж боломгүй ховорхон чанар билээ. Нэртз охион бүтээгчдийн амьдралд энэхүү ухаан ямагт хадгалагдаж байжээ.

Жорж Стифсон залуучуудад хандаж "Би үнэхээр хар хүчээрээ чармайж зүтгэж ирлээ. Та нар ч мөн адил чармайж зүтгэ" хэмээн ховорхон зөвлөгөө өгсөн байдаг.

Тэрээр угтаа уурын хөдөлгүүрт машин бүтээгчдийн дотор нэгдүгээр хүн болтлоо өсөхдөө арван таван жил гаруй хугацаа зарцуулжээ. Мөн уурын хөдөлгүүрийг сайжруулсан зохион бүтээгч Жеймс Хотт судалгаагаа бүрмөсөн дуусгах ын тулд гуч гаруй жилийн хичээл зүтгэл гаргасан гэдэг.

Шинжлэх ухааны салбарт ч бай, технологийн салбарт ч бай ийнхүү урт удаан жил тасралтгүй хүчин чармайлт гаргах нь тун чухал гэдгийг үгээр хэлэхэд багадаа юм. Шинжлэх ухаан болон утга зохиолын салбарт агуу их бүтээл үлдээсэн хоёр хүний тухай авч үзье. Тэдний амьдралын замнал эцэст нь хүргэх тэвчээрийн ухаан ямар их чухал болохыг тодорхой зааж өгнө буй за.

##### ***Тэнгэрлэг авъяасыг тэжээж тэтгэх "өглөө эртний хоёр цаг"***

"Тэнгэрлэг авъяас гэдэг тэвчээрийн нэр" хэмээн өгүүлсэн Францын байгалийн шинжээч Вюхон байгалийн шинжлэх ухааны салбарт агуу их бүтээл хийсэн боловч залуу цагтаа бусдаас илүү гарах юмгүй жирийн л хүний нэгэнд тооцогдож явжээ. Үнэн хэрэг дээр тэрээр юмыг эргэцүүлэн ойлгож, нэгэнтээ олж авсан эрдэм мэдлэгээ сэргээн санахад нэлээд цаг зарцуулах болсон юм. Түүгээр барахгүй энэрэн нигүүлсэх сэтгэлгүй хатуу зантай нэгэн байв. Баян чинээлэг айлд төрсний учир тэр чигээрээ тансаг танхил амьдралд хөлбөрөх замд орчихсон юм биш биз ч гэж бодогдохоор болчихоод байжээ. Гэвч Вюхон жаргалд ташуурахаас биеэ суга татан авахаар эрслэн шийдэж эрдэм судлал хөөж, өөрийгөө боловсруулахаар чармайсан билээ.

Вюхон цаг гэдэг юмыг хязгаартай, олдшгүй ховор өв хөрөнгө хэмээн бодож ирсэн боловч эрт босч чаддаггүй, чухал цагаа дэмий өнгөрөөж байжээ. Тэрээр их унтдаг муу зуршлаа таягдан хаяхаар хатуу шийдэж, эртлэн босож туршиж үзэхээр санаа шулуудсан боловч цагтаа барагтай л бол хүссэн цагтаа босож чаддаггүй байжээ.

Ингээд зарц Жозефээс туслахыг хүсч, хэрэв өглөө бүр зургаан цагаас өмнө сэрээж өгвөл тэр бүрд кроны нэгтийн дэвсгэр өгч байхаар тохиролцсон байна. Гэтэл эхний үед, Жозеф дуудлаа ч нойр ханаагүй учир дахиад жаахан унтуулаач хэмээн уйлагнаж, тайван унтахад садаа хийлээ гэж хүртэл уурлаад босч өгдөггүй байв. Тийм мөртлөө арайхийн сэрэхээрээ "яагаад амласан цагтаа босгосонгүй вэ?" гэж үглэдэг байв.

Эзнийхээ энэ мэт байдалд уур нь хүрсэн Жозеф яаж ийгээд кроны дэвсгэртийг нь гартаа оруулья хэмээн шийдэв. Тэрээр эзнийхээ чин санааны нойрмог гуйлт болон "ажлаасаа хөөгдчих вий" гэх мэтээс эмээсэнгүй, нөгөөх цагт нь орноос нь татаад унагачихдаг болжээ. Нэгэн өглөө Вюхон уйлагнаад үглэж эхлэнгүүт зоригжсон Жозеф түмпэнд хүйтэн ус дүүргэж, унтлагынх нь хувцасны ар луу цацаж орхив. Тэгсний үр дүн даруй гарчээ.

Ийнхүү зүтгэл гаргасны үр дүнд тэрээр өглөө босдоггүй зуршлаа таягдан хаяж чадсан билээ.

"Байгалийн шинжлэх ухаанаар миний бичсэн бүтээлийн дотроос гурав, дөрвөн боть нь зарц Жозефийн минь хүч юм" гэж тэрээр дахин дахин өгүүлсэн байдаг.

##### ***Дэглэмтэй ажиллаж мэддэггүй хун авъяасынхаа дөрвөний гурвыг ашиглаж чаддаггүй***

40 гаруй жил Вюхон өглөөний 9 цагаас 11 цаг хүртэл хичээллэж, орой 5 цагаас 9 цаг хүртэл ширээнд суудаг амьдралтай хүн болжээ. Өдөр бүр цаг тогтож эрдмийн ажил нүдэж байх зуур уг хөдөлмөр нь заншил болон тогтож биенд нь бүрмөсөн шингэж орхисон ажгуу.

Вюхоны намтрыг зохиогч бичихдээ: "Тэрээр ажилгүй бол амьдарч чадахгүй хүн байлаа. Түүний судалгаа нь түүний амьдрал увидастай том хүч байсан. Тэрээр алдар хүндээр

дүүрсэн амьдралынхаа сүүлчийн өдрүүдэд ч "дахиад хоёр, гурван жил ч байсан болно, судалгаагаа бас жаахан үргэлжлүүлэхсэн" хэмээн дахин дахин ярьж суусан" гэжээ.

Вюхон үнэнч сэтгэлтэй эрдэмтэн байсан бөгөөд уншигчиддаа өөрийнхөө хамгийн дээд үзэл санааг хамгийн сайн хэллэгээр дамжуулахаар цаг үргэлж махран зүтгэж байсан. Тиймийн тулд бичлэгийн хэл найруулга нь тун төгөлдөр, гар бичмэлдээ дахин дахин гар хүрч, залхуурахыг ер мэддэггүй хүн байв. "Байгалийн цаг" (Epoques de La Nature) зэрэг бүтээлээ бичиж байх үедээ санаандаа нийцтэлээ цөөхөндөө л арав гаруй удаа засч найруулж байсан гэдэг.

Ийнхүү Вюхон чин сэтгэлээсээ ажилсаг хүн бөгөөд ямар ч зүйлд арга барилаа тохируулж яв цав гүйцэтгэхээс нааш сэтгэл нь амардаггүй хүн байлаа. "Дэглэм журам тогтоож ажил хийдэггүй хүн хэчнээн ч тэнгэрлэг авъяастай байсан тэр авъяасынхаа дөрөвний гуравыг ашиглаж чаддаггүй нь мэдээж хэрэг" гэж тэрээр өгүүлдэг байв.

Тэр үеийн францын эрдэмтдийн гол хүний нэг Негел хатагтай Вюхоны тухайд ингэж ярьсан байдаг.

"Гоц авъяас гэдэг нь нэг асуудалд гүн гүнзгий, хэт анхаарч үр дүн гаргахыг хэлдэг" гэж Вюхон үздэг байсан. Тэр зөвхөн гар бичмэлээ бичиж дуусгахад л эрчим чадлаа шавхаж байсан боловч ядарсан биеэ ташуурдаж, төгс боловсронгуй болгох үзгээ атгадаг байсан гэдэг. Мэдээж аль эрт төгс төгөлдрийн өндөрт хүрчээ гэж бодогдохоор өгүүлбэрүүдийн тухайд ч гар хүргэхгүй орхидоггүй. Залхмаар бичиж засах үйлдэл нь нэг мэдэхэд л баяр хөөр болон хувирчихдаг" гэжээ.

Эцэст нь Вюхоны агуу их бүтээлийн ихэнхи, хүнд өвчинтэй тулалдаж байхад нь бичигдэж хэвлэгдсэнийг нэмж дурьдахад илүүдэхгүй байхаа.

### ***"Идэвх чармайлт"-тай нөхөрлөдөг хүн хүчтэй***

Утга зохиолын салбарт ч Вюхонтой адил жишээ олон бий. Үүний нэг нь Вольтер Скотт юм. Тэрээр залуудаа хуулийн товчоонд бичигдансыг хуулбарлан буулгах чимхлүүр ажлыг олон жил хийжээ. Түүний зохион туурвихад бүхнээ зориулсан үйлсэд нь энэ үеийн туршлага ихээхэн нэмэр болсон гэдэг.

Хуулийн товчоонд өдөр бүр залхмаар ажил дахин дахин хийж суудаг тул Скотод өөртөө зориулах цаг зөвхөн шөнө байсан агаад, энэ үе юунаас ч илүү тайтгарал болж байлаа. Тэрээр шөнө орой болтол ном уншиж, судалж суудаг байв. "Бидний зохиолчдод хичээл оролдлого гэдэг юм зарим талаар дутагдаж байдаг ч түүнийг биедээ эзэмшиж чадсан явдал залхуутай газар хөдөлмөрлөсний маань ач үр юм" гэж тэрээр өгүүлдэг байв.

Бичвэр хуулбарлан буулгахад нэг хуудас нь гурван песоний үнэтэй байв. Тэрээр үе үе цагаасаа илүү сууж ажиллаад 12 цагт 120 хуудсыг буулгаж 30 шиллинг гаруйг ч олдог удаатай байлаа. Тэр мөнгө нь голдуу ном авахад зориулагдаж байсан бөгөөд хэрвээ тэгэж байгаагүй бол ихээхэн ном авах бололцоо түүнд гарахгүй байсан билээ. Скотт өөрөө ийм албанд зүтгэж байснаараа бахархаж байжээ. Гоц авъяас гэдэг өдөр тутмын аахар шаахар ажилд дургүй, түүнийг Дорд үздэг эд" гэж сонссон мэтээр ярих шүлэгч нөхөртэйгээ тэрээр эсэргүүцэн маргалддаг байлаа. Скотт хэрвээ хүн өдөр тутмын аахар Шаахар ажлыг нягт нямбай гүйцэтгэж чадаж байвал илүү өндөр чадварыг биедээ эзэмшинэ гэж үздэг байжээ.

Мөн дээд шүүхийн газар нарийн бичгийн даргаар ажиллаж байхдаа ч Скотт утга зохиол туурвих ажлынхаа ихээхэн хэсгийг өглөөний хоолны өмнө амжуулж, өдөр нь шүүх дээр нарийн бичгийн даргын ажлаа болон бичвэр хуулах бусад албаа гүйцэтгэдэг байлаа.

"Скоттын намтар"-ыг зохиосон түүний хуурай хүү Локкхарт "Скоттын амьдралын замналд заавал бичих ёстой нэг чухал тал бол хамгийн ихээр уран бүтээлдээ улайрсан үедээ хүртэл тэрээр багаар бодоход хагас жил гаруй өдрийнхөө ихэнх хэсгийг нарийн бичгийн даргын ажилдаа зориулж байсан явдал" гэж бичсэн байдаг.

Орлогыг өдөр тутмын ажлаас олох ёстой зүйл бөгөөд утга зохиолыг амьжиргааны тогтсон хүнс болгож болохгүй. Энэ бол Скотт өөрөө өөртөө тавьж биелүүлсэн амьдралынх нь чиг шугам ажээ. Тэрээр "Утга зохиол миний оюун санааны түшиг тулгуур болохоос биш амьдралын тэжээл

биш. Хэдийгээр миний бүтээл зарагдлаа ч гэсэн чадвал тэр мөнгийг амьжиргааны өртөг болгон эргүүлж суумааргүй байна даа" гэжээ.

### ***Өсөлт хөгжилт гэдэг" үл мэддэгээ мэдэх"-ээс эхэлдэг***

Скотт цагийг хатуу баримтлахад сэтгэлээ зориулж, үнэхээрийн горим зөвтэй амьдралыг туулж өнгөрүүлсэн билээ. Эс тэгвээс тийм их хэмжээний уран бүтээлийг төрүүлэн гаргаж чадахгүй байсан бизээ. Түүний хаягаар өдөр бүр, зузаан зузаан баглаа захидлууд ирдэг байсан. Тэр бүрд нь хариу бичих нь нозоорлон назгайрч суух лугаа адил бэрх хэцүү хэрэг билээ. Гэвч тэрээр судалгаа шинжилгээ болон найруулан төгөлдөржүүлэх ажилд нь хэрэг болохгүй мөнөөхөн Захидлуудад тэр өдөрт нь хариу явуулахыг өдрийнхөө ажил болгож байсан учир нэг удаа ч эзэнд нь илгээхгүй дутааж байсан удаагүй.

Скотт өглөө бүр 5 цагт босч, өөрөө пийшиндээ гал түлдэг. Сахлаа хусч, хувцас хунараа сольсны дараа 6 цагийн үед ширээндээ суудаг ажээ. 9 цагаас 10 цагийн хооронд гэрийнхэн нь цуглаж өглөөний цайгаа уудаг бөгөөд тэр болтол тэрээр өдрийнхөө бичих ёстой төлөвлөсөн зүйлийнхээ ихэнхийг нь хийдэг ажээ.

Ийнхүү Скотт ядрахаа үл тоон хичээллэж, өргөн мэдлэг биедээ шингээж, урт настай, гайхамшигтай бүтээлийг хүн төрөлхтөнд бэлэглэсэн билээ. Түүгээр үл барам, тэрээр ямагт өөрийнхөө чадал хүчгүйг гайхаж ирсэн юм. "Эргэцүүлэн бодоход, би ямагт өөрөө өөрийнхөө бага гэгээрсэн байдалд зэм өгч ирсэн гэж бодогддог".

Скоттын энэхүү үгэнд чин үнэнчийн агуу утга болон төлөв даруу байдал илэрхийлэгдэж байна. Хүнд зөв мэдлэг хэчнээн их байхын хэрээр биеэ тоохын сэтгэл нь арилж байдаг бололтой. Нэгэн коллежийн оюутан "дээд сургуульд сурах ёстой бүхнийг сурч эзэмшлээ" гэж бодоод анги даасан профессортойгоо салах ёс гүйцэтгэхээр иржээ. Тэгтэл профессор "Би одоогоор мэдлэгийн эрдэнэсийн хайрцагт хүрэх хаалгыг олж харснаас ер хэтрээгүй" гэж хариулаад тэр оюутныг ичээсэн гэдэг.

Хөнгөмсөг хүн юмны мөн чанарыг эргэцүүлэн бодолгүй, хагас дутуу мэдлэг олсон төдийгөөр өөрийн авъяасаар бардамнах гэдэг Харин ухаантай хүн "Би өөрийнхөө бага мэдлэгтэй болохыг мэддэгээс цаашгүй" хэмээн улам цааш урагшлахаа хүлээн зөвшөөрдөг ажээ. Агуу Ньютон хүртэл "Нүдний минь өмнө үнэний онгон их баялаг далай мэт цалиглаж байвч би түүний эрэг хавийн дунг түүж цуглуулснаас хэтэрсэнгүй" гэж өгүүлсэн байдаг.

### Нэг тохиосон хувь дахиж ирдэггүй

*Амьдралын орчлыг туулах самбаа, эзэгнэх сэхээ*

#### 1. Хичээл зүтгэл дотор "гялбаа" бий.

Тохиолдлын учралаас агуу их бүтээл төрж гарах нь нэн ховор. Мэдээж хэрэг, хааяа аз таарч амжилтанд хүрэх явдал байдаг бизээ. Гэлээ ч үнэнхүү хичээл чармайлт болон чин зүтгэл л амжилтанд хүрэх цорын ганц бат найдвартай зам билээ.

Байгалийн зураач Вильсоны нэг удаад уран бүтээлээ туурвиж байх үед нь тохиолдсон сонин явдлын тухай яриа байдаг. Вильсон уламжлал болсон аргаараа нэгэн зураг зурж бараг дуусч байжээ. Гэтэл тэрээр бийрээ гартаа барьсан чигээрээ хойш ухарч дэлгэцээ харж зогсоод, гэнэт зураг руугаа ухасхийн очиж үг сүггүй хоёр гурван газар бийрээ хүргэжээ. Энэхүү хамгийн сүүлчийн үйлдлээр зураг нь гайхалтай сайхан болсон гэдэг. Ийм ур чадвар хэн бүхэнд ч заяагаад байдаггүй. Өдөр бүрийн тасралтгүй хичээл чармайлт бөөгнөрөн хуримтлагдаж байсан учраас л бийрийн ганц таталт нэгэн ширхэг зурганд урлагийг амь оруулах бололцоог бүрдүүлжээ.

Хэрэв туршлага дутуу зураач байсан бол гайхамшигтай бүтээлээ дуусгах нь бүү хэл, бүр дэлгэцээ бийрийнхээ үзүүрээр завааруулж орхих нь мэдээж билээ.

Үнэхээрийн гайхалтай ажил хийдэг хүмүүс ямагт тэвчээртэйгээр ажилдаа шургуу байж, бие сэтгэлээ хайрлалгүй хичээн зүтгэж байдаг. Агуу их хүмүүс өдөр тутмын эргэн тойрныхоо аахар шаахар зүйлийг үл тоомсорлож, харин барихын аргагүй асуудалд түүнийг засан сайжруулахаар хүчээ зориулж байдаг.

Нэг удаа Микеланжелогийн урланд найз нь иржээ. Микеланжело баримлынхаа нэгийг хуруугаараа зааж найзынхаа урьд нь ирээд явснаас хойш яаж зассанаа хичээнгүйлэн тайлбарлаж эхлэв. "Энэ хэсгийг зассан юм. Тэр хэсгийг ч бас зүлгэж өнгөллөө. Энэ зураасыг өмнөхөөсөө зөөллөж тэр булчин товойж байгаагаар гаргалаа. Уруулд нь ч зарим нэг сэтгэлийн хөдлөл гаргаж, гар хөлд нь бүр хүчтэй шинж байдлыг суулгасан юм" гэжээ.

"За, иймэрхүү аахаар шаахар зүйл надад тийм чухал гэж бодогдохгүй байна..." гэж найз нь хүзүүгээ гилжийлгэхэд

Микеланжело:

"Мэдээжээр бүр нарийн засвар хийхэд энэ дутагдалтай байж ч магадгүй. Гэхдээ иймэрхүү зүйл хуримтлагдаж байж гоо сайхан цогцолдог. Өөрөөр хэлбэл гоо сайхан бүрэлдэж бий болоход ямар ч үл ялиг зүйл чухал байр суурь эзэлдэг" гэжээ.

Францын нэгэн зураач "Сэтгэл татагдах л ажил байвал, тэр нь юу ч байсан эцэстээ гайхалтай сайхнаар бүтэж байдаг учиртай" гэж хэлсэн байдаг. Нэр алдартай зураач болж чадсаны учрыг найз нь асуухад тэрээр "Ямар ч жижиг сажиг асуудлыг хайхрахгүй орхидоггүй байснаас тэр" гэж хариулжээ.

#### *Нүд дассан юмны ар өврийг нэвт шувт хардаг төрх*

Ямар нэгэн санаандгүй тохиолдлоос том нээлт төржээ гэсэн яриа нэлээд байдаг. Харин сайтар тунгаан бодож үзвэл огт гэнэтийн зүйл байсан тохиолдол үгүй юм. Гэнэтийн тохиолдол гэж үздэг зүйлийн ихэнх нь угтаа бол гоц авьяас, хичээл зүтгэлийн үр дүн байдаг.

Ньютон хөл доороо унасан алимны ачаар таталцлын хуулиа нээжээ гэж ярьцгаадаг. Энэхүү яриаг санамсаргүй тохиолдол том нээлтэд хүргэсний жишээ болгож иш татдаг. Харин Ньютон энэ хүртэлх урт удаан хугацааны хооронд хүндийн хүчний асуудлаар дагнан хөөцөлдөж, байнга судалгаагаа үргэлжлүүлж ирсэн учраас л нүдний өмнө алим унахыг хараад инерцийн холбогдол толгойд нь гялс хийж таталцлын хуулийг ухаарахад хүрсэн ажээ.

Байгаль шинжээч Янг бас Ньютонтой төстэй зүйл ярьдаг. Тэрээр хөөсөн бөмбөлөгт гэрлийн туяа гялалзан тусахыг үзээд гэрлийн интервенцийн онолыг бодож олж тэр нь гэрлийн туяаны хугарлын үзэгдлийг тайлбарлахын үүд болж өгчээ. Жирийн хүмүүсийн нүдэнд зөвхөн "гэрлийн аальгүйгэл" гэхээс өөрөөр буудаггүй үзэгдлээс шинэ үнэнийг олж гаргаж буй нь тэрээр удаан жил уг асуудлыг судалж ирснээс болжээ.

Хорвоод агуу хүмүүс хийсвэр асуудлыг л судлан шийдэж байдаг гэхмэтээр ярих ньбий. Гэвч Ньютон, Янг нарын жишээнээс харахад ойлгогдож буйчлан, тэд хэнд ч энгийн санагдах юмс үзэгдлийг маш сайн ажиглаж, тэнд нуугдаж буй чухал утга санааг барьж авдаг. Мэдээжийн байдаг л юмс үзэгдлийн цаана байгаа мөн чанарыг гүн гүнзгий ойлгож чаддагт агуу хүний агуу хүн болох хамгийн гол учир начир байдаг бололтой.

### " Ухаантны нүд толгойдоо байдаг"

Ажиглах чадварын сайн муугаас хүн хүн янз янз байна. Анхаарах чадвараар алмай хүн "ойгоор явлаа ч түлээ олж хардаггүй" гэсэн росын зүйр үг байдаг юм. Эртний Израйлын ухаантан Соломон "ухаантны нүд толгойдоо байдаг, мунхаг хүн мухар сохор явдаг" гэжээ. Бас Самуэль Жонсон, Италиас дөнгөж буцаж ирсэн жентельменд хандаж :Миний суудаг Хамстедт гудамжинд (Лондонгийн нэгэн гудамж, урлагийнхан олноороо суудаг) амьдардаг хүмүүс дотор ч европ руу аялалд хошуурагчдаас эрдэмтэн хүн илүү олон байдаг юм шүү" гэжээ. Ерөөс хүний сэтгэл нүдтэй адилхан гайхалтайгаар юмс үзэгдлийг харж нэвтэрч чаддаг. Хөнгөн хуумгай сэтгэдэгхүнд юу ч харагддаггүй харин ухаантай, гүнзгий ухаарч ойлгох чадвартай хүн нүдний өмнө юмс үзэгдэл рүү гүнзгий нэвтэрч түүний цаад мухарт буй үнэнд тулж хүрдэг ажээ.

Галилейгээс өмнө ч оосорны үзүүрт уясан туухай савлахыг харсан хүмүүс олон. Гэвч энэ баримтын хичнээн чухлыг анхаарсан хамгийн анхны хүн нь Галилей байлаа. Нэг удаа Пизагийн их сүмийн манаач дээрвээс өлгөсөн чийдэнгийн тоосыг арчаад, чийдэнг савлуулж орхиод явжээ. Тэр үед 18 настай байсан Галилей чийдэн савлаж байхыг анхааралтай ажиглаж түүнийг цаг хугацааны хэмжүүрт хэрэг болох болов уу гэж бодож эхлэсэн байна. Түүнээс хойш тавин жил судалгаа хийн хүч чармайлт гаргасны үр дүнд тэрээр цагийн дүүжмэг бүтээжээ. Түүний нээлт бидний амьдрал болон физикийн шинжлэх ухаанд томоохон зүйл болсон юм.

Бас Галилей, тохиолдоор Нидерландын нүдний шилчин алс холын юмыг ойроос харж буй мэтээр хардаг хэрэгсэл бүтээж түүнийгээ Морис гүнтэнд өргөн барьжээ гэсэн яриаг тохиолдлоор сонсчээ. Галилей тэрхүү хэрэгслийн бүтцийг сэтгэж, удалгүй холын зайн дуран авай бүтээв. Түүний ачаар орчин үеийн одон орон судлалын анхны алхам хийгдсэн билээ. Хэрвээ Галилей үзсэн харсан зүйлээ сэтгэж ухааралгүй, бусдын яриаг хүртэгч төдий байдлаар сонсож суудаг хүн байсан бол иймэрхүү нээлт огт гарахгүй гэдэг нь маргаангүй юм. *Хоёр мянганыг элээж байж цэцэглэх цэцэг ч бас байдаг* Гүн гүнзгий анхааралтай ажиглаж сэтгэдэг хүмүүс ухаалаг нүдээр юмс үзэгдлийг нэвт шувт хардаг учир ердийн жирийн үзэгдлээс ч чухал утга санааг сугалж гаргаж чаддаг .

Колумб шинэ тив нээхээр урт удаан аян замд гарсан авч зорьсон тив нь тийм амархан үзэгдсэнгүй. Далайчид сэтгэл дундуур болж, хөлөг онгоц дотор таагүй уур амьсгал дэгдэж эхлэв. Нэгэн өдөр Колумб хөлөг онгоцны хойт хавьд далайн ургамал урсаж явахыг олж харжээ. Энэ нь эх газар ойрхон байгаагийн тэмдэг аж. Тэрээр далайн энэхүү өчүүхэн ургамлын ачаар эрж хайж явсан шинэ тив нь ойрхон байна гэдгийг хөлгийн багийнхандаа итгүүлж, үймээн самуун гарахыг урьдчилан зогсоосон гэдэг.

Иймэрхүү баригдахтай үгүйтэй, өчүүхэн жижиг зүйл ч үнэхээрийн их хэрэг болох тохиолдол олон байдаг. Тиймээс бизнесийн тухайд ч, урлаг, шинжлэх ухааны тухайд ч, бас бусад салбарт ч жижиг сажиг зүйлийг нарийвчлан ажиж байх нь амжилт олохын нууц болдог.

Хүний мэдлэг гэдэг жижиг баримтуудын цуглуулгаас өөр юу ч биш. Олон үеийн турш хүмүүс аахар шаахар мэдлэгийг цуглуулан хурааж ирсэн билээ. Ийм мэдлэг хийгээд туршлагын тасархай цугларсаар удалгүй агуу том пирамидыг барьж босгосон юм. Эхэндээ тийм ч чухал гэж тооцогдоогүй зүйл алсдаа маш том үүрэг гүйцэтгэх болсон жишээ ч олон бий.

Эртний Грекийн математикч Аполлониус тэр үедээ конусын огтлолцлыг тодорхойлчихоод байв. Гэвч энэхүү тодорхойлолт хоёр мянган жил хэмээх үнэхээрийн ухаан алдам хугацааны дараа л далайн аяллын технологит хэрэглэгдэх болсон билээ. Үүнтэй адил эртнээс нааш олон математикч шулууны болон гадаргуутай холбоотой олон хийсвэр онолыг батлахын тулд чөмгөө дундалж байлаа. Өнгөц хүмүүсийн нүдэнд тиймэрхүү судалгаа огт ашиггүй зүйл хэмээн бууж байсан байж магадгүй юм. Гэвч тэдний байнгын хичээл зүтгэл байгаагүй бол одоо үеийн нээлт ер нь байх байсан болов уу даа.

### *Мянган жилд ганц тохиох учралыг амьдруулах самбаа*

Америкийн эрдэмтэн, улс төрч Бэнжамин Франклин аянгийн эх бие нь цахилгаан болохыг туршлагаар баталжээ. Гэвч тэр үед хүмүүс "энэ чинь чухам юунд хэрэг болох юм бэ" хэмээн шоолжээ. Тэгэхэд Франклин: "Хүүхэд ямар хэрэгтэй юм бэ гэж асуух нь уу? Одоо хүүхэд ч гэлээ тун удахгүй гайхамшигтай хүн болохыг хэн байг гэх вэ" гэж хариулжээ.

Италийн биологич Гарбани яст мэлхийн хөлийг төрөл өөр металлд зэрэг хүргэхэд булчин нь татвалздаг болохыг тогтоожээ. Гэвч тэр үед энэ бол онцын хэрэгцээгүй зүйл гэж үзээд, тэнд цахилгаан Дамжуулах технологийн үүсэл оршиж буй гэж төсөөлсөн хүн байсангүй.

Хүмүүс газрын гүнээс ус хутгаж, тээрэм хөдөлгөж, үйлдвэрт бүтээгдэхүүн үйлдвэрлэж, усан онгоц, машин давхиулна. Энэ бол халууны улмаас тэлэгдсэн усны дуслын хүч, өөрөөр хэлбэл уур ашиглагдсны үр дүн юм. Металл данхны амнаас уур савсаж гарах нь бидэнд хэзээний дассан үзэгдэл билээ. Гэвч нарийн бүтээгдсэн механизмын дотор энэхүү уурыг ашиглавал хэдэн зуун мянган морины хүчээр тооцогдох их хүчийг гаргадаг ажээ.

Мэдээллээс үзэхэд Лондонд хоригдож байсан Маркиз Уста халуун ус хийсэн савны таг хол шидэгдэхийг хараад тохиолдлоор уурны хүчийг анхаарч эхлэсэн гэдэг. Тэрээр өөрийн ажиглалтын үр дүнг "Нээлтийн эрин" (Century of Invention) хэмээх номондоо нэгтгээд хэвлүүлсэн юм. Энэ ном хэсэг хугацаанд судлаачдын гарын авлага байж, удалгүй нэр бүхий эрдэмтэд судлан уурын хөдөлгүүр бүтээсэн билээ.

Ньюкомены уурын хөдөлгүүр Глазгогийн их сургуульд хадгалагдаж байсан ба түүнийг засварлахыг Уатт гэгчээс гуйжээ. Энэхүү гэнэтийн тохиолдол түүнд мянган жилд ганц тохиох шанс олгосон гэдэг. Юу гэвэл тэрээр энэ хөдөлгүүрээс санаа авч, бүхий л амьдралаа зориулж байж, өндөр чадвартай уурын механизм бүтээж чадсан билээ.

### **3. Биеэ даан алхах хүнд ялах боломж олддог.**

Бололцоог барьж авч, тохиолдлын учралыг ямар нэг зорилготойгоор ашиглаж явах нь амжилтын нэг томоохон нууц юм. Жонсон гоц авъяасын хүчийг "өргөн салбарыг элгэндээ тэврэх агуу оюун санаа гэнэт учрах тодорхой чиглэлийг ч эзэмдэх чадвартай байдаг" гэж тодорхойлжээ. Өөрийн хүчээр гарцаа сэтлэж нэе гэх хүнд түүнд тохирох бололцоо заавал гарч ирдэг. Ойр хавьд боломж байхгүй байлаа ч түүнийг өөрийн хүчээр бий болгож болдог ажээ.

Шинжлэх ухаан, урлагт маш том бүтээл туурвигчид бүгдээрээ л их сургуульд сурч музей, галерей сэлтэд орж чадах боломжтой орчинд амьдарч байгаагүй. Агуу их технологич, зохион бүтээгч нар заавал мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагад боловсрол олсон байх албагүй.

Ийм болохоор тав тухтай байгууламж, тоног төхөөрөмжөөс илүү, харин бүр хэрэгцээ л нээлтийн эх бөгөөд, бэрхшээл зовлон агуу их үр дүнг төрүүлэхийн үнэн сургууль байдаг гэж хэлж болох юм.

Шилдэг судлаачдын дотор үнэхээрийн ердийн багаж хэрэгслээс өөр юмгүй хүмүүс олон байжээ. "Муу дархны багаж их" гэж үг бий. Гайхамшигтай үр бүтээл төрүүлэх нь багаж зэвсгийн сайн мууд биш, тэр хүний өөрийнх нь боловсронгуй технологи болон хичээл чармайлтад оршино.

Английн нэгэн алдарт зураач өнгө будгийн зохицолд гайхамшигтай авьяастай бөгөөд түүний нууцыг асуухад "би зургийн хэрэгсэлдээ толгойгоо хольж нийлүүлдэг юм" гэсэн гэдэг. Шотландын эрдэмтэн Фергсон жирийн ганц тонгорго барьж суугаад гайхал төрүүлмээр нарийн хийцтэй модон цаг зэргийг бүтээсэн ажээ. Хэн гуайд ч ганц тонгорго байдаг боловч тэр бүр түүн шиг юм бүтээдэггүй.

Химич Блейк ус хийсэн тогоо, хоёр ширхэг "халуун хүйтнийг хэмжигч"-ийг ашиглаж нээлт хийжээ. Гэрлийн найрлага болон өнгөний гарлыг нээсэн Ньютон ч призм, линз, нэг ширхэг нимгэн цааснаас өөр хэрэгсэлгүй байсан билээ.

Олон тооны нээлтээрээ шинжлэх ухааны хөгжилд гавьяа байгуулсан Урастоны ажил руу гадаадын нэртэй эрдэмтэн сураглаж очоод судалгааны ажлын өрөөгөө үзүүлээч гэж хүсчээ. Урастон жижигхэн кабинетад зочдыг дагуулж очсон бөгөөд түүний ширээн дээр хуучин цайны гүц байх ба дотор нь энгэрийн цагны нүүрний шил хоёр гурван ширхэг болон шалгах цаас, жижигхэн сорогч (химийн туршилтын багаж, гаазны дөлөнд агаар соруулахын тулд шулуун өнцгийг махийлгасан металл сав) зэрэг байлаа. Тэрээр эдгээр багажийг хуруугаараа заагаад: "Миний судалгааны өрөө бүхэлдээ байгаа энэ дээ" гэжээ.

Нэгэн алдартай зураач галын шилээврийн хугархай, пүнзний хаалга хоёроор бийр, дэлгэцээ орлуулж байжээ.

Зураач Бьюк залуудаа жижиг өрөөнийхөө ханан дээр цэрдээр зураг зурж дасгал хийдэг байв. Бэнжамин Вестийн хамгийн анх хэрэглэж байсан бийр нь, тэрээр өөрөө муурны сүүлний үсээр хийсэн эд байжээ. Франклин хоёр ширхэг мод болон торгон алчуураар „цаасан луу „ хийж түүнийгээ хөөргөн аянгын үүлнээс цахилгаан хүлээж авч чаджээ. Вутт, нас барсан хүний шарилд задлан шинжилгээ хийхийн өмнө судсанд нь тариа хийдэг тариурын нэгэнт хэрэглэчихсэн хуучин хэрэгсэлий гэмчээс нь гуйн авч ашиглаж анх уурын тэрэгний загвар хийсэн гэдэг. Иймэрхүү жишээг тоолж баршгүй.

### ***Залуу цагийн гэнэтийн учрал нэг насны чиг болох учир бий***

Өчүүхэн, өдөр тутмын явдал судалгааны ажлын шалтгаан хийгээд дуудлага болох тохиолдол олон байдаг. Мэдээж хэрэг, уг хүн соргогоор тэрхүү боломжийг шүүрч ашиглаж чадвал шүү. Физикч Фарадей ном хавтаслагч байхдаа архины ганц шил ашиглаж цахилгааны туршилтыг анх хийжээ. Жирийн ажилчин хүн шинжлэх ухаанд зориглох нь нэлээд содон явдал боловч, түүний шалтгаан өчүүхэн бага зүйлээс улбаатай байлаа. Нэг удаа Фарадей нэвтэрхий толь бичигний хавтасхийж байсан өгөөд тэнд "цахилгаан" гэсэн бүлэг байхыг санаандгүй анзаарчээ. Сонирхолтой байсан тул тэр хэсгийг байн байн уншдаг байсан бөгөөд тэднийд хааяа вангийн шинжлэх ухааны хүрээлэнгийн гишүүн нэг хүн ирдэг байлаа.

Тэрээр ажилчин залуу цахилгааны асуудал сонирхож байгааг мэдэж хүрээлэн дээрээ очиж лекц сонсох боломж олгожээ. Тун удалгүй Фарадей тийш очиж, эрдэмтэн Дейбийн цахилгааны тухай лекцэнд суусан байна. Тэрээр лекц тэмдэглэсэн дэвтрээ түүнд үзүүлтэл Дейби түүний тэмдэглэл шинжлэх ухааны хувьд яв цав зөв болсныг анзаарчээ. Тэр үед Фарадейг ердийн л ажилчин хүн гэдгийг сонсоод бүр ч гайхсан гэдэг.

Фарадей шинжлэх ухааны судлалд сонирхолтой гэдгээ илэрхийлэхэд нь Дейби энэ бодлоо орхихыг түүнд ятгаж байсан удаатай. Гэвч нэг мэдэхэд залуу хүүгийн эргэлт буцалтгүй халуун хүсэлд цохигдож, түүнийг туслахаа болгон вангийн шинжлэх ухааны хүрээлэнгийн ам бүл нэгэн

гишүүнээр нэмэгджээ. Дейби ч өөрөө, угтаа эмийн санчийн шавь байсан бөгөөд түүний бүтээл ийнхүү Дейбигээс дутахгүй ухаалаг, ном хавтаслаач залуу Фарадейд уламжлагдсан ажээ.

Францын эрдэмтэн Кюбиер туйлын зөв тодорхой, няхуур, шургуу, ажиглах хараа бүрдсэн хүн байв. Байгалын шинжлэлд татагдсан шалтгаан нь хүүхэд байхдаа Вьюхоны бичсэн нэг номтой учирсан явдал байлаа. Тэрээр уг номын зургийг буулган авч, номонд тайлбарласан ёсоор өнгөөр будаж хичээллэсэн ажээ. Бас сургуулийнхаа багшаас Линнерын "System of Nature" номыгбэлгэнд авсан бөгөөд эл ном тэр цагаас хойш арав гаруй жилийн турш түүний ширээний ном байсан гэдэг. Кюбиер 18 настайдаа Норманж мужид айлд гэрийн багшаар очсон байна. Тэднийх далайн эрэг хавьд байсан тул гайхамшигт далайн амьтдын амьдралын хэв маягийг бүр ойрхноос ажиглаж чадах болжээ. Нэг өдөр элст эргээр зугаалж явтал нэгэн наймаалж усны захад хэвтэж байлаа. Тэрээр тэрхүү ховорхон хэлбэртэй амьтныг сонирхож түүнийг задлан үзье хэмээн гэртээ авч иржээ. Ийнхүү зөөлөн биет амьтны судалгаа нь эхлэсэн түүхтэй. Энэ судалгаагаараа тэрээр сүүлд нь өндөр алдар хүндэд хүрсэн билээ.

Кюбиер судалгаандаа хэрэг болох нэг ч гарын авлагатай байсангүй. Гагцхүү их байгаль гэгч агуу их сурах бичиг тийнхүү хуудсаа нээгээд түүнийг хүлээж байсан байна. Тэрээр нэгд нэгэнгүй няхуур ажиглах чадвараа соргог ашиглаж одоогийн далайн амьтдын анатоми болон чулуужилт хоёрыг харьцуулсан судалгаагаа үргэлжлүүлсээр гурван жилийн дараа далайн амьд амьтдын цоо шинэ системийн хуулийн үндсийг тавьсан билээ. Энэ судалгааныхаа ачаар залуу биологич Клобиерын нэр удалгүй дэлхий дахины анхаарлыг татах болсон гэдэг.

#### **4 Аз жаргал чиний гар хүрэх газарт чамайг хүлээж буй**

Дахин давтан хэлж буйчлан биднийг аварч туслах нь тохиолдлын хүчин бус, хатуу тогтсон зорилгодоо хандаж тэвчээртэй шургуу урагшлах явдал л юм. Зориг зүрх муутай, залхуу хүн, бас зорилгогүй сэлгүүцэх хүнд ямар ч аз жаргал хүртэл утга учиртай байдаггүй. Тэдний нүдний өмнүүр бололцоо жирэлзэн өнгөрлөө ч түүний утгыг ч ойлголгүй үүлгэртэн байсаар хараа алдан хоцордог юм.

Нөгөө талаар, аз жаргалын охин тэнгэрийг тэвэрч тогтооё гэж анаж байгаад дайрвал заавал ч үгүй гайхмаар амжилт олж магадгүй. Боломж ямагт бидний гар хүрэх газар хүлээж буй. Гагцхүү хэргийн гол нь түүнийг сэргэг барьж авч гүйцэлдүүлэхийн тулд урагшаа алхаж чадах уу үгүй юу гэдэгт байдаг.

Вутт тооцоолуур зохион бүтээхийн хажуугаар хими болон физик судлаж, Швейд будагчнаас герман хэл сурсан гэдэг. Уурын хөдөлгүүрт машин зохион бүтээсэн Стифсон нүүрсний уурхайд машин барингаа ээлжгүй шөнөө тоо бодлого, Геометр үздэг байлаа. Үдийн ундны өчүүхэн чөлөөндөө нүүрсний тэрэгний тэвшийг самбарын оронд хэрэглэж ,цэрдээр тоо бодлогын дасгал хийдэг байсан гэдэг.

Физикч Дальтоны хувьд хичээл зүтгэл гэдэг бага наснаасаа биедээ эзэмшсэн амьдралынх нь хэвшил байлаа. Тэрээр ердөө арван хоёрхон насандаа хөдөө тосгоны сургуульд багшилж байжээ. Өвөл хичээлтэй, зун нь эцгийнхээ тариан талбайд ажиллана. Эрхэмсэг санваартны гэр бүлд төрсөн хэдий ч тэрээр найзуудтайгаа ямагт мөнгөөр дэнчин тавих хүртлээ эрдмээр өрсөлддөг байв. Нэгэн удаа түвэгтэй асуудлыг амжилттай шийдэж, тоймгүй их мөнгө гартаа хийсэн ч тэр их мөнгөөрөө өвөл хэрэглэх лаа худалдан авч бэлдсэн гэдэг.

Дальтон нас барахаасаа нэг хоёр өдрийн өмнөхөн хүртэл үзэгдэл зүйн хуулийг үргэлжлүүлэн судалж байсан бөгөөд бүхий л амьдралдаа хурааж бөөгнүүлсэн ном судар нь хорин түм давсан гэдэг.

#### ***Мунхагийг агуу болгон хувиргахад "ганц цаг"ч нөлөөтэй***

Багахан цагийг ч дэмий үрэлгүй байнгын хүчин чармайлтаа ҮРгэлжлүүлж байвал хуран хуримталсаар том үр дүнд хүрдэг. Өдөр бүр ганц цаг ч бай, зорилго үгүй өнгөрөөж байгаа хормыг

ямар нэгэн ашиг тустай зүйлд хандуулж үзэх нь сайн. Тэгвэл жирийн, ердийн чадвараас илүүгүй хүн хүртэл заавал нэгэн эрдэм зэргийг төгөлдөр эзэмшиж чадах болно. Ингэвэл ямар ч мэдлэггүй хүн хүртэл арван жил хүрэхгүй хугацаанд замаа өөрчлөх хүртэл асар мэдлэгтэй агуу хүн болон хувирах нь лавтай.

Цаг хугацаа бол сурвал зохих үнэ цэнтэй мэдлэгийг хурааж, аихалтай итгэл, зоригийг төрүүлж, сайн дадал заншлыг биедээ эзэмшихийн тулд л зарцуулагдах ёстой зүйл билээ. Үр жимсгүй амьдралаар цагийг барахыг өршөөж боломгүй.

Эмч Мейсон Гүүд хүн үзэхээр Лондонгийн гудамжаар морин тэргээр давхиж явахдаа хүртэл жуузан дотор эртний Ромын яруу найрагчийн шүлгийг орчуулсаар байсан гэдэг. Дарвин мөн адил морин тэргээр өвчтнүүдийн гэрийг тойрч байсан бөгөөд тэмдэглэлийн цаасыг барьж алхлан толгойдоо орж ирсэн санааг тэр дор нь тэмдэглэж авахаар хичээж байжээ.

Чарльз Барней франц болон итал хэлийг шавьдаа хөгжим заахаар явах замдаа мориныхоо эмээл дээр сурч, яруу найрагч Кирк Вайт грек хэлийг ажиллаж байсан хуулийн товчоондоо очих, буцах замдаа эзэмшжээ. Америкийн хэл шинжлэлч Элихю Варрит "миний амжилтанд хүрсэн нь гоц авьяас бус. Өдөр бүр өчүүхэн бага цагийг ч болов үр ашигтай өнгөрөөснийх" гэж өгүүлсэн байдаг. Тэрээр амьдралын хэрэгцээгээ дагаж металлургийн ажилчнаар ажиллах явцдаа эрт эдүгээгийн арван найман хэл, европын хорин хоёр аман аялгууг төгс эзэмшсэн ажээ.

### ***"Цаг хугацаа гэдэг арилж үгүй болдог зүйл, арилж үгүй болохын нүгэл нь бидэнд буй"***

Цаг хугацаа гэдэг арилж үгүй болдог зүйл, арилж үгүй болохын нүгэл нь бидэнд бий. Оксфордын нэгэн коллежийн цаг дээр сийлсэн энэхүү гайхамшигтай үг шиг залуу хүмүүсийн хүмүүжил сахилгад тохиромжтой үг үгүй юм. Мөнхийн энэ ертөнцийн үнэн дотор, өчүүхэн бага цаг хугацаа л бидний чөлөөтэй шийдлийн мэдэлд байдаг. Тэгээд хүний амьдралтай адилхан, цаг хугацаа ч гэсэн өнгөрч орхивол дахиад дуудан эргүүлж болдоггүй. Санваартан Жексон: "Хорвоогийн эд баялгийн тухайд бол урьд нь ужид самуунд байдгаа барлаа ч гэсэн ирээдүйдээ арвилан хэмнэлтэд шамдаж чадвал түүгээрээ тэнцээд авч магадгүй юм. Харин "өнөөдөр дэмий үрсэн цагийг маргаашийн цагаар зээлдэж нөхье" гэж хэн хэлж чадах юм бэ?" гэжээ. Цаг хугацаа гэдэг ховор чухал өмч юм. Өнгөрсөн үеийн суут хүмүүс бүгдээрээ цагийг үр ашигтай ашиглаж баялаг сэтгэлгээ болон амжилт бүтээлийг төрүүлж, тэрхүү эрдэнэсийг хойч үеийн бидэнд үлдээж өгсөөр ирсэн билээ. Амжилт олох хүртлээ асар их цаг хугацааг тэвчин элээж, хичээн зүтгэсээр ирсэн хүний жишээ цөөнгүй байдаг. Ньютон "Он дарааллын бичиг" бүтээлээ өөрийн санаандаа хүртлээ арван таван удаа засварлан бичиж, түүхч Гибон "Өөрийн намтар"-ын гар бичмэлээ 9 дахин зассан гэдэг. Хьюм "Англи улсын түүх" бүтээлээ бичиж байхдаа өдөрт 13 цаг ширээндээ суудаг байжээ. Монтескью өөрийн бүтээлийн тухай найздаа ярихдаа: "Чи энэ номыг хоёр гурван цагийн дотор уншаад дуусгаж магадгүй. Харин түүнийг бичихээр адгаж суух үеийн миний алжаал ядаргаа гэдэг толгойны үс цайх шахуу бэрх зүйл байсан юм шүү гэжээ

Сэтгэлдээ орж ирсэн санаа, үзэж сонссон бодит баримтыг зайлшгүй бичиж тэмдэглэж үлдээдэг заншлыг эзэмших хэрэгтэй. Ингэвэл хүчтэй сэтгэгдэл санаанд тод үлдэж, чухал зүйлийг марталгүй авч хоцордог. Бэкон олон тооны гар бичмэл үлдээгээд эцэслэсэн бөгөөд түүнийгээ "бүтээлдээ хэрэглэхээр бичиж тэмдэглэж авсан санаанууд" гэж гарчигласан байжээ.

Пай Смитт залуу байхдаа эцгийнхээ хамтаар номын үйлдвэрт очиж үзэж байсан бөгөөд тэр цагаас эхлэн өөрийнхөө уншсан номын чухал хэсгийг товчлон авч, өөрийн шүүмж сэтгэгдлээ ч бичиж буулгах заншилтай болжээ. Тэрээр бүхий л амьдралдаа материал цуглуулахад идэвхийлж ирсэн бөгөөд "цаг ямагт суралцаж, урагшилж, мэдлэг хуримтлуулж байх" гэж намтар бичигч хүнд ахадмаар шахам мэрийн чармайгч байлаа. Ийнхүү бичиж тэмдэглэсэн дэвтэр нь зохиол бүтээл туурвихын сацуу эрт эдүгээгийн хэрэг явдлын гайхам эрдэнэсийн агуулах болох нь дамжиггүй.

Нэрт эмч Жон Хантер ой тогтоох чадвараа муудахаар тэмдэглэл хийж нөхөж байсан бөгөөд тэмдэглэл хийхийн ач холбогдлыг тайлбарлаж: "Санаандаа орсноо болон үзсэн харсанаа бичиж тэмдэглэж авах нь худалдаачин хүн эд бараандаа тооллого хийхтэй адил юм. Түүнийг хийхгүй бол өөрийн дэлгүүртээ юу байгаа, юу байхгүйг огт мэдэхгүйтэй адил биз дээ" гэжээ.

## ***5.Итгэл хүч болдог***

Бусдад хүлээн зөвшөөрөгдөлгүй байсаар халуун чулуу долоосон хүн агуу хүмүүсийн дунд олон. Гэвч агуу хүн, бусдын үнэлэлт сэлтийг тийм ч ихээр тоодоггүй. Өөрийнхөө хувь нэмрийг чин үнэнчээр гүйцэтгээд сэтгэл нь ханавал, тэдний хувьд зүйрлэшгүй баяр хөөр болж байдаг. Вильям Харвей цус биеийн дотор эргэлдэж байдаг гэсэн баримтыг анх нээсэн эмч билээ. Тэрээр энэхүү тайлбарыг нийтэд зарлах хүртлээ найман жил гаруй судалж, бэрх төвөгтэй туршилтыг дахин дахин хийж өөрийнхөө нээлтийн зөв болохыг баталсан юм. Гэлээ ч тэрхүү тайлбар тэр цагийн эрдэмтдийн ертөнцөөс улангассан эсэргүүцэл хүлээнэ гэдгийг тэрвээр багцаалдаж байсан бололтой. Харвей удалгүй өөрийн нээлтийг нэг ном болгон нийтлэв.

Тэрхүү илтгэл хэллэг нь хүртэл эеврүү агаад илтгэлийн гол утгыг хялбар тайлбарлаж, сэнхрүүлэх чадвараар баялаг байв. Гэсэн хэдий ч түүнийг зөвхөн тохуурхлын дуу хоолой хүлээж авсан юм. Түүний тайлбар нь галзуу солиотой луйварчны чалчаа үг гэж тооцогдон зүйл дуусчээ. Хэсэг хугацаанд Харвейн тайлбарыг дэмжих хүн нэг ч гарсангүй. Түүний чихэнд хүрч буй бүхэн нь доромжлол, доог тохуу л байлаа. Тэрээр эртнээс нааш гүн хүндэтгэн үзэж байх ёстой анагаах ухааны сүр хүчинд эргэлзээ төрүүлсэн мунхаг мугуйд этгээд хэмээгдэж, түүний тайлбар Библийн судрын бишрэл итгэлийг эвдэж, ёс суртахуун хийгээд шашин шүтлэгийн үр үндэс сэлтийг ч эвдлэх зүйл хэмээн буруутгагдсан байна.

Харвей эмчийн ажлаа ч санаснаараа хийж чадахгүй болов. Найз нөхдийн ихэнх нь түүнийг орхин оджээ.

Түүнээс хойш нэлээд хэдэн жилийн дараа сэтгэлгээний сайн мууг ялгадаг хүмүүсийн дунд түүний тайлбар бага сагаар анхаарал татаж эхлэсэн байна. Харин цусны циркуляци шинжлэх ухааны батлагдсан үнэн болж, нийтэд хүлээн зөвшөөрөгдөх хүртэлээ хорин таван жил шаардагдсан билээ.

## ***Бодоод суулгүй туршаад уз***

Харвейгээс дутахгүй халуун чулуу долоосон нь цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх аргыг нээж, түүнийгээ хүмүүст түгээн дэлгэрүүлэхийг хүссэн Эдвард Женнер билээ. Тэр цаг үед, хэзээний үхрийн бодоо өвчин байдаг нь мэдэгдэж, Женнерийн төрсөн нутгийн саальчин хүүхнүүдийн дунд "үхрийн бодоогоор өвчилсөн хүнд цэцэг өвчин тусдаггүй" гэсэн яриа өргөн тархсан байлаа. Харин анагаах ухааны ертөнцөд тэрхүү тайлбар ор үндэсгүй, дэмий ярианаас хэтрэхгүй хэмээн нэгэнт шийдэгдсэн, хэн ч тэрхүү үнэнийг баталж үзье гэсэнгүй. Женнер ч тэрхүү асуудалд анхаарлаа хандуулах болсон нь тохиолдлын учралаас болсон ажээ. Залуудаа тэрээр Содбелид эмчийн туслагч болж эрдмийн ажилдаа шамдаж байсан бөгөөд, тэнд тосгоны нэг охин хааяа үзүүлэхээр ирдэг байлаа. Эмч түүнийг цэцэг өвчтэй гэж оношлоход сайхь охин гайхсан мэт хүзүүгээ гилжийлгээд "Цэцэг өвчин гэжүү?, тийм учиргүй байх аа. Яагаад гэвэл би, үхрийн бодоо өвчин тусч байсан удаатай юм чинь" гэжээ.

Охины үг Женнерийн зүрхийг зүүгээр хатгах мэт болов. Тэгээд тэрхүү асуудлыг шууд судлан шинжлэхээр шийдэж, ажиглалтаа хийж эхэлжээ. Женнер үхрийн бодоод, хүнийг цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх ямар нэгэн зүйл байгаа юм биш биз гэсэн санааг хамтрагч эмч нартаа хэлсэн байна. Гэвч цаадуул нь эл саналыг нь сонсоод инээлдэж байсан төдийгүй, бүр тийм үл гүйцэлдэх тайлбар дэгдээгээд хамтран зүтгэгчдээ эвгүй байдалд оруулаад байх юм бол эмчийн ертөнцөөс хөөхөөс өөр аргагүй гэж түүнийг буруутгаж байв. Түүний дараа Женнер Лондон явж, нэрт эмч Жон Хантерт очиж шавь оржээ. Тэр явдал түүний хувьд туйлын азтай хэрэг байв. Хантерт өөрийн бодлоо ярихад тэрхүү нэрт анатомич: "Бодоод суугаад байлгүй, туршаад үзэгтүн. Харин тэвчээртэйгээр, бат ноттой хийж үзэх нь чухал шүү" гэжээ.

Женнер энэхүү чин сэтгэлийн үгэнд зоригжсон байна. Шинжлэх ухааны судалгааны утга чанар чухам юу вэ? гэдгийг Хантерийн үгийг сонсч байж гүн гүнзгий мэдсэн ажээ.

Тэрээр нутагтаа буцаж ирэв. Эмчийн ажлаа хийхийн хамт, хорин жилийн турш цэцэг өвчнөөс сэргийлэх судалгаагаа үргэлжлүүлсэн ажээ. Тэрээр өөрийн нээлтийнхээ зөв гэдэгт итгэж байснаас гадна, хүүдээ гурван удаа вакцин тарьж туршив.

Ингээд удалгүй судалгааны үр дүнгээ дэлгэрүүлэх цаг ирлээ. Женнер хорин гурван хүнд урьдчилан сэргийлэх туршилт хийн амжилт олж, цэцэг өвчний халдвараас сэргийлж чаджээ. Түүнийгээ далан хуудастай ном болгон нарийн тодорхой сийрүүлж, 1798 онд гаргажээ. Цэцэг өвчний вакцины тухай нэн тодорхой ойлголттой болж эхэлсэн нь 1775 он гэвэл хорь гаруй жилийг энэ судалгаанд зориулсан байна.

### *Хөндийн замаар алхаж яваа мэт чимээгүйхэн амьдрал*

Женнерийн нээлт яаж байж хүлээн зөвшөөрөгдөх болов? Эхлээд үл ойшоогдож, тун удалгүй яс хугарам эсэргүүцлийн үгсээр булагдаж байв. Цэцэг өвчний вакцины үр ашгийг тайлбарлаж түүнийг дэлгэрүүлэхээр Лондонг зорьсон Женнер тэр цагийн анагаах ухааны ертөнцөөс хоосон ам өмхөж, гурван сар шахам дэмий чармайлт гаргавч тэр болгондоо нутаг орондоо буцахаас өөр замгүйд хүрдэг байлаа.

Түүгээр зогсохгүй Женнерийн эрмэлзлэл хүмүүсийн дунд гуйвуулагдан тархаж, хов жив хийгээд гүтгэлгээр гутаагдаж байв. "Тэр муу золиг, үхрийн сүүнээс гардаг өвчний нянг хүний биенд суулган, хүнийг "адгуус мал" болгон тамд унагаахаар зэхэж байна гэнэ" гэж байлаа. Малчид вакциныг "шулмын нэг төрлийн увидас" хэмээн эсэргүүцнэ. Вакцин хийлгэсэн хүүхэд "царай нь үхэр шиг болж хувирдаг гэнэ", "дух нь хавдаад эвэр ургадаг гэнэ", "дуу хоолой нь хүртэл үхэр мөөрч байгаатай ав адилхан болдог гэнэ" гэх мэт эцэс төгсгөлгүй цуу яриа энд тэндгүй тархжээ. Нэг тосгонд хамгийн анх Цэцгийн вакцин хийлгэсэн эрэгтэй хүнийг гадаа явж байхад тосгоны хүмүүс чулуу нүүлгэж, гэр лүүгээ зугатааж орохоос өөр аргагүй болж байсан гэнэ.

Гэлээ ч Женнерийн аргад лавтай үр өгөөжтэй зүйл байсан тул, ийнхүү эсэргүүцлээс хамааралгүй цэцгийн вакцинд итгэдэг хүмүүсийн тоо удалгүй өсөв. Хоёрын зэрэг язгууртан эмэгтэйн нэр хожим хүмүүст ам дамжин яригдаж, их хүндлэлийг хүлээсэн билээ. Яагаад гэвэл тэд зориглон өөрийн хүүхдүүдээ цэцгийн вакцин хийлгэсэн ажээ. Язгууртан давхрааны иймэрхүү үйлдэл тэр цагийн завхралыг арилгах үүд хаалга болж өгсөн байна.

Ийнхүү анагаах ухааны ертөнцөөс үлээх хорт салхи бага багаар хувирах болов. Цэцэг өвчний вакцин чухал гэдгийг хүлээн зөвшөөрөөд эхлэнгүүт Женнерийн үр дүнг завших гэсэн эмч хүртэл гарчээ. Гэвч эцсийн дүнд Женнерийн нотолгоо ялж, тэр цэцэг өвчний вакциныг анх нээсэн хэмээн олон түмнээс хүндлэл хүлээх болсон байна.

Женнер амжилтын оргилд хүрснийхээ дараа ч хувь муутай, алдар нэргүй үеийнхээ номхон хүлцэнгүй байдлыг алдахгүй байдаг байлаа.

"Лондонд шилжин суурьшиж, эмчээр ажилла, жилийн орлого чинь баараггүй нэг түмэн фунт" гэж түүнд хэлэхэд тэрээр эрс эсэргүүцэв.

"Залуу байхдаа би хөндийн замаар алхаж буй мэт чив чимээгүй, илүү дутуугүй амьдралыг хүсч ирсэн билээ. Гийм мөртлөө өтөл настай өнөө цагт яаж өөрийн биеэ өндөр газар луу өгсөөн хөтлөх билээ дээ. Баян чинээлэг хийгээд нэр, алдрыг хүсэх нь миний дуурайхуйц амьдрах арга биш байхаа" гэсэн гэдэг.

### *Хичээнгүй хийгээд төлөв даруу амьдрах*

Чарльз Белл мэдрэлийн системийн талаар шинээр шинжлэх ухааны тайлбар хийсэн бөгөөд тэрээр хатуу тэвчээртэй, нугарашгүй хүн байлаа.

Мэдрэлийн үйл ажиллагааны тухайд тэр үед янз бүрийн тайлбар үй олон байвч, энэ салбарын судалгаа гурван мянган жилийн өмнө эртний Грекийн Демокрит, Анаксагорын үеэс бараг урагш дэвшээгүй байсан нь тодорхой байлаа.

Белл олон жилийн турш, анхааралтай, нарийн нягт туршилт дахин давтан хийж, 1812 оноос хойш судалгаандаа тулгуурлан өөрийн байр сууриа цуврал илтгэлээр илэрхийлж иржээ. Тэрхүү илтгэлд бүдүүлэг биет амьтнаас амьтдын ертөнцийн хаан- "хүн"-ийг хүртэл мэдрэлийн системийн хөгжлийг нягт нямбай судлаж, тов тодорхой тайлбарлажээ .

Беллийн нээсэн баримт ийм юм: нугасны мэдрэлд хоёр хөдөлгөөн байдаг. Тэр нь нугасны хоёр үндэснээс үүсдэг. Нэг талын үндэснээс үүссэн мэдрэл хүний сэтгэхүйг дамжуулж, нөгөө талаас үүссэн мэдрэл нь мэдрэхүйг дамжуулдаг байна.

Белл энэхүү санааг дөчин жилийн турш сэтгэлдээ хадгалсаар 1840 онд хамгийн сүүлийн илтгэлээ Английн шинжлэх ухааны хүрээлэнд өргөн барьжээ. Гэвч тэрвээр Харвей, Женнер нарын адил доог тохуу, эсэргүүцлийн угаал хүртсэн байна.

"Дараа дараалан илтгэлээ гаргахын хэрээр эмч хэмээх нэрээ хадгалахад бэрх түвэгтэй болж, нэг мэдэхэд нэг ч өвчтөн ирэхгүй болсон байв" гэж хожим бичиж үлдээсэн байдаг. Гэвч түүний онолын үнэ цэн хүлээн зөвшөөрөгдөх болоод ирмэгц "би ч энэ тайлбарыг анх нээсэн юм" хэмээн шаардах хүн дотоод, гадаадад гэнэт олноороо үзэгдэх болсон гэдэг. Харин юутай ч Беллийн амжилт эцсийн эцэст шинжлэх ухааны баталгаатай тайлбар мөн хэмээгдэж бүрэн төгс хүлээн зөвшөөрөгдсөн билээ.

Амьсгал хураахынхаа өмнөхөн, алдарт биологич Кюбиер өөрийнх нь нүүр нэг тал руугаа татваганан мурийхыг хуруугаараа заан асрагчдаа "Хараач хөөе! энэ шинж тэмдэг Беллийн онолын зөв гэдгийг баталж байна" гэж хэлсэн гэдэг.

Одон оронч Вильям Харшел-ийн амьдрал ч дуусашгүй хичээл чармайлтаас бүтсэн билээ.

Германы ядуу хөгжимчний гэр бүлд төрсөн Харшел залуудаа Англид очиж, цэргийн хөгжмийн салаанд орж, цоор хөгжим үлээдэг байв. Түүний хөгжмийн авъяасыг удалгүй нэгэн эмч мэдээд, түүний гэрт очдог болов. Харшел концертод хийл тоглож, сүмийн найрал хөгжимд оролцох зэргээр орлого олж, завтаа цагтаа эмчийн гэрийн номын санд шамдан хичээллэдэг байлаа.

Тэр үед одон орны нээлт удаа дараалан гарч Харшел ч энэ шинжлэхуааныг ихээхэн сонирхох болов. Эхлээд найзаасаа жижиг дуран авай зээлж авсан бөгөөд удалгүй тэр нь шаардлагын хэмжээнд хүрэхгүй болж, бүр том дуран авай хэрэгтэй болжээ. Гэвч авъя ч гэсэн өндөр үнэтэй учир аргагүй байдалд орж гар хийцний дуран авайг өөрөө бүтээе гэж бодох болжээ.

Дуранд тусгалын толь хамгийн чухал агаад гүвгэр талын металл толийг бүтээхэд өндөр технологи хэрэгтэй байдаг. Харшел цуцалтгүй хөдөлмөрлөсний үр дүнд диаметр нь таван фут-ийн тусгалтай толь бүхий дуран авайг бүтээж, Санчирын тойрог болон түүний дагуул одыг ажиглаж тооцоолоход амжилт олжээ.

Харшел энэ амжилтдаа сэтгэл ханалгүй цаашлан асар том дуран авай бүтээхийг оролдох болов. Диаметр нь долоон фут-ийн тусгалын толь бүтээхийн сацуу, санаанд хүрснээ хийх хүртлээ мянга нэг зуун ширхгийг туршин бүтээсэн гэдэг. Түүгээр үл барам амьдралынхаа салшгүй хэсэг болсон хөгжмөө орхисонгүй. Концертод үедээ завсарлагын цаг болонгуут тайзаа орхиж, дуран бүтээж буй газраа эргэн ирж ажиллаад цоороо үлээх ээлжээ дөхөнгүүт буцаж очдог байжээ.

Ийнхүү урт удаан жилийн хичээл зүтгэлийн үр цэцэглэж, Харшел удалгүй нарны аймгийн долоо дахь гариг Тэнгэрийн ванг нээсэн байна. Тэрээр энэхүү гаригийн хөдөлдөг зам хийгээд хөдөлгөөний хурдыг нарийвчлан тооцож, үр дүнгээ Английн шинжлэх ухааны академид илтгэв. Жирийн цоор хөгжимчний нэр гялалзан гэрэлтэх болж, 3-р Жорж-ийн хүндлэлийг хүлээжээ.

Харин Харшел алдар цуутан болсон ч, алдар нэр олоогүй байсан үеийнх шигээ элгэмсэг хийгээд төлөв даруу зангаа ер хувиргаагүй гэдэг.

Бэрхшээлийг гэтлэн давж ялаад агуу их амжилт олсон энэ мэт хүмүүсийн жишээ эрт эдүгээгийн түүх намтар бичлэгт ч цөөхөн буй за.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

### Ажил хөдөлмөр

*Өөдлөх хуслийн өмнө хаалт байдаггүй*

#### 1.Өөрийгөө боловсруулахуй

Аугаа их урлаг бусад салбарын нэг адил чөмөг дундрам хүчин зүтгэлийн дүнд буй болдог. Гайхамшигт уран зураг ч, чансаатай уран баримал ч аль аль нь тохиолдлын бүтээлээс эрс өөр юм. Уран бүтээлчийн гаршиж мэргэшсэн бийрний таталт, хурдан шалмаг ажиллагаа нь хэдийгээр тэнгэрлэг авъяас гэж хэлж болох боловч, яах аргагүй тасралтгүй боловсорсны үр дүн билээ. Зураач Леонорс ч иймэрхүү үзэл бодолд итгэж иржээ. "Гайхалтай урлагийн бүтээл нь гоц авъяас, төрөлхийн билгийн нүд, бурхан тэнгэрээс хайрласан хишиг зэрэг үгээр илэрхийлэгддэг боловч угтаа бол зохиогчийн нөр их зүтгэлийн хүчээр бүтдэг зүйл болой" гэж өгүүлсэн байдаг. Бас тэрээр нэгэн захидалдаа "Уран зурагт ч тэр, бусад ямар ч урлагт ялгаагүй, төгөлдөр бүтээл бий болгоё хэмээн шийдсэн л бол, үүрийн гэгээнээс үдшийн бүрий болтол бүхий л оюун санаагаа тийш нь цутгахгүй бол болохгүй" гэжээ.

Бас өөр нэг тохиолдолд "Уран бүтээлч болж бусдын өмнө нуур улайхгүй явъя гэвэл, санаа бодлоо нөгөө тийш хандуулахгүйгээр өглөө ч, өдөр ч, шөнө ч нэгэн үзүүрт сэтгэлээр бүтээл рүүгээ чиглүүлэх ёстой юм. Үүнийг зугаа цэнгэлийг аль эрт огоорч, нямба барих гэж нэрлэвэл илүү зохилтой" гэж бичсэн байдаг. Мэдээж хэрэг, төрөлхийн авъяасгүй хүн хичнээн хүчээ шавхан зүтгэж үзлээ ч гайхамшигтай уран бүтээлч болж чадахгүй. Авъяасыг тэнгэрийн харьяат гэж үзвэл тэрхүү авъяасыг уудлан гаргаж, төгөлдөржүүлэх хүч нь өөрийгөө боловсруулах арга юм. Харин бүх хүмүүст эрх тэгш бололцоо олгож байдаг сургуулийн сурган хүмүүжүүлэхээс энэхүү өөрийгөө боловсруулах арга нь авъяасаа хөгжүүлэхэд хавьгүй илүү хэрэг болох юм гэж хэлэхэд илүүдэхгүй.

Уран бүтээлч хүн нэр алдар олох нь ерөөс аз хийгээд тохиолдлын хүч бус, нөр их оролдлого, хичээл зүтгэлийн үр дүн мөн.

Уран бүтээлчдийн дунд алдар нэрээрээ эд баялагт хүрсэн хүн бий боловч, зөвхөн эд баялаг тэдний гол зорилго болох явдал ховор. Үнэн хэрэгтээ уран бүтээлч хүн залуугаасаа эхлэн өөрийгөө хөсөр хаятлаа бүтээлч үйл ажиллагаанд зүтгэж байдаг бөгөөд зөвхөн мөнгө хүсэх хүн иймэрхүү бэрх хөдөлмөрөөр дүүрсэн амьдралыг туулахгүй нь лавтай. Урлагийн сүнсийг нэхэмжлэгч нь баяр баясгалан бөгөөд тэрхүү баяр баясгаланг олох төдийд уран бүтээлч хүн сэтгэл нь бүрэн дүүрэн ханадаг. Эд баялаг нь хааяа түүнд бараа болох тохиолдлоос ер хэтэрдэггүй.

Өөртөө итгэлтэй уран бүтээлчдийн олонхи нь өөрсдийн тэнгэрлиг авъяасын зоргоор амьдардаг агаад хүмүүсийг аялдан дагалдах дургүй. Испанийн зураач Либела өндөр алдар хүнд, эд баялаг олсон хойноо ч тансаг амьдралд хордохоос дургүйцэж урьдынхаа ядуу буурай амьдралдаа эгэн очиж уран бүтээлээ туурвиж байсан гэдэг.

Бас алдарт Микеланжело мөнгөний төлөө зураг зурж буй зураачийн тухайд юу хэлэх вэ? гэсэн асуултад хариуллахдаа: " Яаж ийгээд баян чинээлэг болохсон гэсэн хүслээ хаяхгүй байх тусам уран бүтээлчийн хувьд цааш хол ахих зам нь хаагдана" гэжээ.

## **"Би одоо ч суралцаар л байна"**

Өмнө өгүүлсэн зураач Леонорстой нэгэн адил Микеланжелло ч оролдлого зүтгэл нэн чухал гэдэгт хатуу итгэж ирсэн билээ. Сэтгэлийн хөдлөлөөсөө шалтгаалж, цүүцээ чөлөөтэй эзэмших хүртэл дадал сууж чадвал толгойдоо орж ирсэн бодлоо том чулуунд тэр хэвээр нь илэрхийлж чаддаг болно гэж тэр хэлдэг байв. Микеланжелло цуцахаа мэдэхгүйгээр уран бүтээлдээ улайрдаг хүн байв. Тэрээр тухайн үеийнхээ уран бүтээлчдийн хэнээс нь ч илүү удаан цагаар ажилладаг байсан бөгөөд энэ нь түүний эгэл даруухан амьдралын дадал хэвшлийнх нь ач байлаа.

Бараг бүх л өдөржингөө бүтээлтэйгээ зууралдах Микеланжеллод хэрэгтэй гэж үздэг зүйл нь нэг зүсэм талх, нэг хундага дарс төдий байв. Орондоо орлоо ч голдуул шөнө дунд босч, ажлаа үргэлжлүүлнэ. Тэр үедээ зузаан цаасан малгай дээрээ лаа хавчуулаад гэрэл гаргаж, тэр малгайгаа өмсөөд сийлбэрээ гэрэлтүүлж, цүүцээр засч эхэлнэ. Ядарвал хувцастайгаа зүүрмэглэж, ядаргаагаа гарвал тэр даруй ажилдаа эргэж ордог ажээ. Микеланжелогийн өөрийнх нь хайртай бүтээлүүдийн нэгэнд элсэн цаг гартаа барьсан өвгөн хүн тэргэнцэр дээр сууж буй сийлбэр орох бөгөөд уг элсэн цагдээр "би одоо ч суралцаар байна" гэсэн үг сийлээстэй байдаг.

Уран бүтээлчийн агуу их бүтээлийг үзлээ ч түүнд шингэсэн хүчтэй тэвчээр бүхий хичээл зүтгэл хийгээд он удаан жилийн нөр хөдөлмөрийн ул мөрийг мэдрэх хүн цөөхөн. Мэдээжээр тэдгээр бүтээл хялбархан, богинохон хугацаанд бүтээгдсэн мэт бодогддог. Гэвч түүний цаана уран бүтээлчийн төсөөлөхийн аргагүй зүдэргээ оршиж байдаг билээ.

Нэг өдөр Микеланжелогийн урланд нэгэн язгууртан ирж, өөрийнхөө цээж баримлыг бүтээж өгөхийг хүсчээ. Тэрээр арав хоногийн дотор түүний баримлыг дуусгаад тавин ширхэг алтан лэвсгэрт төлөхийг хүсчээ. Язгууртан "арав хүрэхтэй үгүйтэй хоногт бүтээсэн бүтээлийн тухайд ёсноос гадуур их мөнгө байна даа" хэмээн ундууцав.

Микеланжелло хариуд нь: "Ноёнтон, та нэг зүйл мартагнаад байна уу даа. Цээж баримлыг аравхан хоногт бүтээдэг болох хүртлээ суралцахын тулд миний бие гучин жил зарцуулсан юм шүү гэдгийг..." гэжээ. Түүний энэхүү үгнээс харахад урлаг угаас хүний амьдрал өөрөө мөн бөгөөд амжилтынх нь нөхцөл түүн дотор нуугдаж байдаг болой.

## ***Зовсны эцэст ялж дийлж олсон зүйл л жинхэнэ байдаг***

Төрөлхийн билэг авъяастай төрсөн хүнд ч урлагийн хүрээгээ тэлэхэд нь урт удаан жилийн тасралтгүй хичээл зүтгэл хэрэгтэй. Балчир бага насандаа тэнгэрийн хүү хэмээн нэрлэгдэж байгаад, түүний дараа авъяасаа сэлбэхээ алгуурлаж, эцэст нь "жирийн хүн" болж хувирсан жишээ олон бий. Үүний томоохон жишээ нь зураач Бенжамин Вэст билээ. Тэрээр ердөө долоохон насандаа эгчийнхээ дүүжин орон дээр унтаж буй хүүхдийг хараад, түүний үзэсгэлэнтэйд сэтгэл хөдөлж, яаран цаас бэлдэж, нялх хүүгийн царайг зурж эхэлсэн гэдэг. Энэхүү багахан зүйлээр түүний уран бүтээлчийн авъяасын тухай дэлхий даяар шуугиж, гоц авъяастай жаал хүүгийн алдар нэр хангалттай өсчээ. Харин хэтэрхий эртэдсэн амжилт жаал хүүгийн ирээдүйд гарзтай ҮР дүн авчирсан байна. Тэгээгүй бол тэрээр агуу их зураач болох байсан нь дамжиггүй.

Лавтай тэрээр ихээхэн нэр алдартай байсан боловч түүнийгээ эрдэм болгон, турших алдахын зүдүүрийг туулж байж олж аваагүй билээ. Тиймээс эцэст нь тэрхүү нэр алдар удаан үргэлжлээгүй тэгсгээд дууссан ажээ.

Нөгөө талаар, хар бор орчинд өсч бойжлоо ч түүндээ сөхрөлгүй оролдож хичээсээр агуу их ур ан бүтээлч болсон хүн олон бий.

Францын зураач Клауд Лорран хөдөөгийн ядуу гэр бүлд төрж, эхлээд нарийн боовчныд шавиар оржээ. Түүний дараа сийлбэрчин байсан ахаасаа сийлбэрийн технолог сурч, тэндээс улмаар уран бүтээлийн гараагаа эхэлжээ.

Нэг өдөр явуулын нэгэн худалдаачин Клаудын авъяасыг олж харж, түүнийг Итали руу дагуулж явах хүсэлтэйгээ хэлж ахыг нь ятгажээ. Тэрээр ахаасаа зөвшөөрөл авч Ром руу гарч, зураач Агостина Ташшийн гэрт зарцаар суух болов. Ташш-аар байгалийн зургийн эрдэм заалгасан Клауд удалгүй өөрөө бүтээлээ гаргаж эхлэлээ. Үүний үрээр олон орноор явж, зургийн авъяасаа тордсон байна. Ийнхүү Клауд олны анхаарал татах болж, түүний алдар нэр Европ даяар түгжээ.

Клауд байгалийн янз бүрийн илэрхийллээс зургийнхаа амин сүнснийг олж авах дасгалыг цаг ургэлж хийж иржээ. Өдрийнхөө ихэнхийг байшин барилга, газар, мод зэргийг зурж өнгөрүүлэх нь олонтоо байлаа.

Өглөөний нарнаас үдшийн бүрий болтол тэнгэрийг ажиж, нүүгээд өнгөрөх үүлсийн хувирал хийгээд нарны гэрлийн цацрах байр байдал сэлтийг ажигладэг байлаа.

Ийнхүү цаг ямагт дасгал сургууль хийсний ачаар Клауд бага багаар зургийн чадвар хийгээд билгийн хараагаа өргөжүүлж, улмаар "хамгийн дээд байгалийн зураач" хэмээх алдар хүндийг хүртсэн билээ.

### *Цаг ямагт хамгийн сайнд хүчээ зориулж, алхам алхмаар урагшлаарай*

Байгалийн зураач Тигпег "Английн Клауд" хэмээн нэрлэгдэж ирсэн бөгөөд, бүтээлийн онцлог нь язгуур шинждээ бус түүний амьдралдаа хөлөө олж өндийж ирсэнтэй нь ижилсэх тал ихтэй байдаг. Turner бас л ажил хийж мөнгө олж, суралцсаны эцэст алдар нэр олсон уран бүтээлч билээ.

Түүний эцэг нь Лондонд үсчний газар эрхэлж байсан учир, тэрээр хүүхэд байхаасаа ажилд нь тусладаг байлаа. Нэг өдөр тэрээр мөнгөн цар дээр сийлэх хээний загвар хийж байхад нь нэгэн үйлчлүүлэгч тааралдаад тэрхүү зурагны сайхан болсныг сонирхож, зургийн авьяасыг нь хөгжүүлж үзвэл яасан юм бэ? хэмээн эцэгт нь зөвлөжээ. Энэ явдлаас санаа авч Turner зургийн зам руу хөл тавьсан ажээ.

Залуу уран бүтээлчдийн дийлэнх нь зам зуураа олон бэрхшээлтэй тулгардагтай нэгэн адил Тигпег ч тэр жишгээс тойрсонгүй. Түүгээр барахгүй тэрээр ядуу байсан тул зовлон бэрхшээл бүр ч их байлаа. Тэрээр зураг урлахын зовлонг тоолгүй, ясаа гартал боловсрохуйд зүтгэв.

Бусдын зургийг будаж өгөх мэтийн ажил байсан ч зөвшөөрч нэг оройдоо хагас крон олж, түүгээрээ оройн хоол иддэг байлаа. Тэрээр ийнхүү мөнгө олохын зэрэгцээ мэргэжлийн технологи эзэмшиж байв. Бас аяллын хөтөлбөр болон хэвлэлийн газрын хүсэлтийг зурж, номын зургийн ажлыг ч хүлээн авч, түүгээрээ өчүүхэн бага мөнгө олдог байлаа. "Тэр үед, үүнээс өөрөөр явах зам надад байсан болов уу? Энэ л миний хийж чадах хамгийн сайн дасгалын арга байсан юм" гэж хожим өгүүлж байжээ.

Тэрээр өөрт нь таарч тохирохгүй ажлыг ч анхааралтай хянамгай гэгч нь хичээнгүй хийдэг байв. Цаг ямагт хамгийн сайнд хүчээ шавхаж өмнө хийснээсээ нэг хоёр алхмаар урагшилсан зүйлийг зурж бүтээе хэмээн чармайсан юм. Түүнтэй адилхан ажил хэрэгт хичээнгүй хандвал хэн ч гэсэн нүдэнд нь харагдсаар буй өсөлт дэвшилтэд хүрэх нь дамжиггүй.

Turner-ийн зургийн авьяас ийнхүү өсч дэвжсэн юм. Харин түүний тухай үүнээс илүү магтах нь илүүц байж магад. Яагаад гэвэл, бидний үед хадгалагдаж үлдсэн түүний бүтээлүүд түүний алдар нэрийн багтай хөшөө дурсгал болж байгаагаас тэр билээ.

### *2.Өөрийгөө эзэмдэх сэтгэлийг ургуулж тордох тухайд*

Сийлбэрчин Жон Флексман Лондонд гөлтгөнө (гипс) эдлэлийн жижиг худалдаачны гэр бүлд төржээ. Бага байхаас өвчинд ээрэгдэж, дэлгүүрийн лангууны сүүдэрт нуруун дороо дэр ивэж зураг зурах, ном унших зэргээр цаг өнгөрөөж суудаг байв.

Нэг өдөр Флексманд үнэн алдартны шашны нэгэн лам Хомер-ын шүлгүүд хийгээд Сервантес-ийн "Дон Кихот" номыг уншуулахаар өгчээ. Тэрээр ялангуяа Хомерын бүтээлийн бүх ботиудыг шимтэж баатарлагийн үзэлд сэтгэл татагдан баатруудынх нь дүрийг бүтээе хэмээн сэтгэл шуударчээ. Гэтэл түүний анхны уран бүтээл нэлээд эв хав муутайхан болсон гэнэ. Гэвч хүүгийнхээ бүтээлээр бахархсан аав нь нэгэн сийлбэрчинд үзүүлтэл тэрхүү алдартай сийлбэрчин маань "хн, хн" хэмээн хамар дотроо дуугарахаас өөрийг үзүүлсэнгүй нүүр буруулан оджээ.

Харин Флексман хүүд уран бүтээлч хүнд байх шилдэг чанарууд бүрдсэн байв. Өөрөөр хэлбэл хичээл зүтгэл хийгээд тэсвэр тэвчээр гэх мэт. Тэрээр тээнэгэлзэх юмгүй уншиж судласаар бас зураг болон сийлбэр бүтээхээр чармайж байлаа. Түүний эхний үеийн бүтээлүүдээс хэд хэд нь өнөөг хүртэл хадгалагдаж ирсэн бөгөөд-тэдгээр нь гайхалтай бүтээл биш ч гэсэн тэр үеийнх нь агуу их тэсвэр тэвчээртэй хичээл зүтгэлийнх нь ул мөр яах аргагүй тодоос тод үлдсэн байдаг юм.

Түүнд ганцаараа хөл дээрээ босч чаддаг болтол урт удаан хугацаа шаардагдсан билээ. Эхэндээ нарсны мөчрөн таяг тулж дэгэн догон алхдаг байв. Улмаар таягаа орхиж, явдаг болтлоо өсч хөгжсөн байна. Амжилт олохоор шийдэж, хичээл зүтгэлийнхээ үр дүнд итгэлтэй байх тухайд Зураач Дэвид Уилки-ийн амьдрал ч оролдлого зүтгэл, чармайгч төлөвөөр дүүрэн ажээ. Шотландын, үнэн алдартны шашны санваартны гэр бүлд төрсөн

тэрээр бүр багаасаа уран сайхны авьяасаа харуулжээ. Сургууль дээрээ хойрго, тааруухан сурагч мөртлөө, хүнийг зурах болохоороо гайхалтай нямбай болно. Бүрэг дуугайхан бага наснаасаа эхлэн тэрээр эрчимлэг зан чанарыг биедээ нууж байжээ. Тэр чанар нь амьдралынх нь туршид түүний онцлог шинж болсон юм.

Тэрээр цаг ямагт зураг зурах бололцоо нөхцлийг хайж байдаг байлаа. Сүмийн хана, голын захын элс зэрэг нь түүний зорилгоо биелүүлдэг дуртай газар нь байв. Ямар ч зүйл байсан арга эвийг нь олох төдийд зураг зурахад хэрэг болдог аж.

Галын шилээврийн хугархай модоор бийр хийж, зөөлөн чулуугаар дэлгэц хийж, ноорхойг хэдэрсэн гуйлгачинтай дайралдвал шууд л тэр хүн, зургийнх нь сэдэв болно.

Бусдын гэрт очихоороо хананд нь эрээчиж орхидог тул, ханаа хараад нөгөө жаалхүү Уилки ирээд явжээ гэдэг нь төвөггүй ойлгогддог байсан гэнэ. Тэр ч байтугай цэвэр цэмцгэрт дуртай эхнэрүүд дураараа занд нь уурсаж байсан бололтой.

Эцгийнх нь хувьд санваартан хэмээх ажил үүрэг гүйцэтгэх тул, зураач гэх мэт "нүгэл ихтэй" ажилд туйлын дургүй байв. Тийм боловч хүүгийнхээ шийдлийг өөрчлөхдөө тулсангүй, эцэст нь хүү нь зураач болохоор бэрхшээл төвөгтэй өгсүүрзамаар шийр заан авирах болсон билээ.

Тэрээр Шотландын урлагийн сургуульд орохоор санал тавьсан ба бүтээл нь бүдүүн болхи тул учир дутагдалтай гэдэг шалтгаанаар зөвшөөрөгдсөнгүй. Гэсэн ч улам илүү шилдэг бүтээл туурвитлаа хичээн зүтгэсээр удалгүй амжилттай тэнцсэн байна. Элсэн орсноосоо хойш ч түүний ахиц дэвшилт алгуур удаан байсан ч хөрөг зураг урлахаар шимтэж буй түүний өөрийнх нь дүр зураг амжилт олохоор шийдэж, хичээл зүтгэлийн үр дүндээ баттай итгэлтэй

### ***Ажилла! ажилла! бас дахиад ажилла!***

Гоц авьяастайгаа өөрөө хүлээн зөвшөөрдөг залуучуудад өвөрмөц зан төрхтэй нэгэн байхад эрх танхил ч ажилдаа улайрдаг зантай нь ч олон байдаг. Харин Уилки бол тэднээс өөр байлаа. Тэрээр цөхрөлтгүй, тогтвортой хичээн зүтгэсээр ирсэн билээ.

"Миний амжилт төрөлхийн билэг авьяас гэхээсээ илүү, газар мөлхөж буй мэт шаргуу зүтгэлийн үр юм.

Миний зураг сайжирсны шалтгааныг ганцхан үгээр илэрхийлж болно. Өөрөөр хэлбэл шантрахгүй хичээллэсэн учраас тэр юм" гэж тэрээр өгүүлсэн байдаг.

Хожим Уилки Лондонгоос явж хямдхан сууцанд амьдрах зуур "Тосгоны улс төрчид" хэмээх зураг зурсан байна. Энэ зураг сайн үнэлэлт авч, зургийн захиалга ч өсчээ. Гэсэн ч тэрээр урт удаан хугацааны туйлын ядуу буурай амьдралтай эвлэрэхээс өөр аргагүй болсон юм. Учир нь тэрээр зургаа бүтээхдээ хэтэрхий их цаг хугацаа байсан тул тэрхүү зураг нь зарагдлаа ч ихэнхдээ ашиг болж чаддаггүй байлаа.

Үнэндээ, тэрээр нэг ширхэг зураг зурахад урьдчилан сайн судалж, хичээнгүйлэн бэлтгэл хийнэ.

Нэг амьсгаагаар зураад гаргадаг зураг нэг ширхэг ч байгаагүй бөгөөд, олонхи зургаа зурж дуусгахад нэлээд хэдэн жил зарцуулж байв. Зураад дууссан зургийг ч дахин дахин засвар хийж, дараа нь дахин тодруулалт хийгээд арай гэж гараас гаргана. Ингэж л нөр их анхаарч байсан юм.

"Ажилла! ажилла! бас дахиад ажилла!" Энэ бол Уилки-ийн лоозун байлаа. Тэрээр чалчих дуртай уран бүтээлчийг ерөөс үздэггүй байв. Ярихдаа чадмаг хүн үр тарих төдийг бол чадаж магадгүй юм. Гэвч аль ч үед боловсорсон үр жимсийг хурааж авах нь хэл үггүй гуйцэтгэгч маягийн хүмүүс байдаг. "Цаг үргэлж ямар нэг ажил хийж байцгаая" хэмээж тэрээр дэмий чалчих хүмүүсийг буруутгаж, залхуу хүнийг зэмлэж байлаа. Нэг өдөр найздаа ийн ярьжээ:

Уилки Шотландын урлагийн академид сурч байхад, тэр үеийн захирал нь зураач Леонарс-ын үгийг оюутнууддаа сонсгох дуртай байсан гэнэ.

"Та нар билэг авьяастай юм бол хичээл зүтгэл түүнийг чинь улам бататгаж өгнө. Хэрвээ авьяасгүй бол хичээл зүтгэл түүнийг орлох болно", "Тийм учраас л" гэж Уилки үргэлжлүүлэн ярьдаг байжээ. "Би чадлаараа хичээж зүтгээд үзье гэж шийдсэн юмаа. Билэг авьяас үгүй гэдгээ өөрөө түмэнтээ сайн мэдэж байсан болохоороо..." гэжээ.

### ***Сурах эрмэлзлэлээр шатаж яваа хунд хаалт байдаггүй***

Гаслант ядуу амьдралтай ч эр зориг хийгээд тэсвэр тэвчээрээ шавхан гаргаж, түүндээ дөрөөлөн улмаар амжилт олсон уран бүтээлчид олон билээ. Нөгөөтэйгүүр ядуугийн зовлонгоо тэсч чадалгүй хийсч унасан хүмүүс ч цөөнгүй бий. Зураач Жон Мартин ховорхон гэмээр туйлын ядуу амьдралыг биеэрээ туулсан нэгэн билээ. Анхныхаа томоохон бүтээлээ туурвихаар ид ажиллаж байх үедээ тэрээр нэг бус удаа өлсч үхэхийн ирмэгт тулж очиж байжээ. Нэг удаа өөрт нь ердөө ганцхан шиллингийн зоосноос өөр юм байсангүй. Тэр

зоос гайхамшигтай гялгар байсан тул ямагт гараасаа салгалгүй барьж байсан боловч аргаа барсан тэрээр түүгээрээ талх авч идэхээр явжээ. Талхаа аваад буцах гэж байтал дэлгүүрийн хүн гэнэт Мартины гараас талхаа булааж авчээ. Тэгээд төлөхөөр өгсөн мөнгийг нь чулуудаад буцаах нь тэр. Гэрэл ойн гялалзаж байсан өнөөх зоос ядуу зураачид хэрэг болсонгүй. Учир нь тэр хуурамч зоос байсан ажгуу. Оромжиндоо буцаж, тэндээс эрж хайж байж өчүүхэн талхны үйрмэг олж, түүнийг үмхэж өлсгөлөнгөөс аврагдсан гэдэг.

Ийм бэрх нөхцөлд ч Мартин зургаа бүтээхээр улайрч, бүхий л чадлаараа сэтгэлгээгээ шавхаж байлаа. Цөхрөлтгүй хичээн оролдож, бас бололцоог алдалгүй барьж байх зориг түүнд байсан. Хэдэн өдрийн дараа бүтээлээ зарлахад хүмүүс түүний бүтээлийг шагшин магтаж алдар нэр нь түгжээ.

Ямар ч тохиолдолд хичээл зүтгэлээрээ төрөлхийн билэг авъяасаа улам додомдсоор байх ахул, өөрийгөө хамгаалах хүч чадал заавал суудаг байна. Хичнээн аажуу удаан байлаа ч заавал алдар нэр хүрч ирэх нь лавтай юм. Олон агуу их уран бүтээлчидтэй нэгэн адил, Мартины амьдрал ч үүнийг тодорхой харуулж байна.

Уран зураг, барималтай нэгэн адил хөгжимд ч бусдаас цойлон гарахын тулд хичээл зүтгэл болон шаргуу оролдлого нэн чухал юм.

Хендел ядрахаа мэдэхгүй, цөхрөлтгүйгээр ая зохиох гэж зүтгэж байлаа. Ялагдал хүлээж гансрал гутралын байдалд орох тусмаа тэрээр хүчээ улам бүр шавхан дайчилж байлаа. Нэг удаа өрд баригдаж, бэрх ичгүүр гутаал амссан ч, түүнд огт гуньсангүй.

Тэр жилээ тэрээр "Саул" "Египедийн израильхүн", "Драйдений магтуунд зориулсан аялгуу", "Арван хоёр дугаар концерт", "Аргосын Жюпита" дуурь зэргийг зохиосон бөгөөд эдгээр нь цөм түүний оргил бүтээлүүдийн тоонд ордог ажээ. Нэгэн зохиолч Хенделийн тухайд: "Тэрээр юуг ч эрэлхэг зоригтойгоор давж гарч чадаж байв. Хэний ч тусламжийг авалгүй ганцаараа арван хоёр хүний ажлыг хийж гүйцэтгэсэн" гэжээ.

Хайндон өөрийн урлалын тухай: "нэгэн сэдэв зурсхийн орвол эцсийг нь хүртэл түүний араас мөрдөх нь чухал" гэжээ. Моцарт "ажил л миний хэмжээлшгүй баяр баясгалан байдаг" гэж өгүүлсэн байдаг.

Бетховены хэлэх дуртай үгийг доор сийрүүлбэл: "Сурах эрмэлзлэлээр шатсан авъяаслаг, хичээл зүтгэлтэй хүнд "энд хүрээд зогсоё" хэмээх хаалт байдаггүй".

Нэг удаа төгөлдөр хуурч Мошиэлс Бетховенд нэгэн дуурийнхаа төгөлдөр хуурт зориулсан аяны ноотоо гардуулсан бөгөөд түүнийхээ эцсийн хуудасны өнцөгт "Бурхны авралаар эсэн мэнд дуусах болтугай" гэж бичсэн байлаа. Түүнийг нь харсан Бетховен тэр дор нь үзгээ авч түүний доор ийн таталгажээ: "Бурханд найдах нь юу вэ. өөрийнхөө хүчээр өөрийгөө аврагтун".

Энэ үг л уран бүтээлч Бетховены амьдралаараа туулсан, хамгийн ойр дотны уриа лоозун нь болж байсан гэдэг .

## **Зориг хийгээд амьдрах хүч**

*Өөрийн тавилангаар шатаж амьдар*

### **1.Зам үгүй бол замаа бүтээ**

"Өтгөс би бурханд ч, чөтгөрт ч итгэдэггүй. Өөрийнхөө бие хийгээд сэтгэлийн хүчинд л асар их итгэл тавьж явдаг". Энэ бол Скандиновын эртний нэгэн ухаантны хэлсэн алдартай үг юм. Эртний Скандинов хүний сүлд нь зээтүү бөгөөд түүн дээр "Бид зам хайж байна. Зам байхгүй бол замаа бий болгоно" гэсэн цэцэн үгийг сийлсэн байдаг. Энэ нь дээр өгүүлсэн ухаантны үгтэй агаар нэг, билэг танхай сэтгэлийн илэрхийлэл агаад тэрхүү онцлог одоо ч тэдний үр саад уламжлагдсаар ирсэн буй.

Скандиновын домог үлгэрийн хамгийн гол онцлог нь алх барьсан бурхан юм. Ерөөс алхыг яаж барьж буйтай адил яльгүй нэг хөдөлгөөнийг нь хараад л тэр хүний араншинг мэдэж, түүний бие сэтгэлийн хүчийг багцаалдаж болох талтай ажээ.

Нэр алдартай нэгэн зохиолч найзыгаа хөдөө нутагт газар худалдаж аваад тийшээ нүүх гэж байхад нь тэр газрын оршин суугчдын зан төрхийг ганц үгээр шулуухан онож хэлсэн байдаг: "Энэ газрыг худалдаж авна гэдэг анхаарал самбаа шаарданагэсэн үг. Үүнийг эндхийн хүмүүс сайн мэдэж байгаа. Парисаас ирж миний мал эмнэлгийн сургуульд явж байгаа хүн ч бий, хэрэв тэрээр найзтайгаа ирвэл ганц төмөр оронд чинь сэтгэл ханаад тэрсэлдэхгүй. Өөрөөр хэлбэл биеийн хүч ч, сэтгэлийн хүч ч тэдэнд дутагдаж байдаг юм. Тийм хүний амьдардаг газар хичнээн хөрөнгө орууллаа ч тийм хэрэгтэй үр ашгийг горьдолтгүй бизээ" гэж өгүүлжээ.

Иймэрхүү, зан төрхөнд тохирсон таталбарыг юм анхааралтай гэгч ажигладаг хүнээс өөр хэн ч хийж чадахгүй. Дээрх үгнээс "Төр Улсад хүч өгч, хагалж буй газарт нь үнэ цэнэ олгоход тэнд амьдрах хувь хүмүүсийн биеийн болоод сэтгэлийн хүчнээс өөр юм тус болохгүй" хэмээх үнэн тодоос тод харагдаж байна. Өөрөөр хэлбэл Францын зүйр үг ёсоор "газрын үнэ, тэнд суух хүний үнээр шийдэгддэг" ажээ. Амьдрах хүчээ дээшлүүлж, төлөвшүүлэх явдал маш чухал. Үнэ цэнтэй зорилгоор хөөцөлдье хэмээх шийдэл хүний янз бүрийн гайхалтай онцлог шинжийн суурийг бүрэлдүүлж өгдөг. Хэн ч гэсэн амьдрах хүч байвал нэг хэвийн, хүчир ажил эс бөгөөс сонирхолгүй тулга тойрсон аахар шаахар ажилд дарагдалгүй өдрөөс өдөрт өөдөө урагшилж явдаг. Амьдрах хүчээр бялхсан хүн цөхрөх, эрсдэл хүлээхээс айлгүй, жирийн хүн амжуулж үл чадах агуу их ажил хэргийг гүйцэтгэж чаддаг.

Ямар ч салбарт амжилт гаргахад чухалчлагдах зүйл бол, давуу онцгой авъяас гэхээс илүү эрс шийдэл юм. Эцсийг нь хүртэл бүхий л чадлаараа хичээж оролдоё хэмээх шийдлийн хүч чухал юм. Ийм болохоор, амьдрах хүч гэдэг нь хүний зан төрхийн гол цөм болох хүч бөгөөд, энэ цөм дүүрээд ирэх үед жинхэнэ хүн болдог гэж хэлж болох юм.

Амьдрах хүчний улмаас хүн үйлдэл хийж, оюун санаагаа хөвчилсөн хичээл зүтгэлээ эхлэдэг. Тэгээд амьдрах хүчинд суурилж чин үнэн хүсэл эрмэлзлэл үүснэ, өөрөөр хэлбэл хүний амьдралд жинхэнэ үнэрийг шингээж өгөх эрмэлзлэл төрдөг.

Баторь сүмийн дотор булагдсан хагархай дуулганд" хүсэл эрмэлзлэл хүч болдог" гэж сийлээстэй байв. Энэ бол түмэн хүний сэтгэл зүрхэнд сийлэх ёстой үг болов уу. Ширакийн хүү Иеэс "Аймхай хулчгар хүн гамшигт унадаг" гэж өгүүлсэн байдаг. Мэдээж хэрэг зүрх зоригтой хүн шиг хувьтай хүн үгүй. Тухайлбал хичээл зүтгэл нь хөөс шиг ариллаа ч өөрөөсөө хамаарах бүхнийг хийлээ гэж санагдаж л байгаа бол түүгээр сэтгэл нь ханаж чадна. Зовлон бэрхшээлтэй олонтоо шургуу тэвчээртэй тулалдаж ялан дийлсэн хүн хөлнөөсөө цус дуслуулж дөрвөн мөчөө хүлүүллээ ч эр зориг хэмээх таяг тулан алхаж буйг харах шиг биднийг "Хүмүүс" хэмээх сургуульд сурах Геологийн эрдэмтэн Хю Миллер "Миний бие цорын ганц зөв сургааль хүлээсэн нь хүмүүс хэмээх сургууль юм. Тэнд" зовлон бэрхшээл" хэмээх бэрх чанга, эрхэмсэг багштай санаандгүй учирсан билээ" хэмээн өгүүлсэн байдаг. Чармайж зүтгэж явах зуураа гараагаа алдаж, аахар шаахар хэл ам өдөөн, ажлаа хийдүүлэхэд хүрвэл, алдаа мадаг чинь асч буй галнаас илүүтэй гэрэлтдэг юм. Ямар ч ажил байсан түүнээс зугатаж болохгүй хэмээн бодвол ажил удалгүй гарт чинь хялбархан ороод ирнэ.

Зүтгэл оролдлого хэмээх заншил бусад заншилтай адилхан цаг хугацаа өнгөрөхийн хэрээр биенд хялбархан хэвшээд ирдэг. Тиймээс эгэл жирийн чадвараас өөрцгүй ч нэг удаа зөвхөн нэг зүйлд анхаарлаа төвлөрүүлэн хийж дуусгавал том үр дүн гарч ирдэг ёстой.

Паул Бакстон жирийн авъяастай хүнээс илүү жир бусын хичээл зүтгэлтэй хүнд найдвар тавьдаг байлаа. Тэрээр өөрөө "Тийм байх ёстой гэж тангарагласан зүйлдээ бүх хүчээ шавхаж түүнийгээ гүйцэтгэ" хэмээх Библийн сургаалийг эрэгцүүлдэг байснаас тэр юм. Бас тэрээр өөрийнхөө амжилтын тухайд нэг удаа нэгэн зүйлд бүхий л хүчээрээ босч сөрсний л ач юм гэж өгүүлдэг байжээ.

Үнэхээрийн үнэ цэнтэй зорилтыг бол баатарлаг зоригтойгоор барьж авахгүйгээр биелүүлж чадахгүй. Хүний өсөлт хөгжилт бэрхшээлтэй тулалдах зоригийн хүч, өөрөөр хэлбэл оролдлого зүтгэлээс хамаарч байдаг. Нэг хараад бололцоогүй гэж бодогдох зүйлийн ихэнх нь оролдлого зүтгэлээр бололцоотой болохыг хараад бид ихээхэн гайхдгийг үгүйсгэж боломгүй.

Найдлага тавих сэтгэл хүчтэй байвал зөвхөн түүгээр боломж бодиг байдал болон хувилдаг. Хүчтэй хүсэл горьдлого нь бид ямар нэг юмыг хийж гүйцэтгэхийн совин болдог. Гэтэл аймхай хулчгар агаад эргэж хургасан хүн эхнээсээ ямар нэг зүйлийг өөрөө өөртөө бололцоогүй гэж бодчихдог тул нэг ч ололтод хүрч чаддаггүй.

Францын залуу офицер үргэлж л өрөөн дотуураа холхиж "хэзээ ч юм, заавал хуурай замын цэргийн маршал болчихоод үзүүлээд өгнө дөө" гэж чанга дуугаар хэлдэг байсан гэдэг. Залуу офицерын дийлдэшгүй мөрөөдөл удалгүй бодит биеллээ олжээ. Хожим нь тэрээр командлагчаар дэвшиж нэрээ дуурсган цаашлаад үнэхээр мөрөөдлийнхөө дагуу Францын хуурай замын цэргийн маршал болж, амьдралаа өнгөрүүлсэн гэдэг.

## ***2.Өөрийгөө залах "зоригийн хүч"***

Зоригийн хүч л байвал хүн өөрийнхөө шийдсэн ёсоор зорилгоо гүйцэтгэж, өөрийнхөө тийм байх юмсан гэж бодсон ёсоор тийм хүн болж чаддаг. Нэгэн ухаантан дандаа ийн өгүүлдэг байжээ:

"Та хүсвэл ямар ч хүн болж болно. Бидний зоригийн хүч бурхны хүчтэй холбогддог тул түүний үр дүн туйлын их. Чин сэтгэлээсээ буурь суурьтайгаар түүнийг нэхэмжилж явбал бүгд бололцоотой болно. Гэвч төлөв даруу зан, тэвчээр, аядуу зөөлөн хийгээд уужуу талбиу ааш зэргийг биедээ шингээе гэж чин сэтгэлээсээ хүсэхгүй оайхын хэрээр юуг ч мөрөөдөөд биелэхгүй болов уу".

Нэгэн мужааны тухай ийм нэгэн яриа өргөн тархсан байдаг. Нэг өдөр тэрээр хотын захирагчийн амрах сандал засах тушаал авч харуулдаг байлаа. Гэтэл ажил хийж байгаа байдал нь нэг л гажиг, хэтэрхий нямбайлж байхыг хөндлөнгөөс харсан хүн учрыг нь Лавлажээ. Гэтэл мужаан: "Үнэн хэрэг дээрээ, би өөрөө энэхүү сандал дээр сүүжээ амраах тэр өдрийн төлөө л, суухад эвтэйхэн болгоод орхих гэж болсондоо л шүүдээ" гэжээ. Харин гайхалтай нь тэрээр хожим нэрээ хотын захирагч болж, мөнөөхөн сандал дээрээ суусан гэдэг.

Логик судлаачид зоригийн эрх чөлөөний тухайд янз бүрийн онолын маягийн дүгнэлт хийдэг. Гэвч бид цөм "сайн муугийн сонголт тэр хүний эрх чөлөөнд даатгагдаж байдаг" гэж бодож байх ёстой юм. Өөрөөр хэлбэл хүн гэдэг усан дээр шидэгдэж, урсгал даган хөвөх дэрс лугаа адил бус, бүр чадамгай сэлэх хүчтэй байж, давалгаа сөрж өөрийн зорих зүг рүүгээ хангалттай урагшилж явах ёстой амьтан юм гэж бодож байх хэрэгтэй. Тэр үнэхээр тийм агаад, бидний өөрөөс гарах зоригт заавал хүлээс болж байх зүйлс энэ ертөнцөд үгүй билээ. Цаашлаад бид, өөрийн үйлдэл нь чөтгөр шулмын хараалаас болж хүлэгдэх ёсгүй гэдгийг бүрэн дүүрэн сайн мэдэж байгаа. Эс тэгвэл бусдаас цойлж гарахсан гэх мэтийн хүсэл бүгд нөгөө талын хараалаар тарнидуулж орхино биз дээ. Ажил төрөл, бидний амьдрал, айл гэрийн өнгө зүс, нийгмийн шийдвэр, бас бүхий л нийгмийн бүтэц, зэрэг эд эс цөм хүмүүсийн дур зорго бол эрх чөлөөтэй юм гэдэг бат итгэлийг өмнөтгөл болгоод бүтэж байдаг зүйлс юм. Харин энэхүү бат итгэл алдагдаж орхивол нийгэмд хариуцлагагүй байдал дэлгэрч, боловсрол хийгээд зөвлөмж, ухуулга зэрэг арга барил ямар ч хэрэгцээгүй болох бус уу. "Хүний дур зорго бол эрх чөлөө байдаг" гэж ямагт бидний сайн сэтгэл тунхаглаж байдаг. Дур зорго л хүний төгс өмчилж чадах цорын ганц өв хөрөнгө юм. Тэгээд дур зоргыг зөв тал руу хандуулах уу, буруу тийш залах уу гэдэг нь бидний хүн тус бүрд тохоогдсон асуудал юм. Дадал заншил болон уруу татах хүчинд татагдлаа ч сайн сэтгэл бидэнд "цаашлахаа боль" гэж тушаадаг. Харин дадал заншил, дур хорхойгоо захирахад ер бусийн хүч зэрэг нь хэрэгцээгүй юм. Чадах чинээгээрээ хатуу чанга шийдлээ эвцэлдүүлбэл л гүйцээ.

## ***Хамхуулын амьдралаас хагацаж чадах зориг***

Францын шашны зүтгэлтэн Ламуне завхарсан амьдралаар амьдарч яваа нэгэн залууд: "Хүүхээ чи одоо, өөрийн амьдрах замаа өөрөө шийдэх цаг чинь болжээ. Энэхүү боломжийг үргээж орхивол чи өөрийнхөө ухсан булшинд булшлагад, дээр чинь унасан чулууг түлхэж чадахгүй байсаар үхэн үхтлээ зовлонтойгоор

тарчлахын эхлэл болж магадгүй. Зоригтой амьдрала гэдэг нь бид хамгийн амархан эзэмшиж чадахдаг заншил юм. Тиймээс хүчтэй, бат бэх зоригтой болох хичээл зүтгэл гаргаад үз л дээ. Үндэс үгүй өвс лүгээ адил амьдралаа одоо үүгээр цэглээд, газарт хөлөө тавиад алхаж үз. Хамхуултай адил салхинд биеэ даатгаад хийсэх мэт амьдрал чинь гэнэтхэн хаягдаж арилна даа." гэжээ.

Буяны зүтгэлтэн Бакстон эрс шийдмэг, түүнийгээ хамгаалсаар явахыг хүсдэг хүний хүсэл мөрөөдлийн ихэнх хувь нь биелэгддэг гэж ноттой итгэдэг байлаа. Тэрээр хүүгийнхээ нэгэнд хаягласан захидалдаа: "Чи ч гэсэн тун удахгүй, баруун тийш явах уу, зүүн тийш явах уу гэдгээ шийдэх насандаа хүрээд байна. Тиймээс өөрийнхөө үзэл зарчим, шийдвэр гаргах чадвар, бас оюун санааны хүч чадал сэлт чинь хэр зэрэг хүчтэй байгааг өөрийн биеэр баталж үзвэл сайн.

Эс тэгвэл чи залуу хойргот уусаж, үүлгэртэж амьдрах, чадваргүй залуугийн муу зуршлаар будагдаж орхихоос зайлахгүй. Нэг удаа л тийм нөхцөлд биеэ унагаачихвал тэндээс мөлхөж гарах хялбар арга байхгүй- Залуу хүнд бол өөрийнх нь мөрөөдлийн ихэнх хэсэг биелэгдэх ёстой юм. Би ч тийм л байсан... Яг чиний насан дээр би өөрийнхөө амьдралыг орвонгоор нь эргүүлсэн бөгөөд, өнөөгийн аз жаргал, алдар суу түүгээр олгогдсон юм гэж хэлж болно. Чи ч бас амьдрах эрчим буцалсан, чармайлт зүтгэлтэй амьдрах замыг зорихоор хатуу шийдэх хэрэгтэй юм шүү. Одоо шийдээд нэг алхам гишгэж чадвал чи өөрийнхөө тийм ухаантайд бүх насаараа талархаж явах болов уу" гэжээ.

Хүний дур зорго гэдэг зүг чиг хамаагүй, хар хурдаараа цойлон урагшлах гээд байдаг. Тийм болохоор дур зоргоо зөв зорилт тавьж, таарч тохирсон зүг чиг рүү нь залахыг оролдох нь хамгийн чухал юм. Тачаал хийгээд жаргал цэнгэл хөөхөөр зүглэсэн дур зорго хурдан хугацааны дотор чөтгөр шулмын мөн чанарт хувилж, оюун ухаан нь түүний дорд боол болох болов уу. Харин түүний эсрэгээр, сайнтай хөөцөлдөхөөр зүглэсэн дур зорго бол нэр алдартай агаар нэг. Тэнд оюун ухаан хүний хамгийн дээд мандал бадралыг авч ирэх эзэн болох нь дамжиггүй.

### ***"Бололцоогүй гэдэг уг мунхагийн толь бичигт холхиостой"***

"Зориг байгаа газар зам нээгддэг". Энэхүү хуучны зүйр үг бол эргэлзээгүй үнэн өөрийн биеэрээ байгаа нь тэр юм. Ямар нэг зүйлийг бүтээе хэмээн шийдсэн хүн итгэлтэйгээр тэрхүү шийдлийг хүчээр олон тооны саад бэрхшээлийг гэтлэн давж, зорилтдоо хүрдэг. Чадна гэдэг бодол л орвол аравны найм ес нь биелдэг. Өөрөөр хэлбэл бат ноттой шийдэл л байвал тэр нь аль хэдийн бодит байдалд зорилгоо биелүүлсэнтэй адил. Зүрх сэтгэлээсээ шийдсэн шийдэл авъяасын тэнгэр лугаа адил хүчийг авч явдаг. Оросын цэргийн жанжин Суворовын буулт хатуутай араншин, түүний бат нот зоригийн хүчинд ялалт ирэх нь цөөнгүй байсан.

"Зориг зүрхгүй хүн заавал ялагддаг" гэж тэрээр ямагт өгүүлдэг байв.

Францын нэгэн улс төрч эзэн хаан Наполеонтойгоо нэгэн адил "бололцоогүй" гэдэг үгийг толь бичгээс гаргаж хаях хэрэгтэй гэж хүсч байсан бололтой. "Би мэдэхгүй юм байна", "чадахгүй", "боломжгүй зүйл юм" зэрэг үгсэд тэрээр туйлын дургүйлхдэг байсан. Тэгээд ямагт "Сур, хий, үзээд алд" хэмээн тунхагладаг байлаа. Намтар бичигч зохиолч, Суворовыг үнэлж "ямар ч хүнд чадал авъяас бий бөгөөд, түүнийг бүрэн дүүрэн нээж гаргахыг оролдож зүтгэвэл томоохон үр дүнг олж болохыг тэрээр биеэрээ баталсан юм" гэж бичсэн байдаг.

Наполеоны хэлэх дуртай үгсийн нэг бол "хамгийн үнэн оюун ухаан бол эрс шийдмэг шийдвэр байдаг" гэдэг өгүүлбэр юм. Түүний амьдрал хүчирхэг хүч хийгээд ухаалаг шийдвэр гаргах хүч юунд хүргэдэг гэдгийг тодорхой харуулж байна.

Наполеон биеэ ч, сэтгэлээ ч цэргийн хэрэгт зориулж өргөн барьсан эр хүн байв. Дорой буурай язгууртнууд, бас түүний ардтүмэн ээлж дараалан цэрэг армийнх нь дээвэр дор бөхийн сөгдсөн юм. Нэгэн удаа түүний цэргүүдийг Альпийн нуруу хаачихаад байна гэсэн мэдээ аваад Наполеон "За тэгвэл Альпийг цэгцлээд орхиё" хэмээн "том дуугарчээ". Тэгээд өдий болтол хэн ч ойртож байгаагүй Санфурон оргилд зам гаргахаар одсон гэдэг.

Тэрээр "Бололцоогүй гэдэг үгс мунхагийн толь бичигт холхиостой" гэж хэлсэн байдаг.

Дайнд ялах зөв арга зам нь гэдэг асар хурдан шийдвэр гаргаж, дайсны өө сөв сиймхийг нь далимдуулж асар хурдан үйлдэл хийх явдал юм. Наполеон: "Алкосын тулаанд ердөө л 25 морьт цэрэгтэйгээр ялсан билээ. Дайсан /Австрийн цэрэг/ ч, манайхан ч сэтгэлийн хүчгүй байдалд унаад байсан нэгэн агшны боломжтаарч, морьт цэргүүдэд сэлэм бариулж нөгөө талын цэргүүд рүү хүчтэй дайралт өгсөн юм. Ердөө л тэгэж ялалт манай цэргийнх болсон билээ. Тулалдаанд хоёр талын цэрэг нөгөө талаа дарж устгахаар үхэн хатан тэмцдэг бөгөөд тэр дунд нэг мэдэхэд гэнэт дайсан айж мэгдэхийн өвчинд ороогдох үе гардаг. Тэрхүү торгон агшинг сайтар ашиглах нь ялалтын нууц юм даа" гэсэн нь бий.

Цааш нь Наполеон: "Ганцхан агшны тийм боломжийг хийсгэж орхивол тэр нь хувьгүй ялагдалд хүргэдэг. Австрийн цэргүүд цагийн үнэ цэнийг мэддэггүй. Тэд үргэлж үүлгэртэж, цохилтод шийдмэг бус байсан учраас манай цэргүүдэд ялагдсан юм аа" гэжээ.

Гэвч Наполеоны агуу үйл хэрэг ч бас эцэс сүүлдээ бүгд дэмий зүтгэл болсон юм. Шазруун, дураараа түүний авир байдал өөрийгөө егүүтгээд барахгүй, бүр франц орныг хүртэл бусниулсан билээ. Тэр эрхмийг үгүй болсон хойно Франц орон огт засаглалгүй байдалд унасан юм. Наполеоны амьдрал бидэнд дараах зүйлийг сургаж байна, юу гэвэл сайнтай ойртож дөхөөгүй эрх хүч гэдэг хичнээн хүчирхэг байлаа ч төр улсын мөхлийн амин шарх болдог буюу. Бас сайнтай үл шүргэлцэх мэдлэг хэмээгч нь чөтгөр шулмын хувилсан бие болдог юм шүү...

### 3 Сэтгэлд шингэх үнэн үгс

Тулааны баатруудтай нэг адил, христосын шашны замнал дахь баатруудыг ч мартаж боломгүй. Тэд амьдралдаа цөхөрч бүдэрсэн хүмүүст туслаж гачаал зовлонгоос гаргахаар нэгэн үзүүрт сэтгэлээр, хорвоогийн алдар хүндэд нүд унагалгүй, биширмээр, өөрийгөө золиослох ухаанаар хөтлөгдөж ажилдаа махарч байсан билээ. Үл цөхрөх зориг зүрх дор тэвчээрийг эвцэлдүүлсэн тэд, ядуу гуцуугаа тэвчиж, эрсдэл хүлээж, халдварт өвчний голомттой хөдөө нутгаар хөндлөн гулд явж байлаа. Ямар ч зовлон хийгээд гамшигт шантралгүй шашнаа сурталчлахад шамдаж, тухайлбал шашныхаа төлөө зовлон эдлэгч болохоор, бүр тэр явдлыг өөрийн баяр баясгалан, бахархал болгон гарсан улс юм. Тийм хүмүүсийн нэг бол Франциско дс Хабиер билээ. Өндөр язгууртай хүний гэр бүлд төрсөн түүний хувьд жаргал цэнгэл, эрх хүч болон нэр алдар тэргүүтнийг гартаа оруулах зэрэгт ер бэрхшээл байсангүй. Гэвч тэрээр тэрхүү амьдралыг сөрж, нийгмийн байдал, байр сууриас илүү чухал зүйл, мөнгөжих хөлжихөөс өөр гайхамшигтай зүйл байдаг гэдгийг баталсан юм.

Хабиер биеэрээ ч, сэтгэл зүрхээрээ ч жинхэнэ женгельмен байсан билээ. Бусдын үгэнд оромтой, сайхан үгэнд хууртагдахад амархан маягийн зан торхтэй ч нөгөө талаар хүнийг хөтлөх сэнхрүүлж ятгахдаа сайн, тэсвэр тэвчээр болон хүсэл тэмүүлээр дүүрэн, эрчимлэг хүн байлаа. Хорин хоёр настайдаа тэрээр францын их сургуулийн гүн ухааны багшаар ажиллаж, амьдралынхаа нэгэн үеийг өнгөрөөсөн, тэнд Роялтай танилцаж, хоёулаа шинэ шашны байгууллага Исүсийн нийгэмлэгийг үүсгэжээ. Тэгээд Хабиер Исүсийн нийгэмлэгийн нэг байгууллагыг толгойлж Ром руу мөргөлийн аянд гарчээ. Тэр үед Португали улсын эзэн хаан 3-р Жон өөрийн улсын захиргаанд байдаг энэтхэгийн газар нутагт Христосын шашныг дэлгэрүүлэхээр бодлогоширч байлаа. Сурталчлах багшаар эхлээд Бобажира хэмээх хүнийг сонгосон авч, өвчин тусаад үүргээ гүйцэтгэж чадахгүй болж, дахин хүн сонгосны эцэст Хабиер оногдсон байна.

Хабиер навсархай өмсгөлөө хэдэрч, Библийн судраа өвөртлөөд яаран Лиссабон руу одов. Тэндээсээ усан онгоцоор дорно зүг мордов. Энэтхэгийн Гоа явах тэрхүү усан онгоцонд уул газар илгээгдсэн хамгаалан сэргийлэх мянган цэрэг захирагчийн хамт сууж буйтай таарчээ. Хувийн өрөө оногдсон хэдий ч Хабиер ямагт усан онгоцны банзан дээр амьдарч байлаа. Эвхээстэй олсоор дэр хийн зүүрмэглэж Далайчидтай хамт хооллож байлаа. Далайчдад анхаарал **сайн** тавихын сацуу, уйтгартай өдөр хоногийг сарнитал жижигхэн тоглоом сэлтийг бодож олох, өвчтнийг асрах зэргээр санаа тавьж байсан тул тэрээр удалгүй далайчдын сэтгэлийг эзэмдэж, хүндлэл хүлээх болжээ.

Гоа-д хүрэлцэн ирсэн Хабиер нүүн суурьшигчид болон уугуул хүмүүсийн хооронд ужид самуун хийгээд ялзрал нүүрлэж байгааг хараад ихээхэн цохилт авчээ. Суурьшин ирэгсэд, иргэншлийн гэрэл гэгээ хүрээгүй энэхүү газар олон тооны муу зуршлыг дэлгэрүүлж уугуул хүмүүс болохоор уралдан байж тэрхүү муу үлгэр дуурайллыг эзэмшихийг хичээх байдалтай байлаа.

Тиймээс тэрээр хонх дуугарган, тосгоны дундуур алхаж, хүүхдүүдийг өөрийн буй газар ирүүлж хичээллүүлэхийг уриалж байв. Тун ч удалгүй цугларч ирсэн олон сурагчдад тэрээр өдөр бүр идэвхийлэн бурхны сургаалийг тайлбарлаж байлаа. Түүний зэрэгцээ өвчтэй хүн болон уяман /нойтон хамуу/ өвчтөн, янз бүрийн зовлон эдэлж буй хүмүүсийн байгаа газраар очиж тэрхүү гаслан зовлонг эдлэлцэх, тэднийг "үнэн" рүү хөтлөхөөр хичээж зүтгэж байлаа.

Хүмүүсийн зовлонг дууг сонсвол ямар ч зүйл байсан Хабиер тийшээ зүтгэж байлаа. Жишээ нь Манаар мужийн сувд хураагчид зовлон гаслант амьдралаар амьдарч буйг сонсоод тийшээ очиж, хонхоо чанга дуугарган энэрэнгүй сэтгэлийг даллан дууддаг байв. Тэрээр угаалгын сахил хүртээн, бурхны сургаалийг тайлбарладаг байв. Тэрхүү сэтгэлд шингэх мэт ухуулгаар зовлон зүдүүр хийгээд бэрх хүндийн туйлд буй хүмүүст авралын гарыг сунгаж өгч байлаа. *"Сургаалийг хүртэн авагчид олон ч сургааль ёсоор хэрэгжүүлж байгаа нь цөөхөн"* Хабиер хонхоо дуугарган далайн хөвөөгөөр алхаж, хот тосгон дамжин, сүм хийд зах зээлийг зорьж байлаа. Тэгээд уугуул нутгийн хүмүүсийг, цугларч ирээд миний ярихыг сонсоцгоо

хэмээн уриалж байв. Догма мэтгэлцээний эмхтгэл, Мозэ-гийн арван номнол, эзний мөргөл зэрэг христос шашны өгүүллүүд Хабиерын тусламжтайгаар тэр нутгийн хэлээр хөрвүүлэгджээ. Тэрээр эхлээд өөрөө цээжилж, хүүхдүүд түүнийг нь даган уншаар цээжилтэл нь сонсоно. Дараа нь хүүхдүүдээр эх эцгүүд болон хавь ойрын хүмүүст дамжуулдаг байжээ.

Коморин буланд шашин дэлгэрүүлэгч гучин хүн илгээгдсэн бөгөөд тэд Хабиерын удирдлагаар гучин сүм нээсэн байна. Мэдээж, сүм болхи, ихэнх хэсэг нь жижигхэн тасалгаанд загалмай босгосон төдий зүйл байсан гэдэг.

Ийнхүү шашин сурталчлах үйл ажиллагаа Хабиерын өөрийнх нь хэлснээр "Үнэндээ тооцоолоогүй шахам их амжилт олсон" ажээ.

Түүний унаган араншин, чин сэтгэл, магтаж дуулвал зохих түүний амьдралын зам хийгээд бас үйлдэл аясаас нь аяндаа гарах ухуулан сэнхрүүлэх хүчнийх нь ачаар Хабиерын очих газар бүр христосын шашинд итгэгчид цуварч байлаа. Түүний уулзалт яриаг сонссон хүмүүс хүчирхэг хүчинд автагдах лугаа адилаар таниулгад нь даган баясч, нэг л мэдэхэд түүний сэтгэл урамд өлгийдүүлж оддог ажээ.

"Боловсорч гүйцсэн жимс их байвч хураан түүх хүн хэтэрхий цөөхөн" /сургаалийг хүлээж авах хүн олон ч, сургааль номыг гүйцэлдүүлэх хүн нь хэтэрхий цөөн/ гэдгийг мэдэрсэн хэдий ч Хабиер дараагийн зорилгот газар Марокко, Япон руу усан онгоцоор хөдөлжээ. Тэнд түүнийг хүлээн авсан хүмүүс нь өөр хэлээр ярьдаг бүр шинэ үндэстэн байлаа. Түүний чадах юм гэвэл бололцоогоороо өвчтэн сувилж, ор засаж, нулимсаа дуслуулан мөргөж, заримдаа шашны хувцасныхаа ханцуйг усанд дүрэн базаж, дуслан гоожих усны дулаар үхэл рүү одож буй хүнд угаал үйлдэх зэрэг байсан гэдэг.

Гэлээ ч тэрхүү эр зоригт, үнэний цэрэг хүсэл мөрөөдлийн дэнлүүгээ өндөрт өргөн, юунаас ч айж эмээлгүй, итгэл хийгээд эрчимтэйгээр цөхрөлтгүй урагшилж байсан. "Үхэл хийгээд бэрх зүйл хүлээж завдаж байлаа ч гэсэн нэгэн сүнсэнд туслахын төлөө бол түмэнтээ ч болов түүний дотор үсэрч орох тангарагтай байдаг" гэж тэрээр өгүүлсэн байдаг. Өлсгөлөн хийгээд цангаа, гуйланчлал зэрэг янз бүрийн аюултай тулалдангаа Хабиер энэрлийн өртөөгөө үргэлжлүүлсээр, ядарч зүдэрснээ мэдээгүй билээ. Гэлээ ч арван нэгэн жил үргэлжилсэн христос дэлгэрүүлэх үйл ажлынхаа төгсгөлд хятад руу явахаар завдаж байсан түүний бие нэг л мэдэхэд хумхаа өвчинд баригдаж, түүний өндөр дээд сүнсийг бурхан хөтлөж одсон билээ. Түүн шиг чин сэтгэлээр өөрийгөө золиос, зориг хоёрт даатгасан амьдралаар амьдарч өнгөрүүлсэн хүн лавтайяа дахин төрөхгүй байж магадгүй юм.

#### **4. Чин үнэнч амьдрах**

Хабиерээс хойш христосын шашин дэлгэрүүлэх үйлсэд амьдралаа зориулсан хүмүүс олон ч, тэдний дунд гүнзгий сонирхол татахуйц нь Дэвид Ливингстон юм.

Түүний өвөг нь ядуу зүдүү ч шударга шулуун үгтэй шотланд хүн оаилаа. Тэрээр маш ухаалаг, эрэгцүүлэн бодох сэтгэлгээ гүнзгийтэй оөгөөд нутаг нугынх нь бүгд түүнийг мэддэг, нас барахынхаа өмнө хүүхдүүдээ дуудан цуглуулж, цорын ганц өв хөрөнгө болгон ийм нэгэн үгийг үлдээсэн гэдэг: "Би бүхл амьдралаараа өөрийн удмынхаа уламжлалыг нэгд нэгэнгүй шалган нягталж ирэв, өвөг дээдсийн маань дотор үнэнч шударга бус хүн нэгээхэн бээр ч байсангүй.

Тиймээс төсөөлөхөд бэрх хэдий ч та нар болон та нарын үр сад үнэнч шударгуу бус замаар алхлаа гэвэл, тэр нь манай удмынхны гүйж байгаа цусны учир бус. Та нар шударга бусаар амьдрах удам судар авч төрөөгүй. Тэгэхээр үнэнч шударга л амьдрах ёстой. Энэ бол миний үлдээж байгаа цорын ганц сэрэмжлүүлэг юм шүү" гэжээ.

Арван настай Ливингстон Глазго-гийн ойрхон байх хөвөнгийн үйлдвэрт ажиллахаар болжээ. Тэрээр ажилд зүтгэж байж анх удаа авсан цалингаараа латин хэлний үг зүйн ном худалдан авч, латин хэлний хичээлд шамдаж эхэлжээ. Түүнээс хойш хэдэн жилийн турш оройн сургуульд явж хичээллэсээр байлаа. Үйлдвэр өдөр бүр өглөө 6 цагаас ажил нь эхэлдэг бөгөөд эртхэн унтаарай гэж ээжийгээ сануулж хэлэхгүй л бол тэрээр үргэлж шөнө дунд өнгөртөл хичээлээ үздэг байлаа. Ингээд аажим аажмаар эртний Ромын шүлэгч Белгиус болон Хорачиусыг уншиж дуусган улмаар туужаас л өөр ном байвал ямар ч ном байсан нүд гүйлгэжээ. Түүний дотор шинжлэх ухааны болон аян замын тэмдэглэлийг ихэд уншсан байна.

Өчүүхэн бага чөлөө завандаа ойр орчноороо эргэлдэж, ургамал цуглуулан ургамал судлалын ухааны судалгаанд ч хөл тавьж эхэлжээ. Үйлдвэрийнх нь машин "унгас алдан" эргэлдэж байх хооронд ч тэрээр номоо л уншиж байдаг байлаа. Өөрөө ажиллуулж буй Жэни машины дээр номоо тавиад, машины өмнүүр өнгөрөх бүрдээ бүлэг бүрийг уншихаар арга чарга хийж байлаа. Ийнхүү хичээн мэриймтгий залуу хүү

ихээхэн мэдлэгийг хуримтлуулсаар байв. Ингээд улам улмаар түүний сэтгэл зүрхэнд боловсорч нээгдээгүй хүмүүст христосын шашин заан сургая хэмээх мөрөөдөл ургаж эхэлсэн байна.

Зорилгоо шийдсэн Ливингстон дан ганц шашны суртлаачаас гадна мэдлэг боловсрол олохын тулд анагаах ухаанд суралцаж эхлэв. Идэх, өмсөхөө хасч танан байж, аль болох мөнгө хуримтлуулж, зөвхөн өвлийн улиралд Глазго-гийн их сургуульд анагаах ухаан, грек хэл, шашин судлалын ухаанд суралцан, үлдсэн бүх цагаа хөвөнгийн үйлдвэрт ажиллаж өнгөрөөж байлаа. Их сургуулийн зардлаа бүгдийг үйлдэрт ажилласан цалингаараа дарж, хэнээс ч сохор зоосны тусламж аваагүй юм.

"Одоо эргэцүүлж санахад тэр цагийн хүнд бэрх амьдрал миний өсөлт хөгжилтөд маш том нөлөө болсон нь лавтай билээ. Би тэр цаг үедээ талархахаас өөр аргагүй. Хэрвээ дахин төрдөг бол би мэдээж хэрэг тэр үетэй адилхан зүүдүүхэн амьдарч, хатуу бэрх сорилтыг даван туулах замаа сонгох болов уу" гэжээ. Энэ нь түүний үнэн сэтгэл болохоос зайлахгүй юм.

### ***Биеэ даасан сайн дурын сэтгэл***

Ливингстон анагаах ухааны программаа дүүргэж, латин хэлээр илтгэл бичиж шалгалтаа амжилттай даваад дотрын болон мэс заслын эмчилгээний эрх авчээ. Тэр цагаас эхлэн тэрээр Хятад руу явахаар зэхэж байлаа. Гэтэл тэр үед Англи Хятадтай байлдаж байсан тул төлөвлөгөө нь нурж орхив. Тэгэхлээр нь Лондонгийн шашин номлогч сүмд зүтгэхээр санал өгсөн боловч түүнийг Африкт илгээх болж, 1840 онд Африкт очжээ.

Гагцхүү, түүний үгийг сонсохуул энэхүү Африкт явахад санаа зовж буй юм нэг байгаа ажээ. Хятад руу явах түүний төлөвлөгөө өөрийн хүчиндээ дулдуйдаж байсан бол энэ удаад Лондонгийн шашин номлогч сүм зардал төсвийг нь дааж буй ажээ.

"Биеэ дааж явж ирсэн хүн цөөхөн ч гэсэн бусад хүний ач буян харна гэдэг тийм ч таатай эд биш дэгээ" гэх ажээ.

Африкт очсон Ливингстон хэцүү хатуутай тулж, ажил хөдөлмөрт баригдсан юм. Тэрээр бусдын ажлын араас барьж үргэлжлүүлэх төдийд сэтгэл ханалгүй, өөрийн биеэ даасан үйл ажиллагааны хүрээг өргөтгөж, уугуул нутгийн хүмүүс амьдрах барилга барих мэт ажилд ч зүтгэж байлаа. Мэдээж хэрэг, шашин дэлгэрүүлэхийг гол болгож байсан ч тэрхүү шашин дэлгэрүүлэх ажил нь "хөвөнгийн үйлдвэрт ажиллаж байсантай ав адилхан ядрааж, шөнө дүл болтол хичээл хийхэд ч хүргэж байсан" гэж тэрээр өгүүлсэн байдаг. Түүний дараа цувана үндэстэн /одоогийн Боцувана үндэстний нэг/-тэй ажиллах болсон Ливингстон суваг ухаж, гэр барьж, хээр талыг хагалж, мал тэжээж, уугуул хүмүүст ажил хөдөлмөр хийгээд сүсэг бишрэлийг зааж байлаа. Нэг өдөр тэрээр цувана үндэстний хүмүүстэй анх удаа холын аялалд явахаар зэхэж байтал сонсох аргагүй ийм яриа чихийг нь дэлсэв. Тэр нь түүний гадаад төрх, биеийн хүчнийх нь тухай үг байлаа. "Энэ хүн эрүүл чийрэг байрын хүн биш дэгээ, нэгдүгээрт бие нь гэж туранхай. Хувцас өмсөөд л гайгүй харагдаж байгаа болохоос удахгүй нүцгэрэхээрээ хийсэх биз".

Үүнийг сонссон шашин номлогчийн биеэр гүйх Шотланд хүний цус хөөрөхийг хэлээд яах вэ. Тэрээр аяллын замд хэдэн өдрийн турш цуваначууд гуйвж дайван ядарсан ч Ливингстон бүхий л хурд хүчээрээ алхсаар байлаа. Ингээд удалгүй тэд ч Ливингстоны тэвчээрийн хүчтэйг хүлээн зөвшөөрөхөөс аргагүйд хүрсэн ажээ.

Өтөл насандаа Ливингстон ийм явдал учирснаа бичиж үлдээсэн байдаг. Африкт хамт очсон уурын усан онгоц Баргенхедт нь нэлээд эвдэрч орхисон тул эх орон руугаа өөр онгоц захиалжээ. Бараг 2000 Фунтын өртөг шаардсан тул аян замын тэмдэглэлээ хэвлүүлсэн шагналын мөнгөө түүнд нийлүүлэхээр болов. Уг нь тэр мөнгийг хүүгийнхээ хөрөнгө хэмээн хурааж байсан ажээ. Усан онгоц бариулах зардалд тэрхүү мөнгийг шилжүүлэхийг хүүхдүүдээ захьсан захиандаа Ливингстон: "Энэ зардлыг нөхөхийг та нар өөрсдөө биелүүлж гүйцэтгэхгүй бол болохгүй шүү" гэжээ.

### ***5.Цог жавхаатай амьдрах хүч хийгээд цөхрөлтгүй зорилгоор бялхаж байх тухайд***

Англи оронд болон түүний колони газар нутагт боолын системийг халах хөдөлгөөн олон хүний хүч энерги бялхсан амь хайргүй хөдөлгөөнөөр түшүүлж тулуульж ирсэн билээ. Түүний дотор Их Британий эзэнт улсад дээр дооргүй боолын системийг халахыг тууштай болгох их хэргийг гуйцэлдүүлж ирсэн хүний нэг нь парламентын доод танхимын гишүүн Паул Бакстон орно.

Бага байхдаа Бакстон адтай биш, үүлгэрдүү хүүхэд байлаа. Бас өөрийгөө төвойлгох нь түлхүү, энэ араншин нь эхэндээ эрх дураараа болон зөрүүдлэн зүтгэх байдалтай болж илэрдэг байв. Тэрээр бага байхдаа эцгээсээ хагацаж, харин азаар ухаалаг ээжтэй төржээ. Тэр бүсгүй хүүгийнхээ зоримог байдлыг

анхааралтайгаар ирлэж, зарим талаараа ээж нь захирдаг байсан ч, нөгөө талаар түүнд даалгаад орхилоо ч санаа амар байж болох зүйлийг өөрийнх нь санааны зоргоор нь хийлгэдэг байжээ.

Омог бардам байдлыг нь үнэ цэнтэй зорилгод чиглүүлж, хүү нь таарч тохирсон залуур жолоодлогыг хүлээж авч чадах юм бол хүн болох ховор чухаг чанарыг эзэмших нь тэр гэж ээж нь итгэж, тийм бодлыг барьж хүүгээ хүмүүжүүлж ирсэн байна. Тиймээс бусад хүмүүс хүүгийнх нь зөрүүдийг гайхахад ээж нь: "Үгүй ер, илүү халамж бологдоо, энэ хүү одоо эрх дураараа нь үнэн ч гэсэн, удахгүй гайхалтай хүн болох ёстой юм шүү" гэдэг байв.

Бакстон сургуульд байхдаа ер хичээл хийдэггүй, тааруухан сурагч, залуу хэмээн хүмүүс боддог байлаа. Гэрийн даалгавраа найздаа түлхэж орхиод өөрөө энд тэнд үсэрч харайн, тоглоомонд улайрдаг байв. 15 настайдаа сургуулиа дүүргээд гэртээ ирсэн авч тэр үед тэрээр том биетэй, хүмүүжлийн талаар ёс журам тааруу залуу болсон бөгөөд завиар зугаалах, ан хийх, морь унах зэрэг хээрийн спортоос өөр ямар ч сонирхол байсангүй. Өдрийн хагас илүүг ан хийх газар манаа манадаг эртэй хамт өнгөрөөж байв. Тэрээр сайн хүн байсан агаад хүний амьдрал, байгалийн талаар ихийг мэдэж байсан ч унших бичихийн талаар хоосон маруухан байлаа.

Тэр үеийн Бакстон сайн араншин биедээ зүүх үү, эсвэл муу зуршлаар будагдах уу гэсэн салаа замын бэлчирт ирэв. Энэ бэлчир дээр тэрээр азаар Гарнир-ын гэр бүлийнхэнтэй учирчээ. Тэднийхэн нийгмийн байр суурь өндөртэй, боловсрол гэгээрлээр баян, хүмүүнлиг үзлээр дүүрэн, нэр төртэй гэр бүл байлаа.

Хожим Бакстон өөрөө дурсаж буйчлан тэдний гэр бүлтэй нөхөрлөх болсон нь түүний амьдралд тод томруун зүйл болсон ажээ. Гарнир-ынхан Бакстныг боловсрол мэдлэгээ өндөржүүлэхийг хүчтэй дэмжиж байлаа. Тэр нөлөөгөөр Бакстон Их сургуульд элсэн орж тэргүүний амжилттайгаар дүүргэсэн байна. Төгссөн тухайгаа тэрээр "Сайн дүнтэй суралцсан минь тэдний гэр бүлийнхэн дэмжиж байсны ач тус юм. Баярын бичгээ авч очоод тэдэнд үзүүлмээр байна" гэж өгүүлсэн байдаг.

Удалгүй Бакстон Гарнир-ын охидын нэгэнтэй нь гэрлэж, Лондонд хадам эцгийнхээ эрхэлж буй пивоны үйлдвэрт орж шинэ амьдралынхаа анхны алхмыг хийв.

Хүүхэд байх үеийнх нь хүсмээргүй зөрүүд зан одоо түүнд хүчтэй зоригийн хүч болж түүний араншингийн гол нурууг бүрдүүлж, түүний ачаар ямар ч ажил байсан цөхрөлтгүй эрчимлэгээр давж гарч байлаа. Түүгээр барахгүй тэрээр ажилд бүх хүч чадлаа цутгаж байв. Хоёр метр шахам өндөр нуруутай "заан Бакстон" хэмээн дуудуулдаг байсан тэрээр чадавхи хийгээд гүйцэтгэх чадлаараа барагтай бол хүнийг урдаа оруулдаггүй байлаа.

Тэрээр: "Эхлээд нэг цаг пиво үйлдвэрлэх ажлаа хийнэ. Дараа нь нэг цаг тоо судлана, тэгээд нэг цаг ан хийнэ, алийг нь ч орхигдуулахгүй шүү" гэж өгүүлсэн байдаг.

Пивоны үйлдвэрийн менежер болон дэвшсэн тэрээр удалгүй чадварлаг менежер болж авъяасаа нээжээ. Ямар ч том наймаа байсан жижиг сажиг хэсгийг нь хүртэл тэрээр нарийвчлан удирддаг байлаа. Түүний ачаар компани нь урьдахаасаа шал өөрөөр цэцэглэн хөгжжээ. Мэдээж хэрэг, Бакстон оюуны боловсролын талаа ч алгуурлалгүй, орой үдэш нь эрдэм судлалд шамдаж байлаа.

"Уншаад л эхлэвэл заавал дуусга." "Доторхыг нь төгс эзэмштэлээ тэр номыг уншчихлаа гэж бодож болохгүй." "Оюун ухаанаа төвлөрүүлж янз бүрийн зүйлийг мэдэж ав". Эдгээр нь ном уншихын тухай түүний сургааль юм.

### *Агуу хүн хэмээн авч үзэхэд учир дутагдалтай хуниш онцлог*

Дөнгөж гучин хоёрхон насандаа парламентын доод танхимын гишүүнээр сонгогдсон Бакстон Английн колонийн газар нутагдахь ооолын системьг бүрмөсөн халахад оролцож эхэлжээ. Тэрээр ийнхүү боолыг чөлөөлөх хөдөлгөөнд эртнээс сонирхолтой болсон нь Фрушела Гарнир хэмээх эмэгтэйн нөлөө билээ. Тэрээр тун ухаалаг, халуун дулаан сэтгэлтэй бүсгүй байлаа. 1821 онд үхлийн ирмэг дээр тулж очоод байсан тэр эмэгтэй Бакстныг хэдэнтээ дуудан уулзаад "боолыг чөлөөлөх ажлыг таны амьдралын зорилго болгохыг хүсч байна" гэж хичээнгүйлэн захижээ. Амьсгаа хураахдаа ч бас энэ тухай дахин нэг хэлэх гээд чадалгүй эцэслэсэн гэдэг.

Бакстон тэр эмэгтэйн үгийг мартахын аргагүй байв. Тэгээд өөрийнхөө охидын нэгийг тэр бүсгүйг мөнхжүүлж Фрушела хэмээн нэрлэжээ. Тэр охин гэрлэсэн 1834 оны 8 дугаар сарын 1-ний өдөр бол англит боолчуудыг чөлөөлсөн өдөр юм. Тэр өдөр охин нь хүүхэд хэмээх албанаас чөлөөлөгдөж нөхөртэйгээ хамт гэрээсээ гарч одоход үдэж хоцорсон Бакстон найздаа бичсэн захиандаа: "Охин маань дөнгөж сая хадамлаад байна. Түмэн хэрэг гайхалтай байдлыг авчирлаа. Өнөөдөр английн колонид нэгч боол хүн байхгүй" гэжээ. Бакстон ерөөс суутан бус. Агуу удирдагч, эсвэл зохион бүтээгч ч биш. Гэвч хичээнгүй агаад шударгуу, хатуу шийдмэг, амьдрах хүчээр бялхсан эр хүн байсан гэдэг нь лавтай юм. Түүний бүхий л зан араншин түүний дараах үгэнд бүрэн дүүрэн илэрхийлэгджээ. Тэрээр:

"Урт наслухын хэрээр улам бүр итгэлтэй нь аргагүй хэлэх үг гэж хүнд байдаг. Хүчтэн хүчгүй хоёрын ялгаа, агуу хүн гэж үзэхэд учир дутагдалтай хүний ялгаа нь тэр хүн цог жавхаатай амьдрах хүч хийгээд шантрашгүй зоримог шийдэлтэй байна уу үгүй юү гэдгээс харагддаг. Эргэлт буцалтгүйгээр зорилгоо тогтоож чадвал дараа нь ялах уу, үхэх үү гэдгээс өөр юм үгүй. Ийм бат хатуу шийдвэр л чухал байдаг. Яралзсан амьдрах хүч, цөхрөлтгүй зоримог шийдвэр л байвал энэ хорвоод бүтэхгүй зүйл гэж нэг ч байхгүй. Нөгөө талаар үүнийг бүрдүүлж чадахгүй бол ямар ч тэнгэрлэг авъяас, тааламжтай боломж тохиолоо ч хоёр хөлт амьтны ертөнцөө давж чадахгүй, өөрөөр хэлбэл жинхэнэ хүмүүн болж чадахгүй болов уу" гэжээ.

**Цаг жугацааны ухаан**

*Гүйцэтгэх чадваргүй хүн амжилтад хүрсэн нь үгүй*

**1.Бизнесийн авъяасаараа шалгарсан суутнууд**

"Бизнесмен гэдэг худалдаа наймаа агаад ажил мэргэшилдээ сэтгэлээ өгч шуударсан хүнийг хэлдэг. Тэд нүд салгалгүй мянган хэргийг гагцхүү тогтсон журмаар нь залж хөдөлгөж байвал л боллоо. Бизнесээ гартаа оруулж хөгжил цэцэглэлд хөтлөхөд дүрсэлэн бодох хүч хийгээд үзэл санаа ер хэрэгцээгүй. Хамгийн чухал нь эгэл жирийн бодол санаа болон хамгийн нарийн утгаар хохирлоо тооцоолох ухаан л хэрэгтэй" гэж шүүмжлэгч Хазлидт өгүүлсэн байдаг.

Энэхүү тодорхойлолт шиг нэг талыг барьсан, эндүүрсэн зүйл байхгүй болов уу. Явцуухан сэтгэлгээтэй бизнесмен мэдээж буй. Гэлээ ч энэ нь эрдэмтэн, зохиолч, хуульчид дотор ч явцуу сэтгэлгээтэй хүмүүс байдагтай адилхан хэрэг мөн. Бас нөгөө талаар уудам сэтгэлтэй, сэтгэлгээний багтаамж баянтай, үйл ажиллагааны хүрээ томтой бизнесмен ч олон. Улс төрч Эдмонд Бак өгүүлсэнчлэн, ганзгын наймаачны босгыг даваагүй улс төрч бас байдаг бол, гайхалтай улс төрчийн сэтгэлгээтэй хөдлөх наймаачин ч бас байдаг байна.

Эрт дээр үеэс суут хүн хэмээн нэрлэгдэж ирсэн хүмүүс өндөр Дээд зорилго хөөхийн сацуу амьдралаа залгуулахын төлөө шударгаар ашиг орлоготой ажлыг огт ичгүүртэй гэж бодолгүй хийж ирсэн билээ.

Эртний Грекийн долоон ухаантны нэгдүгээрт тооцогдох Фалес болон Афинын хоёрдугаар үндэслэгч Солон, бас математикч Хюператес зэрэг нь бүгд худалдаачид байлаа.

Цуутай ухаантан, бараг бурхан хэмээн тооцогддог Платон ч гэсэн Египетэд аяллаар явахдаа замдаа тос худалдаж байж аяны зардлаа олж байжээ. Бас гүн ухаантан Спиноз линз угааж хоолоо олж идэхийн хажуугаар гүн ухааны судалгаагаа үргэлжлүүлж, агуу их ургамал судлаач Линне гутал хийхийн хажуугаар судалгаагаа хийж байжээ.

Шекспир театрын даргынхаа хувьд амжилт олж байсан.Тэрээр жүжиг болон шүлэг бичих авъяасаасаа илүүтэй сайн менежер болох практик ажлын чадвараараа илүү бахархаж байсан байж магадгүй. Яруу найрагч Побб-ын тайлбараас үзвэл Шекспир утга зохиолд суралцсаны хамгийн гол зорилго бол албан ёсны, өөрөө өөртөө үйлчлэх замыг эрт олох явдалд байсан гэдэг. Үнэн хэрэг дээрээ, тэрээр утга зохиолынхоо нэр алдрыг ойшоодоггүй байсан гэдэг. Тэрээр жүжгийнхээ тавилтыг өөрөө энд тэнд зааварласан, бүтээлээ хэвлэх эрхийг өөрөө хөөцөлдөж явсан гэх мэт яриаг сонссон удаа үгүй. Тийм учраас л түүний бүтээл бичигдсэн цаг хугацаа одоо болтол оньсого хэвээрээ байдаг ажээ. Нөгөө талаар хамгийн тодорхой ойлгогдож байгаа зүйл бол театрын менежментийн ажилд ихээхэн өв бий болгосон гэдэг нь бодитой юм. Тэр амжилтынхаа ачаар төрсөн нутагтаа сэтгэл амар хоргодон суух боломжтой болсон ажээ.

Шүлэгч Теодар залуудаа цэргийн албанд зүтгэж, дараагаар нь татварын албаны зааварлагч болон ой хээрийн салбарын дарга болж чадал авъяасаа нээсэн байна. Мөн шүлэгч Спенсер Ирландын дэд губернаторын нарийн бичгийн дарга болон Гок мужийн даргын албанд томилогдож байсан бөгөөд практик ажлын тал дээр үл дутах оргилуун хүн байсан гэдэг.

Яруу найрагч Милтон ч бас эхэндээ дунд сургуулийн багш байсан, дараа нь дэвшиж, улсын улс төрийн бодлогын зөвлөлийн нарийн бичгийн дарга болж байжээ. Орчин үежиж буй тэр цагийн конгрессын хэлэлцэх асуудлын зар бичгийн жагсаалт хийгээд хадгалагдаж үлдсэн Милтоны өөрийнх нь бичигданс сэлтээс харахад ойлгогдож буйчлан тэрээр тэрхүү албаа гүйцэтгэхийн тулд эрчимтэй ажиллаж, чухал тустай үр дүн гаргаж байжээ.

Их эрдэмтэн Исаак Ньютон ч гэсэн нөгөө талаараа мөнгө цутгадаг газрын авъяаслаг дарга байлаа. 1694 онд англид шинэ мөнгөн тэмдэгт гүйлгээнд гарсан нь түүний шууд удирдлагаар хийгджээ. Эдийн засгийн эрдэмтэн Дэвид Ликард Лондонд биржийн ажил эрхэлж, нэлээд баялаг олохын сацуу, дур сонирхолтой судалгаандаа ч шамдаж байлаа. Удалгүй тэрээр ортодокс эдийн засгийн ухааны талын онолыг үндэслэсэн ба ухаалаг худалдаачин хийгээд өргөн дэлгэр мэдлэгтэй эрдэмтэн гэсэн хос өөртөө эвцэлдүүлжээ.

## *Тойруу аялал жинхэнэ баяр авчирдаг*

Бизнесийн амжилтанд хүрэх зам, хэрсүү ухааныг биедээ шингээх зам хоёр угтаа нэг юм. Энэ тал дээр мэдлэг хүртэж олж авах, шинжлэх ухааны судалгаа хийхтэй адилхан шургуу, хүчтэй зүтгэл, хичээл оролдлого хэрэгтэй.

Грекийн эртний сургаал үгэнд "ямар ч ажил мэргэжилтэй байсан чадварлаг хүн болоход дараах гурван зүйлийг дутааж үл болно. Тэр нь уугуул чанар, сурц, дээр нь дадлага" гэж байдаг. бизнест толгойгоо ажиллуулж, шургуухан дадлага хийгээд явах нь амжилт олохын нууц болдог. Хааяа "аз таарах" явдал байж болох л доо, тэр нь мөрийтэй тоглоомоор олсон "бохир" мөнгө шиг хүнийг орооилдуулж эвдэж магадгүй юм.

Бэкон бизнесийг замтай адилтгаж өгүүлсэн байдаг. "Хамгийн богинохон, ойрхон зам нь олонхи тохиолдолд хамгийн муу зам байдаг. Тиймээс хамгийн сайн замыг сонгоё гэвэл их бага ч тойруу замаар явах хэрэгтэй юм" гэжээ.

Тойруу замаар аялахад мэдээж хэрэг цагийг илүү зарцуулах нь дамжиггүй. Гэвч зүдрэлийн эцэст том үр дүнд мацаж хүрвэл тэр үе л жинхэнэ баяр баясгаланг авч ирэх нь маргаангүй билээ. Ямар ч аахар шаахар, яль шальгүй зүйл байлаа ч шийдсэн л ажил бол түүнийгээ яг таг хийж дуусгавал үлдсэн амьдралын тэр хэсэг чинь заавал ч үгүй гайхалтай зүйл болон эргэх болно .

Үхэлгүйг олохын тулд гурван бэрх үйлээс зугатсан Хераклесийн үлгэр нь янз бүрийн хүмүүсийн үйлдлийн загвар билээ. Ялангуяа залуу хүмүүс, хүний амьдралын аз жаргал, цэцэглэл мандал нь бусдын тусламжаар авах, юмны ард зогсохоор бүтэхгүй, түүнийг өөрөө өөрийнхөө хүчээр ялж олж авахад оршино гэдгийг чанд ухамсарлах хэрэгтэй .

Яруу найрагч Мор, Жон Лассел-ыг зуучлагч болгож Мелбоннд өөрийн хүүдээ туслахыг гуйсан тухай яриа байдаг. Мелбонн Ласселд хаягласан хариу захиандаа тун их үр өгөөжтэй зөвлөмж өгсөн байдаг.

"Эрхэм хүндэт Жон танаа Мор-ын захидалд хариу өгье. Хунд туслах төдий чадвар надад байгаа учир, миний бие хүүгийн хүсээнийг гүйцэлдүүлэхэд болохгүй юм байхгүй ээ. Гэвч тусламж үзүүлнэ гэдэг тухайд Мор гуайн хувьд өөрөө зохимжтой юм гэж би бодож байна. Түүний хүүтэй адил залуу хүнд өчүүхэн бага боловч тусламж үзүүлнэ гэдэг яаж ч бодсон зөв зүйтэй арга хэмжээ биш юм. Түүгээр барахгүй тэр залууг ташаа ойлголтоор хучиж ч магад. Бодит байдлаасаа илүүтэй ихээхэн зүйлийг бусдаас авч байна хэмээн бодож орхивол залуу хүн хичээл зүтгэлээ гаргахгүй болчихно. Тиймээс түүнд ийм зөвлөмж өгөөд орхивол хангалттай гэж бодож байна. "Өөрийн замаа өөрөө гарга. Өлсөх үү, өлсөхгүй юу, бүгд өөрийн чинь хичээл зүтгэлээс шалтгаална..., миний хэлсэн үгэнд итгэж өгөөч!" гэжээ.

## **2. "Хийх ажилгүй амьдрал" аймшигтай!**

Толгойгоо ажиллуулж, бүхий л хүчээрээ хичээж зүтгэвэл заавал сайхан үрдүн гардаг. Хичээл оролдлоготой хүнийг урагш хөдөлгөж, бодьгал чанарыг нь татаж гаргаж, бусдын үйл хөдөлгөөнд ч түлхэц үзүүлж болдог. Түмэн хүн ав адилхан тушаал дэвших учир үгүй ч, бүхэлдээ хүн өөр өөрийн хичээл зүтгэлд нийцэж дэвшиж дээшлэх нь зүйтэй. Италийн Тоскан нутгийн зүйр үгэнд: "Хэн ч задгай талбай дээр амьдрахыг байг гэх газаргүй боловч нарны гэрэл бүх хүмүүсийн дээр эн тэнцүү тусаж байдаг" гэснийг сана.

Нийтлэг байдлаар хэлбэл нэлээд шулуун дардан амьдрал хүнийг эвдэлдэг. Ойр хавьд нь ямар нэг дутуу гуцуу үгүй, унтах идэхэд зовлон үгүй амьдралаас илүү, хэрэгцээнд хөөгдөж, хичээнгүйлэн хөдөлмөрлөж, даруухан амьдарсан нь дээр юм. Бэрх хэцүү аж байдлаас амьдралаа эхэлбэл тэр чинээгээр ажил хөдөлмөр хийх хүслэн босч ирдэг. Ийм болохоор ядуу зүдүү амьдрал амжилт олохын чухал нөхцлийн нэг гэж хэлж болох юм.

Хуулийн ертөнцөд нэр алдартай нэгэн шүүгчээс амжилт олохын нууцыг асуухад тэрээр: "Шилдэг авъяасынхаа ачаар амжилт олсон хүн байдаг бол, бас бүр гайхалтай учралаар амжилт олсон нь ч бий. Гэхдээ олонхи нь цулгүй хоосон нөхцөл байдлаас үхтлээ хичээл зүтгэл гаргаж байж одоогийнхоо байр сууринд хүрсэн байдаг юм даа" гэжээ.

Нэгэн лут барилгачны тухай ийм нэгэн яриа тархжээ. Тэр эр удаан хугацаанд барилгын талаар судалж, чадал сууж нэлээд орноор явж юм үзэж нүд тайлсныхаа дараа, эх орондоо буцаж ирээд ажлаа эхлэхээр шийдэж гэнэ. Тэрээр ажил хийлгэе гэвэл юу ч байсан хийе хэмээн сэтгэлдээ шийдээд байжээ. Хамгийн анх хүлээж авсан үүрэг нь хүн суухаа больсон байшинг засварлан

босгох ажил байлаа. Энэ нь барилгын ажил дотроо хамгийн дорд ажил хэмээгдэж, үнэ мөнгөний тал дээр ч гавихгүй зүйл байжээ. Гэлээч тэрээр ухаалаг эр учир огт дээгүүр харж голж шилсэнгүй. "Юутай ч албан ёсны ажилд орсон болохоор бүхий л чадлаараа хичээж, хэзээ нэг цагт сайн ажилд шилжиж очно" гэж шийдсэн ажээ.

Долдугаар сарын халуун өдөр тэрээр нэгэн навсгар байшингийн дээвэр дээр авирч гараад ажил хийж байлаа. Тийшээ хааяа найз нь дайраад буцдаг тул тэрээр нүүрсний тортогтой хөлсөө гараараа шудрангаа дээвэр дээрээс хашгирч байна гэнэ.

"Би Грекийгбүхэлд ньтойрч ирсэн атлаа ийм ажил хийж сууна гэдэг үнэхээр утга алга байгаа биз!".

Гэвч хичнээн тааруухан ажил байлаа ч тэрээр оромдолгүй маш сайхан хийж дуусгажээ. Тэгээд тэвчээртэй хичээж чармайсаар аажмаар мөнгөтэй ажил руу шилжсэн байна. Удаа ч үгүй мастер барилгачин хэмээн нэрлэгдэх болсон гэдэг.

Үнэн чанартаа хичээл зүтгэл нь хувь хүний ахиц хөгжил болон нэг улсын иргэншлийн хөгжлийн суурь үндэс болж байдаг. Хичээл зүтгэл гаргалгүй ямар нэг хүсэл мөрөөдлөө биелүүлнэ гэвэл хүн юунд ч тэмүүлэхгүй, түүндээ хүрье хэмээх хүслэнгүй болох бус уу. Энэ бол амьдрах хамгийн муу арга, хурдан арилгах ёстой тэр зүйл мөн. Хүний амьдралд өчүүхэн ч болов зорилго, ажлын хэрэгцээ, шаардлага байхгүй байна гэдэг ухаалаг хүнд бол, тэр тухай бодох төдийд л байж суухын аргагүй шахам зовлон билээ.

Нэгэн язгууртны ах нас барах үед танил тайж нь үхлийн шалтгааныг нь асуухад дүү нь: "Ах үхсэн нь хийх ажил байхгүй байснаас болсон юм" гэжээ. "Хөөрхийлөлтэй байна" гэж тайж хэлэхэд "Хийх ажилгүй амьдралд живж орхивол авъяаслаг жанжин хүртэл ингээд биеэ мөхөөчихдөг юм байна аа" гэжээ.

### *Нойрмог арслангаас хуцдаг нохой дээр*

Амьдралдаа бүдэрсэн хүн заримдаа өөрийгөө гэм зэмгүй хохирсон хэмээн тооцож, өөрийнхөө хувь тавилангүй байгааг бүгд өөр хүний буруугаас болсон гэж юуны түрүүн боддог. Жишээлбэл, нэртэй нэгэн зохиолч зохиолдоо өдий болтол олон зүйлд алдаа гаргасан тухайгаа өгүүлсэн байдаг. Тэрээр бүтэлгүйтсэнийхээ шалтгааныг алдах, олохын тооцоонд ер мэдлэггүй байсантайгаа холбож хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ, эцсийн эцэст дампуурлынхаа жинхэнэ учир шалтгааны бурууг тэр цагийн мөнгө хүүлэх үзлийн урсгалд тохсон байдаг.

Өөрийгөө хувьгүй одонд төрсөн хэмээн бодох хүн ч буй. Тэд өөрийгөө ойчих учир үгүй атал хорвоо ямагт тэдний бодсоноос эсрэг зүг рүү чиглэн явж байдаг гэж итгэж суудаг. Иймэрхүү нөхдийн дотор "намайг малгайчин боллоо ч гэсэн тэр үед хорвоогийн хүмүүс цөмөөрөө толгойгүй төрөх биз, тиймээс яагаад ч амжилт олохын учир байхгүй" зэргээр цөхөрсөн царайгаар ярих нөхөр ч байх буйза.

Гэлээ ч "азгүй, азтан хоёр хаяа залгаж суудаг" гэсэн Орос ардын цэцэн үг байдаг билээ. Үргэлж өөрийнхөө хувь муутайг үглэж суудаг хүний олонхи нь өөрийнхөө залхуу хойрго, үр дүнгүй, чадваргүй, бас оролдлого зүтгэлээр дульмагаа л хүлээж байгаа хэрэг.

Жонсон доктор хөдөөнөөс Лондонд ирсэн үедээ халаасандаа ердөө диннер-ийн ганц дэвсгэртээс өөр юу ч үгүй байв. Тэрээр нэгэн язгууртанд бичсэн захидалдаа өөрийн нэрнийхээ оронд "идэхээс Дутсан хүмүүн" гэж гарын үсэгээ зурж байсан гэдэг. Тэрээр дараахь зүйлийг товч тодорхой онцлон өгүүлжээ. "Хүмүүст энд тэнд зовлон жаргалаа тоочих нь үнэхээрийн эндүүрэл мөн. Ямар нэгэн сайн талтай хүн бол цаг үргэлжид үл тоомсорлогдсоор байдаггүй. Амжилтыг барьж авч чадахгүй байгаа нь барагтаа л бол уг хүний өөрийн муугаас болдог юм".

Америкийн зохиолч Вашингтон Арбинг ч Жонсон доктортой адил бодолтой байгаа нь дараахь үгнээс нь харагддаг.

"Хүн нэг ч бай хоёр ч бай сайн талтай байтал хэнд ч тоогдохгүй байна гэхчилэн шалтаг тоочиж байгаа бол тэр нь үнэхээр худлаа яриа юм. Голдуу л тийм нөхөр өөрийнхөө залхуу зуршил, зоримог шийдмэг бус байдлаа хаацайлж, амжилт олж чадахгүй байгаагаа бусдаас болж байгаа мэт болгодог. Мэдээж хэрэг, хүний сайн талын тухайд мянган ялгаа, түмэн янз бий агаад түүний

олонхи нь зам зуураа замхардаг эд юм. Гэвч үнэхээрийн хурц, чадмаг сайн талтайдүүнийгээ цаг үргэлж илэрхийлж байдаг хүнийг бол, хүмүүс харахгүй алдана гэж үгүй билээ. Харин ямар ч сайн талтай байсан түүнийгээ гэрийн хорионд байлгаж, бололцоо ирэхийг зөвхөн хүлээж суудаг бол ярих юм алга.

"Шууд л дайрдаг, ичгүүргүй хүн амжилт олдог бөгөөд авъяас байлаа ч ичимтгий бүрэг хүн хүнд хайхрагддаггүй" гэх мэт тайлбар ч бас нэлээд сонсогддог. Гэвч энэ ч бас айхавтар яриа юм.

Тийм хүмүүст сортоотой хөдлөх гэдэг ховорхон чанар заяасан байдаг. Энэ чанар байхгүй бол хичнээн гайхалтай сайн талтай байсан ч тийм үнэт эрдэнээ өмхийрүүлэхээс хэтрэхгүй. Ингэхэд хуцдаг нохой нойрмог арслангаас илүү хэрэг болох нь олонтой догоо.

### **3.Бизнесийг амжилтанд хүргэх зургаан зарчим**

Ямар ч бизнест түүнийг үр ашигтай удирдахад дутааж үл болох зургаан зарчим байдаг. Тэр нь анхааралтай хянамгай байх чадвар, хичээл зүтгэл, нарийн нягт нямбай байдал, чадварлаг гүйцэтгэл, цагийг хатуу баримтлах, дээр нь хурдан гавшгай байдал билээ.

Эдгээр зургаан зарчим өнгөц харахад яль шальгүй зүйл мэт санагдах авч, үнэн хэрэгтээ хүний хорвоод хэрэг болох, аз жаргал, мандал бадралаа өөрөө олоход туйлын чухал утга учир агуулж байна. Эдгээр зургаан талыг мэдээжийн өчүүхэн бага зүйл гэвэл, хүний амьдрал гэдэг эртнээс нааш, харьцангуй өчүүхэн бага сага зүйлээс бүрдэж буй болдог гэдгийг санаарай. Өчүүхэн төдий үйлдлийн давталтын улмаас хүний бүх араншин бүрдэж бүтэж, төр улсын шинж чанар хүртэл шийдвэрлэгдэж байдаг.

Суртахуун самуурсан хүн хийгээд ужидад унасан төр улсад өчүүхэн бага зүйлийг үл тоомсорлож ирсний ул мөр үзэгдэж байдаг, энэ бол бараг заавал шүү.

Хүн гэгч хэнд ч болов. өөр өөрийн үүрэг гэж байдаг. Үүнээс улбаалаад үүргээ гүйцэтгэхийн төлөөх чадвараа зүлгэх хэрэгцээ гэж буй. Өрхийн төсвөө арга чаргыг нь олох ч бай, бизнесийн шинжлэх ухааны судалгаа ч бай, бүр нэг улсын улс төр ч бай бүгд ижил юм.

Бид энэ хүртэл үйлдвэрлэл, урлаг, шинжлэх ухааны салбарт агуу зүйлийг хийж гүйцэтгэсэн хүмүүсийг жишээг олноор үзэж ирлээ. Тиймээс ямар ч ажил мэргэжилд шургуу байдал, хичээл зүтгэл нь чухал юм гэдэг тал дээр маргах зүйлгүй бизээ. Өчүүхэн жижиг сажиг зүйлд цаг үргэлж анхаарал тавьж байх явдал хүний дэвшил хөгжлийн эх юм гэдгийг өдөр тутмын туршлага зааж өгч байна. Тиймээс хичээл зүтгэл бол аз жаргалыг төрүүлэх ээж мөн гэлцдэг билээ. Нарийн нягт нямбай байдал ч маш чухал тал мөн. Уг хүн боловсрол, дасгал сургуулийг хангалттай хуримтлуулсаар ирсэн үү, үгүй юү гэдгийг тодорхойлдог шалгуур ч болдог зүйл.

Юмс үзэгдлийг анхааралтай ажиглах, хүний өмнө ярих, ажил хэргийг зохион байгуулах явцад нарийн нягт байдал юу юунаас ч илүү эрхэм юм. Бизнесийн хувьд бол оногдсон хариуцлагыг чадварлаг гүйцэтгэх явдлыг цаг ургэлж шаардаж байдаг. Багахан ажлыг гайхалтай хийж давах нь түүнээс арав дахин илүү ажлыг дунд нь орхисноос хавьгүй дээр билээ. Нэгэн ухаантай хүн "ажлыг арай л илүү хурдан хийж дуусгамаар байвал, бага зэрэг завсарлаж амарсан нь дээр" гэж үргэлж ярьдаг байсан гэдэг.

Ингэхэд өнөө үед, нягт нямбай байдал хэмээх маш чухал чанарт бараг анхаарал тавихгүй болжээ. Алдартай нэгэн эрдэмтэн "Гайхалтай нь хэрэг явдлыг нарийн нягт үнэн зөв магадалдаг хүнтэй одоо хүртэл бараг учирч явсан удаа алга байна" гэж өгүүлж байсан гэдэг.

Бизнест аахар шаахар хэрэг явдлыг яаж шийдвэрлэж байгаагаар тэр хүний байр суурь хийгээд чадвар хэмжигдэж байдаг. Тухайлбал хүн чанарын хувьд халуун дулаан, бусад тал дээр гайхалтай хөдөлгөөнтэй байлаа ч юмыг нарийн нягт зөв явуулж чадахгүй бол итгэл хүлээхгүй. Тийм хүнээр хийлгэсэн ажлыг дахин хянаж зааварлахгүй бол болдоггүй. Тэр ажил маш их тээртэй, яс хугарам үйлдэл болдог. Ийм учраас л тиймэрхүү хүн бусдад тоогдохгүй болчихдог талтай.

## ***Өнөөдөр хийх ёстой ажлаа маргааш гэж буу сунга***

Самбаатай гүйцэтгэл ч бизнесийн амжилт олоход дутааж үл болох зүйл мөн. Энэ чадвар байвал ажлын хэмжээ их байлаа ч түүртэх юмгүй бүтдэг.

Христийн лам Ричард Сешел "Самбаалаг гүйцэтгэл гэдэг нь хайрцагт юмыг савлах ажилтай төстэй юм. Чадварлаг ажилладаг хүн, тааруухнаасаа хоёр дахин их ачааг савлана шүү дээ" гэсэн байдаг. Тэрээр ажлыг гялс манас хийхдээ гойд авъяастай байлаа. Олон ажлыг гүйцэтгэх хамгийн ойр зам бол нэг удаад нэгээс өөр ажлыг хийхгүй байх явдал юм" гэдэг байв.

Тэрээр нэг ажилд гар хүрэхээрээ дуусгалгүй хэвээр нь орхиж хожмын цаг завандаа даатгах хэмээх салан палан явдлыг хэзээ ч хийж байсангүй. Нэн яаралтай ажил гарвал өмнөх ажлынхаа зарим нэг хэсгээс гар салгахын оронд харин хоол унд, нойрноосоо хасахыг сонгох нь дээр гэж үздэг байсан.

Голландын улс төрч Де Витт-ын гүйцэтгэх зуршил Р.Сешелтэй төстэй байв. Тэрээр "Нэг удаад нэг л ажлыг хий. Хэрвээ яаралтай ажил гараад амжуулахгүй бол болохгүй байдалд орвол түүний үр дүнг гартал өөр ажлыг битгий бодож бай. Тухайлбал гэрийн доторхи зүйл эмх замбараагүй болсныг анзаарвал нэг амьсгаагаар эцэс болгож орхих нь зөв".

Францын нэгэн элчин сайд ажил хэргийг хийж гүйцэтгэхдээ хурдан гавшгайгаараа алдартай байв. Бас тэрээр зугаа цэнгээний газар өдөр алгасахгүй дандаа очдогоороо ч алдартай байв. "Хоёуланг нь ингэж чаддагийн нууц нь юунд байна" хэмээн асуухад тэрээр: "Өнөөдөр хийх ёстой ажлаа маргааш гэж бүү хойшлуул хэмээх сургаалийг хатуу чанга баримталж ирсэн төдий л юм" гэжээ.

Гэтэл Английн нэгэн элчин сайд энэ дэглэмээс тэс зөрүү үйлддэг байсан гэнэ. Өөрөөр хэлбэл тэрээр "маргааш хүртэл хойшлуулж болох ажлыг өнөөдөр хийх албагүй" гэж боддог байв. Харин энэхүү ховорхон улс төрчийн нэр өнөө бидэнд мартагдаж орхисон агаад, иймэрхүү нөхөд нэлээд олон байдаг.

Өнөөдрийн ажлаа үүлгэртэн байж нэг өдрөөр хойш сунгаж байх нь залхуу хүний юмуу эсвэл ялагдагчийн зуршил юм. Түүгээр ч барахгүй тэд өөрийнхөө ажлыг шууд л өөр бусдад даатгахыг хичээдэг.

Харин бусдад хэтэрхий итгэвэл хэцүү юмтай тулгарах тохиолдол олон бий. Нэн ялангуяа хамгийн чухал ажлаа өөрөө хийж байх ёстой. Сургааль үгэнд байдагчлан "Заавал хийх ажлаа өөрөө хийж, за яасан ч яахав гэснээ бусдад даатгах" ёстой юм.

Нэгэн нутагт залхуу, газрын эзэн амьдардаг байлаа. Эзэмшиж буй газраасаа жилд таван зуун фунтын түрээсийн мөнгө олдог авч, удалгүй орд харш баригдсан тул газрынхаа хагасыг зарж, үлдсэн хэсгийг нь ажилсаг зарцдаа хорин жилийн гэрээ хийж түрээслүүлжээ. Гэрээний хугацаа дуусах үед зарц нь газрын эзний гэрт очиж түрээсийн мөнгөө төлөөд зээлүүлсэн газраа надад худалдахгүй юу гэж гуйжээ.

"Чи газар худалдаж авна гэв үү" хэмээн газрын эзэн гайхсанд зарц нь юу ч болоогүй царайгаар:

"Тэгээд яагаав, гэхдээ үнэ хөлсөө тохирвол ярих яриа шүү" гэв.

"Яагаад ч юм сэтгэлд багтахгүй байна даа" хэмээн газрын эзэн яриагаа үргэлжлүүлэв.

"Миний бие урьд чамаас олон дахин илүү том газартай байж, бас газрын түрээсийн мөнгө төлөх шаардлагагүй байсан атал эцэст нь амьдрал маань болж бүтсэнгүй. Гэтэл чи хорин жил надад газрын түрээсийн мөнгө төлөөд дээр нь газар худалдаж авах хэмжээний мөнгө хураасан гэх юм. Чухам юу болж байгаа нь энэ вэ?" гэв.

"Ямар нэг учир шалтгаансаад байх юм алгаа хө. Эзэнтэн та цаг үргэлж унтаж нойрмоглоод, өв хөрөнгөө идэж байсан. Харин би өдөр бүр өглөө эрт босч, газрын ажилд дарагдаж байсан. Зөвхөн ийм төдий л ялгаа л даа ноёнтоон" гэжээ.

## ***Цагийг дэмий өнгөрүүлэл сэтгэл шарилжинд идэгддэг***

Ажил хөдөлмөрийн гараагаа эхлэхэд ойртсон нэгэн залуу, яруу найрагч Вольтер Скотт-д хандаж зөвлөгөө өгөхийг хүсчээ. Скотт энэхүү залууд хаягласан захидаддаа:

"Цагийг хангалттай бүрэн дүүрэн ашиглахгүй бол удалгүй муу зуршилд идэгдэх болдог. Өөрөөр хэлбэл "бохир зуршил". хэмээх эдэд баригдана.

Ийм муу зуршилд торж унахаас сэргийлээрэй. Чи "бүхий л чадлаараа хичээж зүтгэх"-ийг маанийн уншлага болгох ёстой юм. Хийх ёстой ажлаа шууд л гүйцэтгэж бай. Цэнгээний цагаа ажлынхаа дараа болго. Ажлаа хэрэгсэхгүй зугаацаж байж болохгүй.

Цэргүүд давшиж байхад жагсаалын сүүлийн салааныхан бужигнадцаж байх нь олонтоо ажиглагддаг. Тэр бол толгой хэсгийн цэргүүдийн такт алдагдан, давшилт бөглөрч орхидгоос тэр юм. Бизнес ч мөн адил. Хамгийн эхний ажлаа шууд л барьж аван, итгэлтэй хурдан хийж эхлэхгүй бол бусад ажил нь бөөгөөрсөөр, удалгүй хуримтлагдсан асуудалд шахагдаж, бодит байдлаа авч гарч чадахгүйд хүрэх болов уу" гэжээ.

Цагийн үнэ цэнийг зөв ухаарвал үйл хөдөлгөөн хүртэл өөрөө сэхээтэй самбаатай болж ирдэг. Италийн нэгэн гүн ухаантан "цаг бол эд хөрөнгө юм" гээд, харин энэхүү өв хөрөнгө хэрэглэх арга нь муу байвал огтхон ч үнэ цэн төрүүлэхгүй, сайтар ашиглаж чадвал заавал аз жаргал авчрах зүйл мөн гэжээ.

Үнэндээ, цагийг үр ашиггүй өнгөрөөвөл оюун санаан дотор хогийн хорт ургамал дүүрдэг. Юу ч боддоггүй толгой чөтгөр шулмын ажлын байр болж, залуу хүн чөтгөр толгойгоо дэрлэх дэр нь болж өгдөг. Зав чөлөөгүй ажиллах нь бусад хүнд хоосон гэрээ хөлслүүлж байгаатай агаар нэг, эсрэгээр хийх юмгүй залхуурч байгаа нь хоосон гэрээ сул орхиод хаяж буйтай адил юм. Хоосон гэр болж орхисон оюун санаанд дэмий хүслийн хаалга нээгдсэнээс болоод дур хорхой гэтэж ирэн, хорлонтой бодол сүргэлэн орж дүүрдэг юм шүү.

Далайд аялахад ч хөлөг онгоцонд суугсад зав чөлөө ихдэх хэрээр элдэв шалтаг тоочиж хөлгийн капитаныхаа эсрэг хөдлөх боддог.

Үүнийг сайн мэддэг өвгөжөөр нэгэн капитан далайчид нь хийх ажилгүй завтай болонгуут заавал "уур хилэнгээ угаацгаа" гэж тушаал өгдөг байсан гэнэ.

### ***Өдөрт арван таван минутыг ашиглах арга хүний амьдралын гэгээрэх, харанхуйлахыг шийддэг***

Бизнестэй холбоотой хүмүүс "цаг бол мөнгө" гэдэг зүйр үгийг иш татах дуртай байдаг. Харин "цаг бол мөнгөнөөс илүү" гэж хэлэх нь зөв юм шиг.

Цагийг зөвөөр ашиглавал өөрийгөө гэгээрүүлж, зан араншингаа сайжруулж, бодгаль чанараа тэлдэг. Хэрвээ өдөр бүр дэмий хэрэгт зүглэж, цагаа утга учиргүй, үр ашиггүй зүйлд зарцуулж байгаа бол тэр дундаасаа ганцхан ч цагийг болов өөрийгөө гэгээрүүлэхийн тулд олгох хэрэгтэй юм. Тэгвэл ямар ч эрдэм боловсролгүй хүн ч гэсэн хэдэн жилийн дотор ухаалаг хүн болж хувирна.

Гайхамшигт ажил хөдөлмөрт цагаа зарцуулбал хүний амьдрал үр жимсээр баян болж, үхэх хүртлээ утга учирлаг үр дүнг олонтоо гаргах болов уу.

Нэг цаг гэлтгүй, нэг өдөрт арван таван минут ч байсан болно, өөрийгөө боловсруулахад хандуулж үзвэл сайн. Нэг жилийн дараа заавал баттай үр дүн илэрхийлэгдэх ёстой билээ.

Шилдэг үзэл бодол хийгээд зовж зүдэрч байж олж авсан туршлага бол хадгалсан ч орон байр эзлэхгүй, хаашаа ч аваад явсан мөнгө зардал нэхэхгүй, хөл гар хүлэхгүй. Цагийг арвитай ашиглах нь зав чөлөөг баталгаажуулах зөв арга ч болдог. Цагийг чадарлагаар зохицуулбал, ажилд хөөгдөлгүй, асуудлаа бүрэн дүүрэн гүйцэтгэхийн дээр, цаашлаад дараагийн ажилдаа ч эхлэл тавьж чадах болдог.

Харин бүр эсрэгээр цагийг ашиглах арга дээр эндүүрвэл, яруу сандруу, эмх замбараагүй хоног өдрүүд үргэлжилж, аль аль нь мухардалд орох болно. Иймэрхүү мухар сохор амьдрал удалгүй томоохон гай түйтгэр авчирдаг. Нелсон адмирал "Би амжилтанд хүрсэн нь ямар ч хэрэг болж байсан, тогтсон арван таван минутын өмнө ажлаа эхэлж байсны ач юм" гэж өгүүлсэн байдаг юм шүү.

Мөнгийг зарж барах хүртлээ түүний арга ухааныг анзаарч үздэггүй хүн олон. Цагийн тухайд ч бүр их.

Залхуу хойрго амьдралд биеэ зөнд нь орхиод, хүний амьдралд үлдэж буй хугацаа цөөрөөд ирэхийн хамт "цагийг илүү ухаалаг зарцуулах ёстой байлаа" гэх мэтээр гэмших хүн хэчнээн олон байдаг гээ. Гэвч тэр үед цаг аль хэдийн энэрэлгүйгээр арилж, бас залхуу хойрго амьдралын хэвшил нь хувирч өөрчлөгдөх шинж ердөө ч үгүй, өөрөө дүрсэн хавхнаасаа хөлөө сугалах нь хүртэл бололцоогүй болчихсон байдаг.

Алдагдсан эд баялаг хичээл зүтгэлийн улмаас хуучин хэвдээ орж чадахыг үгүйсгэхгүй. Алдагдсан мэдлэг хичээнгүй сурлагаар эргэж дүүрч чадах, алдагдсан эрүүл мэндийгтэвчээр хийгээд эмээр эгүүлэн буцааж авч магадгүй. Харин алдагдсан цаг мөч л гагцхүү үүрд мөнх эргэж ирдэггүй юм шүү.

### ***Цагт хайр гамгүй хүн амжилтын галт тэрэгнээс хоцордог***

Цагийн үнэ цэнийг үнэн зөв ухаарч ойлгож чадвал цагийг хатуу баримтлах зуршил аяндаа биед хэвшээд ирдэг. 14-р Луй "цагийг чанд баримтлах нь ван миний хувьд ёс жаяг" гэж өгүүлж байсан ба тэр нь тэр цаг үед бид бүхний үүрэг мэт болж, бизнест хамаатай хүмүүсийн тухайд зайлшгүй чухал нөхцөл мөн. Энэхүү сайн үйлсийг хамгаалж байвал хэнээс ч илүү хурдан түргэн итгэлийг олж авч чадах ба харин нөгөө талаар тэрхүү сайн үйлсийг дутааж орхивол шууд л бусдын итгэл алдахад хүрдэг.

Бусад хүмүүстэй хэлэлцэн тохиролцсондоо хүрч, уулзахаар болзсон цаг хугацаандаа хоцордоггүй хүн өөрийн цаг төдий бус нөгөө талынхаа цагийг ч хүндэтгэж үзэж байдаг. Хэн нэгэнтэй ажил хэргээр уулзах тохиолдолд, тэр хүн цаг хэр баримталж байгаагаар хүндэтгэлд хүрэх эсэх нь тодорхойлогддог. Цагийг хатуу баримтлах нь хүний сайн сэтгэлтэй ч хамаатай асуудал юм. Хэлэлцэж тохиролцох гэдэг нь тов тодорхой шийдсэн зүйл ч бай, хараахан тодорхой бус ч бай нэгтөрлийн гэрээнээс өөрцгүй. Хэлсэн амандаа хүрдэггүй хүн нөгөө хүнийхээ цагийг ёс бус үрээд зогсохгүй, шударга үнэнд эсрэг, итгэл эвдсэн үйлдлийг гаргаж буйтай адилхан. Ийм хүн заавал ч үгүй хүмүүсээс доод үнэлэлтийг авах болов уу.

Ингэж эргэцүүлэхэд мэдээжийн хэрэг нэгэн дүгнэлтэд хүрч байна. Өөрөөр хэлбэл, цаг хугацаанд нүдэн балай чихэн дүлий хүн, бизнест мөн адил нүдэн балай чихэн дүлий, тийм хүнд нэн чухал асуудлаа эрхлүүлэхээр итгэж даатгаж болохгүй юм. Вашингтон ерөнхийлөгч нарийн бичгийн дарга нь цагаас хоцорсныхоо шалтгааныг цагаа хадуурч явж буйтай холбож тайлбарлахад :

"Тийм л юм бол шинэ цагаар солих хэрэгтэй. Эс тэгвэл, би нарийн бичгийн даргаа шинэ хүнээр солихгүй бол болохгүй болж байнаа даа" гэжээ.

Цагийг үл тоомсорлож, түүний ашиглах арга эвийг огт боддоггүй хүн бусад хүний тайван, амар жимэр амьдралыг бусниуламтгай байдаг. Честфейлд нэгэн, өвгөжөөр гүнтний тухайд ийн ярьж байна. "Энэ эрхмийг ирэхээр өглөөний нэг цагийг заавал ч үгүй дэмий өнгөрөөж, өдрийн үлдсэн хугацаанд түүнийгээ эргүүлэн авах гэж гэр Дотроо бужигнуулж, сандааж суух юм даа" гэжээ.

Үнэн хэрэгтээ, цаг баримталдаггүй хүнтэй нөхөрлөхөд, хэн ч байсан санаа сэтгэлээрээ хохирдог. Юутай ч тэдний хувьд цаг хоцрох нь хэвийн үзэгдэл, дүрэм журамгүй амьдрал нь мэдээжийн хэрэг болж буй учир эцэс дүндээ тэд нь нэг их хохироод байдаггүй юм.

Болзсон цагтаа хоцорч очдог. Галт тэрэг хөдлөөд байхад арайхийн буудалд хүрч очдог. Шууданчин явсан хойно захидлаа шуудангийн хайрцагт хийдэг. Энэ мэтээр ажил замбараагүй болж, оролцогчид бүгд уурандаа дэлбэрэх шахах учиртай.

Иймэрхүүгээр цаг хоцрох хүн, мэдээж хэрэг амжилтаас хоцрох нь дамжиггүй, Тэгээд хүмүүсээс зэм хүлээж, хувь заяаныхаа бурхан тэнгэрт гомдол, зарга мэдүүлж эхлэдэг. Бидний эргэн тойронд ч харамсалтай нь ийм нөхөд зөндөө олон байдаг юм.

### **4.Вейлинтоныг их жанжин болгосон "ажил хэрэгч чадвар"**

Энэ хүртэл өгүүлж ирсэнчлэн, анхаарлын өндөр чадвартай, хичээл зүтгэлтэй, нарийн нягт нямбай, самбаа сайтай байж, цагийг нарийн баримтлаж, бас дээр нь хурдан шалмаг байх хэмээх зургаан нөхцөл нь бизнесменд дутагдаж үл болно. Гэхдээ тэргүүн зэрэглэлийн бизнесмен болохыг зорьж байгаа бол цаашлаад хурдтай мэдрэмжийн хүч, төлөвлөснөө баттайгаар хийж дуусгах хүчтэй зориг чухал юм.

Үүний дээр хорвоог туулахад авхаалж самбаа ч хэрэгтэй чанар юм.

Энэхүү чанар нь нэг талаар төрөлхийн авъяаст багтах авч, ажиглалт, туршлагын улмаас түүнийг зүлгэж, уртасгаж ч бас болох билээ. Авхаалж самбаатай хүн зөв үйлдэл аргыг хурдан олж харж

гаргадаг. Тиймээс зорилгоо л тодорхой тогтоовол хүлээж авсан ажлаа хүрэх газарт нь амжилттай хөтөлж оддог.

Хурц мэдрэмж, бат нот зориг, авхаалж самбаа энэхүү гурван чанарыг дайны талбарт цэрэг командлаж буй жанжинтай адил ажилтнууд, удирдах хүмүүс эзэмшсэн байх ёстой. Жанжин хүн цэргийнхээ хувьд гарамгай төдийгүй, ажил хэрэгч байх тал дээр ялгарсан чадвартай байхгүй бол болохгүй. Яагаад гэвэл, ялалтын өдрийг хүртэл тулалдаанаа үргэлжлүүлэхэд цэргүүддээ хоол хүнс, хувцас, бусад зүйлээр бүрэн хангаж, элдэв нарийн халамж анхаарал тавьж байхгүй бол болохгүй. Тиймийн тулд жанжинд бялхсан хурц ухаан, хүний мөн чанарын тухай гүн гүнзгий мэдлэг, бас бүх цэргийнхээ үйл хөдлөлийг атгаж байх чадвар шаардагддаг.

Вейлинтон жанжин ажил хэрэгч чанарынхаа хувьд гойд хүн байлаа. Түүний зүглэсэн газарт дайсан ямагт ялагдаж, тэрээр нэрт жанжин болж амьдралаа өнгөрөөсөн агаад үнэхээр гоц авъяастай, ажил хэрэгч хүний бэлэг тэмдэг байсан.

Вейлинтон, түшмэл Еорк, Вормоден жанжны удирдлага дор Франц болон Холландын дайнд оролцож, цэргийн хүн болох анхны алхмаа хийжээ. Энэхүү тулаан Английн цэргийн хувьгүй ялагдлаар дууссан бөгөөд, тэнд тэрээр цэргийн ажил хэрэгч гүйцэтгэл болон удирдлагын муу байдал нь байлдагчдын сэтгэлийг эвдлэх учир шалтгаан болдгийг биеэр амсаж мэдэрчээ.

Цэргийн албанд орж арван жил болоод Вейлинтон хурандаа цолтой болж Энэтхэг рүү илгээгдэв. Удирдлагынх нь ярианаас үзвэл, тэрээр цуцахыг мэдэхгүй, эрчимтэй ажилладаг хичээл зүтгэлтэй офицер байлаа.

Цэргийн ажлын тухайд бүр өчүүхэн жижиг зүйлийг хүртэл өөрөө нягталж, цэргийн сахилга батыг хамгийн дээд түвшинд хүртэл өөд нь гаргахаар махран тулалдаж байв. 1799 онд Харис жанжин захидалдаа:

"Вейлинтон хурандаагийн хороо, бүх цэргийн үлгэр дуурайлал мөн. Цэргийн хүний байр байдал, сахилга бат, боловсрол хүмүүжлийн аль аль дээр үнэхээрийн хэлэх зүйл алга" гэжээ. Ийнхүү цэргийн командлалаас итгэл хүлээсэн Вейлинтон удалгүй Майсол мужийн захирагчаар томилогдов. Марат үндэстэнтэй тулалдсан тулалдаанаар анх цэргийн командлагыг хүлээн авсан тэрээр ердөө 1500 англи, 5000 сепой цэрэгтэй холимог хороог удирдаж, хорин мянган явган цэрэг, гучин мянган морьт цэргээс бүрдсэн маратчуудыг ялсан билээ. Тэр нь мөнөөх аддарт "ассейны тулалдаан" юм. Тэр үед тэрээр гучин дөрөвхөн настай залуу байлаа. Тэрхүү гайхамшигтай ялалтад ч ер биеэ тоолгүй, чин сэтгэлийн зан төрх нь жаахан ч гэсэн хувираагүй билээ.

### *Эрүүл саруул бас цагаа олсон шийдэл*

Маратчуудтай байлдсаны дараа Вейлинтон удирдагч мөнийхөө хувьд магтан дуулах ёстой авъяасаа гаргаж ирэх бололцоо бүрдэж ирэв.

Дайн төгсгөлийн үедээ орж, нэгэн чухал бүсийн командлагчаар томилогдсон тэрээр удирдлагадаа байгаа цэргүүддээ хатуу сахилга бат тогтоохыг хамгийн гол зорилт болгож байлаа. Яагаад гэвэл дайнд ялсандаа хөөрсөн цэргүүд удирдлагынхаа тушаал зааврыг ер сонсолгүй, тал хагас нь дураараа дургиж, төрөл арилжих шахам болж байсан ажээ.

"Залхаан цээрлүүлэх цагдаагийн даргыг илгээж, миний Удирдлагад ажиллуулна уу. Хүч түрэмгийлэгч хэд хэдэн хүнийг Дүүжлуурт өлгөхөөс нааш дэглэм журам, амар тайван байдлын баталгааг гаргаж чадахгүй нь" гэж тэрээр төв штабтаа бичиж илгээсэн байна. Багагүй бэрх яриа хэдий ч байлдааны талбарт тэгтлээ хатуу байдлыг тогтоосон нь л түүний хорооныхон олон удаа байлдааны даалгавраа амжилттай гүйцэтгэж чадах нөхцөл болсон гэж хэлж болно. Вейлинтон дараа нь зах зээлийг сэргээж, амьдрад нэн хэрэгцээт бүтээгдэхүүний нийлүүлэлтийг голидролд нь оруулахыг зорьсон билээ. Харис жанжин, командлагчдаа илгээсэн захидалдаа Вейлинтон зах зээлийн зохицуулалтын чадварыг өндрөөр үнэлж:

"Тэрээр материал хангамжийн тухайд ухаалаг, шийдмэг арга хэмжээ авсны ачаар чөлөөтэйгээр бараа таваарын худалдаа хийж чаддаг боллоо. Түүний ажиллаж байгаа байр байдлыг гайхамшигийн гайхамшиг гэхээс өөрцгүй" гэжээ.

Ийнхүү Энэтхэгт түр сууж буй Вейлinton жижиг сажиг зүйлд ч маш их анхаарал тавьж, бүхий л зүйлд заавар өгч иржээ.

Жир бусын удирдах чадвартай Вейлinton Англид буцсаныхаа дараа, ээлжит албандаа тохоогджээ. Тэр үед Наполеоны командлаж байгаа Францын цэрэгт эзлэгдсэн Португалийг чөлөөлөхийн тулд 1808 онд Англиас тусламжийн цэрэг хүрч ирсэн бөгөөд тэрээр тэдний дундаас нэг түмэн хүнтэй цэргийн хороог командлах том хариуцлага хүлээжээ. Тэрээр Португалд десант буулгаж байлдан, хоёр ч тулаанд ялалт байгуулав. Бүхцэргийн командлагч Жон Морыг нас барсны дараа, Португалийн явуулын цэргийн шинэ ерөнхий командлагчаар дэвшсэн байна.

Ийн зуураа хойгийн дайнд (Францын армитай Испани, Португаль, Английн холбоотны арми тулалдсан байлдаан) Вейлinton эхэндээ сульдаж буурахыг үзжээ. 1809 оноос арван гурван жилийн турш түүний хороо ердөө л гурван түм хүрэхтэй үгүйтэй цэрэгтэй байв. Харин нөгөө тал болох францын цэрэг гучин таван түм гаруй бөгөөд Наполеоны авъяаслаг жанжнууд тохоон томилогдсон байлаа. Тийм хүчтэй дайсны эсрэг яаж байлдал ялалтын үүд нээгддэг байна вэ? Тэр үед Испаны цэргүүд хээрийн тулалдаанд Францын цэргийн шахаанд орж, тэр болгондоо ялагдал хүлээж байв. Вейлinton энэхүү бодит баримтыг анхааралтай ажиг Испаны цэрэг өөр стратеги хэрэглэх хэрэгцээ байна хэмээн шийджээ. Хүчирхэг дайсанд мөчөөгөө өгөхгүй хүчтэй армийг бий болгох нь давын өмнө хийх ажил хэмээн тангараглажээ. Тэр нь эрүүл саруул бас цагаа олсон шийдэл байлаа. Тэрээр Португалийн цэргийн Английн командлалын удирдлагад захируулж, Английн арми Португалийн армитай хамтрах стратегийг сонгож, дасгал сургуулиа эхэлжээ. Тэгээд хоёр армийн хөл жигдрэх хүртэл Францын цэрэгтэй хэрэгцээгүй тулаан хийхээс зайлсхийж байв.

"Францын цэрэг байлдаанд олсон ялалтдаа эрдэж, хүчтэйхэн хэлбэл түүний төлөө л зөвхөн оршиж буй мэт байв. Тиймээс манай цэрэг тулаан эхлэхгүй бол тэдний цэргүүдийн байлдах санаа сэтгэл унах бус уу. Тэгээд манай цэргийн эмх цэгц жигдрэх дуусаад, дайсан байлдах хүслээ алдсан тэр үед нь нэг амьсгаагаар байлдааны галын таглаагаа гэнэт нээх юм" хэмээн тэрээр сэтгэсэн ажээ.

### *Хулчгарыг зоригтон болгон хувиргах жир бусын удирдах хүч*

Хэрэг явдал Вейлintonы таамаг ёсоор болж, түүний цэрэг францын цэргийг ялав. Гэсэн хэдий ч тэрээр, дайны турш янз бүрийн дарамт, эсэргүүцлийн улмаас шаналж байлаа. Түүний туслая хэмээн гараа сунгасан Испаничууд болон Португальчуудын дур зоргоороо аашилж, аймхай, худал хуурмаг сэтгэлтэй байсан нь зовлонтой байлаа. Английн засгийн газар бас өөрөө энэ дайнд чадваргүй гэдгээ харуулж, улмаар засгийн газар дотоодод худал хуурмаг явдал нууц хуйвалдаан эцэс төгсгөлгүй гарч байв. Ийм нөхцөл байдалд тэрээр тулалдаж ялж чадсан нь урам хугарахдаа хүртэл өөртөө бат итгэж, өөрийн хүсэл эрмэлзлэлээ өндөрт өргөж ирснээс тэр юм.

Тэрээр Наполеоны захиргаан дахь цэрэгтэй байлдах төдийгүй Испани, Португалийн засгийн газрыг ч түлхэж өгөхгүй бол болохгүй байлаа. Цэргүүдийн хоол хүнс, хувцасны хангамж туйлын бэрх хэцүү байв. Талабел-ын тулалдаанд Испаны ухарсан цэргүүд холбоотон Английнхаа цэргүүд рүү довтолж, эд материалыг нь булааж авах гэх мэт итгэмээргүй хэрэг явдал ч гарчээ. Гэвч Вейлinton ийм шаналгааныг тэвчиж гарах тэвчээр болон өөрийгөө эзэмдэх ухаантай байсан. Ингээд тусыг усаар хариулах үйлдэл, урвалт, эсэргүүцэлтэй гулгарсан ч буцалтгүйгээр өөрийн замаар алхсаар байв.

Тэрээр бас цэргүүд дотор байх жижиг сажиг үйл явдлыг хүртэл нэг гараар хүлээн авч байлаа. Англиас хоол хүнсний хангамж байхгүй, бүгд өөрийнх нь чадал авъяасаас хамаарах боллоо гэдгийг ойлгонгуут, шууд л цэргийн жанжнаас буудайн худалдаачид хувилж байв. Тэгээд Лиссабоны Английн элчин сайдтай хавсран хоол хүнсний хангамжид амжилт олжээ. Бас аман баталгаа гарган газар дундадын тэнгис болон өмнөд америкийн боомтоос улаан буудай худалдаж авчээ. Ийнхүү зоорио дүүргэсний дараа үлдсэн хэсгийг Португалийн худалдаачинд борлуулж дуусгасан ажээ.

Вейлinton аливааг хувь заяандаа даатгалгүй, гэнэтийн цочмог ажил явдалд ч бэлэн бэлтгэлтэй байхаас залхуурсангүй. Энэхүү шилдэг гүйцэтгэх чадвар янз бүрийн тохиолдолд үр дүнгээ өгсөөр түүнийг амжилтанд хөтөлсөн билээ. "Миний цэргүүд хаана ч очсон нүүр улайлгахгүй" хэмээн тэрээр батлан хэлж байсан агаад туршлага Дульмаг дайчилгааны цэргүүд европын хамгийн хүчтэй цэрэг болон хувирсан нь ч ийнхүү түүний жир бусын удирдан захирах хүчний ач болох нь дамжиггүй.

### *Ялагдашгүй жанжны сүрлэг бишрэм дотоод сэтгэл*

Вейлinton ажил хэрэгч тал дээр гарамгай гэдгийг түүний “балай” шудрага зан чанараас нь ч харж болно. Тэр цагийн байлдааны үеэр Францын Сурт генерал зэрэг хүмүүс Испаниас өндөр үнэтэй уран зураг сэлтийг олноор нь дээрэмдэн эх орон руугаа авч харьж байлаа. Харин Вейлinton, тухайлбал өчүүхэн ч гэсэн эд хөрөнгөд ганц хуруугаа ч дүрж байсангүй.

Тэрээр Испани цэргүүдийг дагуулж Францын хил давсан үед, цэргүүд нь "энд нэг сайн хөлжье" хэмээн байнга дээрэм тонуул үйлдэж байв. Тэрээр юуны өмнө бүх Испани офицерүүдэд анхааруулсан авч ер нэмэргүй байлаа. Тиймээс төдөлгүй Испани цэргүүдийг бүгдийг нь улс орон руу нь буцаан хөөсөн гэдэг.

Бас Английн цэргүүд Францын нутаг руу давшсан үед ч нутгийн уугуул тариачид эх орон нэгтнүүдийнхээ гараас зугатан Английн цэргийн байрлал руу хоргодон ирж, өөрсдийнхөө үнэ цэнтэй эдлэлээ хадгалуулж, түүнийгээ хамгаалж байхыг гуйж байсан гэдэг. Бүр иймдээ хүртэл Вейлintonы цэрэгт итгэж байсан ажээ.

Ийн байх зуур, Вейлinton засгийн газартаа ийм захидал бичиж илгээсэн байдаг.

"Бид дааж давшгүй мөнгөний өрөнд уначихаад байна. Би мэт нь ичиж зовоод гарч чадахгүй шахам байх юм. Яагаад гэвэл эндхийн хариуцлагатан төлбөрөө төлөхийг шаардаад гараас угзарч авч явчих гээд байна" гэжээ.

Жюль Морел Вейлintonы төрх төлвийг үнэлж: "Цаг ямагт ихэмсэгсүрлэг, бас хүн чанарын цэвэр тунгалгийг санагдуулам ийм наминчлал байдаг болов уу даа. Армийн тогоон дахь гучин жилийн түүхтэй хал цэрэг, болд эр хүн, ялагдашгүй жанжин, их цэргийг командалж дайсны нутагт цэргүүдээ зохицуулангаа хариуцлагатны өмнө ийн жижгэрч байна гэдэг...! Эрт эдүгээгийн байлдан дагуулагч хийгээд цөмрөн орогчдын дунд ингэж амар тайван бусаар сэтгэлээ шаналгаж байсан хүн байгаагүй ээ. Дайн тулааны түүхийг сөхөж үзсэн ч түүн шиг эрхэмсэг хийгээд цэвэр тунгалаг сэтгэлтэн байхгүй".

Тэгвэл, Вейлinton өөрөө иймэрхүү магтаал үгийг сонссон бол шууд л толгой сэгсэрч: "Нэг их эрхэмсэг сүрлэг болох гээд ч юмуу, цэвэр тунгалаг байдал үзүүлэх гээд ч юм уу бодоод байсан юм алга. Харин өрөө хугацаа ёсоор нь эгүүлж өгөх нь ажил хэргийн тухайд хамгийн сайн арга хэмжээ гэж бодсоноос л тэр" хэмээн хариулах байсан бизээ.

### **5.Шудрага байх нь хамгийн сайн арга хэмжээ**

Эртнээс нааш "шудрага байх нь хамгийн сайн арга хэмжээ" гэлцдэг. Өдөр тутмын аж амьдралын туршлагаас харсан ч энэхүү зүйр үгний үнэн зөв нь батлагдсаар байна. Ямар ч ажил хэрэг байсан тийм, бизнесийн тал дээр ч зөв санаа үнэнч шудрага сэтгэл амжилтад хүргэдэг.

Шотландын геологийн ухааны эрдэмтэн Хью Милл-ын авга гайхамшигтай хүн байсан агаад Милл-д ямагт захидаг байсан үг нь:

"Хүнтэй нөхөрлөх үед их бага ч болов нөгөө талаа олз омогтой байлгавал сайн. Нөхрийнхөө ая тааг тооцож, юугч гэсэн хангалттай олгож, хэзээ ч гар татаж огт болохгүй. Тэгсэн нь эцэстээ чинийх болдог юм шүүдээ".

Нэгэн алдарт пиво үйлдвэрлэгч өөрийн амжилтаа арвайн соёолж харамлалгүй хэрэглэснээс болсон гэж өгүүлжээ. Тэрээр шар айраг үйлдвэрлэж буй газраа очиж, шалгаж амсах бүрдээ "дахиад л ус амтагдаж байна, соёолжноосоо нэм, нэм" хэмээн ажилтнууддаа тушаадаг байсан гэдэг. Түүний ааш зангийн сайн нь пивондоо хүрсэн үү, түүний пиво сайжирсаар Англи болон хилийн чанадад ч ихээхэн үнэлэгдэх болжээ. Тэрээр ингэж агуу их эд баялгийг гартаа оруулсан гэдэг.

Бизнесийн наймаанд ам, ажил хоёрын нэгдлийг үндэс сууриа болгохгүй бол болдоггүй. Цэргийн хүнд нэр алдар, санваартан хүнд нигүүлсэх сэтгэл чухал байдаг лугаа адил худалдаачин хийгээд үйлдвэрлэгч хүнд энэхүү ам ажил хоёрын нэгдэл юунаас ч чухал байдаг.

Бизнес шиг хүний мөс чанарын сайн мууг хүчтэй шалгаагдах салбар үгүй юм. Тэнд үнэнч шударга байна уу, үгүй юү, өөрийгөө золиослохын ухаанаар бялхаж байна уу, үгүй юү, тал тохой татахгүй, шудрага зөв ажиллаж чадах уу үгүй юү гэдгээр хатуу чанга шигшигдэж байдаг.

Иймэрхүү сорилгод тэнцэж давсан бизнесмен дайны галын аюулыг даван туулж өөрийн зориггоо батлан харуулсан цэрэгтэй адил өндөр дээд хүндлэлд хүрдэг юм. Харин ийм гайхалтай бизнес хүний шилдэг чанарыг өөртөө шингээсэн хүн олон байдаг юм шүү гэдгээр бид бахархаж явах ёстой.

Бодож үзье. Өчүүхэн бага цалингаар арай чамай амьдралаа залгуулж буй дорой буурай нэгэнд хүртэл өдөр бүр асар их мөнгө даатгагдаж байдаг. Худалдагч, наймаачин, банкны ажилтан, гар урлалч гээд хулгай хийе гэж бодвол чадахаар мөнгөний хажууд байдаг. Гэтэл худалдаа наймаанд урваж тэрслэх үйлдэл

гарах нь туйлын ховор байдаг. Гайхуулах хэмжээнд биш ч гэсэн иймэрхүү өдөр тутмын шударга үйл л хүмүүсийн хувьд юунаас ч илүү алдар хүнд байдаг гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.

### ***Шударга хүний дээрээс хишиг буяны бороо цутгаж байдаг***

Ингэхэд аль ч үед байсан шиг өнөө үед ч, нүдэнд торох шударга бус явдал хууран мэхлэх ов заль огт арилж алга болохгүй байсаар байна. Сайн сэтгэлийн хэлтэрхий ч байхгүй хууран мэхлэгч, баян болох гэж яарсан шунахай хүний арга мэх их юм.

Бараандаа юм хольдог наймаачин, ажлаа хийдүүлдэг захиалгын ажилчин олон бий. Цэвэр үс, жинхэнэ хөвөн хэмээн хуурч, хуурамч зүйл худалдаж, утас сүвлэх нүхгүй зүү, огтхон ч иргүй сахлын хутгыг юу ч болоогүй юм шиг царайлан зах дээр гаргадаг хүн харамсалтай нь байсаар байдаг.

Гэхдээ иймэрхүү мэхлэн шулах наймааны аргыг бүүдгэр сэтгэлтэй, шуналт этгээдүүдийн хийдэг ёс бус үйлдлийн жишээ гэж бодсон нь дээр юм. Тэд эд баялаг олж магадгүй. Гэвч тэрхүү эд баялгаараа цэнгэж чадахгүй ээ. Санаа сэтгэл л амар тайван байхгүй бол ямар ч эд баялаг өчүүхэн ч үнэ цэнтэй байж чаддаггүй юм. Шудрага хэмээх зан чанараа гэж орхисон тэдэнд санаа сэтгэлийн амирлал зочилж ирнэ гэдэг огт байхгүй билээ.

Латима ламтан нэгэн сэлэмний багшаас ганц пени ч хүрэхгүй үнэтэй хутгыг хоёр пени-гээр ятгуулж авчихаад "энэ луйварчин намайг мэхэлсэн биш, өөрөө өөрийнхөө сайн сэтгэлийг мэхлэн хуурч байгаа нь тэр дээ" гэж өгүүлсэн гэдэг. Шахаж худалдах, сайхан үгээр хуурах зэргээр мэхлэж олсон мөнгө нь ахархан бодолтой хүмсийн нүдийг хэсэгхэн хугацаанд баясгаж магадгүй ээ. Гэвч ичгүүр сонжуураа алдаж байж олж авсан эд баялаг гэдэг, эцсийн дүнд савангийн хөөс шиг арилж алга болдог зүйл юм.

Хичээл зүтгэлтэй, шулуун шударга хүн хуудуутай амьтдаас урьтаж өмч хөрөнгийг бүрдүүлэн авч чадахгүй байж ч магад. Гэлээ ч заль мэх, шудрага бус аргаар наадалгүй, сайн сэтгэлээрээ нэвт шувт зүтгэж байж олсон амжилт бол жинхэнэ амжилт билээ. Харин хүн хэзээ нэгэн цагт амжилтаа алдаж бүдэрвэл зөв сэтгэлээ л чанд хамгаалж авч явахгүй бол болохгүй. Зан чанараа алдаж унагааснаас бүх өв хөрөнгөө гүвсэн нь хамаагүй дээр. Яагаад гэвэл хүний зан төрх өөрөө гайхамшигтай эд баялаг бөлгөө. Өндөр дээд, цэвэр хүн зоригийг барьж, өөрийнхөө замаар урагшилбал түүнд заавал амжилт зочлон ирж, хүнийхээ хувьд хамгийн дээд гавъяа шагналаа хүлээн авах нь дамжиггүй.

Нэгэн яруу найрагч, хүний амьдралын тулаан дундах "эрхэмсэг дайчин"-ы дур зургийг дараах байдлаар гайхамшигтай магтан дуулсан байдаг.

Нэгэн биенийхээ хүслийг мэдэж  
Нэгэн үзүүрт сэтгэлдээ эргэлздэггүй  
Алдар нэр, эд юмс, эрх мэдлийн төлөө  
Алд биеэ хэмхэлж, эвдэхийг хүсдэггүй  
Ийм суртахуун бүгд тэдэнд цогцлож  
Эгээ л хишиг буяны бороо толгой дээр нь цутгах мэтээ гэжээ.

## Мөнгөний ухаан

*Жаргахыг хүсвэл хөлсөө гарга*

### 1. Мөнгө бол хүний араншин байдаг

Мөнгийг юу гэж ойлгох вэ? Яаж байж мөнгийг гартаа хийж, хурааж, хэрэглэх вэ? Энэ бол бидний, амьдралыг туулж давах ухаантай байна уу, үгүй юу гэдгийн хамгийн том сорьц чулуу юм. Мэдээж хэрэг, мөнгийг хүний амьдралын нэгдүгээр зорилго гэж үзэх ёсгүй. Гэвч үүнтэй зэрэгцээд материаллаг тэнцвэрт байдал нийгмийн хөгжил цэцэглэлтийн ихээхэн хэсэг мөнгөнд түшиж тулж байдаг бодит баримтыг харвал мөнгийг гартаа хийхэд хэцүү ч гэх юмуу, эсвэл христос шашны хуваргууд мөнгийг дорд үзэж байгаа зэрэг нь зөв зүйл бас биш юм.

Угтаа бол хүний шилдэг чанаруудын хэд хэд нь мөнгөний зөв хэрэглээтэй нарийн нягт холбоотой билээ. Уужуу талбиу зөв сэтгэл, өөрийгөө золиослох, бас арвилан хэмнэх, ирээдүйдээ санаа тавих гэх мэт бодитой сайн үйл хүртэл мөнгөтэй салж хагацашгүй холбоотой, эрт дээр үеэс ч тийм байв.

Нөгөө талаар мөнгөжихийн төлөө цусаа урсгахаас сийхгүй хүнд асар их шунал, сайхан үгээр хуурч мэхлэх арга заль, шударга бус байдал, хувиа бодох бэртэгчин сэтгэл бүрдэж цогцолсон байдаг. Цаашилбал, мөнгө хэмээх тэнгэрийн тэтгэмжийг замбараагүй ашиглаж маргаашаа мэдэхгүй үргүй зардал гарган биеэ сул тавьсан хүн ужид самууны ёроолд унаж оддог. Өөрөөр хэлбэл муу үйл ч бас мөнгөнөөс гардаг билээ.

Хенрих Тейлор "Амьдралын сурах бичиг" номондоо: "Мөнгө олох, хурааж хуримтлуулах, орлого зарлага, мөнгөн тусламж авах болон зээлэх зээлдүүлэх, өмч хөрөнгө өвлүүлэх зэргээ зөв хийж байна УУ, үгүй юу гэдгийг нь ажиглах л тэр хүний араншингийн төлөвшил бүрдлийн явц тодхон харагддаг юм" гэжээ.

Хорвоогийн жам ёсны тав тухтай амьдралыг зөв зохистой арга замаар хөөж нэхэх нь огтхон ч буруугүй. Тав тухтай амьдралын хүнд өгөх хангалуун мэдрэмж хүний чанарыг дээшлүүлэх баталгаа болдгийн хамт, амьдралдаа дутуу гуцуугүй байх аваас гэр бүл ч сайн сайхнаар өсч хөгждөг. Христосын арван хоёр ширээт ламын нэг хэлсэнчлэн гэр бүлээ хүртэл сэтгэл хангалуун тэжээж чаддаггүй хүн "сүсэггүй хүнд хүртэл дийлэгдэх" ажээ.

Амьдралаа өөд татахад нэмэр болохуйц боломжийг хүн яаж ашиглаж байна вэ гэдгээс түүнд хүмүүсийн хандах хүндлэлийн хэмжээ сүрхий хамаарч байдаг. Тиймээс бид бүхэн тав тухтай амьдрал хөөцөлдөхөд санаа тавихгүй байж боломгүй.

Амьдралдаа амжилт олж, ямар нэг дутаж гачигдахгүй амьдралыг зохиоё хэмээн хичээж оролдох нь өөрөө нэг ёсны боловсрол юм. Тэрхүү хичээл зүтгэл хүний өөрийгөө хундэтгэх сэтгэлийг тэтгэж, ажил хэрэгч чадварыг нь гаргаж, тэсвэр тэвчээр болон хатуужлын хүч хэмээх сайхан суртахууныг зүлгэж өнгөлж байдаг.

Алсаа хардаг, хүмүүст анхааралтай гэгч нь санаа тавьж байдаг хүн гайхалтай хэрсүү чанарыг тээж явдаг нь лавтай. Өнөөгийн амьдралдаа л баригдаад байлгүй, урагшаагаа харж, ирээдүйдээ бэлтгэж байдаг хүмүүсийн дотор хөнгөндөр бодолтон нэг ч байхгүй. Тиймэрхүү хүмүүс биеэ барин тэвчихдээ анхаарч, өөрийгөө эзэмдэх сэтгэлээ хөгжөөж байдаг. Энэхүү өөрийгөө эзэмдэн барих сэтгэл хэмээх сайхан суртахуун шиг хүний араншин төлөвшихөд хүчтэй нөлөөлөх зүйл үгүй юм.

Шүүмжлэгч Жон Сталинг: "Өөрийгөө эзэмдэх сэтгэлийг зааж өгдөг хүмүүжил ямар ч байлаа гэсэн, өөрийгөө эзэмдэх сэтгэлээс бусад бүх зүйлийг зааж өгдөг хамгийн сайн боловсролоос ч хавьгүй дээр юм" гэжээ.

### ***"Ирээдүйн ашгийн төлөө өнөөгийн сэтгэл хангалуун байдлаа золиослох" тухай***

"Ирээдүйн ашгийн төлөө өнөөгийн сэтгэл хангалуун байдлаа золиослох" хэмээх өөрийгөө эзэмдэхийн ухаанд суралцахад тийм амархан биед хэвших нь үгүй.

Амьдрал нь хэцүү хүн бол мэдээж хэрэг, духандаа хөлс гаргаж байж олсон мөнгөө юунаас ч илүү чухалчилж байдаг. Харин хөлс хөдөлмөрөөрөө тордож ургуулсан мөнгөө ууж идэж дуусгаад, яаж ч байсан биеэ хөдөлгөж чадахгүй болж, хөрөнгөтэй хүний дулаан сэтгэлд багтаад авах гэдэг этгээд зөндөө олон байдаг. Цаашлаад, хэний ч тусламж авахааргүй, дутуу гуцуу юмгүй амьдраад байж болох өв хөрөнгөтэй мөртлөө, шийдвэрлэх мөч тохиолдоход жинхэнэ зовлонтонтой их ялгаагүй нөхцөл байдалд биеэ унагааж орхидог хүн ч олон байдаг. Тэд татвар мэтийн нийгмийн системийн асуудалд голлож анхаараад өөрийгөө эзэмдэх сэтгэл, өөртөө туслах сэтгэлгээний чухалд ер анхаарлаа хандуулдаггүй юм. Жинхэнэ ёсоор хөл

дээрээ босохыг гуйж биш гуядаж олж авах ёстой, үүний тулд хувь хүмүүс хэмнэлттэй байж ирээдүйдээ бэлтгэхэд шамдах нь хамгийн чухал, гэтэл хэн ч тэр тал дээр санаа тавих гэдэггүй болжээ.

Гуталчны амьдралаас гаралтай гүн ухаантан Самиел Долл:

"Сэтгэлгээний чадавхи, арвилан хэмнэлт, цаашлаад овсгоо самбаатай байх явдал нь бурууг засахын мастер юм. Энэхүү мастер ердийн үед гэрийн буланд амьсгаа даран чимээгүй амьдардаг бөгөөд, чухал агшин ирэхээр өнөөг хүртэл парламентыг туулж гарч ирсэн ямар ч хуулиас илүү чадварлагаар амьдралын бэрхшээлийг сэтлэн гаргаж өгдөг билээ" гэжээ.

Сократ "ертөнцийг хөдөлгөө гэвэл эхлээд өөрөө өөрийгөө хөдөлгөө" гэсэн байдаг.

Гэтэл ертөнцийн хүмүүс өөрийн муу зуршлаа жаахан ч гэсэн засаж өөрчлөхөөс илүү, төр улс, шашин сүмээ засан сайжруулах нь хялбар хэмээн бодох нь олонтоо. Тэгэхлээр ерөнхийд нь хэлбэл, хүн өөрийн буруугаа засахаас илүү өрөөл бусдын бурууг өлгөж гаргадаг. Тэр нь бүр таашаалд нь нийцэж байдаг бололтой дог шүү.

### ***Ядуу байдлыг арилгах дөрвөн сайн чанар***

Бүүдгэр амьдралд хөтлөгдөж байгаа хүн доошоогоо зузаарч буй зовлон гачаалаа хэзээ ч нухэлж гарч чаддаггүй. Тийм хүний гээгдэж ганцаардсан, чадал хүчгүй амьдрал нь өршөөлгүй үргэлжилж удалгүй нийгмийн булан руу хөөгдөж, цаг хугацааны ширүүн давалгааны тоглоом болдог. Тийм хүний өөрийгөө хүндэтгэх сэтгэл нь арилж алга болдог учир хавь орчны хүндлэлийг ч эс олно. Уналт доройтолдоо нүд нь эрээлжилсэн хүн шууд л яахаа үл мэдэх гацаанд унадаг. Их бага ч гэсэн хурааж хуримтлуулсан зүйл байвал, хийе гэсэн сэтгэл нь өндийж болох авч, тийм юм үгүй бол бусдын амаар хөдлөхөд хүрдэг ажээ. Буурь суурьтай мэдрэмжтэй хүн ийм амьдралаар амьдрах дээр тулвал эхнэр хүүхдийнхээ явах зүгийг төсөөлөөд шуудхан л бие нь зарсхийн дагжин чичрэх бизээ.

Улс төрч Гобеден Ха ажилчин хүнд:

"Эртнээс нааш, хорвоо ертөнцөд хоёр төрлийн хүмүүн байдаг. Мөнгө хурааж хуримтлуулдаг, мөнгийг үрж зардаг, өөрөөр хэлвэл хэмнэж хямгаддаг хүн, үрэн хийсгэдэг энэ хоёр болой. Хямгач хүн бол гэр, үйлдвэр, гүүрийг барьж байгуулж, цаашлаад асар их ажлыг хийж гүйцэтгэн, бидэнд иргэншил хийгээд баяр баясгаланг бэлэглэж байдаг. Гэтэл өөрийнхөө хөрөнгийг дэмий үрэн таран хийж ирсэн хүн ямагт хямгач хүний боол байсан.

Ямар ч цаг үед ийм үзэгдэл байгалийн хууль бөгөөд бурхны зарлиг юм. Хэрвээ би "ирээдүйгээ огт бодолгүй дэмий сул бүүдгэр амьдралаар явж ирсэн ч амжилт олж чадна" гэх мэтээр ам гарвал утгагүй мэхлэгчийн муу нэрийг зүүж орхих бизээ" гэжээ.

Улс төрч Жон Плойд ч 1847 онд Рождейлын ажилчдын цуглаан дээр мөн адил зүйлийг хэлсэн байдаг. "Одоогийн амьдрал чинь таатай байгаа бол түүнийгээ тэтгэж хадгалж, сайн бус байгаа бол засан сайжруулж явах ёстой бөгөөд ингэхэд баталгаатай арга зөвхөн ганц байдаг. Тэр бол хичээл оролдлого, хэмнэж гамнах, биеэ барин тэвчих, тэгээд зөв сэтгэл хэмээх сайхан суртахууныг дагах явдал юм. Дутагдаж гачигдахын зовлонд хүлэгдсэн, дундуур сэтгэлээр дүүрсэн амьдралыг сэтлэн гарахад энэхүү дөрвөн сайхан чанарыг гүйцэтгэн биелүүлэхээс өөр ойрын зам үгүй юм. Ийм амьдралаа өөд нь татаж, амжилтыг барьж авч байгаа хүн олон байдаг юм шүү".

Жирийн ажилчдын дотор ч гамнаж хямгадахаар чармайж, өндөр эрмэлзлэл өвөрлөн, эрдэм ухаанаар бялхаж, хангалуун амьдралаар амьдарч буй хүн олон. Тэд зөвхөн тэр байдлаараа л хүндлэл хүлээхээр аз жаргалтай хүмүүс, тэднийг нийгэмдээ ч хангалттай хүчин зүгэж байгаа гэж хэлж болох бизээ. Тэгвэл хэн ч гэсэн ингэж амьдаръя гэж бодвол чадах билээ. Тэдэнтэй адилхан аргаар ажиллавал үр дүн нь ч мөн адил гарах бөгөөд тэр ерөөс хэцүү хэрэг биш юм.

Өдрийнхөө хөдөлмөрөөр зөвхөн өдрийнхөө л амьдралыг залгуулж явдаг хүн аль ч улсад бий. Тэд хэмнэж гамнадаггүй бөгөөд, юм мэдэхгүйн хийгээд хувь тавилангүйн нажидыг эдэлж явдаг, тэгээд тийм буй өөрийнхөө нөхцөл байдалдаа ямагт гомдолтой байдаг гэтэл энэ нь өөрсдийнх нь сул тал, дур зоргоороо, зөрүүд гөжүүд байдгийнх нь уршиг юм. Ажил хийдэг хүмүүсийн дунд өөртөө туслахын ухаан үр үндсээ таривал тэд шуудхан л өндөр дээд оюун санаа, сайн суртахуунаар бялхсан амьдрал руу татагдан дээшлэх нь зайлшгүй.

Монтенньо өгүүлэхдээ: "Янз бүрийн зан суртахуун шилдэгсайн хүмүүсийн амьдралд төдийгүй, нэрийг ч үл мэдэх жирийн харц хүмүүсийн амьдралд ч нэгэн адил хамаатай. Хун хэн ч байсан өөрийн дотоод сэтгэлдээ хүн болж амьдрахын төлөөх нөхцлүүдээ бүрэн төгс бүрдүүлсэн байдаг юм" гэжээ.

## **2.Хэмнэлт бол өөртөө туслахын ухааны хамгийн дээд илэрхийлэл юм.**

Ирээдүйгээ бодож амьдарьяа гэвэл ажилгүй болох, өвчин тусах, үхэх зэрэг хувь тавилангүй гай тотгорт бэлэн байхаар бэлтгэхэд залхуурч ердөө ч болохгүй. Энэ дотроос эхний хоёр зүйлийг давж болно, зөвхөн үхэлд л хүний хүч шонгүй билээ. Гэлээ ч гүн гүнзгий оюунлиг хүн бол гэнэтийн ямар ч гай зовлонд уналаа ч гэсэн зовлон зүдүүрээ аль болох тайвшруулах гэж, бас өөрийг нь түшиж амьдардаг хүндээ нөлөөлөхгүй байхын тулд дахин мөнөөх төлөвшлөө төгөлдөржүүлж байдаг бус уу.

Энэ талаас харахад хамгийн гол нь чин шударгаар мөнгө олж, түүнийгээ арвилж хэмнэж хэрэглэх нь чухал юм. Чин шударгаар мөнгө хуримтлуулна гэдэг нь шунал хорхойдоо ялагдалгүйгээр, хичээл зүтгэл гаргаж, хүсэл тэмүүлээ шавхахаас өөр зүйл биш. Мөнгийг арвилж гамнаж хэрэглэнэ гэдэг нь шилдэг сайн зан төрхтний үндэс суурь болох чанар, өөрөөр хэлбэл оюун билэг, алсын хараа, өөрийгөө эзэмдэх сэтгэл төлөвшиж байна гэдгийн шинж тэмдэг юм.

Мэдээж хэрэг ямагт мөнгө хэрэг болж байхын учир үгүй. Гэвч өмсөх хувцас, идэх хоол, амьдралдаа сэтгэл хангалуун байх, өөрийгөө хундэтгэх сэтгэл, өөрөө хөл дээрээ босох сэтгэл зэрэг хүнд байх ёстой утга чанартай зүйлийг яах аргагүй мөнгөний хүчээр олдог билээ.

Тиймээс хуримтлал бол зовлон бэрхшээлийн эсрэг босгох хаалт юм. Хуримтлалаар бид амьдралынхаа гишгүүр шатыг баг тогтвортой болгож, ахуй амьдралын чиглэл сайн тийш эргэх хүртэл итгэл алдалгүй өөдрөг амьдрах болно.

Хуримтлалынхаа хүчээр өөрийнхөө шат гишгүүрийг батжуулья хэмээх хичээл зүтгэл нь бусдад хангалттай хүндлэгдэх болно.

Тэрхүү хичээл зүтгэлийг дамжиж байж хүн өөдлөж, улам хүчтэй болдог. Үйл хөдлөлийнх нь хүрээ өргөжиж, маргаашаа амьдарч туулах чадал нь оргилж ирдэг ажгуу.

Хэзээ ямагт ядуугийн зовлон туулах амьдралд ээрэгдэж байх нь боолын байдлаас бараг өөрцгүй. Ийм хүн өөрийнхөө үйлдлийг хүртэл өөрөө шийдэхгүй, бусад хүнд тушагдаж, бусдын хэлснээр хөдөлж явахад хүрдэг. Түүгээр үл барам нийгмээ буурь суурьтай ширтэж харах зориг байхгүй тул шившиг болохгүй гэхийн газар үгүй.

Ийм өрөвдөлтэй байдлаас гарч, бие сэтгэл хоёрт өөрийгөө даая гэж хүсвэл ердөө хэмнэж гамнахыг л гүйцэтгэвэл болох нь тэр.

Хэмнэж гамнахад гайхшрал төрөм зориг, шилдэг сайхан зан суртахуун ч хэрэггүй. Бага зэрэг санаа сэтгэлийн бэлтгэл, ердийн жирийн ухааны хүч л байхад хангалттай. Хэмнэж гамнах гэдэг нь гэрийн ажил бугдийг ёс горимоор нь зөв удирдах явдал юм. Амьдралаа журам горимоор нь гамтай эрхэлж, дэмийг хасч орхивол тэгээд л болоо.

Христос хэмнэж гамнахын оюун санааг "илүү гарснаа хураан цуглуулж, жаахан ч гэсэн үргүй дэмийг гаргахгүй байх" гэсэн үгээр илэрхийлсэн байдаг.

Төгс авьяаст Христос хүртэл амьдралын жижиг сажиг зүйлийг үл тоомсорлолгүй, хүнд гүнзгий анхаарал сэрэмж хэрэгтэй байдаг тухай сургааль бидэнд үлдээжээ.

Хэмнэх гамнах болон нарийлах харамлах хоёр өөр юм. Арвилж гамнах гэдэгсэтгэлийн өгөөмрийг төрүүлж, тэр нь авир зангийн сайн тал болж илэрдэг. Энэхүү утгаар "хэмнэж гамнах гэдэг нь оюун ухааны охин, биеэ барьж тэвчихийн эгч, эрх чөлөөний ээж мөн" гэж хэлж болох бизээ. Өөрөөр хэлбэл хэмнэж гамнах гэдэг бол өөртөө туслахын оюун санааны хамгийн дээд илэрхийллээс өөр юу ч биш юмаа.

## *Хувиа ухаарсан амьдрал*

Хүн хэн ч болов хувь нийцтэй амьдрахаар арга чарга хайхгүй бол болохгүй. Энэ бол зөв ухаанаар амьдрах аргын шинж тэмдэг юм. Хувиа ухаарсан амьдрал зохиож чадахгүй аас уйдах болсон хүн заавал бусдын хүчинд горьдож эхлэн, шударга бус зүйлээр гараа бохирдуулах болдог. Тэгээд зарлагадаа ер өчүүхэн ч сэтгэл зовохгүй, бусад хүнд гай болох сэлтийг эрэгцүүлэх гэж байхгүй, өөрөө сэтгэл ханах төдийгөө хөөж чухалчилж явдаг. Тэд өөрөө хоцорч хаягдах хүртлээ мөнгөний ухагдахууны тухайд огтхон ч анзаардаггүй юм.

Хямгач сэтгэлгүй хүн эцэстээ унаж хаягддаг. Тэд цагийг ч, мөнгийг ч адилхан үргүй зардаг. Ирээдүйн тодорхойгүй үр жимсийг горьдсоноос хэлэлцсэн амнаасаа няцаж, өр зээлийн баталгаагаа бусниулж, тэр хооронд өр хийгээд зүхлийн үрэл үмхэж, тэнцвэрээ алдахад хүрдэг.

"Хэмнэлт чухал болоод ирэхээр жаахан ч гэсэн хурааж хуримтлуулах хэрэгтэй болно. Харин биеэ доош нь унагаах хүртлээ нарийлан байж мөнгөжихөөр зүтгэе гэж бодож бас болохгүй". Энэ бол Бэконы сургааль юм. Үнэн хэрэгтээ гар дорх мөнгөө огт дэмий чулуудаж байдаг хүн олон. Гэтэл өчүүхэн бага мөнгө байлаа ч түүнийгээ зөв зарцуулбал, ямар нэгэн хэмжээний хөрөнгө төлжиж, ямар нэг байдлаар өөрийгөө амьдруулахын үр болж чадах бус уу.

Үрэлгэн хүн "ахиц гарахгүй байгаа нь хүмүүсийн дунд алагчлал байгаагаас тэр" гэх мэтээр заримдаа гомдол эрдэг. Гэвч тэдний өөрсдийн жинхэнэ дайсан бол бусад хүмүүс биш харин өөрөө байдаг. Өөрөө өөрийнхөө хүртэл талд нь байж чаддаггүй хүнд хэн гараа сунгаж туслах юм бэ?

Нарийлж харамлахыг хэтрүүлэх нь бодож үзүүштэй асуудал юм. Харамч агаад санаа сэтгэл уйтан хүн амьдрал дээр ч, бизнес дээр ч алсаа харж чаддаггүй, эцсийн дүнд алдаа хийдэг. Нэг пэни-гийн үнэгүй хүн, яагаад ч хоёр пэни-гийн үнэтэй хүн болж чаддаггүй гэдэг яриа ихэд дэлгэрчээ. Шударга байх нь хамгийн сайн арга хэмжээ байдагтай адил, өгөөмөр уужуу талбиу, зан араншин сайтай байх нь бас амьдарч явахын төлөөх хамгийн сайн арга зам юм гэж хэлж болох бизээ.

## *Мөнгөний өрний цаана худал зугаалж явдаг*

"Хоосон уутыг босоо зогсоож болдоггүй" гэдэг зүйр үг байдаг агаад энэ бол өртэй хүнд нэгэн адил хамаарах юм. Бас "худал нь өрний ар нуруун дээр сууж зугаалдаг" ч гэлцдэг. Үнэн хэрэг дээрээ өртэй хүн барагтай л бол шударга болдоггүй. Мөнгө зээлэхдээ, бас зээлсэн хүнд төлөх хугацааг сунгахдаа учирлалыг сайн нягталж байж гаргахгүй бол болохгүй, сүүлд нь нэг л мэдэхэд зохиомол яриагаар хүртэл хуурахад хүрдэг.

Эхлээд өр тавих үед хэн ч үхэн хатан байж, хугацаат өдөрт нь мөнгөө эргээж төлөхөө амлаж байдаг. Гэсэн ч нэг удаа залилан эргэлж чадвал амтшиж, дахиад зээлсэн ч дажгүй гэж бодоод эхлэнэ. Тэгээд цай буцлахын зуургүй өрний там руу өнхөрч унаад, яагаад ч тэндээсээ сугаран гарч чадахгүй болно. Ер нь өр зээл рүү нэг алхам алхах нь худал хэлэх рүү алхаж буй нэг алхам болдог. Тэгээд өр зээл нь хийлсэн мэт томрохын хэрээр худал нь худлынхаа хүүг төрүүлэн үржих бөлгөө.

Зураач Хэйдоны уруудаж унасан нь өр зээлд гараа дүрсэн тэр өдрөөс эхэлсэн ажээ. Тэрээр "үгүйрвэл мөхөхийн"-ын зүйр үгийг газар дээр нотлох мэт амьдралаар амьдарч ирсэн бөгөөд түүний өдрийн тэмдэглэлийн нэг хуудсанд: "Мөнгөний өрөнд хөөгдсөн амьдралд хөлөө дүрснээс хойш, одоо хүртэл түүнээс гэтлэн гарч чадаагүй явна. Лавтай энэ насандаа би энэ шавар балчигнаасаа зугатааж гарч чадахгүй бизээ" гэжээ.

Тэрээр мөнгөний асуудалд аль хэр цөхрөнгөө барж, ажил ч барьж авч чадалгүй, хэзээ ямагт шоовдорлогдохын ичгүүрийг амталж байсан нь түүний өдрийн тэмдэглэлийг уншихад тодорхой байна. Тэрээр тэнгисийн цэргийн флотод алба хаахаар болсон нэгэн залууд бичсэн захидалдаа:

"Хүнээс л мөнгө зээлэхгүй бол гар дээр хүрч ирэхгүй байгаа цэнгэл мэтийг хэрхэвч хүсэмжилж болохгүй. Мөнгө бүү зээлэгтүн! Өр хүнийг уруудуулж унагаадаг. Мөнгө зээлүүлнэ гэж бүү хэл, өөрийнхөө өрийг эргүүлж өгөхгүй юм бол хүнд ч зээлүүлэхийн хэрэггүй. Ямарч гэсэн, ямар ч тохиолдолд мөнгө зээлж огт болохгүй шүү" гэжээ.

Самуэл Жонсон "Залуу цагийн өр биеэ егүүтгэхтэй хөтлөлдөг" гэж ямагт хэлдэг байжээ. Тэгээд дараах ухаалаг үгийг бичиж үлдээсэн байдаг.

"Мөнгөний өрийг "жаахан базаахгүй эд" гэхчилэн хөнгөхөн бодож боломгүй. Өр бол аюул гамшиг юм. Ядуу болох юм бол сайн Үйлийг хийеэ гэсэн ч арга чаргаа алдаж, бие сэтгэл хоёулаа муугаас хаацайлах чадалгүй болдог. Тиймээс ядуурлаас л яаж ийгээд зугатаах естой юм. Ядуурлаас зайлс хийхдээ тэсч тэвчээд

хэнээс ч гэсэн мөнгө зээлэхгүй байвал сайн. "Ядуурч байх ёстой юу" гэж шүд зуу. Гартаа байгаа юуг ч гэсэн арвилан хямгад. Хоосон ядуу байна гэдэг аз жаргалыг үргээдэг том дайсан юм. Тэр, эрх чөлөөг чинь эвдлэн бусниулж, заримдаа сайн суртахууныг ч бас самууруулдаг эд.

Даруухан амьдралаар амьдарч чадвал сэтгэл зүрхэнд амар тайван зочлон ирж, бусад хүнд ч хишиг буянаа өгдөг. Өөрт нь тусламж хэрэгтэй хүн, өрөөл бусдад туслана гэж байдаггүй. Хангалттай хурааж цуглуулж байж хүнд түүнээсээ хувааж өгдөг юм" гэжээ.

Өрнөөс зайлсхийхэд, мөнгөний орлого зарлагадаа цаг ямагт санаа тавьж, орсон гарсныг хичээнгүйлэн бичиж тэмдэглэж байх нь чухал юм. Гүн ухаантан Жон Локк "мөнгөний орлого зарлагыг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж тэмдэглэж байх заншил бол чинээлэг амьдрахад хамгийн их хэрэг болдог" гэж өгүүлсэн байдаг.

Вашингтон ч гэсэн мөнгөний асуудалд үнэндээ нарийн хандаж, санаа тавьдаг байлаа. Тэрээр ямагт өөрийнхөө хүчин чадалд тохирсон шударга амьдралаар амьдаръя гэж зүтгэж байсан билээ. Америкийн Ерөнхийлөгч хэмээх хамгийн дээд байр суурьт хүрснийхээ дараа ч, нөгөөх л зангаараа гэрийнхээ өрхийн тооцооны дэвтрээ нарийвчлан нягталсаар байсан гэдэг.

### **3.Хийвэл бүү ай.**

Саяхнаас ер нь "дээдсийн амьдрал"-ыг үхэн хатан мөрөөдөх хүн олширчээ. Тэд ноён нуруугаа авч хаяад ч болсон зөвхөн дээшилж авахаар, баян хүн биш мөртлөө баян хүний царай гаргаж, өөрөөр хэлбэл дотроо паланцаг байсан ч гаднаа гяланцагийн дүрийг эсгэх болжээ.

Өөртөө оногдсон бололцоо нөхцлийн дотор хичээнгүй шургуу урагшлах зориг байхгүй, амьтны элэг доогийн үр болно гэдгээ ул мэдэн хорвоогийн чамин гоёыг хөөн нэхэж, дээдсийн нийгмийн нэгэн зурвасыг зээлснээр нэрэлхүү сэтгэл нь ханадаг ажээ.

Иймэрхүү мулгуу хүмүүс нийгэм хэмээх дугуй театрын хамгийн эхний эгнээнд суух гэж аар түлхэлцээн шахалдаан хийж байдаг. Энэ үймээний дунд хүсэл шуналаа хазаарлахын сэтгэл гэдэг юм хөл дор нь гишигдэж, хүний сайн суртахууны ихэнх нь бяц дарагдан амьсгал нь тасардаг юм даа. Гаднаа гяланцагийн бор амжилтаар бусад хүнийг гялбуулахаар зүтгэх нэр алдар хөөцөлдсөн араншингаас ер хичнээн их үргүй зарлага, гуниг зовлон, сөнөл сүйдэл үүсч гардаг болоо! Хүрэх газар бүрт нь түүний балмад үр дүн илэрч байдаг, Ингэхээр муу луйврын жүд тасардаггүй.

Энэ нь өөрийгөө ядуу дорой хүн гэж бодуулахыг тэвчилгүй, тэгүүлсэнд орвол бүр шударга бусыг хийж явах нь илүү дээр гэж бодож байгаа хүний хэрэг явдал юм.

Бас мөнгөний төлөө улайрч, яахаас ч буцахгүйгээр харайлгаж явдаг балай этгээд ч олон байдаг. Гэхдээ энэ тохиолдолд, хамгийн өрөвдөлтэй нь алдаа гаргасан тэр хүн өөрөө бус, харин уруу татагдан буруугүйгээр өөрийн биеэ дорд унагасан олон тооны гэр бүлийнхэн нь хохирч байдаг юм.

### **Шийдмэг бусаар дүлэгнэж байх нь биеэ эвдлэхэд хөтөлдөг**

Чарльз Непиа Английн колони Энэтхэгийн армийн ерөнхий командлагчийн тушаалаас буухдаа офицер, цэргүүддээ сургааль бичиж үлдээсэн байдаг. Тэнд олиггүй завхай амьдралд унаж, ичгүүртэйгээр өр зээлэнд шаналж яваа залуу офицеруудыг зоригтой шулуухан шүүмжилжээ. "Энэтхэгийн армийн офицеруудад хандсан тушаал" хэмээх энэхүү бичигт: "Хичээнгүй шудрага чанар бол боловсролтой жентельменийн зан төрхөөс салгаж болшгүй зуйл юм. Зээлийн тооцоогоор шампанск, пиво ууж, морь унах нь жентельменд үл зохих луйварчны хийх ажил юм. Офицеруудын дунд хувьд нийцэмгүй тансаг амьдралын төлөө өр тавьж, эцэст өөрийн зарц нь шүүхэд мэдүүлсэн хүн ч бий. Тийм хүмүүсбол хэргэм зэрэг нь офицер мөн ч гэлээ жентельмен огт биш юм. Тулалдах төдий нь офицерын гүйцэтгэх ажил биш. Зөвхөн тулалдах төдийсөн бол бульдог ч чадна биз дээ. Хэлсэн амандаа хүрч байна уу. Өр зээлээ нягт чамбай буцааж төлж байна уу. Энэ бол нэр төрийн асуудал юм. Та нар бол "айхыг мэддэггүй" цэргийн хүн мөнхийг чинь сайн ойлгож байна. Гэвч түүнтэй зэрэгцээд "бусдаас ар луугаа чичүүлэхгүй" хүн байхыг чин сэтгэлээсээ хүсч байна. Залуухан зоригтой офицер цутган орох суман бороон дотор цөхрөлтгүй давшиж их цэргийн алдрыг өргөх хүчтэй байдаг. Тийм мөртлөө шунал тачаалыг уриалан даллах мэт дэмий уруу татлагыг эрс эсэргүүцэх оюуны хүч хийгээд эр зоригоор дутагдаж байна. Бас та нарт амьд явж ичгүүр хүлээхээр, үхэх замыг сонгох эр зориг байгаа. Тийм атлаа зугаа цэнгэл, тачаалын чөтгөрийн гараас мултарч гарч л чадахгүй юм даа" гэжээ.

Залуу хүн, хүний амьдралын замаар алхаж явахад, тэрхүү замын хоёр талаар асар олон уруу татлага уртын урт эгнээ бий болгоод хүлээж байдаг. Тэрээр тэр дотор гараараа яраад урагшлах авч, дур хорхойндоо

ялагдвал, эцэст нь уналт доройтолд зайлшгүй хүрэх болно. Залуу хүний бие махбоди тэнгэрлиг хүчээр дүүрэн байдаг хэдий ч, нэг удаа л дур хорхойнд автагдвал тэрхүү хүчээ алдаж орхидог.

Дур хорхойгоо барьж байх цорын ганц арга бол эрс шуудхан "больёо" гэсэн бодлоор оюун тархиндаа дохио өгч, тэр үг ёсоор болгох хэрэгтэй юм. Уруу татагдахад автагдахад хүрвэл тэр дор нь сөргөөр шийдэх хэрэгтэй. Ийм ч, тийм ч учир шалтгааныг жингийн туухайн дээр тавьчихаад "алийг нь сонговол дээр вэ" гэх мэтээр бодлогоширон тээнэглэлээ суух нь дэмий. "Эмэгтэй хүн толгойгоо гашилгатаг бодвол биеэ мөхөөдөг" гэсэн үг байдаг. Энэ үг залуу хүнд ч бас хамаатай. Үнэн чанартаа, эргэлзэн тээнэгэлзэж дүлэгнэж суугаад шийдлийнхээ боломжийг алдаж орхидог хүн олон. Залуу хүний чадлыг сорихын тулд дур хорхой зочлон ирдэг.

Ганцхан удаа ч гэсэн түүнд сөгдвөл залуу хүний хүч чадал улам улмаар суларч, нэн чухал ёс суртахуунаа ч дараа дараалан алдах болдог. Тиймээс дур хүслээ хатуу няцааж байх хэрэгтэй. Эрс шийдсэн шийдлийн анхны алхмаа гишгэж гаргавал, хүний амьдралыг туулж давах их хүч оргилж ирнэ. Энэхүү шийдлийг дахин дахин давтах хооронд дадал хэвшил болж биед наалдах буй за.

Хүний амьдралд залуу байхдаа олж авсан дадал нь муугаас сэргийлэх чин сэтгэлийн далан хаалт болдог. Яагаад гэвэл хүн ажил үйлд чигжрүү хэрсүү болох нь дадал хэвшлийг дамжиж байж төлөвшдөг агаад, ёс суртахуунаа хохироохгүйгээр хамгаалж байх нь ч мөн адил дадал хэвшлийн хүч ажгуу. Сайн дадал хэвшил нь өдөр тутмын амьдралын янз бүрийн өнцөг нугачаанд хүртэл хүрч чадаж байвал тэр хүний үйл, үйлдэл тов тодхон ялгарам гайхалтай зүйл болон хувирч одох нь зайлшгүй.

### *Заримдаа өөрийнхөө алхаа гишгээг нягталж үзэж байх тухай*

Х.Миллер залуудаа эрс шийдэж, хүчтэй уруу татлагаас өөрийн биеэ татаж авсан ажээ. Тэр үед Миллер чулуучин байсан бөгөөд иймэрхүү ажлын хувьд хамтран зүтгэгчид бүгд архи уухыг өдөр тутмын зугаагаа болгодог байв. Нэгэн өдөр, вискигээр шахуулж, шилэн аягаар хоёр удаа нэг амьсгаагаар уужээ. Гэртээ буцаж ирээд өөрийнхөө унших дуртай Бэконы номыг нээтэл доторхи үсэг нүднийх нь хараанаас мултран гарч, утга санааг нь огтхон ч ухаарахгүй болсон байв. Миллер хожим нь:

"Тэр үеийн миний байр байдал яг л ужид самуун гэгч юм өөрийн биеэрээ байгаа мэт байлаа. Буруу нь надад байгаа бөгөөд юутай ч хэсэг хугацаанд бие живэж байгаа мэт санагдаж, хэвийн байдаг шигээр толгой маань ажилласангүй. Шийдвэр гаргаж чадахгүй болсон байсан ч, юутай ч тэр үед би сэтгэлдээ: "Дахиад яасан ч архинд живэж, оюуны баяр баясгалангаа үрэн таран хийхгүй юм шүү" гэж тангараг тавьсан юм. Тэгээд азаар би тэрхүү шийдлээ чанд баримталсаар ирсэн билээ" гэж ярьсан байдаг.

Ийм шийдвэр улам улмаар хүний амьдралын эргүүлэг болж, ирээдүйн нэр алдрын үндсийг бататгадаг юм шүү. Тэр үед дур хүслээ ялахаар зориглоогүйсэн бол Миллерийн амьдрал харанхуй ангалд унасан байж ч магадгүй юм. Залуучуудаар хязгаарлах бус ер хэн ч гэсэн иймэрхүү аюултай уруу татлагаас ямагт сэрэмжилж байхгүй бол болохгүй билээ.

Нэн ялангуяа архи уух нь дур хүслийн дотор хамгийн адгийн муу төрөлд багтана. Хүний амьдралыг тулгуургүй болгохоос сийхгүй эд шүү архи. Вольтер Скотт "янз бүрийн муу уйлийн дотор, архи уух шигамжилтын саад тотгор болох юм үгүй" гэж ямагт ярьдаг байв. Түүгээр зогсохгүй архинд дурлах нь мөнгийг үрэн таран хийж, хүний зан араншин, эрүүл мэндийг бусниулж, хичээнгүй шударга амьдралыг хүртэл эвдэлдэг билээ. Архийг зөв хэрэглэж чадахгүй хүн архийг хорих хэрэгтэй. Самуэл Жонсон өөрийнхөө дадал хэвшлийн тухайд: "Би архийг хорьж тэвчиж чадах боловч биеэ барьж тааруулж ууна энэ тэр гэвэл боллоцоогүй гэж боддог" гэжээ. Энэ үг олон хүнд хамаатай бус уу.

Муу зуршилтай шийдмэг тулалдаж ялахад эгэл жирийн бодож тунгаах чадвар төдийлөн хангалттай гэж хэлэхгүй. Мэдээж хэрэг тэр ч хэрэг болно гэхдээ л өндөр дээд зан суртахууныг биедээ эзэмших хэрэгцээ буй. Өөрийнхөө бодол санаа хийгээд үйл хөдөлгөөнд өндөр хэмжээний шалгуур тавьж, муу зуршлаа засахын хамт ухамсраа бяджуулж, цэвэршүүлж байхгүй бол болохгүй ээ.

Тиймээс залуу хүн өөрөө өөрийгөө сайн судлах нь чухал билээ. Өөрийнхөө алхааг нягталж, шийдэж тогтсон дүрэм журам чинь бодит байдал дээрх бодол санаа, үйл хөдөлгөөнтэй давхцаж тохирч байна уу үгүй юу гэдгийг ажиж тандаж байх ёстой юм. Хүний амьдралд хамгийн үнэ цэнтэй зүтгэл бол одоогийнхоо өчүүхэн бага сэтгэл хангалуундаа амирлалгүй ирээдүйн улам гайхамшигтай хангалууныг эрж олохоор зүтгэх явдал билээ. Чухам энэ л хүний хувьд хамгийн эрхэмсгээр өөрийгөө боловсруулах үйлс мөн. Нэгэн шүлэгч ингэж шүлэглэсэн байдаг.

*Үнэнхүү алдар хүнд гэгч  
Үглэж суулгүй тэвчээртэй зүтгэвэл олдму  
Үлэмжийн баатар эр хүртэл түүгээр дутвал  
Үнэндээ боолоос юуны ялгаатай вэ*

#### **4.Билэг ухаан бадмаарагаас үнэтэй**

Мөнгөжиж баяжихын нууцыг тайлбарласан нийтэд тархсан бичиг ном өнөөг хүртэл тоо тоомшгүй олон ажээ. Гэвч үнэн хэрэгтэй тиймэрхүү амархан нууц энэ тэр гэж байх учиргүй юм. Дэлхийн **янз** бүрийн улс орнуудад ам дамжсан олон зүйр, цэцэн үгсийг харвал харин тодорхой бус уу.Ухаандаа:

*"Бутархай мөнгөнд анхаарал тавибал их мөнгө аяндаа хуримтлагдана"*

*"Хичээл чармайлт бол аз жаргалын ээж мөн"*

*"Биеэ зовоохгүй бол олз ашиг байхгүй"*

*"Ая таатай байя гэвэл хөлсөө гарга"*

*"Ажилсаг хүнд аз жаргал ирнэ"*

*"Өр үүрч өглөө боссоноос, үдэш хоолгүй унтсан нь дээр"*

Амжилт бүтээлийг хураан цуглуулах хамгийн сайн арга хэдэн үе дамжин өвөг дээдсийн туршлага бүхний хуримтлал болсон иймэрхүү сургааль үгэнд тодорхой илэрхийлэгдсэн байна. Эдгээр сургааль балар эртнээс амаар дамжигдан, олон түмний ёс суртахууны хууль болсоор иржээ. Түүгээр үл барам урт удаан түүхийн шалгуурыг даван туулсаар байгаа тул өнөөг хүртэл түүний үнэн зөв чанар өчүүхэн ч буураагүй.Соломоны зөвлөлгөө ч хичээл зүтгэл, мөнгөө зөв зарцуулах замын тухай сургаалиар дүүрэн байдаг.

"Хайхрамжгүй хүн үрэлгэн хүний ах дүү мөн". "Залхуу хүн та шоргоолжны үүрлүү оч. Тэндээс арга ухаанаас нь сурч ав". "Гачаал хоосрол нь аянчин лугаа адил залхуугийнд буудаг бол ядуу гуцуу нь их цэрэг лугаа адил залхуу руу довтолдог". "Үнэнч шударга хүний зүтгэлтэй гар эд баялгийг төрүүлдэг". "Идэх уухын ховдог хоосролтой залгуулдаг бол их нойр хүнд ноорхой навтас хэдрүүлдэг". Эдгээрээс гадна бүр чухал бас нэг үг бий. "Алт мөнгөнөөс илүү билэг ухааныг шүт. Ухаан билэг бадмаарагаас илүү юм. Энэ хорвоод хүсэмжилж олох бүх юмс билэг ухаантай харьцуулагдашгүй байдаг".

#### ***Бутархай мөнгөө хураавал гачаал зовлонгоос ч гарч болно.***

Хичээн зүтгэж, арвилан хэмнэвэл өөрийн хүчээ гаргах зам нээгддэг. Амьдрал ямар ч хэцүү байсан гэсэн эгэл даруухан байж хэрэгцээгүй зарлагаа татвал яаж ийгээд аж амьдралын зорилго өндийн босч ирдэг юм.

Нэг пени-гийн дэвсгэртэд онцгойлоод байх үнэ цэн үгүй. Гэвч тохитой тухтай гэр бүлийн амьдралаар амьдрах уу үгүй юу гэдэг энэхүү дэвсгэртийг зарцуулж буй арга хийгээд хуримтлуульж буй арга зам ямар байгаагаас шалтгаалж байдаг юм шүү. Арайхийн хүнд хөдөлмөрөөрөө чухаг шан ававч, архинд ч юмуу, аахар шаахар зүйлд дэмий зарж нэг пени, дахиад нэг пени хийсэн арилж алга болохыг нь зүгээр хараад суувал адгуусны төрлийн амьдралаас сугарч гарч чадахгүй юм. Үүний оронд гэрийн төсвөө хадгалж, гэр бүлийнхнийхээ боловсролыг санаандаа санаад, цөөхөн бага мөнгө байсан ч хадгаламжид хадгалахаар сэтгэл гаргавал түүний хариуг хэмжих аргагүй. Хөрөнгө нэмэгдэж, амьдрал дээшилж ирээдүйдээ санаа зовнихын ихэнх хэсэг нь алга болж орхино шүү.

Ажил мэргэжилд дээр доорын ялгаа гэж байдаггүй. Газар хагалах ажил ч, багаж зэвсэг хийх ч, нэхмэлчин ч, худалдагч ч, цөм гайхалтай ажил мэргэшил юм.

"Тогтвортой ажилтай байвал ичгүүрт унахгүй. Хөдөлмөрт хүрч чадаагүй хүн л ичгүүрийг амсах ёстой юм" гэж Флехиер өгүүлсэн байдаг.

Бас нэгэн санваартан "духандаа хөлс гаргах ажил ч бай, толгойгоо ажиллуулах ажил ч бай ямар ч гэсэн ажиллаж л байвал түүнд тохирсон шан байдаг" гэж өгүүлжээ.

Хүмүүсийн зүгээс дорд мэт үзэгддэг ажил мэргэшилтэй байлаа ч гэсэн тэндээс биеэ өндийлгөж их амжилтад хүрсэн бол ичгүүрлэхийн хэрэгцээ байхгүй. Түүгээр үл барам хүнд бэрхийг даван туулж өнөөгийн байр сууринд хүрсэнээрээ бахархаж явах ёстой. Америкийн нэгэн ерөнхийлөгч "ургийн тань бэлгэ тэмдэг юу вэ" гэж асуухад залуу байхдаа хийж байсан ажлаа санаад "цамцны хоёр ханцуй" гэж хариулсан гэдэг.

Нэгэн лам лаачин байжээ. Хэн нэгэн эмч түүгээр нь даажигнахад хариуд нь: "Та надтай адил тавиланд төрсөн бол одоо хүртэл лаачин хэвээрээ л явах байсан даа" гэсэн гэдэг.

### *Мөнгөний талаарх андуутай "хайр"*

Энэ хорвоод зөвхөн л эд хураахын төлөө амьд яваа юм шиг баяжихаар харайж явдаг хүн ч байдаг. Мэдээж хэрэг, биеэ ч, сэтгэлээ ч баяжихын төлөө зориулвал ихэнх нь баян хүн болох нь болох л байх. Гэхдээ тэд толгойгоо ашиглахын хэрэгцээ бараг байхгүй. Хөдөлмөрлөснийхөө үрийг үзэхээс илүү зарлага сүйтгэлээ багасгаж нарийлан байж хураавал алтан уулыг ч барьж босгоно гэж боддог юм болов уу даа.

Харин Жон Фостер ингэж бичиж байна.

Нэгэн залуу ужид самуунд биеэ эвдэж, эх эцгээс үлдээсэн өв хөрөнгөө үгүй хийж баржээ. Аргаа барсан тэрээр амиа хорлохоор шийдэж, гэрээсээ гарч ойрхон байх өндөрлөг өөд авирч гэнэ. Тэндээс тэрээр өмч байсан эдлэн газраа гүйлгэн харжээ. Залуу хэсэг хугацаанд бодолд дарагдан сууж байснаа ухасхийн босчээ. Энэ газраа дахин буцааж авъя гэж шийдсэн аж. Тосгон руугаа буцсан тэрээр нүүрс хутгагчийн ажлыг хийж эхлэн, цөөн цөөнөөр мөнгө хурааж байв. Аажмаар мөнгө нь хуримтлагдаад ирэхээр үхэр наймаалах ажил хийх болж, дараа нь бүр томоохон наймаа эхлэжээ. Тэгээд нэг л мэдэхэд тэрээр эдлэн газраа эргүүлж аваад зогсохгүй цаана нь юм үлдэхээр том баян болсон гэдэг.

Гэлээ ч тэрээр шал дэмий, утгагүй бөгөөд "гуятай гутал гуд татах" хүний амьдралаар амьдарсан юм. Удалгүй тэрээр бүрлээч болж хөдөөлүүлсэн бөгөөд энэ нь тэрээр булш болж, буцаж газартаа очсон төдий хэрэг юм. Дээр өгүүлсэнчлэн тийм их шийдэж чаддаг хүн байтлаа, бүр их тэнгэрлэг оюун санаатай байсансан бол зөвхөн өөрийнхөө төлөө төдийгүй, бусад хүний төлөө ч юмаа зориулах байсан нь дамжиггүй. Гэвч тэрээр эцсийн эцэст хувьгүй амьдарч, хувьгүй үхлээр дууссан юм. Эд баялаг төдийг харж, мөнгө хураах нь сэтгэл уйтан харамч хүний хийх ажил юм. Ухаантай хүн, иймэрхүү муу суртахуунд унахаас хангалттайгаар биеэ сэргийлж чадах ёстой бизээ. Нөгөө талаар хэмнэх гамнах гэдэг залуу цагийн бол сайн үйл нас ахиад ирэхээр бэрдийн муухай хармын суртахуунаар солигдох нь бий.

Буруу муу нь мөнгө өөрөө биш юм. Мөнгөний талаарх андуутай "хайр" л тийм юмны үндэс суурь болдог. Энэхүү андуурсан "хайр" нь хүний сэтгэлийг давчуу явцуу болгож, хатааж хагдруулдаг юм. Тэгээд уужуу талбиу амьдрал хийгээд өндөр дээд үйлд хандах оюун билгийг нь цоожилж түгжиж орхихын шалтгаан болдог ажээ.

Вольтер Скоттын туужийн нэгэн баатар: "Пэнигийн нэг дэвсгэрт ч биеийг хэрчиж, хүнийг хороож алдаг сэлэмнээс илүү олон чөтгөрийг тонилгодог эд дээ" гэж хэлдэг. Бизнесийг дагалдаж байдаг зүйлийн доголдолтой нэг тал нь хүний зан араншинг машинтай адил нэг хэлбэрт орууламтгай байдаг оршдог. Бизнес хүний олонхи нь шийдсэн арга замдаа улайраад, урдахаа гүйлгэж хардаггүй. Иймэрхүү, зөвхөн өөрийнхөө төлөө амьдарч байгаа бизнесмен бусад хүнийг өөрийнхөө зорилгод зүгтэх төдий хэрэгсэл юм гээд бодчихдог болов уу. Ийм хүний амьдрал түүний бичиж тэмдэглэж буй хар дансных нь нэгэн хуудастай адилхан үнэ цэнтэйгээс зайлахгүй. Хүмүүсийн амжилт мөнгийг хичнээн хурааж цуглуулснаар хэмжигддэг. Энэ амжилт мэдээж хэрэг нүд эрээлжлэм шахуу гайхамшигтай зүйл аж. Хүн болгон ингэж их багагүй магтан дуулдаг тэр нь дэмий ч яриа бас биш юм. Ухаалаг агаад тэвчээртэй шургуугаар, боломж бололцоог овсгоотой барьж авдаг хүн бол чадварлаг гэгч нь хорвоог туулж, амжилтыг хураан цогцлоох хангалттай боломжтой болдог юм. Харин тийм хүн ямагт гайхам сайхан зан араншин, сайн сайхан чанарыгтээж явдагуу гэвэл ерөнхийдөө бас тийм биш. Юмны учир зүй мөнгөнөөс илүү чухал агаад, харин түүнийг бага ч болов ухаарч ойлгоогүй хүн л баяждаг.

Тэгээд зогсохгүй тийм баян угтаа бол санаанд багтамгүй хувь муутай, үгээгүй хүн билээ. Эд баялаг гэгч ямар ч хүний ёс суртахууны үнэ цэнийн баталгаа болдоггүй. Гэрэлт хорхой өөрийнхөө гэрлээр өөрийн буртагт биеийг гэрэлтүүлэн харуулдаг лугаа адил, гялалзан гэрэлтэх эд баялаг ч өмчлөгч эзнийхээ дорд байдлыг ягуухнаар илэрхийлж байдаг буюу.

Мөнгөнд төөрөлдсөн хүнийг харахаар шуналт сармагчны тухай яриа санаанд ордог юм. Алжирын Кабнер мужийн тариачин эр хулууг модонд өлгөж чанга гэгч уяад дотор нь нэг ширхэг будаа хийгээд орхижээ. Хулуунд сармагчингийн гар орох төдий нүх гаргаж. Шөнө болоход сармагчин модонд ирж, хулууны нүхэнд гараа шургуулаад будааг базаж авчээ. Тэгээд атгасан гараа тэр чигээр нь сугалж гаргах гэсэн боловч, чадсангүй гэнэ. Гараа эргүүлбэл болох авч тэгэх ухаан хүрсэнгүй. Үүр цайж мань сармагчин тариачинд баригдсан бөгөөд баригдахдаа сармагчин будаагаа чанга атгасан чигээрээ үнэндээ бол гараа салгаад авчихсан юм шиг царайлаад сууж байжээ.

Энэ явдал лавтай хүмүүсийн тухай шог зураг мөн. Энэхүү ярианы сургамжийг бид өөрсдийхөө амьдралд ч хамааруулаад эргэцүүлж үзвэл болох биш үү.

Хэзээ ямагт мөнгөний хүчийг хэтэрхий үнэлэж ирсэн билээ. Энэ хорвоод хэрэг болох агуу их нээлт, бүтээлийн олонхийг нь баячууд бус санхүүгийн хувьд хувьтай бус хүмүүс хийж ирсэн билээ. дгуу их сэтгэгчид, шинжлэн судлаачид, зохион бүтээгчид, уран бүтээлчдийн дунд том баячууд байгаагүй, бүр тэдний олонхи нь хүмүүсийн орчин нөхцлийн талаас нь хэлвэл ядуу амьдралтай амьдарч ирсэн юм. Эд баялаг хүмүүсийн үйл хөдөлгөөнд түлхэц өгөхөөсөө илүү хойш татах нь бий. Ихэнх тохиолдолд эд баялаг аз жаргалыг дуудахын хажуугаар зовлонгийн үрийг ч тарьдаг. Ихээхэн өмч залгамжилсан залуу хүн ужид самуун амьдралд урсаж оромтгой байдаг. Хүссэн зүйл нь яаж ийгээд гарт нь ороод ирдэг тул тэгэхээр амьдралд ханаж цадаад ирдэг байна.

Тэмцэж байж олж авах гэх мэтийн тусгай зорилго байхгүй тул ганихарч уйтгарласан өдөр хоногийг өнгөрүүлдэг болно. Түүний ёс суртахуун, оюун санааны хүч хэзээ ямагт нойрмог байдалд нүдээ аниастай. Мэдээж хэрэг, баячуудын дунд ч зөв ухаантай хүмүүс цөөнгүй бий. Тийм хүн залхуу хойргыг эр хүний шинж биш гэж үзэн хүлээж авахгүй байх болов уу. Эд баялаг, өмч хөрөнгөтэй зууралдах юм бол тэр хэмжээний хариуцлагаа ухамсарлаж, бүр их эрхэм сайн ажил хийхээр зорих хэрэгтэй. Гэхдээ яагаад ч юм тиймэрхүү жишээ бараг л байдаггүй нь хорвоогийн зан юмуу даа.

### ***"Зан чанарын төрсөн ээж"-ийн тухай***

Хамгийн сайн утгаар буй "эрхэмсэг шинж" нь гайхамшигтай чанар билээ. Өндөр дээд зан чанартай хүн хүндлэгдэж, эргэцүүлээд бодох төдийд татах хүч агуулж байдаг. Харин хүмүүсийг бүхэлд нь эзэмдэх гэсэн эрхэмсэглэлд л өчүүхэн ч үнэ цэн байхгүй. Баян тансаг муу хүнээс эрхэм сайн ядуу хүн нь дээр. Тансаг гэрт сууж, машин хөлөглөж сайхан ааш эсгэж буй танхай этгээдтэй харьцуулахад Дуугайхан, даруухан амьдарч яваа хүн ямар их сайхан бэ? Нийгмийн гарал ямар ч байсан хамаа алга, уужим амгалан сэтгэл, гүнзгий мэдлэгийг эзэмшиж, хүмүүст хэрэг болохоор хичээж зүтгэх нь нэг хэвийн эрхэмсэглэлээс бүр их чухал утгыг агуулж байдаг юм шүү.

Хүний амьдралын хамгийн дээд зорилго нь авир араншингаа хүчтэйхэн засан цэвэрлэж, бололцооныхоо хэмжээгээр бие сэтгэлээ хөгжүүлж явах явдал юм. Энэ л цорын ганц зорилго, түүнээс өөр зүйл бүхэн үүнийг олохын төлөөх арга замаас хэтрэхгүй юм. Хамгийн дээд тав тух, эд баялаг, эрх хүч, байр, суурь, нэр алдар, шагнал авлаа ч тэр нь хүний амьдралын хамгийн том амжилт биш билээ.

Тэгвэл хамгийн өндөр дээд хүн чанартай, бусдад хэрэг болох ажилд биеэ зориулж, хүнийхээ хувьд үүргээ гүйцэтгэж явах л хамгийн эрхэм сайн амьдрах зам билээ. Мөнгө мэдээж хэрэг их хэмжээний хүчтэй. Гэвч оюун санаа, хамтач сэтгэл, ёс суртахуун ч бас хүч буюу. Бүр мөнгөнөөс ч илүү хамгийн эрхэм зүйл юм. Колинвуд найздаа бичсэн захидаддаа: "Мөнгө байхгүй ч гэсэн би баян болж чадна. Янз бүрийн золгүй явдал, ядуу гуцууг даван туулна гэсэн оролдлого зүтгэлийн хүч л байвал надад хангалттай юм" гэжээ.

Нэгэнтээ өмч хөрөнгөтэй болсон хүн бол эрхэм дээдсийн хүрээлэнд багтаж орох нь тийм ч хэцүү биш. Гэвч тийм хүрээлэнд чухалчлагдах юм нь тэнд таарч тохирох авьяас чадвар, аж төрөл, оюуны чадал билээ. Эс тэгвэл ердөө л их мөнгө өвөртөлсөн хэнд ч хэрэггүй хүүхэлдэйд тооцогдоно.

Гэсэн атал өнөөгийн дээдсийн хүрээлэнд тийм чухал шинж чанарт бага ч болов санаа тавьдаггүй, улмаар ойр хавийнхныхаа хүндлэлийг ч хүлээхгүй том баячууд олон болжээ. Яагаад тэр вэ? Тэд ердөө л амьтай түрийвчээс хэтрэхгүй, тэдний чадал мөнгөнийхээ авдар дотроос өөр газар байдаггүйд учир нь оршму.

Нийгэмд үнэхээрийн нөлөөлөх хүчтэй, хүмүүсийн санаа бодлыг манлайлах үүрэг хүлээж, жинхэнэ амжилтыг олж хүмүүст хүчин зүтгэх хүмүүс заавал баян хүн байна гэдгээр хязгаарлагдахгүй. Бүр өндөр дээд ёс суртахуунтай, хэцүү бэрх зам туулж ирсэн, эрхэм сайн зан чанартай хүн л нийгэмд чухалчлагдаж байдаг. Ядуу зүдүү, бараг модоо барьсан хүн ч гэсэн зан төрхөө цэвэршүүлэх боломжийг алдаа эндүүгүй ашиглаж чадвал материаллаг хүч, авьяас чадварынхаа хэрээр хамгийн дээд амьдралаар алхаж явах болно. Тийм хүний зүгээс харвал, бусдын амжилтыг сүүдэр шигдагаж, мөнгөөр амжилт ологсон, мөнгөний боол хүн гэдэг атаархмаар зүйл гэж үү, үнэндээ бол хөөрхийлөлтэй агаад доог тохуутай хэрэг бус уу.

# НАЙМДУГААР БҮЛЭГ

## Өөрийгөө боловсруулахуй

*Хамгийн дээд мэдлэг нэгэн өдрийн ажил дундаас тодордог*

### 1.Өөрийнхөө хөлс, нулимсаар ялж олсон мэдлэг шиг хүчтэй зүйл үгүй

"Хамгийн сайн боловсрол гэдэг хүн өөрөө өөртөө хүртээдэг боловсролыг хэлдэг" гэж Вольтер Скотт хэлжээ. Шинжлэх ухаан, урлагийн салбарт агуу их бүтээл туурвисан хүмүүст лавтайяа дээрх үг тохирч байна. Сургуулийн сурган хүмүүжүүлэх ажил жинхэнэ боловсролын өчүүхэн эхлэл төдийгөөс хэтрэхгүй, оюун санааг өнгөлж зүлгэн хичээл хийх дадал хэвшлийг бий болгох гэдэг утгаар л үнэ цэнтэй юм. Бусдын дэмтэй боловсрол, өөрөө хичээнгүйлэн зүтгэж олсон шиг биед хэвшдэггүй. Өөрийнхөө хөлс, нулимсаар ялж олсон мэдлэг л бүрэн төгс өөрийн өмч болдог. Өөрөө хичээл хийвэл, түүний агуулгын талаарх сэтгэгдэл хэзээд тод үлддэг. Тэр нь бусдаас хүртсэн хангалттай бус мэдээллээс ялгаатай бөгөөд уураг тархинд тодтомруун сийлэгдэж хоцордог билээ. Өөрийн боловсрол нь эрдэм судлал руу хандсан урам онгодыг дуудан босгож, түүнийг хүчтэй болгож байдаг. Нэг асуудлыг давбал, тэр нь дараагийн асуудлыг байлдан дагуулахын хүчин зүтгэлийг нэмж, мэдлэг улам улмаар бодитой хэрэглээг хангах зүйл болж хувирдаг.

Өөрөөр хэлбэл, идэвхтэй суралцах төрх маяг л хамгийн чухал юм. Яаж ийгээд шилдэг сайн ном зохиол, багштай учирахсан гэх нь ч, цээжлэх хичээлийг аль болох хийх гэх мэтийн өөрийгөө боловсруулах арга маяг ч хэрэгцээгүй болох учиргүй юм.

Аль ч үед хамгийн сайн багш нар өөрийгөө боловсруулахын чухлыг эн түрүүнд шаардаж, өөрийн хүчээр мэдлэгийг олж авахыг шавь нартаа захиж ирсэн. "Хичээл"-ээс илүү "хэвшил дасгал"-ыг чухалд үзэж, шавь нар нь өөрсдөө урагшилж эрдэм ухаанд шамдахад бүхнээ зориулах нь чухал. Ийм арга нь мэдлэгийн өчүүхэн хэсгийг ирмэгийн нэг тал руу чичлэдэг анги танхимын хичээлийн хүрч очихгүй шахам үр дүнг өгөх билээ.

Нэрт сурган хүмүүжүүлэгч Арнольдгийн арга барил ч энэхүү санаанд тулгуурласан байдаг. Тэрээр оюутнуудад хүнд найдалгүй, өөрийн хичээл зүтгэлээрээ хүчээ тэлж байх ёстой юм гэж сургадаг байлаа. Тэрээр өөрөө оюутнуудаа зөвхөн залж, шамдуулж, зоригжуулдаг төдий л байжээ. Хүүхдээ Оксфордын Их сургуульд оруулах нь сайн хэдий ч, тансаг амьдралд будагдаж, өөрт оногдсон нөхцөл байдлаа амьдруулъя гэдэг сэтгэлээ алдаж байвал тэдэнд идэх талхаа олохын тулд хөдөлмөрлүүлэх нь дээр юм гэж тэр хэлдэг байв.

Бас нэгэн удаа тэрээр: "Энэ хорвоод үнэхээрийн гайхан шагширах ёстой зүйл нэг байдаг. Тэр юу вэ гэвэл төрөлхийн авъяас билгэтэй учраагүй хүүхэд бага багаар хичээнгүйлэн зүтгэл гаргасаар жинхэнэ боловсрол биедээ эзэмшиж явахыг харах явдал юм. Тийм хүүхдэд би малгайгаа аван толгойгоо бөхийхөөс түвдэхгүй" гэжээ.

Арнольд нэг удаа ойлгоц удаантай жаал хүүд зааж байгаад ширүүхэн загнасан ажээ. Гэтэл нөгөөх сурагч түүний нүүрийг нухацтай гэгч харж байгаад: "Багшаа! Та юунд уурлаад байгаа юм бэ, намайг үнэхээр байдаг чадлаараа хичээл зүтгэл гаргаад байхад..." гэжээ.

Хэдэн жилийн дараа тэрээр энэхүү яриаг өөрийнхөө хүүд яриад, "Миний амьдралд үүн шиг хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн зүйл байгаагүй. Тэр жаалын сургамж, тэр үг одоо ч ердөө мартагддаггүй юм" гэж нэмж хэлсэн гэдэг.

### *Ажил хөдөлмөрийг дамжихаас нааш төрж бий болдоггүй өндөр дээд "оюуны соёл"*

Ядруухан тавилангаас биеэ өндийлгөж, эрдэм судлал урлагийн салбарт нэр алдар олсон хүмүүсийн жишээг энэ хүртэл олонтоо дурдлаа. Өндөр дээд оюуны соёл болон ажил хөдөлмөр хоёр тасалъя гэсэн ч тасалж чадахааргүй холбоотой байдаг нь эдгээр жишээнээс ойлгогдож буй бизээ .

Тохирсон хөдөлмөр зрүүл мэндэд сайн, хүний язгуур чанарт ч таарч тохирч байдаг. Хичээл сурлага хүний оюун санааг зүлгэн гялалзуулж байдаг бол ажил хөдөлмөр бие организмыг хат суулгаж байдаг билээ. Зав чөлөөтэй цагтаа ч болов ямар нэг хэмжээгээр хөдөлж байх хэрэгтэй. Ядаргаагаа гаргая гэвэл, махбодийн цаад хүсэл шаардлагыг хангая гэвэл биеийн хүчний ажил хийх хэрэгтэй.

Даниель Марсас хүүдээ "Их сургуульд эрдэм мэдлэгт хүчээ зориулахын хажуугаар спортод ч оюун санаагаа гаргаж бай" гэдэг байв. Биеийн тамир нь оюуны үйл ажиллагааг идэвхжүүлэх хамгийн сайн арга зам юм. Тэрээр цааш нь: "Янз бүрийн мэдлэгт гар дүрж, байгаль, урлагийг судлавал чиний сэтгэл санаа баян болж, оюун санааны хүч чинь нэмэгдэнэ. Гэхдээ биеийн тамирын тэмцээн чиний бие махбодид адилхан баяр баясгалан, хүч чадлыг бэлэглэх учраас би бүр сэтгэл хангалуун байна. Биеийн тамирын тал дээр ч хүний дор орохооргүй хүч чармайлт гаргаарай. Хүн гэдэг амьтан хөл дээрээ зогсож, биеэ хөдөлгөж байгаа цагт л оюун санааны баяр баясгаланг хамгийн их мэдэрдэг юм шүү" гэжээ.

Эрүүл чийрэг биетэй байна уу үгүй юү гэдэг нь бидний нийтлэг мэдэж байдгаас илүүтэйгээр өнөөгийн нийгэмдэх амжилтыг савлуулж байдаг. Морьт цэргийн захирагч Ходсон Англид байгаа найздаа бичсэн захидалдаа:

"Энэтхэгт миний бие амжилт гаргана гэвэл тэр нь ходоод гэдсээ эрүүл байлгах л явдал" гэжээ. Мэдээж хэрэг, ямар ч ажил мэргэжил байсан түүнээ цааш гүйцэтгэхэд ходоод гэдэс сайн муу байх нь асар их нөлөөлж байдаг. Оюуны хөдөлмөр эрхэлдэг хүн ч эрүүл мэнддээ хангалттай анхаарал тавьж байх ёстой юм. Өөрийгөө хувьгүй хүн гэж бодчихоод сэтгэл хангалуун биш байдалд орсоор хойргошин залхуурч хоосон бодол, дэмий хүслийн ертөнцөд хийсч явдагзалуус саяхнаас нэмэгдэж байна. Тэд өнөөгийн нийгмийг хайхрахгүй, нийтийн жаяг ёсыг дургүйлхэн муучилдаг. Энэ бол залуу хүн бие махбодийн хатуужил хатыг анхаарч үзээгүйгээс тэр юм. Америкийн сурган хүмүүжүүлэгч Чарнинг: "Манай улсад олон залуу хүн хүсэл эрмэлзлэлээ алдах гэгч "сургуульд" сурч хүмүүжиж байна" гэжээ. Залуучуудын иймэрхүү "цус багадаа өвчин"-ийг анагаах ердөө ганц арга байдаг. Энэ нь тэднийг ажиллуулах явдал, өөрөөр хэлбэл биеийн тамир хийлгэж, биеийн хүчний ажил хийлгэж, бие махбодид нь хат суулгах явдал юм.

### *Гарын дорх дасгал сургууль оюуны хүчийг хат суулгадаг*

Залуу байхдаа зохиож бүтээх, машин техник сонирхон оролдох нь хүний хөгжилд ашигтай туршлага болдог. Жишээлбэл, бага байхдаа Ньютон сургуульдээрээ амжилт тааруу сурагч байсан боловч хөрөө, алх, сүх хэрэглэдэг ажилд туйлын дуртай байв. Байрныхаа нэг өрөөнд алх нижигнүүлж морин тэрэгний загвар угсарч, янз бүрийн машины төрлүүдийг бүтээдэг байлаа. Дараа нь найздаа баяртай нь аргагүй жижиг ширээ, хоолны тавиур зэргийг хийж өгсөн гэдэг.

Вутт, Стифинсон нар ч бага байхаасаа эхлэн хэрэгцээнийхээ хэрэгсэл багажийг өөрснөө хийдэг байсан гэдэг. Залуу байхдаа иймэрхүү дасгал сургуулийг хуримтлуулж байгаагүй бол том болоод тийм их гайхалтай нээлт хийж чадах эсэх нь эргэлзээтэй хэрэг шүү. Агуу их зохион бүтээгчид цөм бага балчир байхаасаа цөхрөлтгүй гараа ажиллуулж ур дүй, авьяас чадвар, оюуны чадлаа хатамжилж иржээ. Биеийн хүчний хөдөлмөр хийж байсан хүн оюуны хүчний ажил мэргэжил эрхлэх болсон тохиолдолд ч дээр үеийнх нь туршлага ихээхэн хэрэг болдог юм. Хэл шинжээч Эрик Баритт " Судалгаа шижилгээний ажлыг үр дүнтэй урагшлуулахад хүнд хүчир хөдөлмөрийг дутааж болохгүй" гэж өгүүлсэн байдаг.

Нэг биш удаа тэрээр багшийн ажил болон судалгааны ажлаа орхиж, бүр байтлаа өмнө нь хийж ирсэн юм шиг төмөрлөгийн үйлдвэрт ажиллаж, бие сэтгэлийн эрүүл мэндээ дэмнэж байсан гэдэг. Залуу хүнд багаж хэрэгсэлтэй ажиллах аргыг сургаж зүгшрүүлэх нь өөрийнхөө гар, бугуйг хэрэглэх аргыг зааж өгч байна гэсэн үг. Түүгээр залуу хүн ажил хөдөлмөрийн баяр баясгаланг олж авч бодитой хэрэг тус болох чадвараа нэмэгдүүлнэ. Тэд машин механизмыг оролдож байх хооронд машины хөдөлгөөнд суралцаж түүндээ татагдаж тэвчээр хатуужил биед нь суугаад ирнэ. Харин зөвхөн биеийн хүчний ажилд улайраад байвал оюуны чадавхи болон суртахууны тал дээр буурамтгай болно. Биеийн хүчний маягийн дасгал нь оюуны дасгал сургуультай угсрагдаж таарвал үнэхээрийн үр дүн өгөх зүйл билээ.

## 2.Төмрийг улайстал нь давт

Сурган хүмүүжүүлэхэд бие бялдрын хүч чадал болон эрүүл мэнд үндэс суурь болно, үүнтэй эн сацуу оюун санаагаа ашиглах дадал хэвшлийг бүрдүүлэхийг дутааж үл болно.

"Ажил хөдөлмөр мянган хэргийг эрхшээлдээ оруулдаг" гэсэн цэцэн мэргэн үг нэн ялангуяа мэдлэгийг эзэмших үйлсэд ч таарч байна. Эрдэм мэдлэгийг эзэмших зам, хичээл сургуульд шамддаг л бол хэнд ч гэсэн эрх тэгш нээлттэй байдаг бөгөөд мэдээж хэрэг, зорилготой байвал даван туулахад хэцүү бэрхшээл гэх мэт юм юу ч байхгүй.

"Биднийг бурхан ертөнцөд илгээхийн сацуу, хүн өөрөө зовлон бэрхшээлд унахгүй л бол хаа ч хүрэх боломжийг олгосон юм" гэж шүлэгч Чаттертон хэлсэн байдаг. Хичээл сурлагын тухайд бизнестэй яг адилаар шургуу зүтгэлийг дутааж болохгүй юм.

Бид, төмрийг халуунд нь давтах төдий бус, төмрийг улайстал давтаж байхгүй бол болохгүй билээ. Хүчтэй шургуу, бүхий л чадлаараа хичээн зүтгэж, ямар ч боломжийг алдалгүй ашигладаг хүн бий, гэтэл залхуу хойрго хүн дэмий хоосон өнгөрөөдөг, өчүүхэн бага цагийг ч болов хангалттай ашиглавал амжилтад хүрнэ. Тэгвэл гайхал төрөх шахам, өөрийгөө боловсруулсны үр дүн гарах ёстой юм. Тухайлбал, Фаргсон өндөр уулын оройд хонины арьс нөмрөн гарч хүйтнийг тэсвэрлэн тэнгэр ажиж, одон орон судлалд суралцаж байв. Эдмонд Стон гэрийн багшийн ажлыг үргэлжлүүлсээр математикт шамдаж байлаа. Самуэл Долл гуталчны ажлынхаа завсар хоорондуур самбаачлан хүнд хэцүү гүн ухааныг судалсан бөгөөд Милл чулуу зүсэх газар түр ажилчин болж ажиллангаа бие дааж геологийн ухааны мэдлэгийг эзэмшиж байжээ.

Зураач Леонарс хичээл зүтгэлийн үр ашигт чин сэтгэлээсээ итгэдэг байв. "Шургуу чанга хичээж зүтгэсээр байвал хэн ч гэсэн хүний урд гишгэж чадна" гэж онцлон хэлдэг байв. Өнгөц харахад үл тоогдом ажил хүртэл гоц авьяаст хүргэх зам болох бөгөөд, хязгааргүй хичээл зүтгэл гаргавал хязгааргүй авьяасыг бий болгоно гэж тэрээр үздэг байв.

"Гойд давуу чадвар хичээл зүтгэлээр л зөвхөн олгогдож байдаг. Гайхалтай авьяастай байвал хичээл оролдлого түүнийг улам өндөрт өргөдөг. Чадвар нь бусдаас ялгарамгүй байлаа ч гэсэн зүтгэл оролдлого тэрхүү дутагдалтай талыг нөхөх учиртай. Хичээл оролдлогыг зөв зүг рүү чиглүүлж л байвал ерөөс түүнээс хор гарахгүй.Зүтгэл оролдлого байхгүйгээр юуг ч олж чадахгүй" гэж Леонорс хэлсэн байдаг.

### *Ажилдаа сайн хүний нууц*

Бид ямарваа зүйлийг бүрэн төгс, бүүр зөв тодорхой суралцаж байж төрх байдлынхаа суурь болгоно. Мэдлэгийн үнэ цэнэ гэдэг аль хэр хурааж цуглуулснаар бус, харин зөв зохисоор зорилгодоо хэр зэрэг ашиглаж чадаж байгаад оршино. Бага цөөн мэдлэг ч гэсэн тэр нь зөв зүйтэй төдийгүй төгс төгөлдөр байвал гадар өнгөн төдий түмэн мэдлэгээс бодитой зорилгод хэрэг болох нь илүү их байдаг. Нэгэн санваартан: " нэг удаа нэг ажлаас өөрийг хийдэггүй хүн хэнээс ч илүү олон ажлыг хийдэг" гэж байдаг. Энд тэндхийн олон салбарт гараа хэтэрхий сунгавал эсрэгээр эргэж анхаарлын чадвар дутагдаж, дэвшиж урагшлах нь хоцорч, явцгүй ажил хийдэг зуршил биед хэвшиж орхино. Леонардс өөрийнхөө суралцсан аргын тухайд: "Хуулийн хичээлийг хийж эхлэх үед би ингэж шийдсэн юм."Сурсан мэдлэгээ бүрэн төгс өөрийнхөө яс маханд шингээе. Тэгээд нэг л зүйлийг төгс төгөлдөр эзэмшээгүй үед яагаад ч цааш урагшилж болохгүй шүү" гэж.

Хамт суралцагсдын олонхи маань, би нэг долоо хоног зарцуулж уншдаг номыг ердөө нэг хоногт дуусгадаг байлаа. Харин нэг жил өнгөрөхөөр юу болох вэ. Миний мэдлэгтүүнийгтогтоосон өдрийнх шигээ тов тодхон үлддэг байсан бол тэдний сурсан зүйл ор тас мартагдсан байдаг байв" гэжээ.

Хүн хийсэн хичээлийнхээ хэмжээ, уншсан номынхоо тоогоор цэцэн болдоггүй. Хичээллэх арга өөрийн чинь мөрдөх зорилгод тохирч байна уу, үгүй юү, нэгэн үзүүрт сэтгэлээр хичээлдээ шамдаж барьж авч байна уу, хичээл зүтгэл хэвшил заншил болж байна уу гэдэг л гол асуудал юм.

Нэгэн эмч "Миний оюун санаанд нэгэнт тогтсон хамгийн цаад хязгаарын цэг гэж байдаг" гэж онцлон хэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл мэдлэгээр хэтэрхий чигжиж дүүргэвэл нэгэнт тогтоосон байсан мэдлэг толгойноос гаргагдан хаягдахад хүрдэг гэж тэрээр үзжээ. Анагаах ухааны хичээлийн тухайд: "Өөрөө юуг хийх вэ? гэдгээ л тодорхой мэдэж байвал, түүнийгээ биелүүлэх арга замаа сонгохдоо түүнийгээ баллах гэх нь бараг л байдаггүй болов уу" гэжээ.

Бат ноттой зорилготой байвал хичээл сургууль ур жимсээ өгдөг.Аль нэг салбарын эрдэм мэдлэгийг төгс төгөлдөр эзэмшвэл хэзээ ч түүнийгээ ашиглан хэрэглэж чадна. Ийм учиртайгаас, зөвхөн олон номтой байх, чухал мэдээллээ эрж олоход юуг уншвал болох вэ гэдгээ мэдэж байх нь хангалттай бус юм. Хүний амьдралд ямагт хэрэг болох ухааныг сурч, чарам хийсэн цагт түүнийгээ шууд хэрэглэхээр бэлтгэх учиртай.

Гэртээ хичнээн их мөнгийг цоожлоод орхисон байвч хармаандаа ганц улаан мөнгөгүй явж байгаад яаруу давчуу хэрэглэх болвол түүнээ амжиж авч чадахгүй. Үүн лугаа адилаар, мэдлэг хэмээх дэвсгэртийг нүцгэн биенээсээ ч салгалгүй биедээ авч явж, ямар ч тохиолдолд түүнийгээ суга татан ашиглаж чадах бэлтгэлээ төгс базаасан байх учиртай. Эс тэгвээс мэдлэг яг хэрэгцээтэй болсон үед туслаж үл чадмой. Өөрийгөө боловсруулахын тулд эрс шийдвэртэй, соргог байвал зохино. Үүний учир хүнийг багаас нь бие даалгаж, чөлөөтэй үйлдэл хийх боломжийг аль болохоор олгож байх нь зүйтэй юм.

Хэтэрхий бөөцөөлөх эсхүл хэтэрхий хатуурхах нь өөрөө өөртөө туслах дадал хэвшлийг хүнд хэвшүүлэхэд хаалт болдог. Энэ нь яг, сэлж чаддаггүй хүний суганд хөвдөг уут уяж орхисонтой яг адил хэрэг юм. Өөрөө өөртөө итгэлгүй байх нь хүн урагш дэвжиж хөгжихөд том гай болдог. Морь нь дүүлж давхих гээд байхад зориг алдан цулбуураасаа зуурч татаад байдгаас хүний амьдрал дахь алдааны тал хувь ньүүсдэг гэдэг яриа байдаг.

Самуэль Жонсон "хүчиндээ итгэдэг байсан учраас л би амжилт гаргаж чадсан юм даа" гэж ямагт хэлдэг байжээ. Өөртөө хэт итгэвэл даруу төлөв байдлаа алдах биш үү гэж бодогдож магадгүй юм. Угтаа бол тийм биш. Жинхэнэ төлөв даруу гэдэг бол өөрийнхөө сайн талыг зөв зүйтэй үнэлж цэгнэх явдал болохоос биш сайн талаа бүгдийг үгүйсгэх явдал огт биш билээ.

Өөрийнхөө хүч чадалд хэт итгэдэг, эсхүл өөрийгөө ч мэддэггүй хүн зөндөө буй. Ямар ч гэсэн өөртөө итгэдэггүйгээс болдог бүлбэгэр байдал бол хүний хөгжил дэвшлийг хааж байдаг зан араншингийн томоохон дутагдал мөн. Өөрөө өөртөө итгэлтэй байж идэвхитэй зоримог алхам хийхгүйгээр томоохон үр дүнг хүсэхийн ч хэрэггүй бизээ.

### *Зэвэрснээс хигдэс болсон нь дээр*

Хэн ч байсан өөрийгөө боловсруулахыг дамжиж байж дэвжиж дээшилэе гэж мэддэг. Мөн түүнтэйгээ дүйхүйц хэмжээний хичээл зүтгэл гаргахгүй бол болдоггүй нь хорвоогийн ёс юм. Жонсон доктор энэ тухайд "хичээл зүтгэлийгтэсвэрлэдэггүй нь өнөөгийн хүмүүсийн сэтгэл зүрхний өвчин юм" гэж онож хэлсэн байдаг.

Бид "эрдэм ухаанд хялбар зам байдаггүй" гэдэг цэцэн үгэнд итгэхгүй, шинжлэх ухаанд ч гэсэн ямар нэг амар хялбар зам байх ёстой гэж боддог болжээ. Тиймээс боловсрол эзэмших гэхдээ барагтай бол биеэ зовоолгүй, дөт хялбар замыг бодож олох гэж оролддог болж.

Нэгэн язгууртан хатагтай хэл шинжлэлээр хичээллэж эхлэх үедээ "үйл үг, нөхцлийн дүрмүүдээр намайг битгий шаналгаж үзээрэй дээ" гэж багшаасаа гуйсан гэдэг. Хурдавчилж сурах аргад найдаж, хэл судлалд амжилт олох гэдэг гажуудал яг энэ хатагтайтай төсөөтэй юм.

Шинжлэх ухаанд ч гэсэн нэг их ялгаа байхгүй, амар хялбар сурах арга олох гэсэн хүсэл газар авч байна. Бид харахад сонирхолтой туршилтыг харж, шар өнгөтэй ус улаан болж хувирах, нүүрстөрөгчийн дотор фосфор шатахыг ажиглаад түүхий мэдлэгийг олж авдаг. Түүхий ч гэсэн юу ч байхгүйгээс дээр боловч угтаа бол тийм мэдлэг хэрэг болох нь бага юм. Эцсийн дүнд бид ердөө сонирхолыг боловсролтой андуурч боддог болох нь ээ.

Хичээл ч хийлгүй, зүтгэл оролдлого ч гаргалгүй хялбарханаар мэдлэгийг олж авдаг арга байдаг гэж төсөөлөөд үзье, тэгвэл боловсрол гэж нэрлэх, орлуулах зүйл огт биш юм. Толгойдоо хэсэг бусад мэдлэгийг чихэж чадлаа ч оюун санаагаа баялаг болгож чадахгүй. Хэсэгхэн хугацаанд оюун санаанд түлхэц өгч, оюуны баясгаланг хүртээж болох боловч сонирхолоос илүүтэй дээд зорилгыг үрслүүлж суулгаж чадахгүй бол эцсийн дүнд үр ашиг багатайхан дуусна.

Ийм мэдлэг түрхэн зуурын сэтгэгдэл, мэдрэмж төдийгөөс хэтрэхгүй. Тэр бол агшин зуурын мэдлэг бөгөөд жинхэнэ мэдлэгээс хол юм.

Хүний сайн суртахуун өөрийнхөө хүчээр бүхий л чадлаараа зүтгэл гаргаж суралцсан үед анхлан сэрдэг. Харин сонирхол төдийхний хичээлд автагдахын хирээр тэрхүү сайн суртахуун үүрд мөнх нойрмоглосоор байх болов уу.

Сонирхогчийн хэмжээний мэдлэг хүртэх аргыг хөөцөлдвөл залуу хүн аажмаар хичээл чармайлт зүтгэл оролдлогыг үл тоомсорлоход хүрнэ. Тоглоом наадам шахам мэдлэг олж байгаа хүн дараачийн удаа нь мэдлэгээр даажин хийж тоглож эхэлдэг. Оюун ухаан аажим аажмаар үүл мэт арилж алга болон, цаг хугацаа өнгөрөхийн хирээр оюун санаа ч, авир араншин ч сайн нь сугарч алга болон саар нь шимэлдэг болон үлдэнэ гэсэн үг.

"Өнгөц сонирхол төдийг хөөсөн замбараа муутай уншилт тамхитай адил хүний оюун санааны хүчийг сулруулан муутгаж, доройтолд оруулдаг юм. Энэ бол залхуу заальхайн дотор ч хамгийн муу зүйл нь бөгөөд, хүнийг бүрэн төгс "агталж" орхидог юм" гэж Робертсон өгүүлсэн байдаг.

Амар хялбар суралцах аргын гай өнөө ч мөн улам бүр өргөжиж, янз бүрийн талаар муу нөлөө үзүүлсээр байна. Энэ нь юуны өмнө хөнгөн хуумгай хүмүүсийг олноор бий болгож байгаа юм. Үүний дотор юунаас ч илүү гол зүйл болох баараггүй хичээл оролдлогод дургүйлэхдэг хүн нэмэгдэж, оюун санааны хүчтэй уналт болон сульдаа улам бүр ахиж байна.

Үнэхээрийн цэцэн ухаалаг больё гэж хүсч байгаа бол, эхлээд оролдлого зүтгэлийн заншлыг биедээ хэвшүүлж, тэргүүний хүмүүсийн жишээгээр шаргуу хүчтэй хичээл зүтгэлтэй байх хэрэгтэй. Аль ч үед үнэ цэнтэй үйл хэргийг гүйцэтгэхийн тулд хичээл зүтгэл хэмээх төлөөс заавал шаарддаг. Тиймээс бид зорилгоо өндөрхөн өргөж ,эрдэм ухаан хийгээд ажил хөдөлмөрт шамдахыг үүргээ болгож, үр дүнг нь илэрч гарах хүртэл тэвчээртэй ажилах хэрэгтэй.

Илүү өндөр дээд зорилгод зүтгэх хэрээр ахиц дэвшил нь удаан байдаг. Харин чин сэтгэлээр бүх чадлаараа оролдлого зүтгэлтэй л байвал түүний шан заавал ирнэ. Өдөр бүр хичээл зүтгэлтэй амьдардаг хүн хэзээ нэгэн цагт тэрхүү хүчээ хүндэт зорилгодоо ашиглах болно. Дэвжиж өдөлснийхөө дараа ч бид үргэлжлүүлэн хичээл зүтгэлтэй байх ёстой. Яагаад гэвэл хүний амьдралд өөрийгөө боловсруулахуйд төгсгөлийн буудал гэж байдаггүй.

"Ямар нэгэн юманд шамдаж байх шиг жаргалтай үе байдаггүй" гэж шүлэгч Гурэй өгүүлжээ.

"Зэвэрснээс хигдэс болсон нь дээр" гэж санваартан Камберленд хэлжээ. Бас францын алдартай хүн Арно "Амрана гэдгийг нөгөө ертөнцөд очвол хэн ч чадах бус уу" гэжээ.

### **3."Жинхэнэ мэдлэг" ба "хуурамч мэдлэг"**

Өнөө үед нэр хаягийн соёлын чухлыг хэт дэгсдүүлж хөөргөдөх нь буруу юм. Тухайлбал "номын сан" боловсролын төв олон байгаагаас хүмүүс том ахиц дэвшил гаргалаа гэж бодох нь цөөнгүй. Гэвч угтаа бол тийм байгууламж хүн өөрөө өөрийгөө боловсруулахуйд хаалт болох тохиолдол ч бий . Баян хүн заавал ч өгөөмөр байдаггүйтэй адил гайхалтай номын сан байж, түүнийг чөлөөтэй ашиглаж чадах юм ч гэсэн түүгээр эрдэм мэдлэг төгсжих учиргүй. Сайхан байгууламж байх, үгүй нь хамаагүй, суут хүмүүстэй адилхан анхааралтайгаар юмс үзэгдлийг ажиглаж, шаргуу идэвхитэй оролдлого зүтгэл гаргахаас өөрөөр оюун ухаан болон танин мэдэх чадварыг хүртэх зам үгүй.

Оюун ухаан болон танин мэдэх хүч бол ном уншихаас нэлээд өндөр хэмжээний дасгал сургуулийг дамжиж байж олддог зүйл билээ. Нөгөө талаар ном, бичгээс мэдлэгийг хурааж сорж авах нь бусдын үзэл санааг тэр хэвээр нь ууталж байгаатай адил зүйл бөгөөд, өөрийн санаа бодлоо идэвхтэй хөгжүүлбэ гэж буй оролдлогоос том ялгаатай.

Өөрөөр хэлбэл хэчнээн мянган боть ном зохиол уншъя гэвч тэр нь архийг бага багаар шимэж уухтай адил оюуны зугаанаас хэтрэхгүй. Тэр үед аятайхан хөлчүүхэн мэдрэмжийг амталдаг авч жаахан атугай сэтгэлийн тэжээл болдоггүй, хүний авир араншинг өөд нь татахад хэрэг болдоггүй юм. Ном, зохиол уншихыг өөрийгөө гэгээрүүлж хөгжүүлэхийн арга зам гэж бодож яваа хүн олон байдаг. Угтаа бол ном унших гэдэг нь цаг өнгөрөөж байгаа төдий хэрэг юм. Энэхүү цаг өнгөрөөлтөд ямар нэгэн ашигтай тал байгаа гэж үзвэл тэр нь муу үйл хийх бололцоог тэр хүнээс боломжийн хээрээр булааж авч байгаа төдий юм уу даа.

Бас нэгэн мартаж болохгүй зүйл бол, номноос хэчнээн чухал туршлага суралцаж мэдэж авлаа ч гэсэн, эцсийн дүнд сургаар мэдэхийн хаалтыг давж чаддаггүй юм. Харин бодит амьдралаас олсон туршлага бол жинхэнэ ухаан болдог. Өчүүхэн багатийм мэдлэг асар их хэмжээний сургийн мэдлэгээс үнэ цэнээр хавьгүй их билээ. Нэгэн нэртэй улс төрч өгүүлэхдээ:

"Шууд ч бай, дам ч бай, биднийг сайн хүн, бүр цаашлаад сайн ард түмэн болгон хөгжүүлэхгүй тийм эрдэм ухаан бол үнэмшилтэйгээр хийгдсэн оюун санааны дуураймал тоглоом мөн. Тийм эрдэм ухаанаас мэдлэг олоход эгээ л үл мэдэхээс суралцаж байгаагаас юуны ялгаатай вэ" гэжээ.

### *Дандаа доошоо хараад байвал их зориг ирдэггүй*

Сайн ном зохиол мэдээж хэрэг ашиг тустай, суралцах зүйл их байдаг. Гэлээ ч тэр нь оюун санааг цэвэршүүлэн дээшлүүлэх нэг л арга юм. Хүний зан араншингийн төлөвшилд бодитоор өөрийн биеэр турших юм уу, гайхалтай арга барилд суралцах нь үр дүн ихтэй байдаг.

Жинхэнэ боловсролын зорилго бол бусдын сэтгэлгээ, санаа бодлыг тэр хэвээр нь ууталж, толгойдоо чихэх явдал биш. Хамгийн гол нь чадвараа дээшлүүлж, утга учиртай амьдрахаар оролдож зүтгэх нь чухал. Бид оюун ухаанаа хөгжүүлж, зан араншингаа дээшлүүлж, илүү баялаг бөгөөд аз жаргалтай, үнэ цэнтэй амьдралыг туулахын тулд л суралцах ёстой юм. Мэдлэг нь хүний амьдралын өндөр дээд зорилгыг илүү үр өгөөжтэй мөрдөхөд нөлөөлөх амьдрах хүчний эх ундрага байх ёстой билээ.

Бид өөрсдөө "ямар байх ёстой вэ", тэгээд "юуг хийх ёстой вэ" гэдгийг өөрийн биеэрээ сонгож авах учиртай. Дан ганц ном уншихад улайраад, бусдын хөрөг дүр, үйл хөдлөлийг магтаж муучлаад түүндээ сэтгэл ханах гэвэл хэцүүдэх билээ. Гайхамшигтай мэдлэгийг тэр хэвээр нь өөрийнхөө амьдралд тусгаж, шилдэг сайн санаа бодлыг тэр чигээр нь өөрийнхөө үйл ажиллагаатай холбож байх ёстой юм.

Иймэрхүү практик маягийн мэдлэг ухаан нь өөрийгөө боловсруулахуй болон биеэ эзэмдэх сэтгэлийг дамжиж байж л олддог. Энэхүү хоёр зүйлийн уг үндсэнд өөрийгөө хүндэтгэх сэтгэл оршиж байдаг болой. Хүсэл тэмүүлэл ч бас өөрийгөө хүндэтгэх сэтгэлээс төрж гардаг билээ. Хүсэл эрмэлзлэл нь хүч чадлын нөхөр агаад амжилтын ээж юм.

Өөрийгөө хүндэтгэх сэтгэл гэдэг, хүн биедээ зүүх хамгийн эрхэмсэг өмсгөл бөгөөд юу юунаас илүүтэй оюун санаанд урам өгч байдаг юм.

"Чи өөрийн биеэ хүндэтгэж бай" гэж Пифагор шавьдаа хэлж байв, өөрийгөө хүндэтгэх сэтгэл хэмээх өндөр дээд ухаанаар түшүүлсэн хүн мэдээж хэрэг, тачаалд ойчиж биеэ гэмтээх, эсвэл өөдгүй бодлоор сэтгэлээ бохирдуулах сэлтийг хийдэггүй юм. Өдөр тутмын амьдралын өнцөг булан бүрт өөрийгөө хүндэтгэх сэтгэл гаргаж хүрч чадвал цэвэр тунгалаг болон уужим талбиу, авхаалж самбаа, ёс журамтай байх гэх мэт олон сайн үйлийн үндэс нь болох билээ.

"Хэрсүү чамбай, зөв, өөрийгөө хүндэтгэх сэтгэл гайхамшигтай зүйл бөгөөд учир утгатай бүтээлийг төрүүлэх хөрс суурь, эх ундрага болж байдаг" гэж шүлэгч Милтон өгүүлжээ. Өөрөө өөрийгөө дорд үздэг хүн бусдад ч доордчилогдож байдаг. Өөдгүй муу бодолтой байвал үйл ажилд нь ч тэр нь илэрч байдаг. Дандаа доошоо хараад явбал, хүнд их зориг ирдэггүй. Өөдлөө дээшлээ гэж үнэн сэтгэлээсээ хүсвэл толгойгоо өргөж явах ёстой болно.

Өөрийгөө хүндэтгэх ухаан нь ямар ч хүнд сэтгэлийн дэм болдог юм. Энэхүү сэтгэл л байвал ядуу буурайг үлдэн хөөмү, хэцүү бэрх амьдралд ч нэг зүгт чиглүүлсэн гэгээ гэрэл тусгаж өгдөг. Хэчнээн ядуу зүдүү байлаа ч бахархах юмаа өндөрт хадгалж, дур хорхойг юм гэж үзэлгүй, биеэ доош унагах муу үйлийг тас хорьж явбал, тийм хүнийг харахад өөрийн эрхгүй хүндэтгэх сэтгэл бусдад аяндаа төрмү.

### *Өөрөө өөрийгөө өвчлүүлбэл эм олдохгүй*

Өөрийгөө боловсруулахуйг эрх тушаал хөөцөлдөхийн хэрэглүүр гэж бодох нь үнэн чанартаа тун бүтэлгүй үзэл юм. Ингэхэд өнөө үед өөрийгөө боловсруулах гэж хэчнээн хүчин зүтгээд ч санасанчлан хурдан түргэн албан тушаал дэвшиж чадахгүй тул гутарч гунин, хийе гэсэн сэтгэлээ алдаж буй хүн олон байдаг. Иймэрхүү нөхөд боргоцойн үрийг суулгавал нэгэн агшны дотор царсан шугуй болж өснө гээд хүлээж суухтай адил сэтгэж байна. Тэд мэдлэгийг лавтайяа худалдах бараа гэж ойлгож ирсэн учраас төсөөлөл нь амжилтгүй болмогц асар их гутарч буй нь тэрээ.

Дормен Хилл "Сурган хүмүүжүүлэх илтгэл" /1840-1841/-д ийн өгүүлсэн байдаг. Нэгэн сургуулийн сурагчдын тоо гэнэт цөөрөх болжээ. Нэг багш үүний учир шалтгааныг олохоор болж судлалал ийм баримт илрэв гэнэ. Хүүхдээ сургуулиас завсардуулсан эцэг эхчүүдийн олонхи нь "боловсролтой болвол миний хүүхэд урьдахаасаа амар хялбар амьдарч чадах болов уу" гэж найдаж байсан бөгөөд тэгээд бодит байдалд боловсрол нь "бага ч болов хэрэг болсонгүй" гэж үзээд, түүнээс хойш хүүхдийн боловсролд дэмий зовлогоо зовоохоо болихоор шийдэцгээсэн ажээ.

Өөрийгөө боловсруулахтай холбоотой иймэрхүү бүтэл муутай бодол нийгмийн газар бүрт хүрч, хүмүүсийн янз бүрийн гажуудал нэмэх хэрээр өсч торнисоор байна. Хүний зан төрхийг дээшлүүлж, оюун санааг баялаг болгох язгуур хүч болох ёстой өөрийгөө боловсруулахуй нь хүнийг гүйцэж түрүүлэхийн төлөөх арга зам, оюуны тоглоомын хэрэгсэл болох нь үзэгдэж байна. Бэконы үгийг иш татвал: "мэдлэг нь юм худалдаж мөнгө олохын төлөөх дэлгүүр бус, хүнийг аварч туслахын тулд байдаг баялаг агуулах юм." гэсэн байдаг.

Ажилсаг хүн байр суурь, зэрэг дэвээ дээшлүүлж явах нь мэдээж хэрэг сайн явдал юм. Гэвч бас өөрөө өөрийгөө хохироогоод ч болов тэгж байх ёстой бишээ. Материаллаг хүсэл шуналаа хангах хэрэгсэл болгож оюун санаагаа ашиглаж суух нь угтаа бол дорд хэрэг мөн.

Хүний амьдралын амжилт мэдлэгээр бус хичээл зүтгэлээр олддог зүйл. Эрх тушаалд хүрч чадаагүй учраас гээд хувьгүйгээ гайхаж, уйлан майлан үг цувруулж суудаг хүн бол ядуухан сэтгэлтэй өчүүхэн хүн гэдгээ батлаж буй тэмдэг болохоос өөр юу ч биш. Роберт Саудер иймэрхүү дорой нөхдийг хатуу чанга шүүмжилсэн байдаг. Тусламж гуйсан найздаа бичсэн хариу захидалдаа "Хэрэг болдог юм бол зөвлөлгөө өгье. Харин өөрөө өөрийгөө өвчлүүлсэн хүнийгэмнэх эм энэ тэр гэж байдаггүй. Сайн сайхан, ухаалаг хүн л хааяа хүмүүст УУР хүрч, хүмүүст итгэхээ больчихдог байж магадгүй. Гэхдээ өөрийнхөө үүргийг нягт нямбай гүйцэтгээд явж байгаа хүн бол хүмүүст сэтгэл хангуулан бус байх ёсгүй дээ" гэжээ.

### ***Оюун санаанд " уян хатан чанар" өгөх ном зохиол хэрэгтэй.***

Эрдэм ухааныг зөвхөн оюуны алжаалаа тайлах, зугаацах хэрэглүүр болгон ашиглавал боловсролыг өөрийг нь няцаан гутаасан даллага л болж хувирах болно. Гэсэн хэдий ч өнөө үед боловсролоо худалддаг хүн олон болжээ. Бас хөнгөнцөр хялбар уран зохиол хүмүүсийн сэтгэл зүрхийг сандаан үймээж, хүмүүс ч түүнийг нь дөвийлгөн магтаж байх юм.

Иймэрхүүгээр олон түмний таашаалд нийцэхийн тулд, бичиг ном, сонин сэтгүүлд эвгүйцэм илэрхийлэл багтаж ядан, "сонирхолтой" солиотой үгс өргөнөөр хэрэглэгдэж, нийтийн жаягийг эвдлэх олиггүй зураглал нь миний юм шиг, бидний юм шиг царайгаар улам бүр газар авч байна. Жүжгийн зохиолч Даглас Жейлд энэхүү гажуудлыг дараах байдлаар шүүмжилсэн байдаг. "Юутай ч гэсэн, бүдүүлэг тэнэг, инээлгэх төдий өнөөгийн урсгалаас хүмүүс хэзээ нэгэн цагт уйдах нь дамжиггүй.Бага ч болов тэгээсэй гэж би хүсч байна. Эцсийн эцэст хүний амьдралд буурь суурьтай болохоос өөр аргагүй үе гэж байдаг. Хүний амьдрал бүхэлдээ хүний марзганалын түүх биш учраас тэр юм" гэжээ.

Зохиолч Жон Сталлинг дээрхтэй адил санааг өгүүлсэн байдаг. "Өнөөгийн хүмүүс, тэр дундаа өсөлтийн насан дээрээ яваа залуучуудын хувьд тийм сэтгүүл, тууж гэдэг нь хижиг өвчнөөс ч илүү аюултай оюун санааны өвчин юм. Цэвэр сайхан усыг өмхийрүүлж, гэр орныг идэх гайт хорхой шиг зүйл юм" гэжээ. Хүнд хөдөлмөрөөс амс хийгээд их зохиолчийн гайхамшигтай үлгэрийг унших нь мэдээж хэрэг өндөр дээд оюуны таашаал мөн билээ. Нэртэй бүтээл гэж зард гарсан зохиол бүтээл нь хөгшин, залуу, эр, эм аль ч бай ямар ч уншигчийн оюун санааг хүчтэй татахгүй орхидоггүй билээ. Тохирсон, уншлагын таашаалыг ерөөс алдаж болохгүй.

Харин унтах, идэхээ умартатлаа ном уншихад автагдахыг бодож үзүүштэй. Хэрэгтэй, хэрэггүй номыг ангасан мэт уншиж, тэнд дүрслэгдэж буй нийтээс гажуу амьдралын хээ хуарт сэтгэл татагдаж, цаг завныхаа ихэнхийг өнгөрөөдөг хүн олон. Энэ бол цагийг үргүй зарж буй төдийгүй хүний сэтгэл санаанд ч гарз хохиролтой нөлөө үзүүлдэг.

Уран зохиолд алдарч, хуурмаг сэрэхүйд дарлагдвал, эрүүл чийрэг зүрх сэтгэл муруйж гажаад санаа сэтгэл самуурахын осол ихэснэ. Ном уншиж энэрэн нийгүүлсэхийн сэтгэлийг бадраавч, тэр нь бодит үйлдэлтэй холбогдохын учир үгүй юм. Номонд гарч байгаа хэрэг явдалд сэтгэл хөдөллөө ч гэсэн тэр нь бодитойгоор өөрөө зовох асуудал ч биш, өөрөө золиослогдох ч учир үгүй. Тиймээс адал явдалд дандаа сэтгэлээ хөдөлгөөд байвал бодитой зүйлийн талаар яваа яваандаа мэдрэмжгүй болж ирдэг. Тэгэхээр оюун санаа гэдэг болд төмөр чинь алгуур аажмаар илбэдүүлж, уян хатан чанар хэмээх хувиршгүй онцгой шинж чанараа хэзээ ч юм алдаж орхидог. Нэгэн санваартан ийн өгүүлж байна. " Сэтгэл зүрхэндээ хэчнээн сайн үйлийн зургийг зуравч, энэ нь бодит байдалд сайн үйлийн дадал хэвшил болж биед сууна гэсэн үг биш юм. Түүгээр барахгүй санаа сэтгэл чигжүүрэн хатуурч, аажимдаа харшил болох бус уу".

### ***Залуу цагийн тавилан хөгширсэн хойно заавал тойрч ирдэг***

Алжаал тайлалт хөгжөөн цэнгээн зэрэг нь эрүүл мэндэд ч сайн тул түүнийг дэмжүүштэй. Гэхдээ хэмжээ нь хэтэрвэл хүмүүн чанарыг бүхэлд нь эвдлэхүйн осол бий. "Сайн тоглож, сайн суралц" гэсэн сургааль үг үе үе сонсогддог бөгөөд дандаа тоглоод огтхон ч хичээл ном хийхгүй бол хүн улам бүр дэмий болдог.

Жаргал цэнгэлд хөл алдах шиг залуу хүнд хортой зүйл үгүй юм. Залуу хүний шилдэг чанар сүйтгэгдэж, жирийн баяр хөөр уйтгартай санагдаж, өндөр дээд оюуны баясгаланг нэхэх сэтгэлээ алдаж орхидог юм. Тэгээд ажил хөдөлмөр болон үүргээ гүйцэтгэх тал дээр эсрэг сэтгэл, дургүйлхэн муучлахаас өөр зүйлийг сэрж санахгүй болчихдог гэмтэй.

Зугаа цэнгэлд живэх дуртай, завхай зайдан хүн амин чадлаа үргүй дэмий зарж, жинхэнэ аз жаргалын эх ундаргаа хагсааж хатаадаг юм. Хүмүүст энэ хорвоогийн алив сайхныг хэчнээн магтан дууллаа ч, эцсийн дүнд тэр нь хүний араншин хийгээд оюун ухааны эрүүл саруул хөгжилд хүрч очихгүй. Цэл залуу насаа дэмий балай өнгөрөөж, үнэтэй чухал цагаа үргүй зарсан хүний дүр төрх нь дээгүүр толгойт хөвүүн, бохирдсон охин, худалч хүүг харахаас илүү зэвүүн байдаг.

Францын хувьсгалыг удирдсан баатарлаг улс төрч Мирабо хүртэл өөрөө өөрийнхөө тухай ийн өгүүлсэн байдаг юм.

"Залуу цагийн ужид завхай амьдрал, үлдсэн амьдралаас минь цорын ганц зүйлийг нь булаачихсан юм. Миний амин хүчний ихэнх хэсэг залуу насанд минь үргүй зарагдсан юм даа" гэжээ. Өнөөдөр хэн нэгэнд буруу мууг хийвэл маргааш тэрхүү тавилан өөрт нь эргээд ирдэг. Үүн лугаа адилаар, бага залуу насандаа хэрэг үйлдвэл, нас бие гүйцээд заавал үйл лайг нь хүлээдэг юм. Бэкон "залуу цагийн учир утгагүй хийгээд хэтрүүлсэн явдал нас ахиад ирэхээр нэвт шувт хүрээд ирдэг эд юм" гэжээ.

Энэ үг бие махбодийн талаас гадна оюун санааны тал дээр ч хамаатай байна. Италийн нэгэн яруу найрагч найздаа бичсэн захидалдаа ийн өгүүлжээ. "Ний нуугүй хэлэхэд, би амьдарч явахын тулд хүндхэн золиосыг үүрч байгаа юм. Хүний амьдрал өөрийн бодсон ёсоор болно энэ тэр гэж бодох нь буруу ажээ. Хамгийн эхний үед миний амьдрал нэхээс төлөөсгүй мэт санагдаж байвч, тун удалгүй тэр хэсгийг минь "нэхэмжилсэн бичиг" яг л хүрээд ирдэг юм байна" гэжээ.

Залуу цагийн буруу зөрүү явдлын хамгийн том гай бол эрүүл мэндээ сүйтгэх явдлаас илүү бүр хүн чанараа сэв суулгахад байдаг. Хөнгөнцөр явдалд унасан залуу хүн, яс нь хүртэл үжирч өмхийрсөн том хүн болдог. Нэгэнт л тийм болвол хэчнээн мөрөөдөөд ч өндөр дээд цэвэр хүнд барагтай л бол буцаж очдоггүй. Хэрвээ ямар нэгэн эмчлэх арга байдаг гэвэл, тэр нь залуу хүнд хариуцлагын сэтгэлийг ургуулж, утга чанартай ажилд чин сэтгэлээсээ шамдах явдал л юм даа.

#### **4. Авьяасыг чинээнд нь тултал амьдруулах тухайд**

Хүмүүнийг хүн болгох нь амирлал бус хичээл зүтгэл, таа тааламж бус зовлон бэрхшээл юм. Мэдээж хэрэг хүний амьдралын зам зуур хөндөлсөх зовлон бэрхшээлийг амжилтад нэгэнт тодорхой болсон арга ухааныг олж байж анх удаа арилгаж чаддаг. Гэсэн ч алдаа нь бидний хамгийн сайн туршлага болдогчлон, иймэрхүү бэрхшээл ч бидэнд хамгийн сайн багш болдог юм. "Би, амьдрал нь шулуун дардан байж, өнгөлөг амьдралыг туулж буй хүнээс илүү, алдаа гаргалаа ч түүндээ дарагдаж няцалгүй амьдарч яваа хүнд талархалтай байдаг" гэж улс төрч Чарльз Фокс өгүүлжээ. Цааш нь: "Нэгэн залуу хэтэрхий уран ярих авьяасаараа бага сага нэрд гарчээ гэсэн яриаг сонсоход, мэдээж хэрэг аа тийм үү гэж бодогдоно. Гэвч тэр хэвээрээ өөдлөх дэвжихийг зоривол сайн авч, аягүй бол хамгийн анхны амжилтаараа хөл толгойгоо алдаж орхиж ч магадгүй байдаг. Миний бие бүр эхэндээ бүдэрч унасан ч, цааш нь хичээж зүтгэлээ үргэлжлүүлсээр байх залуутай учрахсан. Ялагдсан ч хамаагүй. Тиймэрхүү залуучууд л бүр эхнээсээ шулуун дардан алхаж яваа хүнээс илүү их амжилт гаргах ёстой доо" гэжээ.

Бид амжилтаас бус, харин алдаанаас л ихээхэн ухаанд суралцдаг. "Юу хийх ёстой вэ" гэдгээ анзаарч мэдэх нь "юуг хийж болохгүй вэ?" гэдгийг тангараглах цаг мөн. Алдаа гаргахгүйгээр хэчнээн цаг хугацаа өнгөрлөө ч түүнийг анзаарч анхаарах хэрэг гардаггүй.

Тухайлбал эрт цагаас нааш олон хүн, усны төвшнөөс 10 метр гаруй өндөрт хийн шахуургаар ус хутгаж авах гэж туршаад, алдаж байлаа. Гэлээ ч энэхүү алдаанаас санаа авч хийн даралтын хуулийг нээж, Галилей, Торичейр, Бойл зэрэг эрдэмтэд шинэлэг ололт нээсэн билээ. Бас эмч Жон Хантер "эмч хүн өөрийн амжилтын жишээ бус алдааны жишээг нийтэд дэлгэх зүрх зориг байхгүй бол анагаахын шинжлэх ухаан урагшаа явахгүй" гэж өгүүлсэн байдаг.

Зохион бүтээгч Уатт ч "техник технологийн салбарт хамгийн чухал зүйл бол дампуурлын түүх юм. Би болхи мулгуу алдааны жишээнүүдийг цуглуулсан номыг хүсч байна" гэж өгүүлжээ. Химич Х. Дейбир нэгэн туршилт эв дүй сайтай урагшилж буйг хараад "би хар ажилд эв дүйтэй биш дээ баярлаж байна. Миний чухал нээлт бүгдээрээ алдаа нь сануулга байснаас гарсан" гэжээ. Бас алдартай биологич эрдэмтэн ийн бичиж үлдээсэн байдаг.

"Судалгааны ажлын явцад, давж гарч чадахгүй хориг саадтай туллаа гэвэл ямар нэг нээлт хийхийн тун өмнөхөн тулж очсоны тэмдэг юм" гэжээ.

Агуу их үзэл санаа, нээлт, бүтээл нь ийм зовлон дунд хүрээлэгдэж, гаслан дунд тунгаагдаж, бэрхшээлийг давж байж, алгуур аажмаар бүтэж ирсэн билээ.

Бетховен Лошшини-г үнэлж "хөгжмийн авьяастай боловч, хүүхэд байхдаа эрхэлж өссөн болохоор авьяас нь эвдэрчээ" гэж өгүүлсэн байдаг. Анхаарууштай нь хэрэгцээ шаардлагаас илүү магтаал, хэтэрхий сайхан үнэлгээнд толгой эргэчихдэг явдал бий. Үүнтэй харьцуулахад хатуу гашуун үнэлгээ нь харин тэр хүндээ тустай байдаг. Менделсон "Элия" оратори-гоо анх тоглож буйтай холбогдуулан, найз шүүмжлэгчдээ инээмсэглэн байж хэлэхдээ "Бодсон санаснаараа алдаа дутагдлыг хайж, хүчтэйхэн сайн шүүмжлээд өгөөч. Аль нь санаанд чинь аятайхан болсныг сонсмооргүй байна. Аль таалагдахгүй байгаага л зааж өгөхийг хүсч байна" гэжээ.

### **"Ялагдлаа захирч" чадсанаар хүн ирлэгддэг**

"Ялагдал нь яах аргагүй жанжныг ялалтад ирлэж хурцлаж өгдөг" гэлцдэг бөгөөд энэ бол үнэний хувьтай үг юм. Тухайлбал Вашингтон америкийн тусгаар тогтнолын дайнд ерөнхий командлагч байж, хамгийн сүүлд ялалт байгуулсан ч тулаанд ялагдсан нь олон байсан. Эртний Ромчууд олон удаагийн байлдаанд ялсан ч эхлээд заавал ч үгүй гэж хэлэхээр шахам ялагдал хүлээдэг байв. Францын жанжин Мор ч хамтран зүтгэгчдээсээ ямагт "чи хэнгэрэгтэй адилхан амьтан" гэсэн хүйтэн үг сонсдог байжээ. Хэнгэрэг бол нүдэхээс бусад цагт дуу гаргадаггүй бөгөөд тэрээр ч дайсандаа цохиулж ялагдсан тухай ярианаас өөр юм дуулгаагүй гэх аж.

Нэрт жанжин Вейлингтон ч бас үнэн хэрэгтээ хүнд бэрх бэрхшээл зовлонтой тулалдаж байж цэргийн хүний чадвараа төгөлдөржүүлсэн билээ. Том бэрхшээл зовлон түүний эрс шийдлийг чангатгаж, шилдэг зан чанарыг төлөвшүүлсэн юм.

Зовлон гачаал бэрх хэдий ч хамгийн сайн багш мөн. Бэрх нөхцөл дунд орхигдох, хатуу хүтүүг амсах нь зөвхөн бодох төдийд ч бие арзасхийлгэдэг. Гэвч үнэн хэрэг дээрээ хүнд бэрх нөхцөлтэй нүүр тулсан тохиолдолд эрэлхэг зоригтой тэмцэхээс өөр аргагүй. Түүгээр үл барам бэрх нөхцөл дунд л бидний хүч чадал бадардаг.

"Зовлонтой тулах нь бурхан тэнгэрт авирах шат юм" гэсэн эртний зүйр үг байдаг бөгөөд Германы зохиолч Рихтер: "Хүн гачаал зовлонд зовоод ирэхээрээ сэтгэл дундуур байгаага яншиж эхлэдэг. Гэвч зовлон гачаал гэж чухам юу юм бэ? Залуу охин ээмэг зүүхийн тулд өвдөхийг тэвчин байж чихээ цоолдог, зовлон гачаал тэрхүү өвдөхтэй адилхан юм. Тэр өвдөлт байхгүйгээр гоёмсог эрдэний чулуу зүүж чадахгүй биз дээ" гэжээ.

Сөрөг нөхцөл орчин бол ядуу зүдүүг ялж, саад тотгорыг даван туулах зоригийг олгож байдаг. Амжилт хийгээд мандал бадрал нь харин бүүр хүнд аюултай урхи болох нь олонтоо. Хорвоогийн хүйтэн салхинд хүрмээ үлээлгэхдээ хийсгэн алдаж орхидог хүн бол сэтгэл зүрх ядруухан хүний ажил юм. Зарим хүн нарны дулаанд гадуур хувцсаа тайлж хаяад, тэр чигээрээ хаана ч юм орхин мартдаг билээ. Эдгээрээс харахад хэцүү бэрх орчин нөхцөл дунд тэсвэрлэхээс, аз жаргал дунд тэсвэрлэх нь биеэ барих сэтгэлийг илүү хүчтэй шаарддаг юм. Амжилт олсны ачаар агуу их санаа сэтгэлийг сэгсрэн босгож эхлэдэг хүн байдаг авч, олон хүн тийм биш юм. Явцуухан сэтгэлтэй хүн эд баялгийг олохын хэрээр бүр өөдгүй ихэмсэг бардам болдог. Иймэрхүүгээр, мандал бадрал нь ихэнхдээ биеэ тоосон, бардам сагсуу болох төдийд л хэрэг болохоос хэтрэхгүй.

Эрс шийдлээ бат ноттой болгож, цөхрөшгүй зоригийг шүүрч босгоход таагүй орчин нөхцөл дунд биеэ байлгах нь илүү ашигтай бус уу. Улс төрийн онолч Бак ийн өгүүлсэн байдаг. "Зовлон бэрхтэй тулалдаж байж, хүн зоригоо дээшлүүлж, авьяасаа төгөлдөржүүлдэг. Бидний дайсан бол угтаа бидний хамсаатан нөхөр мөн" гэжээ.

Зовлон зүдүүртэй тулах хэрэгцээ байхгүй бол хүний амьдрал улам илүү таатай амар болох билээ. Гэвч юу ч хийхгүй дэмий сууж амьдралаа өнгөрөөж байгаа хүнд өчүүхэн ч үнэ цэн үгүй юм. Хэцүү бэрх сорилго л хүн чанарыг өнгөлөн тодруулж, өөртөө туслахын ухаан хийгээд учир утгатайгаар өөрийгөө боловсруулахуйн боломжийг олгож өгдөг юм даа.

## **"Хэрвээ" гэдэг үг авъяасгүйн яншилтаас өөр зүйл биш**

Хүний амьдрал гэгч тулалдаан бидэнд бол ширүүн дайны үргэлжлэл юм. Гэвч хатуу оролдлого зүтгэлгүй олсон ялалт зэрэг нь алдар ч биш, юу ч биш билээ. Эрхшээл зовлон байхгүй газар амжилт байхгүй, зорилго байхгүй бол ямар ч зүйлийг олохгүй.

Хүний амьдрал гэгч нь юуны өмнө оролдож үзэхэд том үр дүн олдог эд юм. Нэгэн алхам гишгэж үзэхээс нааш өөрөө юу чадах вэ? гэдгээ мэддэггүй. Гэтэл ихэнх хүмүүс ямар нэг зүйлийг хийхээс өөр аргагүй болсон нөхцөлд орох хүртлээ юуг ч хийе гэдэггүй.

Сэтгэлийн хүчээр дутсан залуу "үүнийг хийчихвэл сайхнаа", "тэр бололцоотой бол сайхан аа" гэхчилэн дандаа шүүрс алдаж суудаг. Гэвч зөвхөн хүсэл төдийгөөр ямар ч зүйл боловсорч гүйцдэггүй. Тэрхүү хүсэл шаардлагад тодорхой нарийн зорилго тавьж, түүндээ чиглэсэн хичээл зүтгэл гаргах ёстой юм. Мянгантаа шохоорхохоос илүү зөвхөн ганц удаа ч бол зориг зүрх гарган туршаад үзэх нь хавьгүй үнэ цэнтэй. "Хэрвээ" гэдэг үг хүч чадалгүйн хийгээд цөхрөнгүйн яншилтаас хэтрэхгүй. Тэр нь бололцоо хэмээх тариан талбайн эргэн тойронд хашаа хайс хатгаад, арайхийн бий болсон хийе гэсэн сэтгэлийг тусгаарлаж орхидог юм. Хуулийн зүтгэлтэн Линдхауст ийн өгүүлжээ. "Зовлон бэрхшээл нь даван туулахын тулд байдаг ажгуу. Тиймээс шуудхан түүнтэй байлд. Оролдож байх хооронд түүнийг арилгах сайн аргыг ч олж харах ёстой. Хичээл зүтгэлийг дахин давтаж байвал хүч болон зүрх зориг оргилоод ирнэ. Тэгсэн цагт оюун санаа болон зан чанар хэзээ ч юм төгс. төгөлдөр болтлоо өнгөлөгдөж хурц болж, хиргүй тунгалаг эрсхэн байдал биед нь сууж, өөрийнхөө санаагаар үйлдэл хийж чадах болох буй за. Харин, бэрхшээл зовлонтой лавдуухан тулалдаж байсан туршлага байхгүй нөхөд бол үүнийг бүрэн ухаарч чадахгүй гэж бодох юм, гэвч..." гэжээ. Бэрхшээлийг эзэмдэх явцад бид суралцаж явдаг. Нэгэн бэрхшээл зовлон арилгавал, тэр нь дараагийн шинэ бэрхшээлтэй халз үзэхийн тусламж болдог.

Бэрхшээл зовлонтой тэмцэхгүйгээр амьдрана гэдэг бол зөвхөн хүний амьдрал төгсч, боловсорч гэгээрэхүйн хэрэгцээ нь хүртэл байхгүй болсон үед л боломжтой юм. Тэр хүртэл бидний хичээл сурлага болон зүтгэл оролдлого хязгааргүй үргэлжилдэг юм.

Математикийн анхан шатыг ойлгож чадалгүй, гачигдал зовлон тоочиж байсан оюутанд соён гэгээрүүлэгч Даламбер зөв зүйтэй сургааль өгсөн байдаг.

"Юутай ч хичээл оролдлогоо үргэлжлүүлэгтүн! Тэгвэл хэзээ нэгэн цагт заавал өөртөө итгэх итгэл болон хүч чадал оргилоод ирэх бий вий" гэжээ.

## **5. Авъяас нь алгуур аажим буй болсон өвөг дээдсээсээ сурах тухайд**

Ертөнцийг донсолгож, нийгэмд тэргүүлэх байр суурь дээр гоц авъяастай хүмүүс бус, зорилгодоо хандаж цөхрөлтгүй хичээл оролдлого гаргасан хүн л очдог юм.

Агуу их тэнгэрлэг авъяас гэдэг ихэнх тохиолдолд эрт боловсорсон байдаг. Гэвч бага балчир үедээ хэчнээн ухаантай байлаа ч тэр нь нас биед хүрсэн хойно нь хүрч очих цэгийг зааж байгаа хэрэг биш юм. Тэр байтугай гайхмаар шахам ухаантай сэргэлэн байсан хүүхдүүд, онц сурлагатан, ямар нэгэн зүйлээр шагнагдаж байсан хүүхдүүд, тэд өнөөдөр ямархуу байдалтай байгаа болоо. Сургууль төгссөний дараах үеийнх нь амьдралыг мөшгин шинжилж үзвэл, сурлагын амжилт ч муу, тэнэг мануухай шиг байсан сурагчид нь харин тэргүүний сурагчдаа гүйцэж түрүүлсэн жишээ олон бий. Ухаантай сурагч сургууль дээрээ өндөр үнэлэгддэг. Харин ойлгоц нь бусдаас илүү хурдан, авъяастай учир олж авсан алдар хүнд нь заавал ч үгүй бодит амьдрал дээр хэрэг болно гэдгээр хязгаарлаж болохгүй. Жинхэнэ алдар нэрд хүрдэг нь, харин бүр төлөв даруу зангаар нэгэн үзүүрт хичээл зүтгэл гаргадаг сурагчид юм. Төрөлхийн билэг авъяас нь буурч байгаа ч бүхий л хүч чадлаа шавхан хичээдэг хүн л хүмүүст сайшагдаж, хүмүүсийг зоригжуулж байдаг ёстой билээ.

### ***Тааруухан сурагчдын жишээний хэлхээс (Ньютоноос Наполеоныг хүртэл)***

Бага балчир насандаа тааруухан сурагч байсан ч цэцэн ухаантай хүн болж өссөн хүмүүс олон бий. Зураач Петро де Голдуни үнэхээр дүйнгэдүү хүүхэд байж, хавь ойрынхон нь "илжигэн толгойт" гэж хочилдог байжээ. Яруу найрагч Томос Гиедер ч "МангууТоми" гэж дуудагдаж байсан бахичээнгүй зүтгэл гаргасны үр дүнд эцэст нь ялж гайхамшигтай алдар нэрийг олсон билээ.

Сургуульд байхдаа Ньютон сурлагын амжилтаараа хойноосоо хоёрт байжээ. Нэг удаа тэрээр өөрөөсөө илүү ой сайтай сурагчид үл тоомсорлогдон гологджээ, тэгэхлээр нь зориг гарган тэр сурагчтай маргалдаад, юу ч үгүй бут цохигдсон ажээ. Тэр үеэс Ньютон хэрүүл төдийгүй сурлагаараа ч тэр нөхрийг

ялахаар эрс шийдэж, асар ихээр махран хичээллэж эхлэсэн билээ. Удалгүй ангидаа толгой цохих хэмжээнд хүрсэн гэдэг.

Санваартнуудын дунд ч бага байхдаа лоймол байсан хүүхэд цөөнгүй. Тухайлбал Айзак Баро дунд сургуульд байхдаа зартай нөхөр байжээ. Тэрээр дээрэнгүй, юуны түрүүнд хэрэлддэг, залхуу хойрго байв. Тэр эх эцгийнхээ хувьд гаслангийн үр байсан агаад эцэг нь "бурхан тэнгэр миний хүүхдүүд дотроос хэн нэгнийг нь эгүүлэн татаж хайрлавал хамгийн үзэшгүй Айзак-ийг авч үзээрэй дээ" гэж хүртэл гуйдаг байв гэнэ. Жүжгийн зохиолч болон улс төрийн салбарт гоц авъяасын алдарт санаснаараа хүрсэн Шеридан бага байхдаа эгэл жирийн чадвараар ч маруухан нэгэн байжээ. Ээж нь түүнийг гэрийн багшид танилцуулахдаа "гарт баригддаггүй гайхал юм шүү" гэж хэрэгболгон зориуддагалдуулан хэлдэг байсан гэдэг. Яруу найрагч Вольтер Скотт ч сурлагаар хоосон, дэмий хэрүүлд дуртай хүүхэд байжээ. Эдинбар-ын их сургуульд элсэн орсон хойно ч түүнийг "тэр одоохондоо тааруухан оюутан байгаа, цаашдаа ч нэг их өөрчлөгдөхгүй болов уу" гэж профессор нь батлан өгүүлдэг байв. Цэргийн хүн бөгөөд улс төрч Роберт Глайб ч залуу байхдаа бүтэлгүй нэгэн байв. Тэр зөвхөн муу муухайг хийх болон дэггүйтэх үедээ л асар их эрчимлэг эрч хүчээ гаргадаг байжээ. Түүнийг усан онгоцонд далайчнаар явна гэж шийдсэн үед нь ашгүй нэг далд орлоо гэж гэрийнхэн нь бөөн баяр хөөр болж байжээ. Харин Глайб тийн явнаар өөрийнхөө амьдрах ёстой зүг чигээ гаргаж, удалгүй энэтхэгт буй Английн цэргийн сүр хүчийг өргөжүүлэн тэлэхэд мартагдашгүй амжилт гаргасан билээ.

Наполеон, Вейлингтон нар ч мангардуу хөвгүүд байж, сургуульдаа үл анзаарагдм сурагчид байсан гэдэг. Наполеоны хүүхэд насыг мэддэг нэгэн гүнгийн авхай "зөвхөн бие нь чийрэг байсан юм, түүнээс өөрөөр бусад сурагчдаас өчүүхэн ч давуутай юм байгаагүй л юм даа" гэжээ.

### *Сургуулийн сурлагын амжилтаар хэмжиж болдоггүй гоц авъяасын тухай*

АНУ-ын ерөнхий командлагч болсон Ю.Гландыг багад нь ээж нь хүртэл "Юрселс (нэмэр тусгүйн) Гланд гэж дууддаг байжээ. Тийм нэгэн, болхи хүү байжээ.

Бас Ли генералын баруун гар болж хамгийн их итгэгдэж байсан дэд дарга Стонфор Жаксон залуудаа эгээгүй усан тэнэгээрээ гайхагдаж явжээ. Вестфойнтын хуурай замын офицерын сургуульд орсон ч толгой нь бахь байдгаараа хоцорч байсан хэдий ч тэр хэрээрээ хүн хүнээс илүү шаргуу зүтгэлтэйгээр хичээлээ хийдэг байв. Гэрийн даалгавар хийхдээ хагаслаж хугаслаж оромдолгүй бүрэн төгс эзэмшлээ барьж авдаг байлаа. Бас мэдээгүй ч мэдсэн юм шиг царайг огт үзүүлж байгаагүй гэдэг. Нэгэн найз нь тэр үеийн Жаксоны тухай: "Тэр өдрийн цээжлэх асуудлын талаар багшаас асуугдах үед, тэрээр дандаа ...энэ асуудалд харахан гар хүргэж чадсангүй, өчигдрийн болон уржигдрын даалгаврыг эзэмшиж чаддаг болтлоо хичээнгүйлэн үзэж байсан болохоороо... гэж хариулдаг байсан" гэжээ.

Ийнхүү Жаксон 70 хүнтэй анги дотроо 17-р байранд орж төгсчээ. Элсэж орох үеийн сурлагын амжилт нь хамгийн сүүлийн байранд байсан байх тул, тэр 53 сурагчийг гүйцэж түрүүлжээ гэсэн үг юм. "Сургууль маань 4 жил бус 8 жил байсан бол, мань эр яриангүй тэргүүлж төгсөх байсан даа" гэж тэр үеийн ангийнхан нь ам булаалдан өгүүлж байжээ.

Буяны үйлстэн Жон Хаворд тааруухан сурагчийн сонгодог төлөөлөгч агаад сургуульд сурч байсан 7 жилийн хугацаанд хичээл шиг хичээл хийж байсан нь нэг ч үгүй. Зохион бүтээгч Стифсон ч залуудаа шилдэг давуу тал нь гэвэл бөөрөнцөг шидэх, бөх, дээр нь Инженерийн ажилд шургуу оролдогоос өөр зүйлгүй байв.

Нэрт химич Дейбер ч бусад хүүхдүүдтэй харьцуулахад тийм их Ухаантай гэхээргүй байлаа. "Намайг анги дааж байхад авъяас чадварын тал дээр тийм их шилдэг давуу гэж бодогдохооргүй байсан" гэж багш нь дурссан байдаг бөгөөд Дейбар ч хожим "сургуульд байхдаа ханатлаа залхуурч, тоглож нааддаг байсан тул өөртөө жаргалтай байдаг байсан" гэж өгүүлсэн байдаг.

Зохион бүтээгч Уатт-ын тухайд ч эрт гэгээрсэн юм гэсэн яриа үнэмшилтэй нь аргагүй ам дамжиж буй хэдий ч үнэн хэрэг дээрээ мань хүн сурлагаар гавихгүй эр байжээ. Харин тэр үнэхээрийн тэвчээр хэмээх шилдэг сайн чанартай байлаа. Тэрхүү шургуу хүчтэй тэвчээр болон аажим аажмаар төлжиж буй зохион бүтээх авъяасынхаа ачаар удалгүй уурын хөдөлгүүрт механизмыг бий болгон бүтээсэн билээ.

### *Нухацтай хичээл зүтгэл эцэст нь ялдаг*

"Нэгэн хөвгүүн нөгөөгөөсөө ялгарах ялгаа бол авъяас гэхээс илүү идэвхийлэх хүчний сайн саар хоёроор шийдэгдэж байдаг" гэж Арнольд онцлон хэлсэн байдаг бөгөөд энэ нь том хүнд ч бас хамаарна. Шургуу тэвчээр, амьдрах хүч нь эхэндээ заяагдсан мэт байдаг боловч уг хүнд заншил болон биед нь хэвшдэг. Ягуу ягуухан чамбай хичээж зүтгэдэг тааруухан сурагч, залхамтгай онц сурлагатныг гүйцэж түрүүлдэг бус уу. Удаан ч гэсэн найдвартай алхдаг хүн, уралдахад эцэст нь ялдаг.

Сургууль дээрх жагсаалт, жинхэнэ амьдрал дээрх жагсаалт хоёр бүрэн төгс байраа солих жишээ олон байдаг. Оюутан байхдаа үнэхээр алд тасархай байсан хүн, сүүлдээ жирийн хүний амьдралд булагдаж орхидог. Нөгөө талаар, ямар нэг юмыг найдах ч аргагүй байсан маруухан нөхөр цуцалтгүй хичээл зүтгэлийг үргэлжлүүлсний ачаар аажимдаа хүний дээр гарах нь бий. Гайхалтай үзэгдэл юм, гэвч түүний учрыг ухаарах түлхүүр тэр хүний шургуу хичээнгүйн давууд байдаг.

Намайг бага байхад, манай ангид тааруухан сурагчын загвар мэт нэгэн хүү байдаг байв. Багш түүний сурлагын амжилтыг дээшлүүлье гэж хүчээ дайчилсан ч огтхон ч өөрчлөлт гарсангүй. Шийтгэлээ ч, тайтгарууллаа ч, аргадлаа ч ямар ч нэмэргүй. Эцэст нь багш нарын нэг нь түүнийг "хаана ч байхгүй агуу тэнэг" гэж хүртэл дуудсан гэдэг.

Гэтэл нөгөө сулхан амьтан, тархины ажиллагаа нь барагтайхан ч, муйхар гэмээр хатуу зоригийн хүч сууж байжээ. Тэгээд өсч томрохын хэрээр тэрхүү сайн тал нь ягуу ягуухан үндсээ сунгасаар удалгүй тэрээр бизнесийн ертөнцөд хөл тавьж, түүгээр барахгүй ангийнхаа нөхдийн ихэнх хэсгээс хавьгүй шилдэг хүн болж, хорвоод нэрээ гаргасан гэдэг. Түүний дараар тэрээр төрсөн нутгийнхаа хотын захирагч болж гайхамшигтай үйл ажиллагаа явуулсан юм.

Алхахдаа удаан яст мэлхий ч замаа зөв олбол, алдаатай буруу замаар явах өрсөлдөгчөө ялж чадах нь буй. Тиймээс чин сэтгэлээсээ шургуу зүтгэл гаргавал ахиц дэвшил удаан байсан ч сэтгэл өвдөхийн хэрэгцээ байхгүй.

Залуу цагийн сэргэлэн цовоо байдал аягүй бол дутагдалтай тал болон хувирахгүй гэхийн газар үгүй. Юуг ч авхаалжтай сайн ойлгодог хүүхэд, тэр хэрээр юмыг мартагдаа амархан, тэвчээр оролдлого хэмээх чанараа дээшлүүлье гэдэггүй.

Гэтэл угтаа тэвчээр оролдлого хоёр л зан авирын хамгийн чухал эд эс билээ. Чадал сайнгүй хүүхэд харин тэрхүү сайхан суртахууныг бага сага ч болов биедээ хэвшүүлж байдаг. "Өнөө цагийн намайг буй болгосон нь миний өөрийн минь онцгой, цөхрөлтгүй хүч билээ" гэж Дейбнер өгүүлсэн байдаг агаад, энэхүү үг энэ үнэнийг баталж байгаа бус уу.

## Гайхамшигтай учрал

*Хүмүүний амьдралын багш, нөхөр, ширээний ном*

### *1. Хүний амьдралын бэлгэ тэмдэг болох "юм хэлдэггүй тоо ширхэггүй загвар"-ын тухай*

Загвар гэдэг бол үг хэлгүйгээр биднийг сурган удирдах нэртэй багш юм. Зүйр цэцэн үгс, сургааль үг ч лавтайяа бидний урагшлах ёстой замыг зааж өгдөг билээ. Гэлээ ч үнэн хэрэг дээр хүнийг хөтөлдөг зүйл бол юм хэлдэггүй, тоо ширхэггүй загварууд, өөрөөр хэлбэл амьдралыг эргэн тойрон хүрээлэх бодит байдлын жишээ юм. Сайн сургааль үгэнд тэр хэрийн чухал зүйл байх авч, сайн загвараас шалтгаалахгүйгээр эцсийн дүнд төдий л үр дүн үгүй. Хүмүүсийн дотор "Миний хэлснээр хий, миний хийх ажлыг дуурайх гээд хэрэггүй" гэхчилэн ярих нь олонтоо байдаг ч, жинхэнэ бодит амьдралын туршлага дээр үг ярианаас үйл хөдлөл нь илүү чухалчлагддаг юм. Хүн хэн ч байлаа, их ч бай бага ч бай, чихнээсээ илүү нүдээр дамжсаныгаа сайтар ухааран ойлгож байдаг. Бодитоор харсан зүйл, тэр нь хэчнээн өчүүхэн бага зүйл байсан ч зөвхөн уншиж, сонссон зүйлээс хавьгүй гүнзгий сэтгэгдэл төрүүлдэг.

Ялангуяа бага залуу насанд энэ шинж хүчтэй байх бөгөөд "нүд бол мэдлэгийг эзэмшихийн үүд хаалга мөн" гэхэд хэлсдэггүй буй за. Хүүхэд үзсэн харсан зүйлээ юуг ч байсан ухамсарлалгүйгээр дуурайдаг юм. Хорхой шавьжны бие идсэн өвснийхөө өнгөтэй адилхан байдагчлан, хүүхэд нэг л мэдэхэд хавь орчныхоо хүмүүстэй адил төстэй болдог ажгуу.

Гэрийн хүмүүжил нэн чухал гэж хэлдэгийн учир үүнд байна. Сургуулийн сурган хүмүүжил хэчнээн ашиг тустай ч гэр бүлд илэрхийлэгдэж буй жишээ загвар нь хүүхдийн зан араншингийн төлөвшилд хавьгүй их нөлөө үзүүлдэг. Гэр бүл бол нийгмийн талст бөгөөд иргэнлэгчанарын цөмийг бүрдүүлж байдаг. Бидний нийтлэг хувийн амьдралыг эзэмдэж байдаг заншил, сүсэг бишрэл, үзэл баримтлал нь цэвэр ч зүйл байсан, бохир ч зүйл байсан гэр бүлийн дотор л өсч төлжиж байдаг. Төр улс хүүхдийн өрөөн дотор төрж мэндэлдэг. Онол бодролын томоохон хэсэг гэр бүл дотор өсч бойждог. Бас хамгийн өндөр дээд хайр ч айл бүрийн тулганд төрдөг юм шүү.

"Нийгмийн дотор бидний харьяалагдаж буй хамгийн бага нэгж, өөрөөр хэлбэл гэр бүлийг хайрлах явдал нь нийгмийг бүхэлд нь хайрлах хамгийн анхны алхам юм" гэж улс төрч Бак өгүүлжээ. Шийдмэг сэтгэл жижигхэн гэр бүлийн хайраас эхэлж улмаар өргөжин, удалгүй дэлхийг бүхэлд нь бүрхэн нөмөрдөг билээ.

### *Сэтгэлд амьдарсаар байх залуу цагийн сургааль*

Эцэг эхийн араншин нь үйлдлээр дамжиж хүүхдийн зан авирт тусдаг билээ. Өдөр бүр илэрч байдаг эцэг эхийн хайр энхрийлэл, сахилга бат, хичээл зүтгэл, өөрийгөө эзэмдэх сэтгэл зэрэг нь чихээрээ сурсан мэдлэг мартагдаж арилсан хойно ч хүүхдийн сэтгэл зүрхэнд амьдарч, түүний үйлдлийг шийдэж өгч байдаг юм.

Эцэг эхийн үггүй үйл хөдөлгөөн, харц хүртэл заримдаа хүүхдийн зан араншинд хэзээ ч мартагдахааргүй сэтгэгдлийг тарьж суулгадаг билээ. Сайн эцэг эхийн амьдралын замналыг санаж, муу уруу татлагыг тэвчин тасалсан хүн тиймгүйгээсээ их байх учиртай. Тэд нар лавтай ичгүүргүй үйлдэлд автагдан, буруу муухай бодолд хөтлөгдвөл, эцэг эхийнхээ үзэсгэлэнтэй сайхан дурсамж юуг хиртүүлэх болно гэж өөртөө тангарагласан болов уу.

Буяны үйлстэн Бакстон хэргэм зэрэгт хүрсэн хойноо өөрийнхөө ээжид хаяглаж явуулсан захидалдаа: "Хүүхэд байхад ээжээсээ сурсан зөв сэтгэл хийгээд ёс суртахуунлиг байдал хэмээх сайхан сургамжийг одоо ч гэсэн огтхон ч мартдаггүй юм. Ялангуяа бусдын тулд ямар нэгэн зүйл

хийж өгье хэмээх үед ээжийнхээ бахархал болсон сайхан сэтгэлийг хүчтэй мэдрэхгүй байж чаддаггүй билээ" гэжээ.

Бакстон бас, өөрт нь ач тус хүргэсэн агнуурын газрын манаачид ч талархлын сэтгэлээ илэрхийлэхээ мартаагүй ажээ. Залуу байхдаа Бакстон тэр эртэй ан хийж, морь унан зугаалдаг байжээ. Тэр эр бичиг үсэгт тайлагдаагүй байсан ч төрөлхийн хар ухаанаар баян хүн байсан. Бакстон хожим ингэж өгуулсэн байдаг.

"Түүний бусдаас давуу чанар бол зөв сэтгэл, алдар хүндлэлийг амьдралынхаа итгэл болгож байсан явдал юм. Миний ээж эзгүй үед ч, ээжид мэдэгдэхэд ч эвгүй үг хийгээд үйлийг ердөө ч гаргадаггүй байсан. Хэзээ ямагт өндөр дээд хиргүй тунгалагийн жишээ загвар мэт байж, бидний залуучуудын сэтгэлд цэвэр ариун, эрхэмсэг оюун санааг цутгаж өгсөн билээ. Миний хувьд тэрээр амьдралын минь хамгийн анхны, бас хамгийн сайн багш байсан" гэжээ.

Дээр өгүүлсэнчлэн хүмүүний үг яриа, үйл хэрэг эцэстээ ямар нэгэн хэлбэрээр бусад хүнд шингэж байдаг. Тэр бол цохиж арилгахад бэрх хөдөлшгүй баримт мөн. Ямар ч хүн байсан бидний амьдралд их ч бай, бага ч бай жишээ нөлөөгөө үзүүлсээр нэг л мэдэхэд нөлөөлчихсөн байдаг.

Гайхалтай үг яриа, үйл ажил, үгс нь эцсийн дүнд үр дүнгүй зүйл мэт байлаа ч хэзээд хүний сэтгэл зүрхэнд амьдарсаар байдаг. Муу муухай үйл ажил, үгс ч мөн адил юм. Шальдар бульдархан хүнд хүртэл тэрхүү үг яриа, үйл ажил нь сайн загвар, муу загварын аль нэгнээр тусаж байдаг. Хүний оюун санаа арилж үгүй болдоггүй. Тэр бидэнтэй хамт амьдарч, бидэнтэй хамт алхаж байдаг. Улс төрч Дейзлейр хамтран зүтгэгч Ричард Гобден нас нөхцөнд эмгэнэн парламентын доод танхимд хэлсэн үгэндээ:

"Гобден талийгаач болсон авч одоо ч гэсэн парламентын гишүүдийн нэгэн байсаар байна. Парламент тарах, сонгогч түмний адайрлал, бас цаг хугацааны явцтай хамаагүйгээр эрхэм нөхөр маань бидний сэтгэлд үүрд мөнх амьдарсаар байх бизээ" гэжээ.

Дейзлейрийн үгэнд тодорхой буйчлан хүний амь нас үхлээр огтхон ч тасардаггүй. Энэ хорвоод ганцаархнаа амьдарч буй хүн үгүй юм. Нийгэм дотор хүн заавал хэлхэлдсэн барилдлагаат харилцаанд байж, хүн бүрийн үйлдлийн сайн муу нь одоо үе, ирээдүйн нийгмийн бүхий л аз жаргал мандал бадралыг савлагаанд оруулж байдаг.

Одоо үеийн үндэс өнгөрсөн үеийн дотор байж, өвөг дээдсийн амьдрал хийгээд загвар бидэнд эдүгээ ч гэсэн асар их нөлөө үзүүлж байдаг. Түүний зэрэгцээ бидний өдөр тутмын үйлдэл ч үр ач нарын зан араншин төлөвшихөд зориулагдаж байдаг юм. Орчин цагт амьдарч буй хүн болбоос өмнөх олон үеийн соёлоор боловсорсон үр жимсээс өөр юу ч бишээ, түүний хамт тэрээр нэлээд холын өнгөрсөн цаг хийгээд алсын алс ирээдүйтэй үйлдэл, загвар хоёрыг холбох соронзонгийн уургийг хүлээж байдаг билээ.

Хүмүүний үйлдэл бүрэн төгс мөхдөггүй. Тухайлбал бие махбодь манан будан лугаа адил сарнин арилж үгүй боловч сайн муу үйлдэл өөр өөрийнхөө таарч тохирсон үр дүн бий болгож, ирээдүй үед нөлөө эрхшээлээ үзүүлж байдаг билээ. Хүмүүн амьд явж, амьдрахын хамгийн том үүрэг хариуцлага болоод тарих аюул нь үнэн хэрэгтээ энэхүү нэн чухал, хөдөлшгүй баримтаас урган гардаг билээ.

### ***Жинхэнэ уран үг үггүй туршилт дотор байдаг***

Энэ хүртэл өгүүлсэнчлэн, бидний харсан сонссон үйлдэл хийгээд үг ярианаас гадна бидний өөрийн үг яриа үйл хөдлөл ч нөлөөлөх томоохон хүчийг авч явдаг. Тэр хүч нь өөрийн ирээдүй төдийгүй нийгмийг бүхэлд нь зүг чигийг бүхэлд нь савлуулахгүй гэхийн газаргүй юм. Ямар ч хүн энгийн цагаан мөртлөө чухал ховор сургамжийг бусдаас авч байдаг билээ. Ингэж үзвэл ямар ч нөхцөл хүмүүнд заавал учир утгатай ажээ. Яагаад гэвэл намхан газар тавьсан лаа, уулын толгой дээр тавьсан лаатай өчүүхэн ч ялгаагүй хавь орчноо гэрэлтүүлж байдаг билээ. Түр зуурын гадаад өнгөн тал бага хэрэг. Хувь муутай нөхцөлд тухайлбал бөглүү буйд газрын овоохой болон их хотын давчуухан гудманд амьдрахаар таарчихвал жинхэнэ хүн л бол тэр дундаа өсч хөгжөөд явж чадна. Хэр хэмжээгээрээ өөрийнхөө булшийг булах төдий өчүүхэн газраас өөр зүйл үгүй ч

тэндээ үнэнхүү хичээнгүйлэн ажиллавал түүнээс хэдэн мянга дахин өргөн уудам газрыг өвлөж авсан хүнээс илүү гайхалтай зорилтыг гүйцэтгэж чадах билээ.

Хүний амьдрал хэмээх хэн ч болов дамжиж туулах ажлын талбараас хичээл зүтгэл, эрдэм ухаан, өндөр суртахуун төрж мэндэлдэг гэвэл, бас үүний эсрэгээр залхуу хойрго, хөнгөн хуудуу явдал, ужид самуун ч бас эндээс төрж мэндлэх нь бий. Алинаар нь явах нь уг хүн сайн явдлын боломжийг хэрхэн ашиглаж буйгаас шалтгаацдаг гэж хэлж болох бизээ.

Гайхамшигтай алхаж байгаа хүний амьдрал, чин шударгуу зан чанар хоёр үр удам, нийгэмдээ хамгийн үнэ цэнтэй өв хөрөнгө болдог билээ. Ийм амьдрал, хүн чанар хоёр нь сайн үйл гэдэг юу болохыг уран цэцэн сургаж, муу үйлийг хурц шүүмжилж байдаг. Энэ бол хүмүүсийн хувьд хамгийн гайхамшигтай баялгийг төрүүлэх эх булаг болдог билээ.

Яруу найрагч Робб, нэгэн удаа ядуу доройгоос гаралтай гэж тохуурхал сонсох үедээ дараах байдлаар ихэмсэг сүрлэгээр тас цохиж хариулсан гэдэг.

"За тиймээ, миний эх эцэг өчүүхэн хүмүүс байсан хэдий ч, хүү намайгаа нүүр улайлгахаар, ичгүүргүй авирлаж байсан удаа лавтайяа нэг ч байгаагүй юм даг. Хүү нь болсон би ч гэсэн таны харж буй байдал төрхтэй яваа хэдий ч эх эцэг хоёрыгоо уйлуулж байсан удаа огтхон ч байхгүй билээ. Энэ хангалттай бус уу" гэжээ.

Бусдыг хөдөлгөө гэсэн үед, энийг тэрийг гэж тушаах төдийгөөр хэрэг бүтэхгүй бизээ. Юуны өмнө, өөрөө урагшилж загвар болгон санаагаа илэрхийлж байхгүй бол болдоггүй. Нэгэн хатагтай өөрийн амжилтын нууцаа ийн өгүүлсэн байдаг. "Хүнээр ямар нэгэн зүйл хийлгэе гэж хүсвэл өөрөө үлгэрлэн, дуурайлгах хэрэгтэй. Амаараа төдий түрүүлэгч ямар ч хэрэг бүтээхгүй" гэжээ.

Зөвхөн үгээр хэлэх нь жинхэнэ уран илэрхийлэл болж чаддаггүй. Гарчигийг нь хэчнээн уянгалуулавч, төлөвлөгөө нь өчүүхэн ч урагшлахгүй, тэгээд чалчихын хананаасаа нэг алхам ч гардаггүй билээ. Үүнийг мэдэж тангараг тавьсан эрхэм хатагтай өөрийн зүгээс үйлдлийг эхлэдэг ажээ. Тэр эмэгтэйг үнэхээр төлөвлөснөө биелүүлэхийг хараад, хавь орчны хүмүүс түүний эрс шийдлээс цохилт авч, туслахаар боссон байна. Гайхамшигтай бүтээл бий болгох нь уран цэцэн үгтэн бус, өндөр дээд онолч бус, харин үйл ажлаараа бусдыг дагуулагч хүн л мөн билээ.

### *Амьдралыг эргүүлсэн ганц ширхэг зураг*

Байр суурь, хэргэм зэрэг хичнээн доогуур байлаа ч үг төдий бус, бодитой үйл ажиллагаа явуулж, чин сэтгэлээсээ, бүхий л чадлаараа хичээж зүтгэдэг хүн л их амжилт гаргадаг билээ. Жирийн гуталчин Жон Фаунз ядуучуудын сургууль (ядуу гэр бүлийн хүүхдүүдийг сургаж, хооллодог сургууль) байгуулах хөдөлгөөнд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн хүн бөгөөд, тэрээр ийм төрлийн сургуулийн хэрэгцээтэй гэдгийг анх хэлж тайлбарласан биш юм. Харин дуугуйхан байж байгаад, үйл ажлаараа өөрийнхөө үзэл итгэлийг хүндэтгэхээр шийдсэн ажээ. Түүнд үг дуугүй туршихаас өөр зүйл толгойд нь байгаагүй ажээ.

Ядуучуудын сургууль үүсгэн байгуулах хөдөлгөөнийг дэмжихэд тэргүүн зэргийн үүрэг гүйцэтгэсэн Гасли, Жон Фаунз хэмээх загвараас хэчнээн их нөлөө авснаа дараах байдлаар өгүүлсэн байдаг.

"Миний бие нэг зурагны нөлөөгөөр ядуучуудын сургуулийг сонирхон дэмжих болсон билээ. Хэдэн жилийн өмнө нэгэн тосгонд очоод түр амсхийхээр буудлын өрөөнд ортол тэр өрөөний пийшингийн дээд талд нэгэн гайхамшигтай зураг өлгөөтэй байсан юм. Уг зурагт гуталчны өрөөг дүрсэлсэн байлаа. Гуталчин хамрынхаа үзүүр дээр нүдний шилээ тохоод хоёр өвдөгтөө нэгэн хуучин гутал хавчуулж яарангуй ажиллаж байх юм. Түүнийг тойроод навтас хэдэрсэн хөвгүүд, жаал охидууд зогсоогоороо хичээллээд гуталчин өтгөн хөмсгөн дороосоо хайр энхрийллээр бялхаж дүүрсэн нүдээр харж сургаалиа айлдаж буй...

Би сонирхихад автагдаж, тэрхүү зургийн тайлбар бичгийг уншлаа. Түүнээс үзвэл уг зургийн бодит дүр нь гуталчин Жон Фаунз ажээ. Олон тооны ядуусын хүүхэд сүмийн ламтан, хотын дарга, ноёд хатагтай нараас нүд үзүүрлэгдэж, хий дэмий сэлгүүцэн гудамжаар тэнэж байгааг үзээж харж байсан тэрээр эгэл дарууханаар хонь хариулахын зэрэгцээ хүүхдүүдийг

цуглуулж, сурган хүмүүжлийн ажлыг эрхэлжээ. Түүгээр зогсохгүй хөлсөө дуслуулж олсон өчүүхэн бага мөнгөөрөө амьдралаа залгуулж, 500 гаруй хүүхдийг зовлонгоос татаж гаргасан гэдэг. Би өөрөө өөрөөсөө ичив. "Чухамдаа би өнөөг хуртэл юу хийж ирэв ээ" гэсэн өөрийгөө буруушаах сэтгэл цээжинд минь дүүрээд ирсэн билээ. Тэр үеэс би Жон Фаунзын намтрыг судалж эхлэсэн юм. Боомт хот Потсмасын эрэг хавиар навтас хөдөрсөн жаал хүүхдүүдтэй хөөцөлдөн, өөрийнхөө гэрт аваачихаар зүтгэх түүний дүр төрх сайн харагдаж байлаа. Харин цагдаа шиг хүч түрээгүй. Хүүхдүүд төмсөнд дуртай гэдгийг сайн мэдэх тэрээр өөрөө ч навтас хэдэрч, чанаж болгосон төмсийг хүүхдүүдийн өмнө сарвайн гүйх ажээ. Түүний зургийг анх харсан үедээ, би тэр л хүн төрөлхтний бахархал мөнөөс мөн гэж бодсон бөгөөд тэр бодол минь одоо ч гэсэн өчүүхэн ч хувираагүй байгаа билээ" гэжээ.

## **2. Сайн багш, сайн нөхөр хүний амьдралын хамгийн том үнэт эрдэнэс мөн**

Зан араншингийн хүмүүжил хэрхэн төлөвших нь хэнийг үлгэр загвараа болгож байгаагаас хамаардаг. Бидний араншин орчин тойрны хүмүүсийн зан авир, байдал төрх, заншил, үзэл бодол зэргийн улмаас үл ухамсарлагдан хэлбэрээ олдог юм. Сайн дүрэм журам хэрэг болдог хэдий ч сайн үлгэр загварыг гүйцэхгүй. Сайн үлгэр загвар дотор бодитой үйлдлийг туулсан сургааль- амьд ухаан багтаж байдаг юмаа.

Сайн зөвлөлгөө өгөвч, муу үлгэр дуурайлал үзүүлэх нь баруун гараараа гэрээ барихын сацуу зүүн гараараа түүнийгээ эвдэлж буулгаж буйтай адил бөлгөө. Үүнээс улбаалаад ялангуяа залуу цагтаа маш их анхааралтай хянамгай байж, нөхрөө сонгох ёстой юм даа.

Залуу хүнд харилцан татагдаж нийлэх хүч оршиж байдаг бөгөөд нөхөрлөж байхын зуур хэзээ ч юм зан ааш, авир ааль нь төсөөтэй болоод ирдэг. Зохиолч Эдвис-ын тайлбараас үзвэл "ялангуяа залуу хүн улаан шаргалтай харьцвал улаан болох шинж чанар хүчтэй тул хамгийн үлгэр загвар болох найзыгаа зөв сонгох ёстой юм" гэсэн байдаг. Түүгээр барахгүй түүний хэлэх дуртай үг нь "Сайн нөхөртэй нөхөрлө, тийм эс аваас хэнтэй ч бүү нөхөрлө" гэдэг үг байв.

Далайн цэргийн офицер Колингвудт залуу нөхөртөө бичсэн захидалдаа: "Дэмий хүнтэй нөхөрлөснөөс ганцаараа амьдрах нь дээр. Үүнийг баринтагтай сургаалиа болгож сэтгэлдээ гүн гүнзгий сийлэгтүн! Өөрөөсөө илүү шилдэг, үгүй ядаж өөртэйгээ эн сацуу хүнтэй нөхөрлөх ёстой юм. Яагаад гэвэл хүмүүний үнэ цэн найз нөхрийнхөө үнэ цэнээр шийдэгддэг болохоор л тэр" гэжээ.

Нэрт эмч Сиднем "Хүн гэдэг зовлон жаргалаа хуваалцах найз нөхөр нь сайн хүн үү, муу хүн үү гэдгээс болж сайн муугийн аль нэг нь болдог" гэжээ. Холландын зураач Питер Лейр тааруухан зурсан зураг үзэхгүй байхыг хичээдэг хүн байлаа. Дэмий зурагны нөлөөнд автагдвал өөрийнхөө бийрийг хүртэл бохирдуулчихна гэж итгэж байснаас тэр юм. Үүн лугаа адилаар, ужд самуунд унасан хүнтэй нөхөрлөх аваас өөрийн чинь бие сэтгэлд хүртэл бузар нялзаад язгуур чанараа алдаж орчихын үүдийг нээдэг билээ.

### ***Сайн хүнтэй нөхөрлөсөн нөхөрлөл мянган боть номноос илүү***

Залуу хүн ямагт сайн нөхрийг эрж хайн, өөрийгөө өндөржүүлбэ хэмээн оролдлого зүтгэл гаргаж байх ёстой юм. Улс төр судлаач Францис Хорнер зориг чанга ухаалаг хүмүүстэй шууд хувь хүний хувьд нөхөрлөж байх явдал өөрт нь хэчнээн учир утгатай байсныг ийн өгүүлж: "Шуудхан хэлвэл, өнөөг хүртэл уншиж ирсэн ном зохиолыг бүгдийг нийлүүлснээс тийм хүмүүстэй нөхөрлөж байсан нь оюун санааг минь хавьгүй өөд нь татаж өгсөн билээ" гэсэн нь буй.

Нэгэн улс төрч залуу байхдаа Францын нэрт улс төрч Марселеб-ыг зорьж очоод гүн гүнзгий сэтгэгдэлтэй буцсан гэдэг. Тэрээр хожим дурсахдаа: "Би энд тэнд бишгүй аялаж явлаа. Тэр үе шиг, тийм хүнтэй учирсан учрал сэтгэлд хоногшсон удаа үгүй. Энэ явдлаас хойш хүмүүсийн төлөө зүтгэнэ гэвэл, Марселеб гуайтай учирсан дурсамж л миний оюун санааг хөглөж өгснөөс зайлахгүй" гэжээ. Өмнө өгүүлсэнчлэн буяны зүтгэлтэн Бакстоны залуу цагийн зан араншин төлөвшихөд Гарнир-ын гэр бүлийнхэн асар их нөлөө үзүүлсэн билээ. Тэрээр ямагт "Тэр гэр бүлийн хүмүүс миний амьдралд амьдрах хүчийг үлээн дүүргэж өгсөн юм" гэж ярьдаг байлаа.

Тэрээр Даблин-ы их сургуулийг гарамгай амжилттайгаар дүүргэсэн бөгөөд түүнийгээ ч тэрээр "Тэдний гэр бүлийнхэнтэй орж гарч явсны ач юм. Тэр хүмүүсийн өөрийгөө гэгээрүүлэн боловсруулахуйн сэтгэл надад ч "халдварласан" билээ" гэж шударгаар хүлээн зөвшөөрсөн байдаг.

### ***Сайн нөхөртэй нөхөрлөхөд заавал үр нөлөөг нь хүртдэг.***

Зохиолч Жон Старлинг найз нөхөртөө ер хэчнээн их ашигтай тустай үр нөлөөг хүртээж ирсэн тухайд одоо ч ам дамжин яригдсаар байдаг билээ. Түүний ачаар олон хүн өөрийгөө шилдэг гайхалтай оршихуун гэдгээ анзаарсан гэдэг. Өөрөө өөрийнхөө хэн болох, юуг хийх ёстой гэдгээ түүнээс сурч авсан гэдэг. Шашны нэгэн зүтгэлтэн, Старлингийн тухай ингэж дурсаж бичсэн нь бий.

"Түүний эрхэмсэгзан аальтай учирангуут би ч гэсэн сэтгэл өндөр болсон мэт бодогддог юм. Түүнээс салсны дараа ямагт идээшиж дассан орчноосоо илүү зорилготой орчин руу миний сэтгэл татагдан гарсан мэт санагддаг билээ" гэжээ.

Гайхамшигтай сайн араншинт хүн иймэрхүүгээр хавь орчныхоо хүмүүсийг хөдөлгөөнд оруулж байдаг. Бид тэдний хүчээр, үл анзаарагдах хооронд өөдөө дээшээ болж, юмыг мэдрэх арга, үзэх үзэл ч тэдэнтэй төсөөтэй болж ирдэг билээ. Оюун санааны харилцан эерэг хийгээд эсрэг үйлдэл ийнхүү асар том хүчийг хөдөлгөж байдаг ажээ.

### ***"Үлэмжийн хүн" болохын төлөөх онгод чиний авъяасыг дуудан босгодог***

Урлагийнхан ч өөрөөсөө илүү давсан авъяастанд хөглөгдөж авъяасаа хурцлаж дээшлүүлж байдаг. Тухайлбал Хайдоны суут чанарыг Хендер анх хөл дээр нь босгосон гэж хэлэхэд хэтрүүлсэн болохгүй юм. Хендерийн бүтээл сонсоод Хайдон хөгжим зохиох урам онгодоо шатаах болсон билээ.

Хайдон өөрөө өгүүлж буйчлан түүнтэй учраагүй бол түүний "Диваажингийн үүсгэл" оратори бий болоогүй байх байсан ажээ. Хайдон Хендерийн тухай "хөгжмийнхөө санааг шийдээд бариад авахаараа гял манас урагшилдаг хүн дээ" гэж өгүүлжээ. Бас "түүний бичсэн ямар ч аялгууг сонсоход миний цус хөөрч, дагжин чичирдэг билээ" гэж хүртэл ярьсан байдаг.

Хөгжмийн зохиолч Скарллет Хайдоныг бишрэгч хөгжимчин агаад түүний араас хөөж Италийн бүх газар нутгийг тойрсон гэдэг. Хэдэн жилийн дараа ч мөнөөхөн агуу уран бүтээлчийн тухай дурсах үедээ бахдаж шагшсан сэтгэлээ илэрхийлэхийн тулд бараг л загалмайгаа таслах шахаж байжээ. Жинхэнэ уран бүтээлчид бие биенийхээ агууг шууд хүлээн зөвшөөрдөг билээ. Бетховен Кербини-ын хөгжмийн мөн чанарыг хэн ч халдахгүй болтол магтан дуулж, Шубертийн суут авъяасын тухайд ч халуун дотно магтаал илгээж байлаа.

"Үнэхээр ярих юм алга, Шубертын дотор бурхны дөл орогнож байна" гэж Бетховен өгүүлжээ. Уран зургийн ертөнцөд ч адил тухайлбал Носкорд залуудаа Леонорс-ийн бүтээлд сэтгэл татагдцаг байлаа. Нэг өдөр агуу их зураач нийтийн цуглаанд оролцож байхад, Носкорд бөөгнөсөн улсыг зайчлан түүний өмсгөлийн хормойд шүргэх шахам ойрхон очжээ. Сүүлд нь тэрээр "Леонорс багшийн хувцсанд шүргэхүед бараг л нисч хөөрчих шахам баяртай байсан" гэж өгүүлсэн байдаг. Суут авъяасанд хандах залуу хүний солиором тэмүүлэл энэхүү үгээр нэн тодорхой дүрслэгдэж байгаа бус уу.

### **3. "Хойт насанд "уул" болохоор зоригтой амьдрал**

Намтар бичлэгийн хэрэгтэй тал нь гайхамшигтай зан араншингийн үлгэр загвараар баян байдагт оршино. Агуу их хүмүүс, тэдний амьдрал тэмдэглэл бичлэгээр дамжиж бидний сэтгэл зүрхэнд хоногшоод, тэрхүү үйл явдлууд орчин цагт үргэлжлэн амьдардаг билээ. Өнгөрсөн цагийн агуу хүмүүс бидний ширээний хажууд тухлан, гарыг чинь атгаж буй. Тэдний бидэнд хүртээсэн ашиг тустай үлгэр загварыг бид судалж, бахдаж, суралцах ёстой юм шүү.

Өнгөрсөн үеийн агуу хүмүүс өндөр дээд оюунлиг амьдралынхаа дурдатгал бичгийг өв сан болгож хойч үеийнхэндээ үлдээсэн, тэр бол сайн суртахуун хийгээд аз жаргалын ширгэшгүй булаг мөн билээ. Яагаад гэвэл тэдний дурдатгал хойч үеийнхэн өөрийгөө төлөвшүүлэхэд гайхамшигтай үлгэр загвар мөн агаад орчин үеийн хүмүүсийн сэтгэлийг шинэ амьдралаар үлээн дүүргэж, хүний амьдралын дахин эхлэл хийгээд хүмүүн чанарын хувьсгалд туслахаар гараа сунгадаг ажгуу.

Жинхэнэ хүмүүний амьдралаар амьдарч ирсэн агуу хүмүүсийн намтар бичлэг өнөө үед ч үр өгөөжөөр дүүрэн, ховор чухаг үр жимсийг нягт шигүү чихэлдүүлэн байдаг билээ. Ийм намтар бичлэг бол жинхэнэ үнэний дуу хоолой, орчин үед амьдрах оюун санаа мөн.

Шүлэгч Милтон: "Агуу ихийн оюун ухаанаар булиглах цус" гэж хэлсэн нь бий..

Гайхамшигтай хүмүүсийн намтрыг уншвал ямар ч хүн байлаа гэсэн оюун санаа нь баялаг болж, ямар нэгэн шийдэл хийхээр санаа сэтгэл нь хөглөгддөг. Иймэрхүү намтар бичлэг хүний хязгааргүй бололцоог нотлож байдаг тул уншигчид биеэ даахын сэтгэлээр өндийн босч хүний амьдралд хүсэл мөрөөдөл хийгээд зорилго чиглэл өөдөө дээшээ, баттай зүйл болдог билээ.

Ялангуяа уншигчид намтар бичлэгийн дотроос өөрийн дүр зургаа харж гаргаж ирэх тохиолдол байдаг. Тухайлбал нэрт хуульч Самуэл Ромил францын алдарт хуульч Дагесорын амьдралын замнал түүхийг уншаад сэтгэл нь гүнээ хөдөлжээ. "Түүний туулсан гэгээ гэрэлтэй амьдралыг мэдсэнээр миний урам онгод ихээр асч бадамласан юм. Тэгээд миний бие дахин гэрэл гэгээтэй замыг сэтгэлдээ ургуулан бодох болсон билээ" гэж тэрээр өгүүлсэн байдаг.

Франклин ч залуудаа шашны зүтгэлтэн Котон Маза-гийн намтар зохиолыг уншаад сэтгэл нь их хөдөлсөн гэдэг. "Миний бие хүнд хэрэг тус болж, алдар нэр олсон нь ч энэ номтой учирсны ач юм" гэж хожим давтан өгүүлсэн байдаг.

Ийнхүү сайн үлгэр загвар хүнийг өөд нь татаж, ирээдүйг атгах хойч үед уламжлагдан өвлөгддөг билээ. Улмаар ном бичиг унших тохиолдолд ч анд нөхрийн ёсонтой адил сайн зохиолд татагдаж түүний хамгийн сайн хэсгийг үзэж судлах явдал чухал юм. Энэ талаар нэгэн ухаантан: "Би гайхамшигтай ном зохиолоос өөрийг уншмааргүй байдаг. Гайхалтай ном зохиол гэдэг голдуу эртнээс хайрлан уншиж ирсэн номыг хэлдэг. Би энэхүү хуучны танилтайгаа улам нандин холбоотой болохсон гэж хүсч байна. Шинэ номыг анхлан уншихаас илүү хуучин номоо давтан унших нь бүр олз ихтэй байх ёстой юм" гэж бичсэн байдаг.

### **Нэгэн насны амьдралыг шийдвэрлэсэн ганц ширхэг ном**

Цаг нөхцөөх санаатай уншихаар гарт тааралдсан номонд, өндөр дээд хүмүүний амьдралыг туулсан хүний үлгэр бичигдсэн байх тохиолдол ч бий юм. Тэр нь уншсан хүний сэтгэлийг хөдөлгөж, санаанд оромгүй гайхалтай идэвхийлэх хүчийг дуудан босгосон хүртэл удаатай. Игнатис Рояла цэрэгт байхдаа тулалдаанд хөлөндөө хүнд шарх олж, эмчилгээ хийлгэх болжээ. Нэг өдөр, санаа сэтгэлээ онгойлгохоор ном уншъя гэж бодоод, асрагчаасаа гуйжээ. Тэгвээс түүнд өгсөн ном нь "Ариун хутагтын цадиг" байв. Тэрээр энэхүү номын ачаар сэтгэлийнхээ гал дөлийг бадрааж, шашны шинэ байгууллага Исүсийн нийгэмлэгийг үүсгэн байгуулахад биеэ зориулахаар шийдсэн гэдэг.

Мартин Рутер ч түүнтэй нэгэн адил "Ян Гус-ын амьдрал, уран бүтээл" хэмээх номонд сэтгэл татагдсанаас үүдэж шашны өөрчлөн байгуулалтын их хэрэгт бүхий л насаа зориулсан гэдэг. Вольф хэмээгч ч бас залуудаа "Франциско де Хабиерын амьдрал"-ыг уншиж гүн гүнзгийгээр сэтгэл нь хөдөлж, түүний замналыг нэгэн насныхаа ажил болгохыг сонгож авчээ. Цаашлаад Вильям Кэри загалмайтны шашныг түгээн дэлгэрүүлэх ажилд зүтгэхээр болсон нь Капитан Кукк-ын далайн аялалын тэмдэглэлийг уншсанаас үүдэлтэй ажээ.

Францын Харнер өөрийгөө хамгийн их догдлуулсан, сэтгэл хөдөлгөсөн ном зохиолын тухай сэтгэгдлээ өдрийн тэмдэглэл болон захиандаа бичиж үлдээг заншилтай хүн байжээ. Тухайлбал зураач Леонорсын "Урлагийн онол" бүтээлийн тухайд: "Бэконы бүтээлүүдийг эс тооцвол, үүн шиг өөрийгөө боловсруулахуйн чухлыг гүн гүнзгий илэрхийлсэн ном байхгүй"гээд, Леонорс хүн агуу их болохын тулд ямархуу замыг хайвал сайн бэ гэдгийг гайхалтай эелдэгээр тайлбарлажээ. "Хүний хувьд хичээл зүтгэл л бүхнийг мэддэг" гэж тэрээр баттай хэлж буй агаад түүний өөртөө итгэх итгэлээр бялхсан хэллэгт уншигчид ч, гоц авъяас бол төрөлхийн бус, хичээл зүтгэлээр олж хүртдэг зүйл гэсэн итгэлээ хүчтэй болгож байна. Цаг ямагт хамгийн дээдийг зорихоор зүтгэх хүчтэй урам онгод энэхүү номонд хар аяндаа, бүр уран яруу өгүүлэгдэж буй. Ийм оргилуулан, дэгжээх маягийн зохиол өөр байхгүй буй за" гэжээ.

Энд анхаарууштай нь тэр цагийн Леонерс ч өөрөө нэгэн зураачийн цадиг түүхийг уншаад зургийн хичээлд махран шатаж эхэлсэн нь бодит үнэн юм. Бас хойч үеийн алдарт зураач Хендер ч Леонерзийн намтараас үүдэж зургийн замаар зорьж үзэхээр шийдсэн гэдэг. Ийнхүү нэгэн хүний эр зориг, их эрмэлзлээр бялхсан амьдрал түүн лугаа адил авъяас хийгээд урам онгод өвөрлөсөн бусад хүмүүсийн сэтгэл зүрхэнд гал бадраадаг ажээ. Гайхамшигтай үлгэр загвар цаг үеийг гэтлэж хэлхэгдэн, тэрхүү авъяас бас дахин суутнуудаар дамжигдан мөнхөд уламжлагддаг ажээ.

### *Сэргэлэн цовоо байдал хүмүүний оюун санаанд уян хатан чанарыг огдог*

Сэргэлэн цовоо байдлаа алдалгүй ажил хөдөлмөрт шуранхайлж орсон хүний яриа утга учирлаг чанараар арвин төдийгүй нөлөөлөх хүч нь агуу их юм.

Цовоо сэргэлэн байдал нь хүний оюун санаанд уян хатан чанарыг өгч байдаг. Цовоо эрчимтэй ажиллавал аягүйрхэх сэтгэл арилан хийсч, ямар ч бэрхшээлтэй тулгарлаа ч түүндээ "түлэгддэггүй". Энэ бол хүсэл эрмэлзэл сэтгэлийн тулгуур болдогийн учир бөгөөд, хүсэл эрмэлзлэлээр дүүрсэн оюун санаа нь амжилтын боломжийг огтхон ч үргээж хулжаадаггүй билээ.

Хүсэл эрмэлзлэлээр шатаж яваа хүний сэтгэл нь эрүүл чийрэг хийгээд аз жаргал гэгч зүйл тэр биеэрээ байгаа нь тэр буй за. Өөрөө цовоо сэргэлэнээр ажилдаа шамдвал мөн ялгаагүй бусдын идэвхийг хөөрөгдөн босгох нь бий. Махран ажиллавал ямар ч хар бор ажил байсан хүндлэлтэй золгуулдаг билээ. Өөртөө итгэлтэй байгаа эсэхээс ажлын бүтээмж өөр өөр болдог. Чин сэтгэлээсээ баяр хөөртэй ажиллавал биеийн хүчний ч бай, оюун санааны ч бай ажил утга учиртай үр дүн төрүүлдэг юм. Гүн ухааны эрдэмтэн Хьюм "хэзээ ямагт сэргэлэн цовоо байдлаа алдалгүй, юм үзэгдлийн гэгээ гэрэлтэй талыг дандаа харж явууштай. Жилийн орлого нь нэгэн түмэн фунтын үнэтэй томоохон газрын эзэн боллоо ч бүүдгэр сэтгэлээр амьдрах нь үнэндээ муухай" гэж амны уншлага мэт ямагт хэлдэг байжээ.

Сурган хүмүүжүүлэгч Арнольд сэргэлэн цовоо, гайхамшигтай оюун санааны эзэн хүн мөнөөс мөн байлаа. Тэрээр бүхий л бие сэтгэлээ залуус, багачуудыг сурган хүмүүжүүлэх хэмээх агуу их үйл хэрэгт зориулсан билээ. Түүний амьдралын замналыг гайхалтай сайхан намтар бичлэг болгон үлдээсэн бөгөөд түүнд дараах мөрүүд бий.

"Арнольдын сургуульд хачирхмаар шахам эрүүл саруул уур амьсгал сургуулийнх нь байрын өнцөг буланд хүртэл нэвт шувт хүрсэн байв.

Шинээр орсон сурагчид хүртэл шууд л анзаармаар, хэчээнгүй махруу сургалт хүмүүжлийн ажил явагддаг байв. Сурагчид хүн бүр өөр өөрийн үүрэгтэй байлаа. Хийх ёстой зүйлээ сайн биелүүлэх нь сурагчдын үүрэг бөгөөд мөн баяр баясгалан нь ч болдог. Үүнийг сурагчид өөрсдөө маш сайн мэддэг байсан.

Хүүхдүүд цөм л амьдралын талаар хэлж үл мэдэх сонирхлоор дүүрэн байв. Нийгэмд хэрэгтэй хүн, аз жаргалтай хүн болоход чухам юу хийвэл дээр вэ? Ингээд түүний хариултыг тэд олж харахаараа сэтгэл зүрх нь үгээр хэлэхийн аргагүй баяр баясгалангаар бялхдаг ажээ. Хүүхдүүд удалгүй хүний амьдрал хийгээд хүний үнэ цэнийг ойлгуулж, өөрсдийнх нь урагшлах ёстой замыг зааж өгсөн ачит багшдаа хандаж гүн гүнзгий хүндлэл хийгээд хайр энэрлийн гараа сунгадаг ажээ. Сурган хүмүүжүүлэх ийм нөхцлийг бий болгож чадсан нь Арнольдийн хүн чанарын агуу дэлгэр хийгээд нэвт харах чадварынх нь ач юм. Тэрээр энэ ертөнцийн жинхэнэ бодит үнэнийг мэдэж шавхсан сурган хүмүүжүүлэгч байлаа. Ажлаараа нэр төр.албан тушаал хөөлгүй, нийгмийн дэвшил хийгээд хувь хүний хөгжилд эрхэлсэн ажил юу юунаас чухал юм гэсэн бодит баримтыг биеэрээ үзүүлж иржээ. Энэ ухамсар л түүний сурган хүмүүжүүлэх үзэл бодролын тулгын чулууг хэлбэршүүлсэн гэж хэлж болно.

Арнольд өөрийн төлөвлөсөн төлөвлөгөөгөө илүү дутуугүй гүйцэтгэдэг байлаа. Сурагчдын хүлээх үүрэгт ч ялгаварлах зүйлгүй, нэг тал руу хэлбийсэн зорилгод хэт шахах явдал гаргаж байсангүй. Тэрээр зөвхөн ажил л хүний амьд яваагийн баяр баясгалан агаад бүхий л авъяас чадвараа түүнд юүлвэл авир араншин ч дээшилж, дэвшил хөгжлийг ялж байж л гартаа оруулна хэмээн хатуу итгэж байснаас тэр юм" гэжээ.

Арнольддын сургуулиас олон тооны чухаг нандин хүмүүс төрж гарсан билээ. Тэдний нэг, цэргийн хүн болох Ходсон Энэтхэгээс эх орондоо, гэрийнхэндээ илгээсэн захидалдаа хүндэтгэн хайрлах ёстой ачит багшийнхаа тухайд ийн өгүүлсэн нь бий.

"Арнольд багшийн нөлөө үнэхээрийн арилж алга болдоггүй шахам хүчтэй эд юм байна. Алс холын Энэтхэг оронд байлаа ч багшийн сургааль амьд ,үргэлжилсээр л байх юм даа" гэжээ. Ийнхүү зөв, чин үнэнчээр, эрчим буцалсан хичээнгүй чармайгчийн амьдралын замнал хавь орчныхоо хүмүүс, тэр байтугай нэгэн улсын ирээдүйд ч лавтайяа ашиг тустай нөлөө үзүүлдэг ажгуу.

## Хүмүүний чансаа

*Зан араншин бол нэг насанд үйлчлэх цорын ганц эрдэнэ мөн.*

### **1.Зан араншин нэг насанд үйлчлэх цорын ганц эрдэнэ.**

Шилдэг зан араншин бол хүний амьдралд олдох хамгийн дээд үнэт эрдэнэс билээ. Авир араншин өөрөө гайхалтай статус бөгөөд хорвоогийн итгэлийг гартаа оруулах өв хөрөнгө юм. Нийгмийн байр нь суурь ямар ч байлаа гэсэн сайн авир араншинт хүн зөвхөн түүгээрээ хүндлэл хүлээмүй. Зан араншингийн хүч эд баялгаас ч илүү. Сайн араншинт хүмүүн янз бүрийн нэр алдрыг хураан цуглаавч баян хүнтэй адил бусдаас мөнөөх алдар хүндээ харамладаггүй. Бас шилдэг авир араншин асар их нөлөөлөх хүчийг өөртөө агуулж байдаг. Яагаад гэвэл тийм араншин юу юунаас илүү хүмүүст итгэгдэн хүндлэгдэх чанараас өөрөөр хэлбэл, итгэл,зөв хичээнгүй, бат тууштай байдал хэмээх сайн суртахуунаас төрж гардаг юм. Шилдэг зан араншин хүний хамгийн сайн онцгой шинж мөн. Сайн араншинт хүн нийгмийн ариун сэтгэл бөгөөд мөн төр улсын язгуур хөдөлгөгч хүч болж байдаг. Дэлхийг эзэмдэх хүч нь өндөр суртахуунаас өөр зүйл биш юм. Наполеон ч иймэрхүү санаа өгүүддэг байв. Дайны цагт л ёс суртахуунтай сэтгэл, эд материалын хүчнээс арав дахин их сүр хүчийг төрүүлж гаргадаг гэж тэрээр хэлжээ.

Ингэж бодож үзвэл төр улсын хүч, аж үйлдвэрлэл, иргэншил сэлтийн мандал буурал нь ард түмэн хүн нэг бүрийн хүн чанараас шалтгаацаж байдаг гэж хэлж болох юм. Амар тайван иргэний нийгмийн суурь ч бас үүн дээр сүндэрлэж, хууль цааз, бусад систем хүртэл ард түмний энэхүү иргэнлиг чанараас төрж гардаг.

Хувь хүн ч бай, төр улс болон үндэстэн ч бай өөр өөрийн үнэ цэнэдээ таарч тохирох зүйлээс өөр юмыг эрж хайдаггүй, хэр хэмжээндээ үл тохирох өндөр хүсэл санаархал гаргавал эцсийн эцэст талаар болон унадаг билээ. Үрдүн заавал нэг учир шалтгаантай байдаг гэсэн утгаар хэлвэл, хувь хүний зан араншин болон ард түмний иргэнлэг чанарын шилдэг юмуу буурай байдал л хувьхүн болоод нэгэн улсын ирээдүйг шийдвэрлэхэд чухал хэмжүүр болжбайдаг гэдэгнь асч буй галыг харахаас ч илүү тов тодхон үнэн билээ.

### ***Түмэн хүнийг өөртнөө шагнах зан араншингийн нууцаас***

Боловсрол, чадвараар дульхан, өмч хөрөнгө багатай хүн ч гэсэн шилдэг зан араншинг л цогцлоосон байвал бусад хүнд ихээхэн нөлөө үзүүлж байдаг. Энэ тал дээр тухайлбал жирийн ажилчин ч бай, парламентын гишүүн мэтийн чухал албанд хүрсэн хүн ч бай нөхцөл байдал адилхан. Улс төрч Карнинг хэлэхдээ: "Би юунаас ч илүү зан араншингийн төлөвшилийг дамжиж байж эрх хүч олохыг хүсдэг. Энэ бол тийм ч хурдан арга биш байж болох авч хамгийн баттай зам юм, би үүнд хатуу итгэдэг, эргэлздэггүй" гэжээ. Оюунлиг эрдэмтэй хүнийг хүндэтгэх нь огтхон ч хамаагүй. Гэхдээ оюун ухаанаас өөр ямар нэг зүйл түүнд байхгүй бол тэднийг итгэх нь хэтэрхий хөнгөн хуумгай хэрэг мөн.

Улс төрч Жон Лассель өгүүлэхдээ: "Манай улс бурхан тэнгэрээс тусламж гуйж болох ч эцсийн дүнд сайн араншинт хүний заавар удирдлагыг дагах нь илүү бодитой зам гэжүздэг". Энэ бол жинхэнэ унэнийг илэрхийлсэн үг юм.

Францис Хорнерын замналд энэхүү үнэн баттай илэрч байдаг. Шотландын шүүгч Кокбен түүний амьдралын тухай дурсахдаа:

"Түүний зам зөв хичээнгүй бүх залуу хүмүүсийн сэтгэлд гэгээ гэрлийг түгээж үнэнхүү чадсан билээ. Тэрээр ердөө гучин наймхан нас наслаж хорвоог орхисон боловч хэнээс ч илүү өргөнөөр хүмүүсийн сэтгэлийг татаж чадсан юм. Хэрцгий догшин, сэтгэл оюунаар ядмагхан нөхдийг эс тооцвол түмэн хүн түүнийг хүндэтгэн хайрлаж, түүнд итгэж, түүний үхэлд эмгэнэн гашуудаж байлаа.

Одоо би залуучуудаас асууя! Яагаад Хорнер ийм өндөр хүндэтгэлийг хүлээх болсон юм бэ? Өөрийнхөө тусын тулд уу? Тэрээр ердөө Эдинбарын худалдаачны л хөвүүн байсан. Эд баялгийн төлөө юү? Тэр ч, түүний ойр дотныхон ч, элбэг дэлбэг хэрэглэх мөнгө төгрөгтэй байсангүй. Тэгвэл албан тушаалын төлөө юү? Тэрээр хоёр гуравхан жилийн хооронд ямар ч нөлөөлөх хүчгүй, бага цалинтай ажил эрхэлж байсан. Уран цэцэн болохоороо тэр үү? Түүний үг яриа цөөн, эрхэмсэг байсан ч хүнийг алмайруулан татах хүртэл уран цэцэн үгээр уяруулж байсангүй. Өөрийгөө болгохын тулд л бусдыг тагдахүчтэй байв уу? Түүний ааш байдал жирийн хүмүүстэй өчүүхэн ч ялгаагүй төлөв төвшин байсан.

Тэгвэл Хорнер хүмүүсийн хүндлэлийг яагаад хураан цуглааж чадав. Тэрээр эрүүл саруул сэтгэлгээ, хичнээнгүй зан, зөв итгэл баримтлал, сайн сэтгэл зэрэг, өөрөөр хэлбэл хичээнгүй шударгуу хүн хэн боловч тийм ч их зоволгүй гартаа оруулдаг чанаруудыг биедээ бат эзэмшсэн байсан учраас билээ. Өөр үгээр хэлбэл түүний зан аашийн хүч түүнийг ийн өндөрт өргөсөн хэрэг. Харин тэрхүү зан ааль нь төрөлхийн зүйл бус, жирийн л элементээр хичээл оролдлого гаргаж барьж босгосон бүтээл юм.

Авъяас чадвар, уран цэцний авъяасыг голлож харвал түүнийг давах хүн олон. Гэвч тийм авъяас чадвар дээр зан аашийг нэмж хольсон үед түүний дээр гарах хүн нэг ч байхгүй. Жирийн л авъяас чадвараас өөр юмгүй ч сайныгаа алдалгүй боловсрохуйд зүтгэвэл тухайлбал өрсөлдөөн, атаа жөтөө хэтэрсэн нийгэмд ч заавал ч үгүй том амжилтыг олдог билээ. Тэрээр чухам энэ үнэнийг батлахын тулд төрсөн мэт хүн юм" гэжээ.

### *Тэнгэрт дүүлье гэж оролдохгүй оюун санаа эцэстээ удалгүй газарт унадаг*

"Мэдлэг бол хүч" гэлцэх нь бий. Гэвч цаад алсуур утгаар хэлбэл зан араншин л хүч болдог юм. Хайр энхрийлэлгүй сэтгэл, үйлдэлтэй үл хамаарах оюун ухаан, зөөлөн сэтгэлээр дутсан авъяас эд бүхэн хүч мөн боловч, алдаа л хийвэл гарз хохирол авч ирэх төдий зүйл болж хувирах нь амархан байдаг.

Бид мэдээжээр энэ мэт оюун ухаанаас ямар нэгэн зүйлийг сурч авч, сэтгэлийн таашаал хүртэх нь хүртэж байдаг. Харин түүнийг хүндэтгэж чадах уу гэсэн асуулт гарвал хариулахад нэлээд бэрх юм. Маш сурамгайгаар хүний өврөөс түрийвчийг нь сугалж авах халаасны хулгайч хийгээд морийг гайхалтай чадмаг унаад бусдыг дээрэмдэн дутаагчийг хүндэтгэж үзэхийг завдахтай агаар нэг биш үү.

Зөв шударгуу, дээд цэвэр, сайн сэтгэл ухаан хэмээх чанарыг зөвхөн чамин үгээр илэрхийлж чадахгүй юм. Эдгээр чанарууд л хүний зан араншингийн үндсийг хэлбэр дүрстэй болгож байдаг. Энэ шинж чанар дээр бат чанга зоригийг нэмбэл мориндоо ташуур өгсөнтэй адил. Ингэвэл л сайнд садаа бологч мууг тэвчиж, зовлон бэрхшээл гай түйтгэрийг давах хүч шууд л бидний биед буцлахаас зайлахгүй.

Нэгэн цэрэг балмад алуурчинд баригджээ. Тэр алуурчин цэргиш шоолж "чам мууд өөрийгөө хамгаалах нуувч хүртэл алга даа" гээд тохуурхан инээжээ. Тэгсэн чинь мөнөөх цэрэг цээжиндээ гараа' тавиад "миний нуувч эндээ байдаг" гэсэн гэдэг. Үүн лугаа адил золгүй явдалд хэчнээн унавч, цэвэр ариун хүний зан араншин л нү гялбам гэрэл гэгээтэй байдаг. Тухайлбал түмэн хүн унасны хойно тэрээр цэвэр ариун болоод эр зоригоороо өнчин бэхлэлтээ хамгаалсаар байх бизээ.

Аскин бол билэг танхай биеэ даахын оюун санаа хийгээд үнэнийг уйгагүй эрж хайх сэтгэлийг цогцлоосон үнэхээрийн гайхамшигтай хүн байсан. Тэрээр өөрийнхөө үйл ажил, итгэл бишрэлийг дараах байдлаар өгүүлсэн байдаг ба энэ бол хүн бүхэн сэтгэлдээ сийлэх ёстой үг юм. "Ямагт сайн сэтгэлийн тушаалыг гүйцэтгэж, үр дүнг нь тэнгэр бурхандаа даатга. Энэ бол бага байхаасаа эх эцгээсээ хүлээж ирсэн сургааль юм. Би одоо ч гэсэн энэхүү зөвлөлгөөг хэрэгжүүлж байдаг бөгөөд үүнийг огт мартаж чадахгүй байсаар энэ насаа дуусгах бизээ. Энэхүү сургаалийг чанд хамгаалсаар амьдарч ирсэн надад тэр хэмжээгээр өөрийгөө золиослох нь ч их байсан. Гэвч өчүүхэн ч харамсдаггүй. Тиймэрхүү амьдрал л эцсийн эцэст мандал бадрал, аз жаргалд чиглэсэн зам байдаг юм. Би өөрийнхөө хүүхдүүдэд заавал над шиг энэ замаар явахыг сургах санаатай байна" гэжээ.

Хүн хэн ч байсан гайхалтай зан араншин олохыг амьдралынхаа хамгийн том зорилго болгох ёстой юм. Зөв аргаар түүнийг олохоор хүч чармайлт гаргавал улам бүр амьдрах хүч бялхаж, амьдралыг үзэх үзэл ч батжин бэхжих бизээ.

Тухайлбал, бодитой зүйл болж чадахгүй байлаа ч хүн амьдралдаа өндөр дээд зорилготой байх нь өчүүхэн ч дэмий хэрэг биш юм.

"Толгойгоо өөд нь өндөрт өргөө гэдэггүй залуу хүн хэзээд хөлөө үргэлж харж амьдрах болдог. Тэнгэрт дүүлье гэдэггүй оюун санаа газарт дөрвөн хөллөх хувь зохиолыг мөшгих бизээ" гэж улс төрч Дейзлер хэлжээ.

Амьдрал болон оюун санаандаа өндөр хэм хэмжээ тавьж амьдардаг хүн лавтай дэвшигдээшилдэг. Өндөр үр дүнг хүсэмжилж хичээл зүтгэл гаргавал хэн ч хамгийн анхны гарааны цэгээсээ нэлээд урагш давшиж чадах ёстой юм. Харин зорилгынхоо эцсийн цэгт хүрээгүй ч өөдлөхийн төлөө хичээл зүтгэл заавал түүндээ таарсан ач тусыг өгөх нь зайлшгүй.

Хорвоод сайн араншинт хүний дүр эсгэсэн гаднаа гяланцагийн хамсаатнууд олон бий. Мэдээж, жинхэнэ шилдэг сайн араншинтай хүмүүс андуурагдана гэж үгүй. Харин тэдний дунд гайхам сайн араншин мөнгөжиж бэлжихэд тус болж магад гэж боддог нөхөд ч байх бий вий. Тэд хэрэг болгон зориуд сайн зан араншинтай хүний дүр эсгэн хөнгөнцөр хүмүүсийг хуурч мэхлэхийг оролддог.

Нэг хурандаа нэр алдартай нэгэн эрд "чам шиг олны анхаарал татах юм бол нэг түмэн фунт төлсөн ч яах вэ" гэжээ. "Яагаад тэр вэ" гэж асуухад мөнөөх базаахгүй хурандаа "алдар нэрээр суурь мөнгө хийвэл нэг түмэн фунт байтугай ч хялбархан олох юм бишүү" гэж нэрэлэх юмгүй шуудхан хариулсан гэдэг.

## **2.Оюун санаа, бодит байдлыг нийцүүлэх хүчин зүтгэлийн тухай**

Ам ажил хоёрын нэгдэл бол шилдэг зан араншингийн араг яс мөн. Ямагт хичээнгүй шударгуу үг, үйлдлийг сэтгэлдээ тээж явах нь шилдэг зан араншинт хүний гайхамшигтай онцлог чанар мөн юм.

Агуу их улс төрч Роберт Пеел-ийг бие барсны дараа Вейлinton парламентад гашуудлын үг хэлжээ. Талийгаачийн гайхамшигтай зан характер Вейлinton дараах үгээрээ тов тодорхой илэрхийлсэн байдаг.

"Та бүхэн талийгаач Пеел агсны хүндлэх ёстой өндөр дээд зан араншингийн тухай бодол юугаа алсад довтолгож байгаа бизээ. Би ч гэсэн албаны шугамаар талийгаачтай олон жил хамт ажиллаж, амин хувийнхаа талаар ч анд нөхрийн харилцаатай явж ирлээ. Эргээд санахад миний бие өнөөг хүртэл түүн шиг итгэлтэй хүн, шударга ёсны сэтгэлээр бялхсан хичээнгүй шударгуу хүнтэй учирч байсан нь үгүй. Тэрээр ард түмний аж амьдралыг дээшлүүлэхэд хэнээс ч илүү хувиршгүй хичээл зүтгэл гаргаж, урам онгодоор шатаж явсан билээ. Түүнтэй уулзах бүрдээ чин үнэнд итгэлтэй үнэнч байх гэдэг ухааныг ямагт хүчтэй мэдэрдэг байлаа. Энэ бол миний тов тодорхой мэдэж ирсэн баримт юм, үүнд эргэлзэх юм нэг ч байхгүй агаад тэрээр өөртөө зөв гэж баттай итгээгүй зүйлийн тухай нэг ч удаа ярьдаггүй, хичээнгүй шударгуу ганцхан замтай хүн байсан юм шүү" гэжээ.

Үгээр төдийгүй үйл ажлын хувьд ч хичээнгүй шударга байа гэж хичээл зүтгэл гаргах нь өндөр дээд хиргүй зан араншин төлөвшихийн үндэс суурь болдог. Хүн гадаад үзэмж байдал, дотоод төрх чанараа нэгтгэж байхгүй бол болохгүй агаад тийм байх юмсан гэж бодох мөрөөдлийн дүрдээ өөрөө өөрийгөө бодитойгоор тааруулан нийцүүлж явах ёстой юм.

Боолыг чөлөөлөх хөдөлгөөний зүтгэлтэн Гранбил Шейфид нэгэн америк хүнээс захиа иржээ. Тэр хүн Шейфийн шилдэг зан араншинг хүндэтгэж, нэг хүүдээ түүний нэрийг өгч гэнэ. Шейф шуудхан дараах хариуг бичиж илгээжээ. "Эрхэм та хүүдээ миний нэрийг өгчээ гэж сонслоо, тэгвэл заавал манай гэр бүлийнхний бие биедээ дамжуулж байдаг хур сургааль үгийг ч түүнд зааж өгөөрэй. Тэр бол" хүмүүсийн нүдэнд аль болох их харагдъя гэж боддог бол гадна төрх төдийгүй дотор төрх сайтай хүн болохын төлөө хичээж чармайгун" гэдэг үг юм шүү. Эцгээсээ сонссоноор бол өвөг эцэг маань ч энэ үгийг ягштал биелүүлж ирсэн гэдэг юм. Өвөг эцэг маань угийн илүү дутуугүй утга чанарлиг, буурьтай нэгэн байсан агаад түүний хичээл оролдлогын нөлөөгөөр эцэг маань хувийн хийгээд хувьсгалын аль алинд нь ар өвөр гэлгүй, хичээнгүй шударгуу зан араншингаар хандаж ирсэн юмаа" гэж бичжээ.

Өөрийгөө эрхэмлэж, үүнтэйгээ эн сацуу өрөөл бусдыг ч хүндэтгэн үзэх хэн боловч "өөрийн хүссэн зүйлээ итгэлтэй хий" хэмээх Шейфийн сургаалийг биелүүлж чадах буй за. Өөртөө оногдсон ажилдаа хайнга кандалгүй, бүхий л хүч чадлаа дайчлах бизээ. Иймэрхүү хичээнгүй шударгуу, цэвэр сэтгэл бол хүний хувьд бахархах ёстой чанар юм. Харин үйл хөдлөл үг яриа хоёр нь тус тусдаа байдаг хүн ердөө ч хүндлэл олдоггүй, тэдний ярих үгэнд ямар ч үнэ хүнд байдаггүй. Тухайлбал тэдний үгэнд их бага ч гэсэн бодитой ямар нэгэн зүйл байлаа ч гэсэн тэр нь хүртэл амныхаа зоргоор хэлсэн хоосон үг гэж ойлгогдох болдог.

Жинхэнэ сайн араншинт хүн хүний нүдэнд ил далд алин байлаа ч зөв хөдөлж байдаг. Нүдний нь өмнө лийр байхад, хүн амьтны бараа харагдахгүй бол хэд гурвыг хумсалж орхидог хүүхэд байдаг байж магад. Харин нэгэн хөвүүн хүн байхгүй байх тусам лийрээс хулгайлсангүй. Учрыг асуувал тэрээр "Үгүй ээ,

тэнд хүн байсан. Би өөрөө өөрийгөө нүдээрээ харсан юм. Өөрийгөө муу юм хийж байхыг өөрөө харах хусэл надад огтхон ч байхгүй учраас тэр" гэжээ.

Энэ бол ялихгүй хэрэг боловч алдасын сэтгэлийн эрхэм чухлыг харуулсан хамгийн том жишээ мөн. Алдасын сэтгэл гэдэг бол хүн, хүн чанараа хамгаалж байдаг хэрэм бэхлэлт бөгөөд хүний амьдралд том нөлөө үзүүлж байдаг билээ. Мөнөөхөн алдасын сэтгэлээ алдаж орхивол авир араншин зан төрхөө авран хамгаалж явах арга чарга байхгүй болж, уруу татлага дур хорхойн идэш болж дуусах билээ. Дур хорхойд автагдахын хэрээр хүн гэгч дорд бүдүүлгийн болоод шудрага бусын замд унаж сүйрдэг. Дур хорхой уруу татлагад ялагдаад өдөөсөн муу үйл нь хэдийгээр сайтар урагшлавч, эс бөгөөс муу үйл нь илэрч баригдаагүй байлаа ч тэр хүн өмнөхөөсөө тэс өөр хүн болдог. Тэгээд удалгүй дотоод сэтгэлийнхээ зовнилд мөхөөгдөж, алдасын сэтгэлийн гашуун зайлшгүйд дахин сэргэхгүй болтлоо алгадуулдаг юм. Энэ бол гэмтэн хэн боловч мөшгөх, зайлан дутааж үл чадах хувь зохиол юмаа.

### ***Үйл хөдлөлийн хувьд ч, үзэл сэтгэлгээний хувьд ч давтлага л хүч болж байдаг тухай***

Сайн дадал хэвшлийг биедээ нэмээд байвал, зан араншин ч өнгө зүс орж дээшилж байдаг. Эртнээс нааш хэлэлцэж ирсэнчлэн, хүн бол дадал хэвшлийн сийлбэр бөгөөд дадал хэвшил нь хоёр дахь төрөлх чанар мөн.

"Үйлдэлд ч, бай сэтгэлгээнд ч бай давтлага л хүч болж байдаг" гэж баттай итгэж ирсэн шүлэгч Метастаже "Хүнд дадал хэвшил юунаас ч чухал юм. Сайн суртахуун хүртэл дадал хэвшлээс өөр юу ч биш" гэжүздэгбайв. Бас "Иймэрхүү сайн суртахууныг дадал хэвшил болгон биедээ эзэмших хооронд шилдэг гайхамшигтай хүн чанарыг амархан эзэмшиж, нүгэл үйлдэхгүй амьдрахаар боддог" гэж өгүүлсэн байдаг. "Бие махбодийн дадал хэвшил үйлдлээр бий болж байдаг лугаа адил, оюун санааны хэвшил ч бас дуулгавартай байдал, хичээнгүй шударгуу, үнэнч, сайн санаа зэрэг ёс суртахууныг бодитоор үйлдэхийн явцад олгогдож байдаг" гэж тэрээр үздэг байв.

Оросын нэгэн зохиолч "Дадал хэвшил бол хүзүүний сувдан зүүлт юм. Зангилаа нь тайлагдвал сувд ядах юмгүй оосороосоо тасран унадаг шүү дээ" гэжээ. Энэ бол дадал хэвшлийн мөн чанарыг гайхамшигтайгаар онож хэлсэн зүйрлэл мөн. Хүн залуу байхдаа дасгал сургууль хуримтлуулж, зөв хэвшил дадлыг нягт нямбай эзэмших нь чухал юм. Үнэн хэрэг дээр дадал хэвшил нь залуу байхын хэрээр биед суухдаа хялбар, нэгэнт биед хэвшвэл нэг насаар алдагддаггүй эд. Яг л, модны эх биенд сийлсэн үсэг цаг хугацаа элээхийн хэрээр томорч байдаг шиг юм. "Урагш одох замаа хүүхэд байхдаа тогтоогоод давтан сайжруулагтун. Тэгвэл том болсон хойноо хөндлөн замаар хадуурахгүй" гэдэг үг бий. Аливаа зүйлийн эхлэл нь аль хэдийнээ дотроо төгсгөлийг агуулж байдаг бөгөөд, хүний амьдрал хэмээх аян замын хувьд анхны алхмаа зөв тавьбал түүний зүг чиг хийгээд зорилгот газар нэг мэдэхэд шийдэгддэг юм.

Далайн цэргийн офицер Коллингвудт аятай санагдсан залуудаа "25 нас хүртлээ зан араншингаа давтан сайжруул. Тэгвэл дараа нь ном ёсоороо урагшлах болно" гэж захидаг байжээ. Дадал хэвшил он жилтэй хамт хатуурч бэхжиж, тэр нь хүний авир араншинг биежүүлдэг юм. Дадал хэвшлээ өөрчлөх нь нас бие гүйцэхийн хэрээр хэцүү байдаг. Шинэ юмыг тогтоохоос илүү, нэгэнт тогтоосон зүйлээ мартаж хавьгүй хэцүү. Нэгэн лимбэчин өөрөөс нь өмнө тааруухан багштай хичээллэж байсан шавиасаа хоёр дахин илүү хөлс авдаг байсан гэх ба энэ ч бас хүлээн зөвшөөрч болмоор яриа юм. Хуучин хэвшил дадлыг өргүй алга болгох нь хорхойтой шүд авахаас хавьгүй илүү яршигтай агаад түүгээр үл барам бүр бэрх өвдөлттэй хамсах тохиолдол ч олон. Ринч өгүүлсэнчлэн "гайхалтай дадал хэвшлийг биедээ эзэмшихээр санаа тавих нь хамгийн ухаалаг дадал хэвшил мөн" гэжээ.

### ***Зүүний сувэгчин чинээ нухээр ч нарны гэрэл тусдаг шиг***

Энэ хорвоод аливаа зүйлийн өөдрөг гэгээтэй талыг харж явъя гэдэг зантай хүн байдаг, дандаа хар бараан руу нь нүдээ чиглүүлж явдаг хүн ч буй. Жонсоны өгүүлснээс харахад, юмны сайн талыг хардаг хүн жилийн орлого нь нэг түмэн фунтын баян хүнээс ч илүү үнэ цэнтэй болой. Хүн азжаргал хийгээдхөгжил дэвшлийгтөрүүлдэгзүйлдл бодол оюунаа чиглүүлэх зоригийн хүчийг хадгалж байдаг. Тэгвэл эсрэгээр гай зовлон хийгээд ухралтаас нүдээ буруулах хүч ч байх ёстой

юм. Бусад дадал хэвшилтэй адилхан, аливаа юмыг өөдрөгөөр бодох дадал хэвшил ч энэхүү зоригийн хүчнээс төрж гардаг бүлгээ.

Өөдрөг сэтгэлд сургаж өгдөг сурган хүмүүжил нь мэдлэг, боловсролыг чинээн нь тултал чихэхээс хавьгүй чухал сурган хүмүүжил гэж хэлж болох бизээ.

Ямар ч жижиг нүхээр нарны гэрэл тусч байдагтай адилаар өчүүхэн жижиг зүйлээс ч хүн бүрийн хүн чанар тов тодхон харагдаж байдаг. Угтаа бол зан араншингийн шилдэг буурай гэдэг нь өчүүхэн бага ажил үйлийг ч гайхалтай сайхан бүтээж байна уу үгүй юу гэдгээс харагдаж байдаг. Өдөр тутмын амьдрал гэдэг яг л чулуу бутлах газартай адил юм. Тэндээс бид дадал хэвшлийн тулга болох чулууг таслан гаргаж, түүнийгээ бүтээж дуусгахаар цааш явдаг. Бусад хүнтэй харьцаж байгаа байдлыг харвал тэр хүний зан араншингийн ямар эсэх нь гартаа барьж үзсэн мэт ойлгогдож байдаг. Хэргэм зэргийн дээр доорыг бодолгүй хэнтэй ч байсан төлөв даруугаа алдалгүй харьцаж байгаа хүнийг харах нь үнэндээ сэтгэлд сайхан байдаг. Хангалттай хүндэтгэх сэтгэлтэйгээр хүнтэй харьцахад нөгөө хүнийхээ сэтгэлийг таатай болгох тул мэдээж тэр хүнд ч бас ихээхэн баяр баясгалан оргилж ирдэг бизээ.

Иймэрхүү гайхамшигтай хэв ёсыг өөрөө хөдөлмөрлөвөл хичнээнийг ч биедээ эзэмшиж болдог. Тухрайлбал түрийвчиндээ нэг пени байхгүй ч тийм сэтгэл байвал ёс зөвтэй, эелдэг халамжтай хүн болж чадах бүлгээ.

Хүнд хандах өөриймсөг сэтгэл бол түмэн зүйлд амьдрах хүч хайрлах нарны гэрэл лугаа адил үггүй нөлөөлөх хүчийг агуулж байдаг. Том дуугаар чангаан татаж муйхараар зүтгэхээс зөөлөн аядуу байдлаар харьцах нь үр дүнгээр хавьгүй их. Жижигхэн хонхлой хавар болохоор газар түлхэн соёолох нь цэцэглэхийн төлөөх түүний үггүй зоригийн илэрхийлэл билээ. Өөриймсөг сэтгэл ч бас энэхүү хонхлойтой угтаа адилхан агаад чимээгүйхэн шаргуугаар хавь орчны хүмүүсийн сэтгэлд нэвчин ордог бус уу.

***"Ёс жаяг барихад мөнгө хэрэггүй, гэтэл ёслол хүндэтгэлийг гүйцээхэд юу ч гарт орж ирдэг"***

Гайхамшигтай хэвшил амьдралд чийг шингээж байдаг. Гайхамшигтай хэвшил гэдэг нь гайхамшигтай үйлдлийн нөгөө нэр нь бөгөөд тэр нь ёс жаяг зөвтэй байдал болон эелдэг найрсаг сэтгэл хоёроос бүтэж байдаг.

Хүмүүс хоорондоо утга чанарлиг, таатай харилцааг үргэлжлүүлэхэд эелдэг найртай сэтгэл юунаас ч чухал үүрэгтэй. "Ёс жаяг барихад мөнгө орохгүй, харин ёслол хүндлэлийг гүйцээхэд юу ч гарт ордог" гэж Монтанью хэлсэн нь алдартай үг юм. Эелдэг найрсаг сэтгэл лавтайяа юунаас ч илүү хямд төсөр агаад цаг л алдахгүй бол өөрөө өөрийгөө золиослохын явдалгүй юм. Елизавет хатан хаанд Барри хэлэхдээ:

"Хүн санаж дурсаж байхаар бологтун! Тэгвэл та янз бүрийн эрхмүүдийн хайр хүндэтгэл хийгээд түрийвчийг гартаа хураах вий" гэжээ.

Бид хуурай цэмцэгнэхгүйгээр, бас ов мэх гаргалгүйгээр чин сэтгэлээсээ эелдэг найрсаг хандах төдийд л хавь орчиндоо талархал, баяр хөөрийг хүртээж болно. Өчүүхэн бага найрсаг сэтгэл гаргасан төдийд амьдрал эрс хувирах учиргүй хэдий ч, тийм болохоор эелдэг сэтгэлд үнэ цэн алга гэж бодож болохгүй юм. Өчүүхэн бага задгай мөнгийг ч өдөр бүр хурааж цуглуулаад байвал нэг жил, бүх л амьдрал улирах хооронд асар их мөнгө болох билээ. Үүн лугаа адил, өчүүхэн ч төдий эелдэг байж, түүнийгээ дахин давтах явцад наадахын сэтгэл нь цаадахдаа хуримтлагдсаар нэг л мэдэхэд санаанд оромгүй том үр дүнг төрүүлэх болно.

***Ёс жаяггүй байх нь хүний сайн аашийг хуртэл арилгаж үгүй болгодог***

Горим ёс бол үйлдлийг өөд нь татах чимэг зүүлт лугаа адил зүйл юм. Чин сэтгэлийн яриа өдөж, өөриймсөглөлөө үйлдэл төрхөөрөө илэрхийлэхэд өөрт нь таарсан арга зам байдаг. Ийм тохиолдолд горим ёсыг чанд сахих юм бол сэтгэл санаа чинь нөгөө талд бүр хүчтэй дамжигдаж байдаг. Эсрэгээрээ хичнээн эелдэг найрсаг сэтгэл байгаад урам онгодгүй байдал болон өөрийнх нь төлөө нэг их юм хийчихсэн мэт царай гаргавал нөгөө тал түүнийг таалалтай хүлээж авахгүй бизээ. Бас бодит амьдралд, муухай ааш зангаа бүр хөөр бахдал болгон бодож явдаг нөхөр ч бий юм. Ямар ч сайн суртал, чадал авъяастай байлаа ч тийм байдал төрхийг ил гаргаж байх ахул хүмүүсийн зүгээс зайгаа барихад хүрэх болдог.

Ичгуур сонжуургүйгээр, бусад хүний өөрийгөө хүндэтгэх сэтгэлд нь сэв суулгаад, таагүй яриа хөөрөөг сурамгай гэгч нь цааш тарааж байдаг, хүмүүсийн дургүй хүргэсэн амьтанд хэн ч байсан дуртай байхын учиргүй биз дээ.

Бас нөгөө талаар жирийн үед бусдад бялдуучлаж байгаад, өчүүхэн боломж олдвол өөрийнхөө агууг үзүүлээд авахаар оролдох нөхөр ч олон бий юм.

Нэрт эмч Абанеш гэгээн хутагтын эмнэлэгт ажилд орохоор хөөцөлдөж байх үед тааралдсан эр тийм маягийн хүн байлаа. Тэрээр баян, хүнсний дэлгүүрийн эзэн агаад эмнэлгийн захиралын нэр хавсарч байв. Тэрээр хүсэмжилсэн бичиг авахаар хэрэг болгон өөрийнх нь дэлгүүр хүртэл зорьж ирсэн Абанешийн өмнө, тэр их агуу том хүний өмнө дэмий маяглан ийн хэлжээ.

"Миний төсөөлж байгаагаар, эмч таны амьдралд ихээхэн чухал эргэлт болж, одоо миний зөвшөөрлийг хүсэхээр иржээ дээ". Түүрүүнээс хойш мөнөөхөн агуу том маяглалд дургүй нь хүрч байсан Абанеш шуудхан хариуд нь:

"Зөвшөөрөл гэнээ, тоглоом хийж байна уу, би зөвхөн инжир жимс авахаар ирсэн юм, нэг пенигийнхийг хурдан боогоод өг. Гадагш явах гээд яарч байна" гэжээ.

Ёс жаяг барих ч хэмжээ нь хэтэрвэл тус биш ус болно. Гэхдээ тохирсон ёс жаягт суралцах нь бизнест болоод хүнтэй харилцах тал дээр ихээхэн боломжийг олгож байдаг, хүнд дутааж үл болох нөхцөл мөн.

Ялангуяа өндөр албан тушаалтай эс бөгөөс харилцааны хүрээ өргөнтэй хүмүүсийн тухайд эелдэг найрсаг байх болон сайтар ёс жаягтай байх нь амжилтын түлхүүрийг атгаж байдаг гэлцдэг. Хэчнээн хичээнгүй зүтгэл, шударгуу нь чухам зурсан юм шиг хүн байлаа ч ёс жаяг барих тал дээр бүтэлгүй бол сайн зан ааш хүртэл хөшиг шатсан мэт хоосон болж орхидог.

Мэдээжээр ёс дэгийн сайн муу зэргийг тоолгүй харин бүр цаад мухарт нуугдаж байгаа жинхэнэ зан араншинд нь анхаарлаа хандуулах гэсэн ховор сонин хүн ч бас бий.

Гэвч ихэнх хүмүүс ийм өршөөл ивээлтэй биш билээ. Гадна өнгөнд нь илэрч байгаа авир төрхийг хараад тэр хүнийг тодорхойлж дуртай, дургүйгээ шийднэ гэдэг нь хүмүүсийн нийтлэг жирийн явдал шүүдээ.

### ***Хувцсан дор нуугдаж байгаа баян сэтгэлийг сайн ойлгож байх тухай***

Жинхэнэ ёс жаяг, төв дарууг мэддэг хүн бусдын санаа бодолд маш сайн чих тавьж байдаг. Эрт дээр үеэс хэлэлцэгдэж ирсэнчлэн, ёс жудаггүй байдал нь ихсээд ирэхээр биеэ тоон маадайх занд унахдаа хялбар. Ийм биеэ тоосон маадгар зангийн хамгийн муу илрэл нь өөрийн бодлоо хүчээр тулгах болон ихэрхэх зан юм.

Хүн бүрийн сэтгэх арга өөр өөр байдаг гэдэг бодит баримтыг бид эхлээд хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Үнэн хэрэг дээрээ үзэл бодол мөргөлдөж тулах болвол тэвчээр дээр тэвчээрийг давхарлан хурааж, шургуухан хэлэлцэн ярилцаж үзэх ёстой юм. Итгэл үнэмшил, үзэл бодол зэргээ аядуухан илтгэж нийлж байвал л сайн бөгөөд, хөөс цахруулан маргалдах, гар зөрүүлэхэд хүрэхийн хэрэгцээ байхгүй юм. Нудрага зөрүүлж сайн муугаа дуудалцаагүй ч ёсгүй үгийг нөгөө хүнийхээ цээжинд хатган зоож, цээрлэм шарх үлдээдэг тохиолдол ч олон байдаг. Иймэрхүү байдлыг ямагт цээрлэж байх нь чи өөрийнхөөл төлөө юм шүүдээ.

Гайхамшигт ёс жудаг, төв байдал нь хэргэм зэрэг угсаа гарлаас үл хамаарч хичээнгүй шударгуу агаад өөриймсөглөлийн гүн сэтгэлээс төрж гардаг. Биеийн хүчний ажил хийдэг гээд заавал ч үгүй байдал төрх нь бүдүүлэг доорд байх учир үгүй, эрхэмсэг ажил алба хашлаа ч үнэхээрийн ёс жудаггүй нөхөр ч байж л байдаг.

Цаг үргэлж биеэ боловсруулахуйг хуримтлуулж, илүү олон хүнтэй харьцахаар хичээл зүтгэл гаргавал, бид өөрийнхөө язгуур хүн чанараа бага боловч гарздалгүйгээр ёс жудаг төв байдал болон цэвэр тунгалаг шинжийг биедээ зүүж явах бизээ. Дээр доор, баян ядуугийн ялгаанаас хамааралгүй, бас амьдралын бололцоо нөхцлийн өөр ялгаатайгаас үл хамаарч хүн хэн ч байсан уудам дэлгэр, өгөөмөр баян сэтгэлтэй байх ёстой юм. Аль ч үед жинхэнэ сайн араншинт хүн уудам баян сэтгэлийн эзэн байдаг. Язгууртан хүний гоёмсог хувцас дотор төдийгүй тариачны болхи толхихон үнсэн саарал өнгөт хувцас дотор ч энэхүү гайхамшигтай сэтгэл нуугдан байж магадгүй юм.

Нэг удаа Шотландын яруу найрагч Роберт Баренз Эденбара нутгийн залуутай салхилж явжээ. Тэдэнтэй нэгэн шудрага тариачин эр зөрж өнгөрсөнд шүлэгч замын төв дунд эелдгээр мэнд мэдэлцэв. Тэгтэл хамт явсан омголон залуу түүнийг хараад шүлэгчид, биднээс зиндаа доогуур хүн байтал нуруу бөхийлгөнө гэдэг юу вэ? гэж хэлжээ. Үүнийг сонссон Баренз их дуугаар зандарсан нь:

"Чи ер яасан их балай тэнэг гэгч вэ? Би ноорхой гадуур хувцас, дугуй малгайд яриа өдөөгүй. Мэдээж модон гуталд ам нээгээгүй. Би түүн дотор байгаа нэг хүнтэй ярилцсан юм. Тэгээд зогсохгүй, тэр эр бүр байтлаа чи бид хоёр атугай бусад хэнээс ч илүү жин дарах үнэ цэнтэй хүн байхыг хэн мэдэх юм бэ?" гэжээ.

#### **4.Жинхэнэ сайн араншинт хүнийг хэмжих хэмжүүр**

Жинхэнэ сайн араншинт хүн бол хамгийн дээд үлгэр болохуйц зан төрхийн эзэн хүн байдаг. Жинхэнэ сайн зан төрхтэй хүнийг илтгэдэг "буянтан" хэмээх үг нь гарал зөвтэй үг агаад аль ч үед байр суурь, эрх хүчний бэлэг тэмдэг гэж үзэгдэж ирсэн билээ. "Буянтан хэзээ ямагт буянтан байдаг, зовлон гуйланчлал агаад аюул занал болонгуут нэгэн агшинд тэрхүү язгуур чанараа бүрэн дүүрэн тодорхой гаргаж байдаг" гэж Францын нэгэн ахмад жанжин цэргүүддээ хэлж байжээ. Буянтны уян зөөлөн чанар өөрөө сүр хүчтэй юм. Тиймээс өндөр дээд цэвэр оюун санааны эзэн хүн буянтныг төрөлх мэдрэмжээрээ дагаж байдаг юм. Жинхэнэ сайн зан араншинтай хүн мөн үү, биш үү гэдэг нь хувцас өмсгөл хийгээд амьдралын хэв ёс, байдал төрхөөр бус, ёс суртахууны үнэ цэнээр нь тодорхойлогдож байдаг. Өмч хөрөнгө бус зан ааш тэрхүү шийдлийн хэмжүүр болдог юм. Библийн сударт жинхэнэ сайн араншинт хүн "шулуун алхаж, ёс жаяг барьж, сэтгэлийнхээ чин үнэнийг өгүүлж байдаг" гэж бичсэн байдаг. Жинхэнэ сайн араншинт хүн өөрийгөө хүндэтгэх сэтгэл элбэгтэй, юунаас ч илүү өөрийнхөө зан төрхөнд анхаарч байдаг.

Гэхдээ бусдад харагддагаасаа илүү оорөөс нь өөр хүн үздэггүй зан төрхөө эрхэмлэж байдаг. Тэр бол сэтгэлийн дотор буй толиндоо өөрөө зөвөөр харагдахыг хүсэмжилж буй хэрэг юм. Бас сайн араншинт хүмүүн өөрийгөө эрхэмлэн хүндэтгэж буйтайгаа яг адилхан учир шалтгаанаар өрөөл бусдыг ч мөн адил хүндэтгэж байдаг. Тэдний хувьд хүн чанар гэдэг бол ариун хутагт болгоод шүтэж байх ёстой зүйл байдаг. Ийм сэтгэлгээнээс төв ёс, хүлээцтэй хандах, өөриймсог байдал, сайн санааны сэтгэл зэрэг нь торж гардаг.

#### ***Шударга бусыг эрс татгалздаг зоригтой бай***

Жинхэнэ сайн араншинт хүн магтаал хүндлэлийг нандигнах сэтгэл элбэгтэй, үл бүтэх үйлдэл хийхгүй байхын төлөө хэзээ ямагт санаа тавьж байдаг. Үг яриа, үйл хөдлөлийн тухайд юунаас ч илүү хичээнгүй шударгууг сэтгэлдээ хадгалж, арга саам хийх болон амласан ярьснаасаа бунах гэлгүй, шударга бус хийгээд бульхай мэхээр гараа бузарладаггүй. Эцэст нь хүртэл шударга явахаар зүтгэж байдаг.

Сайн араншинтай хүний итгэл үнэмшлийн хамгийн нэгдүгээрт үнэнч шударга ажиллах явдал байдаг. Нэр нүүр, үүрэг ухамсараа бодоод сэтгэлээсээ биш "за" гээд хэлчихсэн бол нөгөө хүндээдалим олгохын шалтаг болно.

Татгалзах ёстой тохиолдолд эрс шийдмэг байдлаар "үгүй" гэж хэлэхгүй бол болдоггүй. Ийм зоригийг бисдээ эзэмшсэн хүн ердөө ч хээл хахуулийн өөшийг үмхдэггүй юм. Авилгалч талын арга мэхэнд сурамгай гэгч нь давхиж орох нь цаад чанар нь оөдгүй, барьцгүй нохдүүдийн хэрэг.

Шударгуу араншингаар явж ирсэн Ханвей тэнгисийн цэргийн хүнсний хангамжийн албаны даргаар ажиллаж байхдаа үйлчлүүлэгчдээс срдөө гар тосч байсангүй. Энэ бол түмэн олны албыг хашиж явахад ивээлд багтах, шадарлах гэх явдал байж болохгүй зүйл гэж бодож байснаас тэр юм.

Үүнтэй адил жишээнд Вейлinton жанжны амьдрал ч багтах юм. Вейлinton Энэтхэгт илгээгдэн ажиллаж байх үед марат үндэстэн Хайдарабад улс хоёрын хооронд дайн болжээ. Дайн дуусч энхийн гэрээ байгуулах шатанд хүрч Хайдарабад улсын ерөнхий сайд түүнийгзорьж ирж гэнэ.

Хэлэлцээрээр өөрийн улсад нь хэр хэмжээний газар нутаг, эрх ашиг хүртээх болоо гэдгийг мөрдөж мэдэх нь түүний цаад санаа аж. Түүнд мэдээлэл өгвөл арван түмэн фунтээс илүү асар их хэмжээний мөнгө өгнө гэж хэлж байна гэнэ.

Гэтэл Вейлinton ерөнхий сайдын царайг хэдхэн хором чимээгүй ажиж байснаа ам нээж: "Миний ойлгож байгаагаар та нууц хамгаалдаг талын хүн юм шиг бодогдож байна, харин..." гэсэнд "мэдээж шүү дээ, мэдээж" гэж ерөнхий сайд өндөлзжээ. Тэгтэл Вейлinton "тийм бол та надтай адилхан юм байна" гэж хариулаад инээмсэглэсэн царайгаар мэхийн ёслож, ерөнхий сайдыг өрөөнөөсөө үдэн гаргасан гэдэг.

Тэр цагийн Вейлinton цэргийн албан дахь амжилтаараа гайхагдсан тул асар их эд баялгийг гартаа хийе гэж бодвол болохоор бололцоотой байв. Гэтэл үнэндээ өврөө дүүргэх гэсэн өчүүхэн ч санаа гаргалгүй ядуухан жанжин хэвээрээ төрөлх орондоо буцсан байдаг. Тэгээд харин тэр байдал нь түүний алдар хүндийг цааш нь нэг шат өндөр болгосон үр дүнд хүргэсэн билээ.

Түүнтэй адил цэргийн хүн Чарльз Непия ч бас Энэтхэгт суурьшиж байхдаа өөрийгөө эзэмдэх сэтгэлийг гайхамшигтай харуулсан байдаг. Уугуул нутгийн томоохон язгууртнуудын өгсөн өндөр үнэтэй бэлэг сэлтээс нэгд нэгэнгүй татгалзаж ирсэн тэрээр дараах байдлаар чин сэтгэлээр илэн далангүй өгүүлсэн нь:

"Тэнд очсоноос хойш, заль гарган сүйхээчилж хөлхсөн бол хангалттай гурван түмэн фунт өвөрт өнхрөөд орж ирэх байсан болов уу. Гэвч миний гарч, сэлэм ч одоогоор өчүүхэн ч бохирдоогүй байна" гэжээ. Эд баялаг, хэргэм зэрэг бол гайхалтай хүн чанартай ямар ч хамаа байхгүй. Хэчнээн ядуу хүн байлаа ч жинхэнэ сайн араншинт хүний сэтгэлийг цогцлуулан явдаг байж магадгүй юм. Өдөр бүр мөнгөөр гачигдаж амьдралаа ч гайхамшигтай хүн чанар хадгалагдан үргэлжилж байдаг.

Хичээнгүй шударгуу болон хэв ёсыг маргалгүй төлөв даруу, эр зоригтой байж, өөрийгөө хүндэтгэх сэтгэл хийгээд өөртөө туслахын ухаанаар зүг чиг хийж амьдарч буй хүн ядуу чинээлэг аль нь ч байсан жинхэнэ сайн зан араншинтай хүн байдаг.

Ядуу ч гэсэн сэтгэлээрээ баян хүн бол, сэтгэл ядуухан баян хүнээс олон талаараа давуу юм. Хутагт Паулийн хэлсэн үгнээс иш татвал ядуу ч гэсэн сэтгэлээр баян хүн"юу ч үгүй юм шиг авч, үнэндээ бол бүгдийг олж байдаг" ажээ. Тийм амьдрал хүсэл мөрөөдлөөр бялхаж юунаас ч айх зүйлгүй болгодог. Эсрэгээр, сэтгэл ядуутай мөнгөөр баян хүн юуг ч гартаа оруулавч үнэндээ бол тэд улаан мөнгөгүйтэй адил. Тийм амьдралд хүсэл мөрөөдөл ч байхгүй, сэтгэл нь айдсаар дүүрч байдаг. Ийм ядуухан оюун санааны эзэн л жинхэнэ утгаараа ядуу хүн бүлгээ.

Харахад сайхан байдал төрхөн дор жинхэнэ эр зориг хийгээд найрсаг шинжээ нуун авч явдаг гайхамшигтай хүн ч бас олон бий. Тийм дурсамжийг та бүхэнд танилцуулъя. Эрт цагт Адейшио гол гэнэт үерлэж ардуудын гэр эгнэсэн Вейрон гүүрийн гол дундахь нэг хэсэг тэр чигээрээ урсаж оджээ. Тэнд нэгэн айл үлдэж хоцорсон бөгөөд цонхоор нь тусламж эрсэн хүмүүсийн бараа харагдана. Үер юу юугүй тэр гэрийг довжоотой нь хамт урсгаж авч явчих гээд байв. Эрэгдээр ирж сандарсан Сфорбелини гүн эргэн тойрондоо цугларсан хүмүүсийг уриалан дуудав.

"Энэ хөөрхийлөлтэй хүмүүсийг аварсан хүнийг нэг зуун пүй-гээр шагнана" гэлээ. Гэтэл нэг залуутариачин эр цугласан хүмүүсийг хага яран урагшилж, жижиг завинд зоригтой үсрэн сууж, аймшигтай хүчтэй урсгал руу ухасхийн орж явчихлаа. Тэрээр гүүрийн зүг чиглэн очиж, хурдан шалмагаар тэр айлынхныг онгоцондоо суулган тэр чигээрээ аюулгүй эргийн зүг буцаж ирэв.

"Үнэн мундаг залуу байна. Шагналынхаа Мөнгийг авбал таарна" гэж талархсан өнгө аясаар гүн түүнд хандаж хэлэв. Гэтэл нөгөө залуу тариачин эр ийн хэлэв гэнэ.

"Тэгэх хэрэггүй. Би амь насаараа дэнчин тавьж аюулыг сөрсөн нь ердөө ч мөнгөний төлөө биш юм. Мөнгө гаргах гээд байгаа юм бол энэ айлд өгөөрэй. Гэрээ урсгачихаад зовж зүдэрч байгаа нь энэ хүмүүс шүү" гэжээ.

### ***Жинхэнэ эр зориг ямагт эелдэг найрсаг сэтгэлтэй хамт байдаг***

Жинхэнэ зан араншин сайтай хүн, бусад хүнээс нэг дахин илүү хичээнгүй шударгууг биедээ шингээсэн байдаг. Ингэж хэлж байгаа нь, хичээнгүй шударгуу байдал л хүний амьдралын алдар хүндийн титэм бөгөөд хүний хорвоод хандах шударга үнэн эндээс төрж гардаг гэдгийг тов тодорхой ойлгож байгаатай холбоотой.

Чейстфейлд "эрхэм таны амжилтыг хичээнгүй шударгуу чанар л бий болгож өгдөг юм шүү дээ" гэж хэлжээ.

Жинхэнэ эр зориг хийгээд эелдэг найрсаг байдал хамтдаа гар гараасаа хөтлөлцөн урагшилж явдаг. Зоригтой хүн бол цар хэмжээ өргөнтэй өгөөмөр байдаг. Уужуу хүлээцтэй сэтгэлээр дутаж, хэв нэг байж

хэрцгий үйлдэл хийгчийг жинхэнэ зоригтон гэж хэлэхгүй. Алдарт далайчин Жон Франклин-ы тухай түүний найз Фари өгүүлэхдээ:

"Тэр бол аюулаас огтхон ч зугатаах маягийн хүн биш. Тийм атлаа ганц шумуулыг хүртэл гараараа шудрахгүй мэт өр зөөлхөн чанар ч бас түүнд байсан" гэжээ.

Ийнхүү Фари-гийн үгэнд зоригтоны жинхэнэ дүр зураг гайхамшигтай дүрслэгдсэн байна. Одоо дахин нэг жишээ өгүүлье. Энэ бол хойгийн дайны үеэр Францын Не жанжны харуулсан өндөр дээд, хиргүй тунгалаг өөриймсөглэлээр бялхсан үйлдэл юм. Тэр үед энэ дайнд оролцож байсан Чарльз Непия Корунагийн тулалдаанд хүнд шархдаж Францын цэргүүдэд олзлогджээ. Түүний аюулгүй байдалд санаа зовнисон анд нөхөр нь тусгай элч илгээж, Не жанжинд бараалхан хоригдолтой уулзуулж өгөхийг шаарджээ. Түүнийг зөвшөөрсөн жанжин доод тушаалын офицертоо ийм тушаал өгчээ. "Непия ноёнтонг энэхүү элчтэй уулзуулж, бие лагшин нь ч сайн, эндэхийн тусгай нөхцөл ч гайгүй байгааг өөрийнх нь амаар хэлүүлээрэй" гэжээ.

Гэтэл нөгөө офицер тэр тушаалыг сонсоод шууд өрөөнөөс гарах шинжгүй байв. Жанжин инээмсэглэн асуулаа: "Непия ноёнд өөр хүсч байгаа юм байна уу" гэв. "Үнэндээ бол төрсөн нутагт нь нас өндөр болсон сохор ээж нь байдаг бололтой".

"Тэр үнэн үү. Тэгвэл шууд суллая. Эсэн мэнд байгаа барааг нь харуулах нь хамгийн чухал шүү" гэжээ.

Тэр үед улс хооронд хоригдол солилцохыг зөвшөөрдөггүй байлаа. Не жанжны тухайд Непия-г суллахад Наполеоныг уурлуулж магадгүй гэсэн айдас дүүрэн байв. Гэвч жанжин, ээжийнхээ биеийг санагалзах Английн залуу офицерыг чөлөөлж тавих хэмээх гайхалтай шийдвэрийг гаргажээ. Бас Наполеон ч энэхүү өгөөмөр арга хэмжээнд санал нэгтэй байгаагаа илэрхийлсэн гэдэг.

### *Хүний үнэ цэнийг шийдвэрлэж өгдөг бяд муутай хүмүүст хандах өөриймсөг сэтгэлийн тухай*

Жинхэнэ сайн зан араншинтай хүн мөн үү биш үү гэдгийг хэмжих хэмжүүр олон бий. Түүн дотроос алдаа мадаггүй нэг арга бол тэр хүн өөрөөсөө доод хүнд яаж хандаж байгааг харах явдал юм. Эрчүүд байвал эмэгтэйчүүд хүүхдүүдтэй ямар байдалтай харьцаж байна вэ? Албан тушаалтан бол доод тушаалын хүнээ яаж авч үзэж байгаа, эзэн бол зарцаа, багш бол шавьдаа яаж хандаж байна вэ? Өөрөөсөө доод бага байр суурийн хүнтэй яаж нөхөрлөж байна вэ. Бас тийм тохиолдолд ялган салгах, хүлээцтэй байх, өөриймсөж үзэх зэргийг гаргаж чадаж байна уу, үгүй юу гэдэг, тэр хүний зан араншинг хэмждэг шийдвэрлэх хэмжүүр болж байдаг.

Яруу найрагч Ла Мотт нэгэн өдөр хүмүүсийн чихэлдээн дунд явж байгаад яльгүй мөргөлдөж, нэгэн залуугийн хөл дээр гишгиж орхижээ. Уурласан залуу гэнэт түүний нүүр лүү дэлсэж орхитол яруу найрагч санаа алдахыг хослуулан байж ингэж хэлсэн гэдэг.

"Та хэзээ нэгэн цагт өөрийнхөө хийсэн хэрэгт харамсах чинь зайлшгүй. Намайг сохор хүн юм гэдгийг анзаарсан бол..." гэжээ.

Эсэргүүцэх чадалгүй нэгнээ гадуурхаж шоглодог хүнийг жинхэнэ сайн зан араншинтай хүн гэхгүй. Бяд чадал муутай хүмүүс болон нэмэр нөөлөг болохооргүй хүмүүсийг шахан хавчиж байдаг нөхөд бол аймхай хулчгар хүнээс өөрцгүй юм. Эрт дээр үеэс хэлэлцэж ирсэнчлэн "өөдгүй эрийг эргүүлээд тавьчихвал дарангуйлагч болж хувирна" гэсэн үг бий. Сэтгэл зөвтэй хүн чадалтай байсан ч түүнийгээ хэрэглэх замыг тов тодхон ухамсарлаж байдаг бөгөөд хүч хэрэглэх үед ч анхаарал сэрэмжтэй хандахаа огтхон ч мартдаггүй.

Ингэж бодоод ирэхээр эелдэг зөөлөн сэтгэл хийгээд өөриймсөг сэтгэл бол хүний хүн чанарыг тодорхойлох маш чухал шийдвэрлэх зүйл мөн гэж хэлж болмоор байна.

Жинхэнэ сайн араншинтай хүн бол өчүүхэн жижиг юман дээр ч бусад хүнд анхаарал тавьж байгаа нь мэдрэгдэж байдаг. Нөгөө тал нь өндөр байр суурьтай байлаа ч, өөрөөс нь доор хүн байлаа ч тэгэж санаа тавих нь өөрчлөгддөггүй.

Жинхэнэ сайн хүн бусдын үйлдлийг хамгийн муухайгаар шүүмжлэн хэлж, бодит байдлыг улам даамжруулан муутгахаасаа илүү, өөрөө их бага шархдсан ч хамаагүй халуун чулуу долоохыг өөртөө сонгож байдаг. Бас өөрөөсөө илүү хувьгүй тавиланд байгаа хүний сул тал хийгээд алдаа мадагт өгөөмөр сэтгэлээр хандахыг зорьдог. Тийм хүн эд баялаг, хүч чадал, авьяасандаа сагсуурч сагалгүй, амжилт оллоо ч тэнгэрт нисэлгүй, алдаанд орлоо ч тийм их унаж шавхайддаггүй юм. Бусдад өөрийн үгээ хүчээр тулгалгүй, шаардлагатай үед л зөвхөн өөрийнхөө бодлыг төв төвшин сэтгэлээ уудлан ярьдаг. Хүнд хэрэг тус болох тохиолдолд ч нэг их зүйл хийгээд өгчихсөн мэт байдлыг огтхон ч үзүүлдэггүй. Энэ бол ёстой жинхэнэ сайн араншинт хүн мөн. Өдөр тутмын амьдралын ямар ч яль шальгүй жижиг тохиолдолд өөрийгөө зөнд нь

орхиод өрөөл бусдын тусын тулд зориулъя гэх энэхүү чанарт л жинхэнэ хүн чанартай хүнд байх ёстой дүр төрх тов тодхон илэрч байдаг болой.

## Уялга үг

Миний бие уншигч Танд нэгэн сонин сайхан ном толилуулахаар шийдсэн юм. Энэхүү ном бол Самуэл Смайлс(1812-1904)-ийн бичсэн "Self-Help, with illustrations of character and Conduct" буюу "Өөртөө туслах ухаан" хэмээх бүтээл бөлгөө. Уг ном 1858 оны 7 дугаар сард, тэхлээр одоогоос зуун тавь шахам жилийн өмнө хэвлэгдэж, тэр даруйдаа Америк, Европ, Ази тивийн олон оронд орчуулагдан түгж, Японд гэхэд л Мэйжийн 4-р онд буюу 1872 онд Накамүра Масанао орчуулж "Барууныхан хөл дээрээ боссон түүх" хэмээн гарчиглан хэвлүүлжээ. Уг ном Фүкүзава Юкичи-гийн "Эрдмийг эрхэмлэхүй" номын хамтаар Мэйжигийн үед залуусын шимтэн унших ном болж, тэр цагийн япон оронд нэг сая хувь борлогдож байсан гэлцдэг. Накамүра Масанао уг номыг орчуулан Япончууддаа хүргэх нь "залуучуудад амьдрах аргыг нь зааж өгч байгаа хэрэг гээд, орчуулж байгаа маань ч эх орныхоо тусын тулд" гэж үзэж байжээ. Тэр үед Мэйжийн эрс шинэчлэл амжилт олсон хэдий ч эгэл жирийн олон түмэн амьдрах аргаа олохгүй, баримтлах чиглэл мухардмал байсан тул тэдэнд асар их нөлөө үзүүлж, өөрөө өөрийгөө өөд нь татаж амьдрахын үзэл санааг шингээхэд их түлхэц болжээ.

Миний бие уг номыг япон хэлнээс хөрвүүлэн хэвлүүлж байна. Ингэхдээ Такеүчи Хитоши-гийн "Өөртөө туслахын онол" (Микаса шёбоо хэвлэлийн газар, 1984 он) хэмээх хураангуйлан орчуулсан эхийг гарын авлага болгосон юм. Японы нэрт эрдэмтэн, нийтлэлч, орчуулагч Такеүчи Хитоши уг номыг орчин үеийн япончуудад дахин хүргэж байгаагаа нэгдүгээрт "хөгжил ханахын өвчнийг илааршуулахад" энэ ном хэрэгтэй, хоёрдугаарт нэн ялангуяа залуучууд заавал унших нь чухал юм гэж тайлбарласан байдаг.

Миний бие шинэ зуун, шинэ мянганы манлай онд энэхүү алдартай номыг эх хэлнээ хөрвүүлж монголчууддаа хүргэж байгаагаа бэлэгшээхийн сацуу эрхэм уншигч Та бүхнээс хүсэх зүйл буй. Юу гэвэл залуу хүн бүр "бусдын ивээл хишгийг горьдох бус, бат чанга өөрийн бодолтой байж, зөв зорилгын араас хөөцөлдөхийн тулд ажил хөдөлмөр, зовлон бэрхшээл, өөрийгөө золиослоход үл шантарч хичээл чармайлт гаргах"-ыг, бас өөртөө туслахын сэтгэл өвөрлөсөн хүнийг бусад нь дэмжиж туслаж явахыг, энэ нь хүн бүрийн амьдралын чиг шугам болохыг, бас энэхүү номын үзэл санаа, арга барил манай шинэ утга зохиолд танил атлаа шинэ сэдэв, шинэ санаа болоосой гэж хүсч байна.

Энэхүү номыг орчуулан хэвлэхэд хамтран ажилласан эрдэмтэн бичгийн хүн Бүдрагчаагийн Даш-Ёндон авгай, чин сэтгэлээсээ дэмжин талархаж, урам хайрласан "Адуунчулуун" хувьцаат компанийн захирал Ц.Шинэбаяр, Япон улсаас Монгол улсад суугаа элчин сайд эрхэмсэг ноён Ханада Марохито, надад байнга үнэтэй зөвлөгөө өгч, туслан дэмжиж ирсэн Токиогийн Азийн Их Сургуулийн захирал, монголч эрдэмтэн, миний багш Койбүчи Шиньичи, уг номыг орчуулан хэвлэхэд сэтгэл, зүтгэл гаргасан Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлагийн эдийн засгийн зөвлөх, ноён Ацүши Фүжимото, нарт гүн талархаж байгаагаа энэ ялдамд илэрхийлье.

Миний бие үүрийн гэгээ, үдшийн бүрийтэй ханьсан байж орчуулахаар чадан ядан махран сууж байхдаа амьдралын хатуу үнэн, гашуун зайлшгүйг сэтгэлд шингэтэл илэрхийлсэн гайхамшигтай хэллэгийг уншаад аньсага чийгтүүлэн, сэтгэл хөдлөн байж, хэдэн жилийн өмнө ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн хайрт эцэг Ренчиний Очирхүү агсны гэгээн дурсгалд энэхүү орчуулгын номоороо зул өргөө гэж шийдсэн юм аа. Номын хишиг буян улам арвин байх болтугай. Очирхүүгийн Жаргалсайхан

Зохиогч САМУЭЛ СМАЙЛС (181С-1904)

Шотландын Хадинтон хотэд төрсөн. Эмчийн мэргэжиг. эзэмшсэн хэдий ч "Өөртөө туслах ухаан" номоороо амжилт олсон тул сэтгүүл зүй, бичиж туурвих ажилд хүчээ сорих болжээ. Түүний бичсэн "Self-Help", "Character", "Thrift", "Duty" бүтээлүүд ихэд алдартай. Америк, Ази, Африк, Европын олон оронд орчуулагдан түгжээ.

Орчуулагч ОЧИРХҮҮГИЙН ЖАРГАЛСАЙХАН

Хөвсгөл аймгийн Баянзүрх суманд 1964 онд төрсөн. МУИС-ийг орчуулагч багшийн мэргэжлээр төгсч, 1993-1998 онд Токиогийн Гакүгэй Их Сургуульд суралцсан. Боловсрол судлалын мастер. Шибa Рёотарогийн "Тал нутгийн тэмдэглэл" (1997) тууж болон "Хорин нэгдүгээр зуунд амьдрах хөвгүүд охидод", "Кооаны гэгээ", "Тэнгэр уулын суган дор их талын эхэнд", "Монгол таталбар" эссэ, "Оросын тухай" тууж (хэвлэлд бэлтгэж буй), Мүрао Ясүкогийн "Талын салхи шигээ болохсон" тууж зэрэг бүтээлүүдийг орчуулсан.